ҮНДЭСНИЙ СТАТИСТИКИЙН ХОРОО

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР

ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ, ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН ЯАМ

# ХӨДӨӨ АЖ АХУЙН 2022 ОНЫ ТООЛЛОГЫН

# НЭГДСЭН ҮР ДҮН



УЛААНБААТАР ХОТ
2022 ОН

# ХӨДӨӨ АЖ АХУЙН 2022 ОНЫ ТООЛЛОГЫН

# НЭГДСЭН ҮР ДҮН

УЛААНБААТАР ХОТ
2022 ОН

ХЯНАСАН:

| | |
|---|---|
| Б.Батдаваа | Дарга |
| Д.Лхамсүрэн | Дэд дарга |
| Б.Саранчимэг | Нэгдсэн статистикийн газрын дарга |
| Ц.Тэгшжаргал | Эдийн засгийн статистикийн газар (ЭЗСГ) -ын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч |

БЭЛТГЭН БОЛОВСРУУЛСАН:

| | |
|---|---|
| Э.Мягмарханд | Хөдөө аж ахуй, байгаль орчин үйлдвэрлэлийн статистикийн хэлтсийн дарга (ХААБОҮСХ) |
| Б.Уянгаа | ХААБОҮСХ-ийн ахлах статистикч |
| Х.Тэмүүлэн | ХААБОҮСХ-ийн статистикч |
| Б.Намсрайжав | ХААБОҮСХ-ийн статистикч |
| Б.Маралсувд | ХААБОҮСХ-ийн гэрээт ажилтан |
| Э.Сарнай | ХААБОҮСХ-ийн гэрээт ажилтан |
| М.Үүрийнтуяа | ХААБОҮСХ-ийн гэрээт ажилтан |

МОНГОЛ УЛСЫН ҮНДЭСНИЙ СТАТИСТИКИЙН ХОРОО

Монгол Улс, Улаанбаатар хот,
Засгийн газрын III байр,
Бага тойруу - 44, Улаанбаатар -11
Утас: (976-11)-326414, (976)-70141212
Факс: (976-11)-324518
Цахим хуудас: www.1212.mn
Цахим шуудан: information@nso.mn

# АГУУЛГА

ӨМНӨХ ҮГ ..... v
ХҮСНЭГТЭН МЭДЭЭЛЛИЙН ЖАГСААЛТ ..... vii
ЗУРГАН МЭДЭЭЛЛИЙН ЖАГСААЛТ ..... xiii
ТОВЧИЛСОН ҮГСИЙН ЖАГСААЛТ ..... xiv
НЭР ТОМЬЁОНЫ ТОВЧ ТАЙЛБАР, ТОДОРХОЙЛОЛТ ..... xv
ХӨДӨӨ АЖ АХУЙН ТООЛЛОГЫН ТҮҮХ ..... 18
I. ТООЛЛОГЫН ЗОХИОН БАЙГУУЛАЛТ ..... 21
I.1. Хууль, эрх зүйн үндэслэл ..... 21
I.2. Хөдөө аж ахуйн тооллогын зорилго ..... 21
I.3. Тооллогын удирдлага, зохион байгуулалт ..... 21
II. ХӨДӨӨ АЖ АХУЙ, ОЙН АЖ АХУЙ, ЗАГАС, АН АГНУУРЫН АЖ АХУЙ ЭРХЭЛДЭГ ӨРХ, АЖ АХУЙН НЭГЖ БАЙГУУЛЛАГА ..... 30
III. ХӨДӨӨ АЖ АХУЙ ЭРХЭЛДЭГ ӨРХ, ТҮҮНИЙ ТЭРГҮҮЛЭГЧ БОЛОН АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГА, ТҮҮНИЙ УДИРДЛАГА ..... 33
IV. ХӨДӨӨ АЖ АХУЙН САЛБАРЫН АЖИЛЛАГЧИД ..... 47
IV.1. МАЛ АЖ АХУЙН САЛБАРЫН АЖИЛЛАГЧИД ..... 49
IV.2. ГАЗАР ТАРИАЛАНГИЙН САЛБАРЫН АЖИЛЛАГЧИД ..... 56
V. ХӨДӨӨ АЖ АХУЙН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ҮЙЛДВЭРЛЭЛ, БОРЛУУЛАЛТ ..... 64
V.1. Мал аж ахуйн салбарын бүтээгдэхүүн үйлдвэрлэл, борлуулалт ..... 64
V.2. Малын тоо, сүргийн бүтэц ..... 65
V.3. Жишсэн хүн амын жилийн мах, сүүний хэрэгцээ ..... 69
V.4. Мал аж ахуйн бүтээгдэхүүнээ борлуулж байгаа байдал ..... 70
V.5. Мал аж ахуйн үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний борлуулалттай холбоотой гардаг хүндрэл, бэрхшээл ..... 71
V.6. Мал аж ахуйн салбарын бүтээгдэхүүнийхээ үнийг тогтоодог хэлбэр ..... 72
V.7. Газар тариалангийн салбарын бүтээгдэхүүн үйлдвэрлэл, борлуулалт ..... 73
V.8. Жишсэн хүн амын жилийн төмс, хүнсний ногооны хэрэгцээ ..... 75
V.9. Га-гийн ургац ..... 75
V.10. Ургац хураалтын дараах боловсруулалтын үе шат бүрийн алдагдал/хорогдол ..... 76
V.11. Газар тариалангийн салбарт үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн, хэрэглээний зориулалтаар ..... 77
V.12. Газар тариалангийн бүтээгдэхүүнээ борлуулж байгаа байдал ..... 77
V.13. Газар тариалангийн бүтээгдэхүүний борлуулалттай холбоотой тулгардаг хүндрэл, бэрхшээл ..... 79
V.14. Газар тариалангийн бүтээгдэхүүний үнийг тогтоодог хэлбэр ..... 81
VI. ХӨДӨӨ АЖ АХУЙН САЛБАРТ АШИГЛАГДАЖ БУЙ МАШИН, ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ ..... 84
VI.1. Мал аж ахуйн салбарын машин, тоног төхөөрөмж ..... 84
VI.2. Газар тариалангийн салбарын машин, тоног төхөөрөмж ..... 85
VII. ХӨДӨӨ АЖ АХУЙН ЗОРИУЛАЛТТАЙ БАРИЛГА, БАЙГУУЛАМЖ ..... 90
VII.1. ГАЗАР ТАРИАЛАНГИЙН ЗОРИУЛАЛТТАЙ БАРИЛГА, БАЙГУУЛАМЖ ..... 91

VII.2. МАЛ АЖ АХУЙН ЗОРИУЛАЛТТАЙ ХӨДӨӨ АЖ АХУЙН БАРИЛГА, БАЙГУУЛАМЖ 96
VIII. МАЛЫН ХАШАА ........ 101
IX. ХУДАГ, УСАН САН ........ 103
IX.1. Мал аж ахуйн салбарт ашиглаж байгаа худаг, усан сан ........ 104
IX.2. Газар тариалангийн салбарт ашиглаж байгаа худаг, усан сан ........ 104
X. ХӨДӨӨ АЖ АХУЙН ҮЙЛДВЭРЛЭЛД ҮЗҮҮЛСЭН ҮЙЛЧИЛГЭЭ ........ 107
X.1. Даатгалд хамрагдсан өрх, ААНБ ........ 107
X.2. Зээл авсан өрх, ААНБ, зээлийн хугацаа, барьцаа хөрөнгө ........ 108
X.3. ХАА-н бүтээгдэхүүн борлуулалтын орчин ........ 110
XI. ГАЗАР ТАРИАЛАНГИЙН САЛБАРЫН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТҮҮД ........ 114
XI.1. Газар түүний ашиглалт ........ 115
XI.2. Ойн зурвас байгуулалт ........ 116
XI.3. Усалгаатай тариалан ........ 117
XI.4. Хөрсний доройтол ........ 124
XI.5. Бордоо, бодис ашиглалт ........ 128
XII. ХӨДӨӨ АЖ АХУЙН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ҮЙЛДВЭРЛЭГЧИЙН ҮНЭ ........ 138
XII.1. Мал аж ахуйн бүтээгдэхүүний үнэ ........ 138
XII.2. Газар тариалангийн бүтээгдэхүүний үнэ ........ 144
XIII. МАЛЫН АШИГ ШИМИЙН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ГАРЦ ........ 147
XIII.1. Малын сүүний гарц ........ 147
XIII.2. Ноос, ноолуур, хөөвөр, хялгасын гарц ........ 150
XIII.3. Малын амьдын болон гулуузны жин ........ 151
XIV. ХӨДӨӨ АЖ АХУЙ ЭРХЭЛДЭГ ӨРХИЙН ХҮНСНИЙ ХАНГАМЖ ........ 154
XV. ОЙ, ЗАГАСНЫ АЖ АХУЙ, АН АГНУУРЫН САЛБАРЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА ........ 162
XV.1. Ойн аж ахуй ........ 162
XV.1.1. Ойн аж ахуй эрхэлдэг аж ахуйн нэгж, байгууллагын тоо ........ 162
XV.1.2. Ойн аж аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага ........ 163
XV.1.3. Үйл ажиллагааны талаарх мэдээлэл ........ 163
XV.1.4. Ой, загасны аж ахуй, ан агнуурын үйл ажиллагаа эрхэлдэг өрх ........ 167
XV.2. АН АГНУУРЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЭЛСЭН ӨРХ ........ 169
XV.3. ЗАГАСНЫ АЖ АХУЙ ЭРХЭЛСЭН ӨРХ ........ 170
XVI. СУМЫН ЗАРИМ ҮЗҮҮЛЭЛТҮҮД ........ 172
XVI.1. Газар зүй, байгаль орчин ........ 172
XVI.2. Нийгэм эдийн засгийн байдал ........ 173
ДҮГНЭЛТ ........ 179
ХАВСРАЛТ ХҮСНЭГТ ........ 183

## МОНГОЛ УЛСЫН ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН САЙД, ХӨДӨӨ АЖ АХУЙН ТООЛЛОГЫН УЛСЫН КОМИССЫН ДАРГА Х.БОЛОРЧУЛУУН



## ӨМНӨХ ҮГ

Статистикийн тухай хууль, Засгийн газрын 2022 оны 2 дугаар сарын 16-ны өдрийн 74 дугаар тогтоол, тооллогын Улсын комиссын хурлын шийдвэрийн дагуу Хөдөө аж ахуйн 2022 оны тооллогыг амжилттай зохион байгууллаа.

Энэхүү тооллогоор хөдөө аж ахуйн салбарын мэдээллийг өрх, аж ахуйн нэгж бүрээр дэлгэрэнгүй цуглуулж, хөдөө аж ахуйн салбарын ажиллах хүч, мал аж ахуйн болон газар тариалангийн машин тоног төхөөрөмж, барилга байгууламж, газар ашиглалт, хөрсний доройтол, ургацын хорогдол, бордоо, ургамал хамгааллын бодисын хэрэглээ, ХАА-н бүтээгдэхүүний зардал, хүнсний хангамж, аюулгүй байдлын талаарх статистик мэдээллийн эх үүсвэр бий болсон. Салбарын үндсэн үзүүлэлтүүд, ялангуяа бүтээгдэхүүний хэмжээ, бүтцэд гарч байгаа өөрчлөлтийг хэмжиж чадсанаар хөдөө аж ахуйн салбарыг хөгжүүлэх бодлого боловсруулах, хэрэгжилтийг дүгнэхэд шаардлагатай дэлгэрэнгүй мэдээллийн сан бий болгох зорилтоо хэрэгжүүллээ.

Тооллогыг амжилттай зохион байгуулахад хуулиар хүлээсэн чиг үүргийн дагуу төр, захиргааны байгууллага, бүх шатны Засаг дарга нарын оролцоо чухал ач холбогдолтой байсныг онцлон тэмдэглэе.

Улсын хэмжээнд Хөдөө аж ахуйн тооллогыг нэгдсэн удирдлага, аргачлал, заавраар хангаж, зохион байгуулсан Үндэсний Статистикийн хороо, түүний салбар нэгжийн ажилтан, нийт албан хаагчдад Хөдөө аж ахуйн тооллогын Улсын комиссын нэрийн өмнөөс талархал илэрхийлье.

## ҮНДЭСНИЙ СТАТИСТИКИЙН ХОРООНЫ ДАРГА, ХӨДӨӨ АЖ АХУЙН ТООЛЛОГЫН УЛСЫН КОМИССЫН ОРЛОГЧ ДАРГА Б.БАТДАВАА



### ӨМНӨХ ҮГ

Үндэсний статистикийн хороо нь Монгол Улсын нийгэм, эдийн засаг, байгаль орчны статистик мэдээллийг хэрэглэгчдийн хэрэгцээнд үндэслэн боловсруулж, төр хувийн хэвшил болон иргэдийн шийдвэр гаргалтад дэмжлэг үзүүлэх зорилт тавин ажиллаж байна.

Статистикийн тухай хуулийн дагуу хөдөө аж ахуйн тооллогыг 10 жил тутамд зохион байгуулдаг. Ээлжит тооллогыг 2022 оны 5 дугаар сарын 21-ний өдрөөс 7 дугаар сарын 8-ны өдрийг хүртэлх хугацаанд зохион байгуулж, үр дүнг бэлтгээд байна.

Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүнс, Хөдөө Аж Ахуйн байгууллагын гишүүн орнууддаа өгсөн зөвлөмж, аргачлалын дагуу дэлхийн ХАА-н хөтөлбөрт тусгагдсан үзүүлэлтийг бүрэн хамруулж, тооллогыг нэлэнхүй болон түүврийн хосолмол аргаар зохион байгууллаа. Ингэснээр тооллогын дүнг өмнөх тооллого, бусад улстай харьцуулах боломжтой болж байгаа.

Энэ удаагийн тооллогын мэдээлэл цуглуулалтыг цахим тэмдэглэлийн төхөөрөмж ашиглан нүүр тулсан ярилцлага хийх аргаар зохион байгуулсан. Мөн тооллогод өндөр нарийвчлалтай сансрын зураг ашиглаж тариалангийн талбайн байршил, өрх, ААНБ-ын цэгийг тэмдэглэснээрээ онцлог болсон. Цаашид эдгээр мэдээллийг газар тариалан, мал аж ахуйн тооцоо, түүвэр судалгаанд ашиглах боломжтой юм.

Энэхүү тооллогын тайлан нь 16 бүлгээс бүрдэнэ. Тооллогын үр дүнгээр хөдөө аж ахуйн салбарын бүхий л үзүүлэлтийг багтаасан, өргөн цар хүрээтэй, салбарын цаашдын хөгжилд шаардагдах, дүн шинжилгээ хийх боломжтой мэдээллийг бүрдүүлсэн нь ихээхэн ач холбогдолтой боллоо.

Энэхүү тооллогыг амжилттай зохион байгуулахад удирдлага, зохион байгуулалтаар хангаж ажилласан тооллогын Улсын комисс, ҮСХ, ХХААХҮЯ, бүх шатны тооллогын ажлын хэсэг, тоологч нарт талархал илэрхийлье. Түүнчлэн мэдээлэл цуглуулалтад цахим тэмдэглэлийн төхөөрөмжөөр дэмжлэг үзүүлж ажилласан Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар, хэвлэл мэдээллийн байгууллагууд, тооллогод хамрагдсан өрх, аж ахуйн нэгж, байгууллага, тариаланч, малчиддаа талархал илэрхийлье.

## ХҮСНЭГТЭН МЭДЭЭЛЛИЙН ЖАГСААЛТ

ХҮСНЭГТ II.1. ХӨДӨӨ АЖ АХУЙ, ОЙН АЖ АХУЙ, ЗАГАС, АН АГНУУРЫН АЖ АХУЙ ЭРХЭЛДЭГ ӨРХ, АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГЫН ТОО, дүнд эзлэх хувиар, оноор ........ 30
ХҮСНЭГТ II.2. ХӨДӨӨ АЖ АХУЙ, ОЙ, ЗАГАС, АН АГНУУРЫН АЖ АХУЙ ЭРХЭЛДЭГ ӨРХ, АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГЫН ТОО, БҮСЭЭР ........ 31
ХҮСНЭГТ III.1. ХӨДӨӨ АЖ АХУЙ ЭРХЭЛДЭГ ӨРХИЙН ТОО, өрхийн тэргүүлэгчийн хүйсээр, мянган хүнээр ........ 33
ХҮСНЭГТ III.2. ХӨДӨӨ АЖ АХУЙ ЭРХЭЛДЭГ ӨРХИЙН ТОО, өрхийн тэргүүлэгчийн насны бүлгээр, мянган хүнээр ........ 34
ХҮСНЭГТ III.3. ХӨДӨӨ АЖ АХУЙ ЭРХЭЛДЭГ ӨРХИЙН ТОО, өрхийн тэргүүлэгчийн эзэмшсэн боловсролын түвшнээр, мянган хүнээр, 2021 он ........ 35
ХҮСНЭГТ III.4. ӨРХИЙН ТЭРГҮҮЛЭГЧИЙН ДААТГАЛД ХАМРАГДСАН БАЙДАЛ, даатгалын хэлбэрээр, мянган хүнээр, 2021 он ........ 35
ХҮСНЭГТ III.5. ӨРХИЙН ТЭРГҮҮЛЭГЧИЙН ДААТГАЛД ХАМРАГДСАН БАЙДАЛ, даатгалын төрлөөр, мян хүн ........ 36
ХҮСНЭГТ III.6. ХӨДӨӨ АЖ АХУЙ ЭРХЭЛДЭГ ӨРХ, ам бүлийн тоо, мянган хүнээр ........ 37
ХҮСНЭГТ III.7. ХӨДӨӨ АЖ АХУЙ ЭРХЭЛДЭГ ӨРХИЙН ТОО, сууцны төрлөөр, мянган өрхөөр ........ 37
ХҮСНЭГТ III.8. ХӨДӨӨ АЖ АХУЙ ЭРХЭЛДЭГ ӨРХИЙН ТОО, сууцны эзэмшлээр, мянган өрхөөр ........ 40
ХҮСНЭГТ III.9. ХӨДӨӨ АЖ АХУЙ ЭРХЭЛДЭГ ӨРХИЙН ТОО, цахилгааны эх үүсвэрээр, мянган өрхөөр ........ 41
ХҮСНЭГТ III.10. ХӨДӨӨ АЖ АХУЙ ЭРХЭЛДЭГ ӨРХИЙН УНДНЫ УСНЫ ЭХ ҮҮСВЭР, өрхийн дунд эзлэх хувиар ........ 42
ХҮСНЭГТ III.11. ХӨДӨӨ АЖ АХУЙ ЭРХЭЛДЭГ ӨРХИЙН УНДНЫ УСАА ЗӨӨВӨРЛӨЖ БУЙ ДУНДАЖ ЗАЙ, улирлаар, метрээр ........ 43
ХҮСНЭГТ III.12. МАЛ АЖ АХУЙ ЭРХЭЛДЭГ ӨРХИЙН УНДНЫ УСАА ЗӨӨВӨРЛӨЖ БУЙ ХЭЛБЭР, дүнд эзлэх хувиар, бүсээр ........ 43
ХҮСНЭГТ III.13. ГАЗАР ТАРИАЛАН ЭРХЭЛДЭГ ӨРХИЙН УНДНЫ УСАА ЗӨӨВӨРЛӨЖ БУЙ ХЭЛБЭР, дүнд эзлэх хувиар, бүсээр ........ 44
ХҮСНЭГТ III.14. ХӨДӨӨ АЖ АХУЙ ЭРХЭЛДЭГ ААНБ-ЫН ТОО, удирдлагын хүйсээр ........ 45
ХҮСНЭГТ III.15. ХӨДӨӨ АЖ АХУЙ ЭРХЭЛДЭГ ААНБ-ЫН ТОО, удирдлагын насны бүлгээр ........ 45
ХҮСНЭГТ IV.1. ХӨДӨӨ АЖ АХУЙН САЛБАРЫН БАЙНГЫН АЖИЛЛАГЧДЫН ТОО, насны бүлгээр, мянган хүнээр ........ 48
ХҮСНЭГТ IV.2. ХӨДӨӨ АЖ АХУЙН САЛБАРЫН БАЙНГЫН АЖИЛЛАГЧДЫН ТОО, боловсролын түвшингээр, мянган хүнээр ........ 49
ХҮСНЭГТ IV.3. МАЛ АЖ АХУЙН САЛБАРЫН БАЙНГЫН АЖИЛЛАГЧИД, өрх, аж ахуйн нэгж, байгууллага, хүйсээр, мянган хүн ........ 50
ХҮСНЭГТ IV.4. МАЛ АЖ АХУЙН САЛБАРЫН БАЙНГЫН АЖИЛЛАГЧИД, өрх, аж ахуйн нэгж, байгууллага, бүсээр, мянган хүнээр ........ 50
ХҮСНЭГТ IV.5. МАЛ АЖ АХУЙН САЛБАРЫН БАЙНГЫН АЖИЛЛАГЧИД, насны бүлгээр ........ 51
ХҮСНЭГТ IV.6. МАЛ АЖ АХУЙН САЛБАРЫН БАЙНГЫН АЖИЛЛАГЧИД, гэрлэлтийн байдлаар, хүйсээр ........ 51
ХҮСНЭГТ IV.7. МАЛ АЖ АХУЙН САЛБАРЫН БАЙНГЫН АЖИЛЛАГЧИД, дүнд эзлэх хувиар, боловсролын түвшнээр, бүсээр ........ 52
ХҮСНЭГТ IV.8. МАЛ АЖ АХУЙН САЛБАРЫН МЭРГЭЖЛИЙН АЖИЛЛАГЧИД, мэргэжлийн чиглэлээр53
ХҮСНЭГТ IV.9 МАЛ АЖ АХУЙН САЛБАРЫН АЖИЛЛАГЧДЫН АЖЛЫН ӨДРИЙН ҮРГЭЛЖЛЭХ ХУГАЦАА, улирлаар, цагаар ........ 54
ХҮСНЭГТ IV.10. МАЛ АЖ АХУЙН САЛБАРЫН ТҮР АЖИЛЛАГЧИД, бүсээр ........ 55
ХҮСНЭГТ IV.11. ГАЗАР ТАРИАЛАНГИЙН САЛБАРЫН БАЙНГЫН АЖИЛЛАГЧИД, өрх, аж ахуйн нэгж, байгууллага, хүйсээр, мянган хүнээр ........ 56
ХҮСНЭГТ IV.12. ГАЗАР ТАРИАЛАНГИЙН САЛБАРЫН БАЙНГЫН АЖИЛЛАГЧИД, өрх, аж ахуйн нэгж, байгууллага, бүсээр, мянган хүнээр ........ 57

ХҮСНЭГТ IV.13. ГАЗАР ТАРИАЛАНГИЙН САЛБАРЫН БАЙНГЫН АЖИЛЛАГЧИД, насны бүлгээр........ 57
ХҮСНЭГТ IV.14. ГАЗАР ТАРИАЛАНГИЙН САЛБАРЫН БАЙНГЫН ГЭРЛЭЛТИЙН БАЙДАЛ, хүйсээр .... 58
ХҮСНЭГТ IV.15. ГАЗАР ТАРИАЛАНГИЙН САЛБАРЫН БАЙНГЫН АЖИЛЛАГЧИД, боловсролын түвшингээр, хүйсээр ........ 59
ХҮСНЭГТ IV.16. ГАЗАР ТАРИАЛАНГИЙН САЛБАРЫН МЭРГЭЖЛИЙН АЖИЛЛАГЧИД, мэргэжлийн чиглэлээр ........ 60
ХҮСНЭГТ IV.17. ГАЗАР ТАРИАЛАНГИЙН САЛБАРЫН ТҮР АЖИЛЛАГЧИД, бүсээр ........ 61
ХҮСНЭГТ IV.18. ГАЗАР ТАРИАЛАНГИЙН САЛБАРЫН АЖИЛЛАГЧДЫН АЖЛЫН ӨДРИЙН ҮРГЭЛЖЛЭХ ХУГАЦАА, тариалалтын үе шатаар, цагаар ........ 61
ХҮСНЭГТ V.1. МАЛ АЖ АХУЙН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ҮЙЛДВЭРЛЭЛ, 2021 суурьтай тооцсон, биет хэмжээгээр........ 65
ХҮСНЭГТ V.2. МАЛЫН ТОО, төрлөөр, мянган толгой ........ 66
ХҮСНЭГТ V.3. МАЛЫН ТОО, төрлөөр, мянган толгой ........ 67
ХҮСНЭГТ V.4. МАЛ АЖ АХУЙН САЛБАРТ ҮЙЛДВЭРЛЭСЭН БҮТЭЭГДЭХҮҮН, бүтээгдэхүүний нэр төрлөөр ........ 67
ХҮСНЭГТ V.5. МАЛ АЖ АХУЙН САЛБАРТ ҮЙЛДВЭРЛЭСЭН БҮТЭЭГДЭХҮҮН, бүтээгдэхүүний нэр төрөл, бүсээр........ 68
ХҮСНЭГТ V.6. МАЛЫН ТОО ТОЛГОЙ, малын төрлөөр ........ 68
ХҮСНЭГТ V.7. МАХ, СҮҮНИЙ ДОТООДЫН ҮЙЛДВЭРЛЭЛ, ХАНГАМЖИЙН ХУВЬ ........ 70
ХҮСНЭГТ V.8. МАЛ АЖ АХУЙ ЭРХЭЛДЭГ ӨРХИЙН БҮТЭЭГДЭХҮҮНЭЭ БОРЛУУЛДАГ ХЭЛБЭР, хувиар ........ 70
ХҮСНЭГТ V.9. МАЛ АЖ АХУЙ ЭРХЭЛДЭГ ААНБ-ЫН БҮТЭЭГДЭХҮҮНЭЭ БОРЛУУЛДАГ ХЭЛБЭР, бүс, хувиар........ 71
ХҮСНЭГТ V.10. МАЛ АЖ АХУЙ ЭРХЭЛДЭГ ӨРХИЙН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ БОРЛУУЛТТАЙ ХОЛБООТОЙ ГАРДАГ ХҮНДРЭЛ, БЭРХШЭЭЛ, бүс, хувиар ........ 71
ХҮСНЭГТ V.11. МАЛ АЖ АХУЙ ЭРХЭЛДЭГ ААНБ-ЫН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ БОРЛУУЛТТАЙ ХОЛБООТОЙ ГАРДАГ ХҮНДРЭЛ, БЭРХШЭЭЛ, бүс, хувиар ........ 72
ХҮСНЭГТ V.12. МАЛ АЖ АХУЙ ЭРХЭЛДЭГ ӨРХИЙН БҮТЭЭГДЭХҮҮНИЙХЭЭ ҮНИЙГ ТОГТООДОГ ХЭЛБЭР, бүс, хувиар........ 72
ХҮСНЭГТ V.13. МАЛ АЖ АХУЙ ЭРХЭЛДЭГ ААНБ-ЫН БҮТЭЭГДЭХҮҮНИЙХЭЭ ҮНИЙГ ТОГТООДОГ ХЭЛБЭР, бүсээр........ 73
ХҮСНЭГТ V.14. ХУРААСАН УРГАЦ, төрлөөр, мянган тонноор........ 73
ХҮСНЭГТ V.15. ХУРААСАН УРГАЦ, нэр төрөл, бүсээр, мянган тонн ........ 74
ХҮСНЭГТ V.16. ТӨМС, ХҮНСНИЙ НОГООНЫ ДОТООДЫН ҮЙЛДВЭРЛЭЛ, ХАНГАМЖИЙН ХУВЬ........ 75
ХҮСНЭГТ V.17. НЭГ ГА ТАЛБАЙГААС ХУРААН АВСАН УРГАЦЫН ХЭМЖЭЭ, бүсээр, центнер........ 76
ХҮСНЭГТ V.18. УРГАЦ ХУРААЛТЫН ДАРААХ АЛДАГДАЛ/ХОРОГДЛЫН ХУВЬ, үе шат, ургамлын төрлөөр ........ 77
ХҮСНЭГТ V.19. ГАЗАР ТАРИАЛАНГИЙН САЛБАРТ ҮЙЛДВЭРЛЭСЭН БҮТЭЭГДЭХҮҮН, хэрэглээний зориулалтаар, мянган тонн ........ 77
ХҮСНЭГТ V.20. ГАЗАР ТАРИАЛАН ЭРХЭЛДЭГ ӨРХИЙН БҮТЭЭГДЭХҮҮНЭЭ БОРЛУУЛДАГ ХЭЛБЭР, бүс, хувиар........ 78
ХҮСНЭГТ V.21. ГАЗАР ТАРИАЛАН ЭРХЭЛДЭГ ААНБ-ЫН БҮТЭЭГДЭХҮҮНЭЭ БОРЛУУЛДАГ ХЭЛБЭР, бүс, хувиар........ 79
ХҮСНЭГТ V.22. ГАЗАР ТАРИАЛАН ЭРХЭЛДЭГ ӨРХИЙН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ БОРЛУУЛТТАЙ ХОЛБООТОЙ ГАРДАГ ХҮНДРЭЛ, БЭРХШЭЭЛ, бүс, хувиар........ 80
ХҮСНЭГТ V.23. ГАЗАР ТАРИАЛАН ЭРХЭЛДЭГ ААНБ-ЫН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ БОРЛУУЛТТАЙ ХОЛБООТОЙ ГАРДАГ ХҮНДРЭЛ, БЭРХШЭЭЛ, бүс, хувиар........ 81
ХҮСНЭГТ V.24. ГАЗАР ТАРИАЛАН ЭРХЭЛДЭГ ӨРХ, БҮТЭЭГДЭХҮҮНИЙХЭЭ ҮНИЙГ ТОГТООДОГ ХЭЛБЭР, бүс, хувиар........ 82
ХҮСНЭГТ V.25. ГАЗАР ТАРИАЛАН ЭРХЭЛДЭГ ААНБ-ЫН БҮТЭЭГДЭХҮҮНИЙХЭЭ ҮНИЙГ ТОГТООДОГ ХЭЛБЭР, бүс, хувиар........ 82
ХҮСНЭГТ VI.1. ХӨДӨӨ АЖ АХУЙН ЗОРИУЛАЛТТАЙ МАШИН, ТОНОГ ТӨХӨӨРӨМЖИЙН ТОО ........ 84

ХҮСНЭГТ VI.2. МАЛ АЖ АХУЙН ЗОРИУЛАЛТТАЙ МАШИН, ТОНОГ ТӨХӨӨРӨМЖИЙН ТОО, бүсээр .... 85
ХҮСНЭГТ VI.3. МАЛ АЖ АХУЙН ЗОРИУЛАЛТТАЙ МАШИН, ТОНОГ ТӨХӨӨРӨМЖИЙН ТОО .................. 85
ХҮСНЭГТ VI.4. ГАЗАР ТАРИАЛАНГИЙН ЗОРИУЛАЛТТАЙ МАШИН, ТОНОГ ТӨХӨӨРӨМЖИЙН ТОО, бүсээр, 2021 он ........ 86
ХҮСНЭГТ VI.5. ГАЗАР ТАРИАЛАНГИЙН ҮНДСЭН ТОНОГ ТӨХӨӨРӨМЖИЙН ТОО .................. 87
ХҮСНЭГТ VI.6. СУУДЛЫН БОЛОН АЧААНЫ МАШИН, МОТОЦИКЛТОЙ ӨРХ, бүсээр, хувиар .................. 88
ХҮСНЭГТ VII.1. ХӨДӨӨ АЖ АХУЙН ЗОРИУЛАЛТТАЙ БАРИЛГА, БАЙГУУЛАМЖТАЙ ГАЗАР ТАРИАЛАН ЭРХЭЛДЭГ ӨРХИЙН ТОО, барилга, байгууламжийн төрөл, бүсээр .................. 91
ХҮСНЭГТ VII.2. ГАЗАР ТАРИАЛАН ЭРХЭЛДЭГ ӨРХИЙН ХАА-Н ЗОРИУЛАЛТТАЙ БАРИЛГА, БАЙГУУЛАМЖИЙН ТОО, бүсээр .................. 92
ХҮСНЭГТ VII.3. ГАЗАР ТАРИАЛАН ЭРХЭЛДЭГ ӨРХИЙН ГОЛЛОХ БАРИЛГА, БАЙГУУЛАМЖИЙН ДУНДАЖ БАГТААМЖ, бүсээр .................. 93
ХҮСНЭГТ VII.4. ГАЗАР ТАРИАЛАН ЭРХЭЛДЭГ ӨРХИЙН ГОЛЛОХ БАРИЛГА, БАЙГУУЛАМЖИЙН ҮНЭЛГЭЭ, бүсээр, сая төгрөгөөр .................. 93
ХҮСНЭГТ VII.5. ХӨДӨӨ АЖ АХУЙН ЗОРИУЛАЛТТАЙ БАРИЛГА, БАЙГУУЛАМЖТАЙ ААНБ-ЫН ТОО, барилга, байгууламжийн төрөл, бүсээр .................. 94
ХҮСНЭГТ VII.6. ГАЗАР ТАРИАЛАНГ ЭРХЭЛДЭГ ААНБ-ЫН ХӨДӨӨ АЖ АХУЙН ЗОРИУЛАЛТТАЙ БАРИЛГА, БАЙГУУЛАМЖИЙН ТОО, бүсээр .................. 95
ХҮСНЭГТ VII.7. ГАЗАР ТАРИАЛАН ЭРХЭЛДЭГ ААНБ-ЫН ГОЛЛОХ БАРИЛГА, БАЙГУУЛАМЖИЙН ДУНДАЖ БАГТААМЖ, бүсээр .................. 95
ХҮСНЭГТ VII.8. ГАЗАР ТАРИАЛАН ЭРХЭЛДЭГ ААНБ-ЫН ХӨДӨӨ АЖ АХУЙН ЗОРИУЛАЛТТАЙ БАРИЛГА, БАЙГУУЛАМЖИЙН ДУНДАЖ ҮНЭЛГЭЭ, бүсээр, сая төгрөгөөр .................. 96
ХҮСНЭГТ VII.9. МАЛ АЖ АХУЙ ЭРХЭЛДЭГ ХӨДӨӨ АЖ АХУЙН ЗОРИУЛАЛТТАЙ БАРИЛГА, БАЙГУУЛАМЖТАЙ ӨРХИЙН ТОО, бүсээр, мянган өрх .................. 97
ХҮСНЭГТ VII.10. МАЛ АЖ АХУЙ ЭРХЭЛДЭГ ӨРХИЙН ХАА-Н ЗОРИУЛАЛТТАЙ БАРИЛГА, БАЙГУУЛАМЖИЙН ТОО, бүсээр .................. 97
ХҮСНЭГТ VII.11. МАЛ АЖ АХУЙ ЭРХЭЛДЭГ ӨРХИЙН БАРИЛГА, БАЙГУУЛАМЖИЙН ДУНДАЖ БАГТААМЖ, бүсээр .................. 98
ХҮСНЭГТ VII.12. ХӨДӨӨ АЖ АХУЙН ЗОРИУЛТТАЙ БАРИЛГА, БАЙГУУЛАМЖТАЙ ААНБ-ЫН ТОО, барилга, байгууламжийн төрөл, бүсээр .................. 98
ХҮСНЭГТ VII.13. МАЛ АЖ АХУЙ ЭРХЭЛДЭГ ААНБ-ЫН ХАА-Н ЗОРИУЛАЛТТАЙ ГОЛЛОХ БАРИЛГА, БАЙГУУЛАМЖИЙН ТОО, бүсээр .................. 99
ХҮСНЭГТ VII.14. МАЛ АЖ АХУЙ ЭРХЭЛДЭГ ААНБ-ЫН ГОЛЛОХ БАРИЛГА, БАЙГУУЛАМЖИЙН БАГТААМЖ, бүсээр .................. 99
ХҮСНЭГТ VIII.1. МАЛЫН ХАШААНЫ ТОО, ХАШААНЫ БАГТААМЖ, төрөл, бүсээр .................. 101
ХҮСНЭГТ VIII.2. МАЛЫН ХАШААНЫ ТОО, эзэмшлийн хэлбэрээр .................. 101
ХҮСНЭГТ IX.1. ХУДАГ, УСАН САНГИЙН ТОО, бүсээр .................. 103
ХҮСНЭГТ IX.2. БЭЛЧЭЭРТ БАЙРШДАГ ХУДГИЙН ТОО, бүсээр .................. 103
ХҮСНЭГТ IX.3. ХУДАГ, УСАН САНГИЙН ТОО, эзэмшлээр .................. 104
ХҮСНЭГТ IX.4. ХУДАГ, УСАН САНГИЙН ТОО, эзэмшлийн төрлөөр .................. 105
ХҮСНЭГТ X.1. ӨРХ, ААНБ-ЫН ДААТГАЛД ХАМРАГДСАН БАЙДАЛ, даатгалын төрлөөр .................. 107
ХҮСНЭГТ X.2. СҮҮЛИЙН 5 ЖИЛД ХАА-Н ЗОРИУЛАЛТТАЙ ЗЭЭЛ АВСАН ӨРХ, ААНБ-ЫН ЗЭЭЛ АВСАН ТОО, зээлийн хугацаагаар .................. 108
ХҮСНЭГТ X.3. ХӨРӨНГӨ БАРЬЦААЛЖ ХАА-Н ЗОРИУЛАЛТТАЙ ЗЭЭЛ АВСАН ӨРХ, ААНБ-ЫН ТОО, барьцаалсан хөрөнгийн төрлөөр .................. 109
ХҮСНЭГТ X.4. МАЛ АЖ АХУЙ ЭРХЭЛДЭГ ӨРХИЙН ХАА-Н БҮТЭЭГДЭХҮҮН БОРЛУУЛДАГ ДУНДАЖ ЗАЙ, км-ээр .................. 110
ХҮСНЭГТ X.5. МАЛ АЖ АХУЙ ЭРХЭЛДЭГ ААНБ-ЫН ХАА-Н БҮТЭЭГДЭХҮҮН БОРЛУУЛДАГ ДУНДАЖ ЗАЙ, км-ээр .................. 111
ХҮСНЭГТ X.6. ГАЗАР ТАРИАЛАН ЭРХЭЛДЭГ ӨРХИЙН ХАА-Н БҮТЭЭГДЭХҮҮН БОРЛУУЛДАГ ДУНДАЖ ЗАЙ, км-ээр .................. 112

ХҮСНЭГТ X.7. ГАЗАР ТАРИАЛАН ЭРХЭЛДЭГ ӨРХИЙН ААНБ-ЫН БҮТЭЭГДЭХҮҮН БОРЛУУЛДАГ ДУНДАЖ ЗАЙ, км-ээр ....... 112
ХҮСНЭГТ XI.1. ААНБ-ЫН ЭДЭЛБЭР ГАЗРЫН ТАЛБАЙН ХЭМЖЭЭ, эзэмшлийн төрлөөр бүсээр, га-гаар ....... 115
ХҮСНЭГТ XI.2. БУСДААС ГАЗАР ТҮРЭЭСЭЛСЭН ААНБ-ЫН ТОО, бүсээр ....... 115
ХҮСНЭГТ XI.3. ААНБ-ЫН ХӨДӨӨ АЖ АХУЙ ЭДЭЛБЭР ГАЗАР, бүсээр ....... 116
ХҮСНЭГТ XI.4. ОЙН ЗУРВАСААР ХҮРЭЭЛЭГДСЭН ТАРИАЛАНГИЙН ТАЛБАЙТАЙ ӨРХ, ААНБ -ЫН ТОО, бүсээр ....... 116
ХҮСНЭГТ XI.5. УСАЛГААТАЙ ГАЗАР ТАРИАЛАН ЭРХЭЛДЭГ ӨРХ, ААНБ -ЫН ТОО, бүсээр ....... 117
ХҮСНЭГТ XI.6. УСАЛГААТАЙ ТАРИАЛАН ЭРХЛЭЭГҮЙ ӨРХ, ААНБ -ЫН ТОО, шалтгаанаар ....... 118
ХҮСНЭГТ XI.7. УСАЛГААТАЙ ТАЛБАЙ, төрлөөр ....... 119
ХҮСНЭГТ XI.8. УСАЛГААТАЙ ГАЗАР ТАРИАЛАН ЭРХЭЛСЭН ӨРХИЙН ТОО, талбайн бүлгээр ....... 120
ХҮСНЭГТ XI.9. УСАЛГААТАЙ ГАЗАР ТАРИАЛАН ЭРХЭЛСЭН ААНБ -ЫН ТОО, талбайн бүлгээр ....... 120
ХҮСНЭГТ XI.10. УСЖУУЛАЛТЫН СИСТЕМ АШИГЛАСАН ӨРХ, ААНБ -ЫН ТОО, усжуулалтын системийн төрлөөр ....... 121
ХҮСНЭГТ XI.11. УСНЫ ТӨЛБӨР ТӨЛДӨГ ӨРХ, ААНБ -ЫН ТОО ....... 122
ХҮСНЭГТ XI.12. УСНЫ ТӨЛБӨР ТӨЛДӨГ ӨРХ, ААНБ-ЫН АШИГЛАСАН УСНЫ 1 ЛИТРИЙН ДУНДАЖ ҮНЭ, төгрөгөөр, бүсээр ....... 122
ХҮСНЭГТ XI.13. УСАЛГААТАЙ ТАРИАЛАН ЭРХЭЛСЭН ӨРХ, ААНБ -ЫН ТОО, усалгааны аргаар ....... 123
ХҮСНЭГТ XI.14. УСАЛГААТАЙ ТАРИАЛАН ЭРХЭЛСЭН ӨРХ, ААНБ-ЫН ТОО, усжуулалтын эх үүсвэрээр ....... 123
ХҮСНЭГТ XI.15. АГРОХИМИЙН ШИНЖИЛГЭЭ ХИЙЛГЭСЭН ӨРХИЙН ТОО, бүсээр ....... 124
ХҮСНЭГТ XI.16. АГРОХИМИЙН ШИНЖИЛГЭЭ ХИЙЛГЭСЭН ӨРХ, ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТЭЭР, хувиар ....... 126
ХҮСНЭГТ XI.17. АГРОХИМИЙН ШИНЖИЛГЭЭ ХИЙЛГЭСЭН ААНБ-ЫН ТОО, бүсээр ....... 127
ХҮСНЭГТ XI.18. АГРОХИМИЙН ШИНЖИЛГЭЭ ХИЙЛГЭСЭН ААНБ, шалгуур үзүүлэлтээр, хувиар ....... 128
ХҮСНЭГТ XI.19. БОРДСОН ТАЛБАЙ, ХЭРЭГЛЭСЭН БОРДОО ХЭРЭГЛЭСЭН БОРДОО ....... 131
ХҮСНЭГТ XI.20. ГАЗАР ТАРИАЛАН ЭРХЭЛДЭГ ӨРХ, ААНБ-ЫН ХЭРЭГЛЭСЭН БОРДОО, БОРДООНЫ ТӨРЛӨӨР, бүсээр, тонноор ....... 131
ХҮСНЭГТ XI.21. ГАЗАР ТАРИАЛАН ЭРХЭЛДЭГ ӨРХ, ААНБ-ЫН БОРДСОН ТАЛБАЙ, БОРДООНЫ ТӨРЛӨӨР, бүсээр, га ....... 132
ХҮСНЭГТ XI.22. ӨРХ, ААНБ-ЫН НЭГ ГА ТАЛБАЙД ХЭРЭГЛЭЖ БУЙ БОРДОО, бордооны төрлөөр, тонноор ....... 133
ХҮСНЭГТ XI.23. УРГАМАЛ ХАМГААЛЛЫН БОДИС/ПЕСТИЦИД ХЭРЭГЛЭСЭН ТАЛБАЙ, АШИГЛАСАН ХЭМЖЭЭ ....... 134
ХҮСНЭГТ XI.24. ГАЗАР ТАРИАЛАН ЭРХЭЛДЭГ ӨРХИЙН ТАРИАЛАНГИЙН ТАЛБАЙД АШИГЛАСАН УРГАМАЛ ХАМГААЛЛЫН БОДИС/ПЕСТИЦИДИЙН ХЭМЖЭЭ, бүсээр, тонноор ....... 134
ХҮСНЭГТ XI.25. ГАЗАР ТАРИАЛАН ЭРХЭЛДЭГ ӨРХИЙН УРГАМАЛ ХАМГААЛЛЫН БОДИС/ПЕСТИЦИД ХЭРЭГЛЭСЭН ТАЛБАЙ , бүсээр, га ....... 135
ХҮСНЭГТ XI.26. ГАЗАР ТАРИАЛАН ЭРХЭЛДЭГ ААНБ-ЫН УРГАМАЛ ХАМГААЛЛЫН БОДИС/ПЕСТИЦИД ХЭРЭГЛЭСЭН ТАЛБАЙ , бүсээр, га ....... 136
ХҮСНЭГТ XII.1. МАЛЫН ДУНДАЖ ҮНЭ, малын төрлөөр, бүсээр, мянган төгрөгөөр ....... 138
ХҮСНЭГТ XII.2. МАХНЫ ДУНДАЖ ҮНЭ, мал, тэжээвэр амьтны төрлөөр, бүсээр, төгрөгөөр ....... 138
ХҮСНЭГТ XII.3. СҮҮНИЙ ДУНДАЖ ҮНЭ, бүсээр, төгрөгөөр ....... 139
ХҮСНЭГТ XII.4. НООС, НООЛУУР, ХӨӨВӨР, ХЯЛГАСЫН ДУНДАЖ ҮНЭ, бүсээр, төгрөгөөр ....... 139
ХҮСНЭГТ XII.5. АРЬС, ШИРНИЙ ДУНДАЖ ҮНЭ, бүсээр, төгрөгөөр ....... 140
ХҮСНЭГТ XII.6. МАЛЫН ҮЙЛДВЭРЛЭГЧИЙН ҮНЭ БОЛОН ЗАХ ЗЭЭЛИЙН ҮНИЙН ХАРЬЦАА, бүсээр ....... 141
ХҮСНЭГТ XII.7. МАХНЫ ҮЙЛДВЭРЛЭГЧИЙН ҮНЭ БОЛОН ЗАХ ЗЭЭЛИЙН ҮНИЙН ХАРЬЦАА, бүсээр ....... 142
ХҮСНЭГТ XII.8. СҮҮНИЙ ҮЙЛДВЭРЛЭГЧИЙН ҮНЭ БОЛОН ЗАХ ЗЭЭЛИЙН ҮНИЙН ХАРЬЦАА, бүсээр ....... 142

ХҮСНЭГТ XII.9. АРЬС, ШИРНИЙ ҮЙЛДВЭРЛЭГЧИЙН ҮНЭ БОЛОН ЗАХ ЗЭЭЛИЙН ҮНИЙН ХАРЬЦАА, бүсээр....143
ХҮСНЭГТ XII.10. НООС, НООЛУУР, ХӨӨВӨР, ХЯЛГАСЫН ҮЙЛДВЭРЛЭГЧИЙН ҮНЭ БОЛОН ЗАХ ЗЭЭЛИЙН ҮНИЙН ХАРЬЦАА, бүсээр....144
ХҮСНЭГТ XII.11. ҮР ТАРИА, ТӨМС, ХҮНСНИЙ НОГООНЫ КИЛЛОГРАММЫН ДУНДАЖ ҮНЭ, бүсээр, төгрөгөөр....144
ХҮСНЭГТ XII.12. ТЭЖЭЭЛИЙН УРГАМАЛ, ТЕХНИКИЙН УРГАМЛЫН НЭГ ТОННЫН ДУНДАЖ ҮНЭ, мянган төгрөгөөр....145
ХҮСНЭГТ XII.13. ГАЗАР ТАРИАЛАНГИЙН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ҮЙЛДВЭРЛЭГЧИЙН ҮНЭ БОЛОН ЗАХ ЗЭЭЛИЙН ҮНИЙН ХАРЬЦАА....145
ХҮСНЭГТ XIII.1. ҮНЭЭНИЙ СҮҮНИЙ ӨДРИЙН ДУНДАЖ ГАРЦ, бүсээр, 2021 он....147
ХҮСНЭГТ XIII.2. ҮНЭЭНИЙ СҮҮНИЙ ӨДРИЙН ДУНДАЖ ГАРЦ, улирал, литрээр, 2021 он....148
ХҮСНЭГТ XIII.3. ҮНЭЭНИЙ СААЛИНД ХАМРАГДАЛТЫН ХУВЬ, бүсээр, хувиар....148
ХҮСНЭГТ XIII.4. ҮНЭЭНИЙ СҮҮНИЙ ЖИЛИЙН ДУНДАЖ ГАРЦ, бүсээр, литрээр....149
ХҮСНЭГТ XIII.5. ҮНЭЭНЭЭС БУСАД ТӨРЛИЙН ХЭЭЛТЭГЧИЙН СҮҮНИЙ ЖИЛИЙН ДУНДАЖ ГАРЦ, бүсээр....149
ХҮСНЭГТ XIII.6. ҮНЭЭНЭЭС БУСАД ТӨРЛИЙН ХЭЭЛТЭГЧИЙН СААЛИНД ХАМРАГДАЛТЫН ХУВЬ, бүсээр, 2021 он....150
ХҮСНЭГТ XIII.7. ҮНЭЭНЭЭС БУСАД ТӨРЛИЙН ХЭЭЛТЭГЧИЙН СҮҮНИЙ ЖИЛИЙН ДУНДАЖ ГАРЦ, бүсээр, 2021 он....150
ХҮСНЭГТ XIII.8. НООС, НООЛУУР, ХӨӨВӨР, ХЯЛГАСЫН ЖИЛИЙН ДУНДАЖ ГАРЦ, малын төрөл, бүсээр, грамм, 2021 он....150
ХҮСНЭГТ XIII.9. МАЛЫН АМЬДЫН ЖИН, малын төрөл, бүсээр, кг-аар....151
ХҮСНЭГТ XIII.10. МАЛЫН АМЬДЫН ЖИН, ГУЛУУЗНЫ ГАРЦ, малын төрөл, кг-аар....152
ХҮСНЭГТ XIII.11. ГАХАЙ, ТАХИАНЫ АМЬДЫН БОЛОН ГУЛУУЗНЫ ЖИН, төрөл, бүсээр, кг-аар....152
ХҮСНЭГТ XIV.1. ХҮНСНИЙ ДУТАГДАЛД ОРСОН ӨРХИЙН ТОО, өрхөд эзлэх хувь....154
ХҮСНЭГТ XIV.2. ХҮНСНИЙ ДУТАГДАЛД ОРСОН ӨРХИЙН ТОО, сараар....155
ХҮСНЭГТ XIV.3. ХҮНСНИЙ ДУТАГДАЛД ОРСОН ӨРХИЙН ТОО, шалтгаанаар....156
Хүснэгт XIV.4. ХҮНСНИЙ ДУТАГДЛААС ГАРАХЫН ТУЛД АВСАН АРГА ХЭМЖЭЭ, хүнсний дутагдалд орсон өрхөд эзлэх хувиар....156
ХҮСНЭГТ XIV.5. ХҮНСНИЙ ДУТАГДЛААС ГАРАХЫН ТУЛД АВСАН БУСАД АРГА ХЭМЖЭЭ, бусад арга хэмжээ авсан өрхөд эзлэх хувиар....157
ХҮСНЭГТ XIV.6. ХҮНСНИЙ ДУТАГДАЛД ОРСОН ӨРХИЙН ХҮНСНИЙ БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ХЭРЭГЛЭЭ, хөдөө аж ахуй эрхлэдэг өрхөд эзлэх хувь....158
ХҮСНЭГТ XIV.7. БАЙГАЛИЙН АЮУЛТ ҮЗЭГДЭЛД ӨРТСӨН ӨРХИЙН ТОО, хувиар....158
ХҮСНЭГТ XIV.8. БАЙГАЛИЙН АЮУЛТ ҮЗЭГДЭЛД ӨРТСӨН ӨРХИЙН ТОО, сараар....159
ХҮСНЭГТ XIV.9. БАЙГАЛИЙН АЮУЛТ ҮЗЭГДЭЛД ӨРТСӨН ӨРХИЙН ТОО, аюулт үзэгдлийн төрлөөр....159
ХҮСНЭГТ XIV.10. БАЙГАЛИЙН АЮУЛТ ҮЗЭГДЭЛД ӨРТСӨН ӨРХӨД УЧИРСАН ХОХИРОЛ, түвшинээр....160
ХҮСНЭГТ XV.1. АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГЫН ТОО, бүсээр....162
ХҮСНЭГТ XV.2 ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛААГҮЙ ШАЛТГААН, бүсээр....162
ХҮСНЭГТ XV.3. АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГЫН УДИРДЛАГЫН ТОО, хүйсээр, бүсээр....163
ХҮСНЭГТ XV.4. ОЙН АЖ АХУЙН САЛБАРТ АЖИЛЛАГЧИД, хүйсээр, бүсээр....163
ХҮСНЭГТ XV.5 МОД БЭЛТГЭЛТ, бүсээр....164
ХҮСНЭГТ XV.6. БЭЛТГЭСЭН МОД СӨӨГНИЙ ҮРИЙН ХЭМЖЭЭ, бүсээр....164
ХҮСНЭГТ XV.7. ТАРЬЦ, СУУЛГАЦЫН ХЭМЖЭЭ, бүсээр....164
ХҮСНЭГТ XV.8. БҮТЭЭГДЭХҮҮНЭЭ БОРЛУУЛДАГ ХЭЛБЭР, бүсээр....165
ХҮСНЭГТ XV.9. ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГО, ЗАРДАЛ, зардлын төрлөөр....166
ХҮСНЭГТ XV.10. МОД БЭЛТГЭСЭН ӨРХИЙН ТОО, зориулалтаар, бүсээр....167
ХҮСНЭГТ XV.11. МОД, СӨӨГНИЙ ҮР БЭЛТГЭСЭН ӨРХИЙН ТОО, мод, сөөгний төрлөөр, бүсээр....167

ХҮСНЭГТ XV.12. МОД ҮРЖҮҮЛГИЙН ГАЗАР БОЛОН ТАРЬЦ, СУУЛГАЦЫН ХҮЛЭМЖТЭЙ ӨРХИЙН ТОО, тарьц, суулгацын тоо, бүсээр ....168
ХҮСНЭГТ XV.13. МОД ТАРЬСАН ӨРХИЙН ТОО ....168
ХҮСНЭГТ XV.14. ОЙГООС ДАГАЛТ БАЯЛАГ АШИГЛАСАН ӨРХИЙН ТОО, төрлөөр, бүсээр....168
ХҮСНЭГТ XV.15. АН АГНАСАН ӨРХИЙН ТОО, зориулалтаар, бүсээр ....169
ХҮСНЭГТ XV.16. АН АГНАСАН ӨРХИЙН ТОО, агнасан ангаар, бүсээр ....169
ХҮСНЭГТ XV.17. АН АГНАСАН ӨРХИЙН ЗАРЛАГА, зардлын төрлөөр ....169
ХҮСНЭГТ XV.18. ЗАГАСНЫ АЖ АХУЙ ЭРХЭЛСЭН ӨРХИЙН ТОО, барьсан загасны хэмжээ, бүсээр .170
ХҮСНЭГТ XV.19. ЗАГАСНЫ АЖ АХУЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЭЛСЭН ӨРХИЙН ЗАРЛАГА, зардлын төрлөөр ....170
ХҮСНЭГТ XVI.1. СУМДЫН ТОО, байгалийн бүс, бүсээр ....172
ХҮСНЭГТ XVI.2. СУМДЫН ТОО, хөрсний төрөл, бүсээр....173
ХҮСНЭГТ XVI.3. ӨРХИЙН ТОО, бүсээр, мянган өрх....173
ХҮСНЭГТ XVI.4. ЦАХИЛГААНЫ ЭХ ҮҮСВЭР, бүсээр ....174
ХҮСНЭГТ XVI.5. СУМААС ТӨВЛӨРСӨН ХОТ, СУУРИН ХҮРЭХ ЗАМЫН ТӨРӨЛ, бүсээр ....174
ХҮСНЭГТ XVI.6. СУМДЫН ТӨВИЙН УСАН ХАНГАМЖ, төрөл, бүсээр....175
ХҮСНЭГТ XVI.7. СУМДЫН БОЛОВСРОЛ, СОЁЛ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ БАЙГУУЛЛАГЫН ТОО, бүсээр......176
ХҮСНЭГТ XVI.8. ХӨДӨӨ АЖ АХУЙН ЗОРИУЛАЛТТАЙ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ БАЙГУУЛЛАГЫН ТОО, бүсээр ....177
ХҮСНЭГТ XVI.9. БАЙГАЛИЙН ГАМШИГТ ӨРТСӨН СУМЫН ТОО, сүүлийн 10 жилийн байдлаар.........177
ХҮСНЭГТ XVI.10. ХЭРЭГЖИЖ БУЙ ТӨСӨЛ, ХӨТӨЛБӨР, санхүүжилтийн эх үүсвэр, бүсээр ....178
ХҮСНЭГТ XVI.11. МАЛЧИД, ГАЗАР ТАРИАЛАНЧДЫН БҮЛГИЙН ТОО, бүсээр ....178

## ЗУРГАН МЭДЭЭЛЛИЙН ЖАГСААЛТ


ЗУРАГ III.1. МАЛ АЖ АХУЙ ЭРХЭЛДЭГ ӨРХИЙН СУУЦНЫ ТӨРӨЛ, хувиар, бүсээр ... 39
ЗУРАГ IV.1. ХӨДӨӨ АЖ АХУЙ САЛБАРЫН БАЙНГЫН АЖИЛЛАГЧДЫН ТОО, үйл ажиллагааны чиглэлээр, хүйсээр, мянган хүнээр ... 47
ЗУРАГ IV.2. МАЛ АЖ АХУЙН САЛБАРЫН АЖИЛЛАГЧИД, мянган хүнээр ... 49
ЗУРАГ IV.3. МАЛ АЖ АХУЙН САЛБАРТ АЖИЛЛАХ ХҮЧТЭЙ ХОЛБООТОЙ ХҮНДРЭЛ, БЭРХШЭЭЛ, хувиар ... 55
ЗУРАГ IV.4. ГАЗАР ТАРИАЛАНГИЙН САЛБАРЫН АЖИЛЛАГЧИД, мянган хүнээр ... 56
ЗУРАГ IV.5. ГАЗАР ТАРИАЛАНГИЙН САЛБАРТ АЖИЛЛАХ ХҮЧТЭЙ ХОЛБООТОЙ ХҮНДРЭЛ, БЭРХШЭЭЛ, хувиар ... 62
ЗУРАГ V.1. СҮРГИЙН БҮТЭЦ ... 66
ЗУРАГ V.2. МАЛ АЖ АХУЙН САЛБАРЫН ҮЙЛДВЭРЛЭСЭН МАХНЫ ҮЙЛДВЭРЛЭЛ ... 69
ЗУРАГ V.3. МАЛ АЖ АХУЙН САЛБАРЫН ҮЙЛДВЭРЛЭСЭН СҮҮНИЙ ҮЙЛДВЭРЛЭЛ ... 69
ЗУРАГ V.4. ГАЗАР ТАРИАЛАНГИЙН САЛБАРЫН ҮЙЛДВЭРЛЭСЭН ҮР ТАРИА ... 74
ЗУРАГ V.5. ГАЗАР ТАРИАЛАНГИЙН САЛБАРЫН ҮЙЛДВЭРЛЭСЭН ТӨМС ... 75
ЗУРАГ V.6. НЭГ ГА ТАЛБАЙГААС ХУРААН АВСАН УРГАЦЫН ХЭМЖЭЭ, центнерээр ... 76
ЗУРАГ V.7. ӨРХИЙН БҮТЭЭГДЭХҮҮНЭЭ БОРЛУУЛДАГ ХЭЛБЭР, хувиар ... 78
ЗУРАГ V.8. ААНБ-ЫН БҮТЭЭГДЭХҮҮНЭЭ БОРЛУУЛДАГ ХЭЛБЭР, хувиар ... 79
ЗУРАГ V.9. ГАЗАР ТАРИАЛАН ЭРХЭЛДЭГ ӨРХИЙН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ БОРЛУУЛТТАЙ ХОЛБООТОЙ ГАРДАГ ХҮНДРЭЛ, БЭРХШЭЭЛ, хувиар ... 80
ЗУРАГ V.10. ГАЗАР ТАРИАЛАН ЭРХЭЛДЭГ ААНБ-ЫН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ БОРЛУУЛТТАЙ ХОЛБООТОЙ ГАРДАГ ХҮНДРЭЛ, БЭРХШЭЭЛ, хувиар ... 80
ЗУРАГ V.11. ГАЗАР ТАРИАЛАН ЭРХЭЛДЭГ ӨРХИЙН БҮТЭЭГДЭХҮҮНИЙХЭЭ ҮНИЙГ ТОГТООДОГ ХЭЛБЭР, хувиар ... 81
ЗУРАГ V.12. ГАЗАР ТАРИАЛАН ЭРХЭЛДЭГ ААНБ-ЫН БҮТЭЭГДЭХҮҮНИЙХЭЭ ҮНИЙГ ТОГТООДОГ ХЭЛБЭР, хувиар ... 82
ЗУРАГ VI.1. ГАЗАР ТАРИАЛАНГИЙН МАШИН, МАШИН, ТОНОГ ТӨХӨӨРӨМЖИЙН ТОО, ашигласан жилээр ... 86
ЗУРАГ VI.2. ГАЗАР ТАРИАЛАНГИЙН ЗОРИУЛАЛТТАЙ МАШИН, ТОНОГ ТӨХӨӨРӨМЖИЙН АШИГЛАСАН ХУГАЦАА, бүсээр ... 87
ЗУРАГ VII.1. ХӨДӨӨ АЖ АХУЙН ЗОРИУЛАЛТТАЙ БАРИЛГА, БАЙГУУЛАМЖТАЙ ӨРХ, АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГЫН ТОО ... 90
ЗУРАГ VII.2. ХӨДӨӨ АЖ АХУЙН ЗОРИУЛАЛТТАЙ БАРИЛГА, БАЙГУУЛАМЖИЙН ТОО, эзэмшлийн төрлөөр ... 92
ЗУРАГ XI.1. УСЖУУЛАЛТЫН СИСТЕМ АШИГЛАХАД ТӨРӨӨС ДЭМЖЛЭГ АВСАН ӨРХ, ААНБ-ЫН ДҮНД ЭЗЛЭХ ХУВЬ, бүсээр ... 122
ЗУРАГ XI.2. АГРОХИМИЙН ШИНЖИЛГЭЭ ХИЙЛГЭСЭН ӨРХИЙН БҮТЭЦ, бүсээр, хувиар ... 125
ЗУРАГ XI.3. АГРОХИМИЙН ШИНЖИЛГЭЭ ХИЙЛГЭСЭН ӨРХИЙН БҮТЭЦ, бүсээр, хувиар ... 127
ЗУРАГ XI.4. НИЙТ ӨРХ БОЛОН БОРДОО, БОДИС АШИГЛАСАН ӨРХИЙН ТОО, бүсээр ... 129
ЗУРАГ XI.5. БОРДОО, БОДИС АШИГЛАСАН ААНБ-ЫН ТОО, бүсээр ... 130
ЗУРАГ XII.1. МАЛЫН ДУНДАЖ ҮНЭ, мянган төгрөгөөр, 2021 он ... 140
ЗУРАГ XIII.2. МАХНЫ ДУНДАЖ ҮНЭ, мянган төгрөгөөр, 2021 он ... 141
ЗУРАГ XII.3. СҮҮНИЙ ДУНДАЖ ҮНЭ, төгрөгөөр, 2021 он ... 142
ЗУРАГ XII.4. АРЬС, ШИРНИЙ ДУНДАЖ ҮНЭ, мянган төгрөгөөр, 2021 он ... 143
ЗУРАГ XII.5. НООС, НООЛУУР, ХӨӨВӨРНИЙ ДУНДАЖ ҮНЭ, мянган төгрөгөөр, 2021 он ... 143
ЗУРАГ XIII.1. ҮНЭЭНИЙ СҮҮНИЙ ӨДРИЙН ДУНДАЖ ГАРЦ, улирал, литрээр ... 148
ЗУРАГ XIII.2. ҮНЭЭНИЙ СҮҮНИЙ ЖИЛИЙН ДУНДАЖ ГАРЦ, аймгаар, 2021 он ... 149
ЗУРАГ XIII.3. БОД МАЛЫН АМЬДЫН ЖИН, малын төрөл, бүсээр, кг-аар ... 151
ЗУРАГ XIII.4. БОГ МАЛЫН АМЬДЫН ЖИН, малын төрөл, бүсээр, кг-аар ... 151
ЗУРАГ XIII.5. ТАХИАНЫ АМЬДЫН БОЛОН ГУЛУУЗНЫ ЖИН, бүсээр, кг-аар ... 152

# ТОВЧИЛСОН ҮГСИЙН ЖАГСААЛТ

| | |
|---|---|
| ААНБ | Аж ахуйн нэгж, байгууллага |
| ББСБ | Банк бус санхүүгийн байгууллага |
| ГЕГ | Гаалийн ерөнхий газар |
| ГТ | Газар тариалан |
| ГЗБГЗЗГ | Газар зохион байгуулалт, геодези зураг зүйн газар |
| ДНБ | Дотоодын нийт бүтээгдэхүүн |
| МАА | Мал аж ахуй |
| МИД | Малын индексжүүлсэн даатгал |
| ТЕГ | Татварын ерөнхий газар |
| УЦУОСМХ | Ус цаг уур, орчны судалгаа, мэдээллийн хүрээлэн |
| ҮСХ | Үндэсний статистикийн хороо |
| ХАА | Хөдөө аж ахуй |
| ХААТ | Хөдөө аж ахуйн тооллого |
| ХХААБ | НҮБ-ын Хүнс, хөдөө аж ахуйн байгууллага |
| ХХААХҮЯ | Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам |
| ХААБОҮСХ | Хөдөө аж ахуй, байгаль орчин, үйлдвэрлэлийн статистикийн хэлтэс |
| ЭЗСГ | Эдийн засгийн статистикийн газар |
| ЭЗҮАСА | Эдийн засгийн бүх төрлийн үйл ажиллагааны салбарын ангилал |

ТЭМДЭГЛЭГЭЭ

* урьдчилсан гүйцэтгэл

[1] эх үүсвэр, тайлбар

## НЭР ТОМЬЁОНЫ ТОВЧ ТАЙЛБАР, ТОДОРХОЙЛОЛТ

Мал бүхий өрх гэж малыг ахуй амьдралдаа туслах чанарын үүрэгтэй өсгөн үржүүлдэг өрхийг ойлгоно.

Малчин өрхөд жилийн 4 улирлын туршид малаа маллаж, малын ашиг шим нь тэдний амьжиргааны эх үүсвэр болж байгаа өрхийг хамруулна.

Малтай өрх гэж мал бүхий өрх болон малчин өрхийг хэлнэ.

Малчид гэж жилийн 4 улирлын туршид мал аж ахуй эрхэлж, малын ашиг шим нь тэдний амьжиргааны эх үүсвэр болж байгаа мал аж ахуй эрхлэгчдийг ойлгоно.

Бодод шилжүүлэх коэффициент:

1 адуу, үхэр - 1 бод
1 тэмээ - 1.5 бод
6 хонь - 1 бод
8 ямаа - 1 бод

Бодод шилжүүлэх коэффициентыг таван төрлийн малыг нэг төрлийн малд шилжүүлэн малын өсөлт, бууралтыг гаргах, үр ашгийг тооцоход ашиглана.

Бог малд буюу хонин толгойд шилжүүлэх коэффициент:

1 тэмээ - 5 хонь
1 адуу - 7 хонь
1 үхэр - 6 хонь
1 хонь - 1 хонь
1 ямаа - 0.9 хонь

Хонин толгойд шилжүүлэх коэффициентыг малын тэжээлийн хүрэлцээ, хангамж, бэлчээрийн даацыг тодорхойлон гаргахад ашиглана.

Нас гүйцсэн малд малын төрөл бүрээр дараах насны малыг хамруулна.

Тэмээ - 4 ба түүнээс дээш настай
Адуу - 3 ба түүнээс дээш настай
Үхэр - 2 ба түүнээс дээш настай
Хонь - Тухайн жилийн төл малаас бусад насны хонь
Ямаа - Тухайн жилийн төл малаас бусад насны ямаа

Өсвөр насны мал

Тэмээ - Өмнөх оны төл, 2, 3 настай
Адуу - Өмнөх оны төл, 2 настай
Үхэр - Өмнөх оны төл
Бог мал - Тухайн жилийн төл мал

Төл малд малын төрөл бүрээрх тухайн жилийн төлийг хамруулна.

Бэлэн хээлтэгчид малын төрөл бүрээрх нас гүйцсэн эм малыг хамруулна.

Малын тоо толгойн өсөлт оны эцсийн малаас оны эхний малыг хасаж, малын тооны өөрчлөлтийг тоогоор илэрхийлнэ. Оны эцсийн малын тоог оны эхний малын тоонд харьцуулж өсөлт, бууралтыг хувиар илэрхийлнэ.

Малын өсөлтийн орлого тал нь төл бойжилт, зарлага тал нь хэрэглээний зарлага, том малын зүй бус хорогдол байна.

Төллөлтийн хувь төллөсөн хээлтэгчийн тоог оны эхний хээлтэгчийн тоонд харьцуулж тооцно.

Төл бойжилтын хувь бойжуулсан төлийн тоог нийт гарсан төлийн тоонд харьцуулж тооцно.

100 эхээс бойжуулсан төл бойжуулсан төлийн тоог оны эхний хээлтэгч малын тоонд харьцуулж тооцно.

Хээлтэгч, хээлтүүлэгчийн тохироо хээлтэгч малын тоог хээлтүүлэгч малын тоонд харьцуулж тооцно.

1 хээлтүүлэгчид ногдох хээлтэгчийн тооны норм нь:

| | | |
|---|---|---|
| Буур | - | 20-25 |
| Азарга | - | 12-15 |
| Бух | - | 35-45 |
| Хуц, ухна | - | 25-30 |

Том малын зүй бус хорогдолд өвчний (халдвартай, халдваргүй) хорогдол, гэнэтийн аюулын (цас, зуд, үер ус, гал түймэр, аянга цахилгаан зэрэг) хорогдол, бусад шалтгааны (малын хариулга, арчилгаа маллагаатай холбогдон гарсан) хорогдлыг хамруулна.

Оны эхний малд том малын зүй бус хорогдлын эзлэх хувь зүй бусаар хорогдсон том малын тоог оны эхний малын тоонд харьцуулж тооцно.

Малын хэрэглээний зарлага оны эхний мал, бойжуулсан төлийн нийлбэрээс том малын зүй бус хорогдол болон оны эцсийн малын тоог хасаж нийт малын хэрэглээний зарлагыг тооцно.

Малын хашааны хангамж хашааны багтаамжийг малын тоонд харьцуулна. Бод малын хашааны хангамжийг гаргахдаа бодын хашааны багтаамжийг үхрийн тоонд, харин бог малынхыг бог малын /хонь, ямааны/ тоонд харьцуулж тооцно.

Тэжээл хангамж тэжээлийн нэгжид шилжүүлсэн тэжээлийн хэмжээг хонин толгойд шилжүүлсэн малын тоонд харьцуулж тооцно.

Малын бэлчээрийн даац гэж бэлчээрийн ургамлын өсөлт, хөгжилт, нөхөн сэргэлтэд сөрөг нөлөө үзүүлэхгүйгээр тодорхой хугацааны туршид нэг га бэлчээрт бэлчээж болох малын тоог ойлгоно.

Тэжээлийн нэгжид шилжүүлэх итгэлцүүр бэлтгэсэн тэжээл нь илчлэг, чанарын байдлаараа харилцан адилгүй байдаг учраас нэг тэжээлийн нэгжид шилжүүлж тэжээлийн хангамжийг гаргана. Дараах итгэлцүүрийг ашиглан тэжээлийн нэгжид шилжүүлнэ:

| Бэлтгэсэн тэжээл | Итгэлцүүр |
|---|---|
| Гар тэжээл, хужир шүү | 1.00 |
| Үр тарианы хаягдал | 0.90 |
| Хадлан өвс | 0.45 |
| Лай | 0.40 |

| Бэлтгэсэн тэжээл | Итгэлцүүр |
|---|---|
| Таримал тэжээл | 0.35 |
| Даршны ургамал | 0.25 |
| Сүрэл | 0.25 |
| Төмс ногооны хаягдал | 0.22 |

Малын тэжээлийн ангилал малын тэжээлийг ургамлын гаралтай, амьтны гаралтай, эрдэс тэжээлийн гаралтай гэж ангилна.

- Ургамлын гаралтай тэжээлд өвс, сүрэл, үр тариа, буурцгийн төрлийн ургамал багтах бөгөөд бүдүүн, хүчит, шүүст гэж ангилна.
  1. Бүдүүн тэжээл - өвс, сүрэл, нэг наст ба олон наст ургамал
  2. Хүчит тэжээл - үр тариа, үр тарианы хаягдал, вандуй, буурцаг
  3. Шүүст тэжээл - Бүх төрлийн дарш, төмс ногооны хаягдал тус тус орно.
- Амьтны гаралтай тэжээлд яс, цусны гурил зэрэг багтана.
- Эрдэс тэжээлд давс, хужир шүү орно.

Тариалангийн талбай хөдөө аж ахуйн таримал ургамлыг тариалсан талбайг хэлнэ. Тариалангийн талбайг тариалсан талбай, хураасан талбай, өнжсөн талбай, уринш боловсруулсан талбай гэж ангилна.

Тариалсан талбай тухайн жилд үр суулгасан газрын нийт талбайн хэмжээг хэлнэ.

Хураасан талбай тухайн жилд ургац хурааж авсан газрын нийт талбайн хэмжээг хэлнэ.

Га-гийн ургац талбайн нэг нэгжээс /1 га-гаас/ авах газар тариалангийн бүтээгдэхүүний /ургацын/ хэмжээ бөгөөд га-гийн ургацыг тодорхойлохдоо тухайн төрлийн ургамлын хурааж авсан бүх ургацыг тариалсан талбайн хэмжээнд харьцуулж тооцно.

Нийт ургац тухайн жилд газар тариалангийн үйлдвэрлэл эрхэлж үйлдвэрлэсэн нийт бүтээгдэхүүний хэмжээ, өөрөөр хэлбэл, нийт тариалсан талбайгаас хураан авсан үр тариа, төмс, хүнсний ногоо, жимс жимсгэнэ, малын тэжээл, техникийн ургамал зэрэг ургамал тус бүрийн төрлөөрх ургацын хэмжээг хэлнэ.

ХАА-н эдийн засгийн бүс 5 бүсэд хувааж, бүс тус бүрд дараах аймаг, нийслэл хамрагдана.

| Бүс | Аймаг/нийслэл |
|---|---|
| Баруун бүс | Баян-Өлгий, Говь-Алтай, Ховд, Увс, Завхан аймаг |
| Хангайн бүс | Баянхонгор, Булган, Архангай, Өвөрхангай, Орхон, Хөвсгөл аймаг |
| Төвийн бүс | Говьсүмбэр, Дорноговь, Дундговь, Өмнөговь, Сэлэнгэ, Төв, Дархан-Уул аймаг |
| Зүүн бүс | Хэнтий, Дорнод, Сүхбаатар аймаг |
| Улаанбаатар | Улаанбаатар хот |

## ХӨДӨӨ АЖ АХУЙН ТООЛЛОГЫН ТҮҮХ

Хөдөө аж ахуйн статистик мэдээллийн хэрэгцээ нэмэгдэж байна. Тухайлбал, хөдөөгийн хөгжил, байгаль орчин, ус, газар ашиглалт, цөлжилт, загас, ойн аж ахуй, хөдөө аж ахуй эрхэлж буй өрхийн орлого, үйлдвэрлэлийн зардал, хүнсний аюулгүй байдал, хомсдол, хангамж, мал эмнэлгийн үйлчилгээ зэрэг үзүүлэлтийн хэрэгцээ сүүлийн жилүүдэд нэмэгдсээр байна.

Олон улсад анх 1930 онд хөдөө аж ахуйн тооллогыг нэгдсэн арга аргачлалаар зохион байгуулсан. 1930, 1940 оны ХАА-н тооллогыг явуулахдаа дэлхийн хэмжээний мэдээллийг нэг ижил цаг хугацаанд цуглуулах зорилгоор улс орнуудыг хойд, өмнөд гэсэн 2 хэсэгт хувааж, хойд хэсэгт тооллого явагдсаны дараа жил өмнөд хэсгийн улс орнуудад тооллогыг зохион байгуулж байсан түүхтэй (НҮБ-ын ХХААБ, 2022).

Харин 1950 оны тооллого нь хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн хэмжээ, газар ашиглалт болон малын тоо зэрэг бүтцийн үзүүлэлтүүдэд төвлөрч, өмнөхөөс илүү хязгаарлагдмал агуулгыг хамруулсан байна. Дараагийн хөтөлбөрүүд ч эдгээр үзүүлэлтэд төвлөрсөн ч тооллогын агуулгыг нэлээд дэлгэрүүлэн, ялангуяа 2000 оны тооллогоор далайн аж ахуй, ажил эрхлэлт болон хүрээлэн буй орчны талаар үзүүлэлтүүдийг нэмж судалсан байна. 2000 оны тооллогоос эхлэн бүх улс орнуудад тооллогыг нэг ижил хугацаанд явуулах шаардлагыг зогсоосон. Тухайлбал 2000 оны хөтөлбөр нь 1996-2005 оны хооронд явагдах тооллого, 2010 оны хөтөлбөр 2006-2015 оны хооронд явагдах тооллогыг хамарч байлаа.

Энэ удаагийн тооллого (WCA 2020) нь 2020 он орчим буюу 2016-2025 оны хооронд нийт 150 улсад зохион байгуулахаар төлөвлөгдсөн. Мэдээлэл цуглуулалтын зардлыг бууруулахын зэрэгцээ илүү өргөн хүрээний мэдээлэл цуглуулах шаардлагатай улс орнуудад ХАА-н тооллогын холимог (нэлэнхүй болон түүвэр) аргачлалыг ашиглахыг зөвлөмж болгосон. Үүнд:

- ХАА-н тооллогын үндсэн модуль нь нэлэнхүй тооллого дээр үндэслэх (*нэлэнхүй тооллого явуулах боломжгүй улс орнуудын хувьд үндсэн модуль нь томоохон хэмжээний түүвэр судалгаанд үндэслэн явагдана*) бөгөөд үндэсний бодлого боловсруулагчид, олон улсын түвшинд зэрэгцүүлэлт хийх, түүврийн хүрээг тогтоох болон бүс нутгийн болоод бусад түвшний мэдээлэлд дүн шинжилгээ хийхэд шаардлагатай хөдөө аж ахуйн үндсэн үзүүлэлтүүдээр хангана. Үндсэн модуль нь өмнө явуулж байсан ХАА-н уламжлалт тооллогуудтай төстэй боловч өмнөхөөсөө арай хязгаарлагдмал тооны үзүүлэлтүүдийг хамруулна.
- Нэг болон түүнээс дээш тооллогын нэмэлт модулийг илүү нарийвчилсан дэлгэрэнгүй мэдээллийг, эсвэл анхан шатны засаг захиргааны түвшинд шаардлагагүй мэдээллийг цуглуулахаар үндсэн модуль буюу ХАА-н нэлэнхүй тооллоготой нэг ижил цаг хугацаанд эсвэл тооллогын дараа нэг их удалгүйгээр явуулах хэрэгтэй.

Манай улсын хувьд дотоод яамны бүтцэд Тоо бүртгэлийн хэлтсийг 1924 онд шинээр бий болгож, мал тооллого явуулахад онцгой анхаарч, тооллого, данс бүртгэлийг нэгтгэх, тушаах цаг хугацааг тогтоож, хуучин төлөөний түшмэл дээр боловсрол чадвартай тусгай түшмэлийг нэмэн томилж, ард олонд тайлбарлан таниулах ажлыг зохион байгуулсан байна. Үүний үр дүнд анх удаа улсын хэмжээнд хугацаа, аргачлалын хувьд нэгдмэл тооллогыг явуулсан байдаг. Мал тооллогод урьд өмнө нь бүртгэгдэхгүй байсан цаа буга, илжиг, луус, өвс хадлан, тариалангийн талаар зарим нэмэлт үзүүлэлтийг 1924 оноос эхлэн хамруулсан байна.

Мал тооллогыг зун, намрын улиралд буюу ихэвчлэн 8, 9 дүгээр сард явуулж байсан бол, 1961 оноос мал, тэжээвэр амьтдыг оны эцэст буюу 12 дугаар сард тоолдог болсон. Хэдийгээр мал тооллогыг жил бүр зохион байгуулж байгаа боловч ХАА-н салбарыг цогцоор нь харуулах мэдээллийг бий болгох хэрэгцээ шаардлага гарч ирсэн.

Монгол Улсын хувьд Хөдөө аж ахуйн анхны тооллогыг 2012 онд НҮБ-ын ХХААБ-ын зөвлөмжид үндэслэн улс даяар зохион байгуулсан. Анхны тооллогод 2011 онд мал аж ахуй, газар тариалан, ой, загас, ан агнуурын салбарт үйл ажиллагаа явуулсан өрх, аж ахуйн нэгж, байгууллагуудыг хамруулсан.

Энэ удаагийн тооллогын мэдээлэл цуглуулалтыг цахим мэдээллийн төхөөрөмж ашиглан нүүр тулсан ярилцлага хийх аргаар зохион байгуулсан. Мөн өндөр нарийвчлалтай сансрын зураг ашиглан тариалангийн талбай, өрх, ААНБ-ын байршлын цэгийг тэмдэглэснээрээ онцлог болсон. Тооллогын хамрах хүрээний хувьд анхдугаар тооллоготой ижил ой, загас, ан агнуур, газар тариалан, мал аж ахуйн өрх, ААНБ-ын мэдээллийг багтаасан.

I
БҮЛЭГ

# ТООЛЛОГЫН ЗОХИОН БАЙГУУЛАЛТ



# I. ТООЛЛОГЫН ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

## I.1. Хууль, эрх зүйн үндэслэл

Хөдөө аж ахуйн ээлжит тооллогын зохион байгуулалтад дараах хууль, тогтоомж, эрх зүйн баримт бичгийг үндэслэл болгосон. Үүнд:

- Статистикийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 1 дэх хэсэг *("хөдөө аж ахуйн ээлжит тооллогыг 10 жил тутам, завсрын тооллого, судалгааг 5 жил тутам явуулна");*
- Малын индексжүүлсэн даатгалын тухай хууль;
- Засгийн газрын 2022 оны 2 дугаар сарын 16-ны өдрийн 74 дүгээр тогтоол;
- ҮСХ-ны даргын 2022 оны 3 дугаар сарын 21-ны өдрийн "Хөдөө аж ахуйн 2022 оны тооллогын үзэл баримтлал, асуулгын хуудас, түүнийг нөхөх зааврыг батлах тухай" А/45 дугаар тушаал;

Түүнчлэн НҮБ-ын ХХААБ-ын гишүүн орнуудад зөвлөмж болгон хэрэгжүүлдэг Дэлхийн хөдөө аж ахуйн 2020 он орчмын хөтөлбөрийн хүрээний аргачлал, үзүүлэлтийн хүрээг баримтлан тооллогыг зохион байгуулсан.

## I.2. Хөдөө аж ахуйн тооллогын зорилго

Тооллогын зорилго нь хөдөө аж ахуйн салбарын цогц үзүүлэлтийг дэлгэрэнгүй түвшинд бүрдүүлж, олон улсад харьцуулахуйц тоон үзүүлэлт, мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлж, хэрэглэгчдийн хэрэгцээ шаардлага, салбарын бодлого боловсруулахад шаардагдах тоон мэдээллийг бий болгоход чиглэгдсэн.




Мөн Тогтвортой хөгжлийн зорилгын 2.1.2, 2.3.1, 2.4.1, 5.a.1, 12.3.1, 15.1.1 зорилтуудын шалгуур үзүүлэлтүүд, мал аж ахуйн салбараас ялгарах хүлэмжийн хийг тооцох, хүнсний аюулгүй байдал, хангамжийг хянах, үнэлэх, дүн шинжилгээ хийх зэрэг хөгжлийн бодлогыг тодорхойлоход шаардлагатай мэдээллийн эх үүсвэрийг бий болгохыг зорьсон.

## I.3. Тооллогын удирдлага, зохион байгуулалт

Тооллогын бүхий л шатны үйл ажиллагааг нэгдсэн удирдлагаар хангах, арга зүйн туслалцаа үзүүлэх, аж ахуйн нэгж, байгууллага, өрхийг тооллогод бүрэн хамруулах, тооллогын явцад хяналт тавих, үр дүнг Засгийн газарт танилцуулах үүрэг бүхий тооллогын Улсын комисс болон Үндэсний статистикийн хорооны ажлын хэсгийг байгуулан ажилласан.

Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 2 дугаар сарын 16-ны өдрийн 74 дүгээр тогтоолоор "Тооллогыг улсын хэмжээнд удирдан зохион байгуулах" комиссын бүрэлдэхүүнийг баталсан. Үүнд, Тооллогын комиссын даргаар Монгол Улсын Хүнс,

Хөдөө Аж Ахуй, Хөнгөн Үйлдвэрийн сайд З.Мэндсайхан, Улсын комиссын орлогч даргаар Үндэсний Статистикийн Хорооны дарга Б.Батдаваа, гишүүдээр холбогдох яам, агентлагийн газар, нэгжийн дарга нар орж, Комиссын нарийн бичгийн даргаар Үндэсний статистикийн хорооны Эдийн засгийн статистикийн газрын дарга А.Дэмбэрэл нар ажилласан. Мөн дээрх тогтоолоор харьяа нутаг дэвсгэртээ хөдөө аж ахуйн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг өрх, аж ахуй нэгжийг тооллогод бүрэн хамруулах арга хэмжээ авч, тооллогын ажлыг зохион байгуулах ажлын хэсгийг байгуулж, дэмжлэг үзүүлж ажиллахыг бүх шатны Засаг дарга нарт үүрэг болгосон. Улсын комиссын хурлын дагуу бүх шатны оролцогч байгууллагын чиг үүргийг дараах байдлаар тусгасан.

А. Улсын комиссын чиг үүрэг

- Хөдөө аж ахуйн тооллогыг явуулахад нэгдсэн удирдлагаар хангах, дэмжлэг үзүүлэх,
- Тооллогын ажлын хэрэгжилтийг хянах, холбогдох арга хэмжээ авах,
- Тооллогын үр дүнгээр тайлан бэлтгэж, Засгийн газарт танилцуулах.

Б. Үндэсний статистикийн хорооны чиг үүрэг

- Тооллогыг улсын хэмжээнд нэгдсэн удирдлага, зохицуулалтаар хангах,
- Улсын комисс, түүний гишүүдэд мэргэжил арга зүйн зөвлөгөө, туслалцаа үзүүлэх,
- Улсын комиссын шийдвэрийн төсөл боловсруулж, хэлэлцүүлэх,
- Улсын комиссын хуралдааны бэлтгэл хангах, хуралдааны тэмдэглэл хөтлөх,
- Тогтоолын талаар гарсан шийдвэрийг албажуулж, арга хэмжээ авах
- Тооллогын үзэл баримтлал, асуулга, нөхөх заавРыг батлах,
- Тооллогын ажилбар тус бүрийг тусгасан төлөвлөгөө боловсруулах
- Тооллогыг зохион байгуулах
- Тооллогын сургалт, сурталчилгааг зохион байгуулах,
- Тооллогын үр дүнг Улсын комисст танилцуулах,
- Тооллогын дүнг хэрэглэгчдэд хүргэх,
- Хууль тогтоомжид заасан, улсын комиссоос өгсөн бусад үүрэг.

В. Төрийн захиргааны байгууллагуудын чиг үүрэг

- Өөрийн чиг үүрэгт хамаарах нэгжийг тооллогод бүрэн хамруулах, тооллогыг чанартай зохион байгуулахад дэмжлэг үзүүлэх, ухуулга, сурталчилгаа хийх,
- Өөрийн байгууллага дээр бүрдүүлсэн мэдээллийн санг тооллогын зорилгоор ашиглах боломжийг бүрдүүлэх,
- Комиссын гишүүний эзгүй үед орлон ажиллах албан тушаалтныг улсын комиссын нарийн бичгийн даргад мэдэгдэх.

Мөн тооллогын бэлтгэл ажлыг орон нутгийн түвшинд хангаж, тооллогыг удирдан зохион байгуулж явуулах зорилго бүхий тооллогын комиссыг аймаг, нийслэлд байгуулж ажилласан. Тооллогын комиссын бүрэлдэхүүнд тухайн орон нутгийн дараах байгууллагын төлөөллүүдийг заавал багтаасан. Үүнд:

- Засаг даргын тамгын газар
- Хүнс, хөдөө аж ахуйн газар
- Статистикийн хэлтэс
- Байгаль орчны газар
- Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар

Аймаг, нийслэлийн тооллогын комисс нь дараах үүрэгтэйгээр ажилласан. Үүнд:

- Сум, дүүргийн тооллогын комиссыг байгуулж ажиллах
- Тооллогыг зохион байгуулахад Орон нутгийн тооллогын комиссын удирдамжийг мөрдлөг болгон ажиллах
- Тоологчийг ажиллуулж, сургалт явуулах, ажлын үр дүнг тооцох
- Тооллогын явц болон тулгарч буй асуудлын талаар Үндэсний статистикийн хорооны ажлын хэсэгт мэдэгдэж, холбогдох арга хэмжээ авч ажиллах, ажлын хэсгийн өгсөн үүрэг даалгаврыг биелүүлэх
- Харьяа нутаг дэвсгэрийн хэмжээнд хяналт, шалгалтын ажлыг зохион байгуулах

Сум, дүүргийн тооллогын комиссын бүрэлдэхүүнд тухайн сум, дүүргийн дараах байгууллагуудын төлөөллүүдийг заавал багтаасан байна. Үүнд:

- Засаг даргын тамгын газар
- Төрийн сангийн мэргэжилтэн
- Багийн засаг дарга
- Мал аж ахуйн асуудал хариуцсан мэргэжилтэн
- Байгаль орчны асуудал хариуцсан мэргэжилтэн
- Газрын асуудал хариуцсан мэргэжилтэн

Сум, дүүргийн тооллогын комисс нь дараах үүрэгтэй ажилласан. Үүнд:

- Тооллогын явц болон тулгарч буй асуудлын талаар аймаг, нийслэлийн тооллогын комисстой холбогдох арга хэмжээ авч ажиллах
- Аймаг, нийслэлийн тооллогын комиссын өгсөн үүрэг даалгаврыг биелүүлэх
- Харьяа нутаг дэвсгэрийн хэмжээнд хяналт, шалгалтын ажлыг зохион байгуулах

Мэдээлэл цуглуулах багт шалгагч, тоологч нар дараах үүрэгтэйгээр ажилласан.

**Мэдээлэл шалгагч:** Хөдөө аж ахуйн тооллогын мэдээлэл шалгагч нь мэдээлэл цуглуулагч буюу тоологчоос ирүүлсэн анхан шатны мэдээллийг шалгах, мэдээлэл цуглуулалтын явцыг хянах, тодруулах үүрэгтэй ажилласан. Орон нутагт сум тус бүрт 1 шалгагч, хүн ам ихтэй сум, тосгонд нэмэлтээр 1 шалгагчийг ажиллуулсан.

**Мэдээлэл цуглуулагч (тоологч):** Хөдөө аж ахуйн тооллогын мэдээлэл цуглуулагч буюу тоологч нь мал аж ахуй, газар тариалан, ой, загас, ан агнуурын үйл ажиллагаа эрхэлдэг аж ахуйн нэгж, байгууллага, өрхийн мэдээллийг цуглуулж, тодруулгын дагуу өөрчлөлтийг тусгах үүрэгтэй ажил гүйцэтгэх гэрээгээр ажилласан.

### I.3.1. Тооллогод ажилласан хүний нөөц

Тооллогын ажлыг зохион байгуулахад ҮСХ-ны даргын 2022 оны 1 сарын 18-ны өдрийн А/07 дугаар тушаалаар ажлын хэсгийг байгуулж, ажлын хэсгийн даргаар дэд дарга Д.Лхамсүрэн, нарийн бичгийн даргаар Эдийн засгийн статистикийн газар (ЭЗСГ)-ын Хөдөө аж ахуй, байгаль орчин, үйлдвэрлэлийн статистикийн хэлтэс (ХААБОҮСХ)-дарга Э.Мягмарханд, гишүүдээр Тамгын газрын дарга Б.Лхагва, Нэгдсэн статистикийн газрын дарга Э.Эрдэнэсан, ЭЗСГ-ын дарга А.Дэмбэрэл, Тооллого, өгөгдлийн шинжилгээний газар (ТӨШГ) -ын дарга Ш.Ариунболд, Мэдээлэл технологийн газар (МТГ)-ын дарга Л.Мягмарсүрэн, Программ хангамжийн хэлтсийн дарга Ц.Эрдэнэмөнх, ЭЗСГ-ын Үнийн статистикийн хэлтсийн дарга М.Оюунжаргал, ХААБОҮСХ-ийн ахлах статситикч Б.Уянгаа, статистикч Х.Тэмүүлэн, Х.Энхжавхлан, Э.Болормаа, ТӨШГ-ын судалгаа шинжилгээ, түүврийн статистикийн хэлтсийн дарга Н.Өлзийханд, статистикч З.Нямбаяр, Бодлого хамтын ажиллагааны газрын Хамтын ажиллагаа тархаалтын хэлтсийн дарга Л.Цэвээнжав, Бодлого, гадаад харилцааны хэлтсийн ахлах статистикч Б.Анхзаяа, Үндэсний тооцооны хэлтсийн ахлах статистикч Б.Энхзаяа нар ажилласан.

Түүнчлэн тооллогын мэдээлэл цуглуулах программ хангамжийг МТГ-ын хамт олон референт Э.Мягмарсүрэн, А.Отгонцэцэг, Э.Энэбиш, С.Мөнхтөр нар боловсруулж, зөөврийн ухаалаг төхөөрөмж (таблет), техник хангамжийн аюулгүй байдлыг хэлтсийн дарга Б.Энх-Амгалан, А.Алтангэрэл, М.Буянхишиг нар хариуцан ажилласан.

### I.3.2. Сургалт

Тооллогын сургагч багш, тоологч, шалгагч нарыг сонгон шалгаруулж, гэрээ байгуулан ажилласан бөгөөд тооллогод нийтдээ 760 тоологч, 345 шалгагч, 93 сургагч багш нар шат шатны сургалтад хамрагдан ажилласан.

Хөдөө аж ахуйн тооллогын үзэл баримтлал, зорилго, ач холбогдол тооллого явуулах хугацаа, асуулгын хуудас, түүнийг нөхөх заавар, орон нутагт хөдөө аж ахуйн тооллогыг зохион байгуулах талаарх 2 үе шаттай сургалтыг зохион байгуулсан. Үүнд:

1. **Орон нутгийн сургагч багш бэлтгэх сургалт:** ҮСХ-ноос 2022 оны 5 дугаар сарын 9-10-ны хооронд багтаан 21 аймаг, нийслэл, дүүргийн нийт 93 сургагч багшийг бэлтгэх сургалтыг Улаанбаатар хотод зохион байгуулсан. Сургагч багш нь аймаг, нийслэлийн статистикийн хэлтсийн дарга, мэргэжилтэн байсан.
2. **Орон нутгийн тоологч, ахлагч нарт зориулсан сургалт:** ҮСХ-ноос бэлтгэсэн сургагч багш нар тухайн орон нутгийн тоологч, шалгагчид зориулан сургалтыг 2022 оны 5 дугаар сарын 16-наас эхлэн орон нутагт мэдээлэл цуглуулах хуваарийн дагуу, орон нутагт зохион байгуулсан. Тоологч, шалгагчийн сургалтын төлөвлөгөө, дадлага ажлын хэсгийг тухай бүрт орон нутагт хуваарийн хамт баталж ажиллаж байсан. Мэдээлэл цуглуулалтын эхэн үед ҮСХ-ны багаас дэмжих зорилгоор зарим аймгуудад сургалт, дадлага ажилд туслалцаа өгсөн.

### I.3.3. Сурталчилгаа

Тооллогын сурталчилгааг Бодлого, хамтын ажиллагааны газар, Эдийн засгийн статистикийн газартай хамтран 2022 оны 4-р сарын 5-наас 7-р сарын 2-ны хооронд үе шаттайгаар явуулсан. Үүнд:

1. Тооллого явагдахаас өмнө

- Тоологч, шат шатны ажиллах хүчинд зориулсан ХАА-н салбарын статистик хариуцан ажиллаж байсан ахмадуудын ярилцлага
- Сэтгүүлчдийн уулзалт, мэдээлэл
- Телевиз, радио, мэдээллийн хуудас, сэтгүүлийн ярилцлагууд
- Сурталчилгааны самбар, зурагт хуудас, хөдөлгөөнт дүрс
- Цахим орчны мэдээлэл
- Нийтийг хамарсан цахим зурвас, шуудан

2. Тооллого явагдах хугацаанд: Тооллогын явцын талаар мэдээлэл хийхээс гадна, тооллогод хамрагдахыг уриалсан мэдээллийг тооллогын хугацаанд хэвлэл, мэдээллийн хэрэгслээр тогтмол явуулсан.

- Уриалга, үндсэн хөдөлгөөнт дүрс /https://youtu.be/bxz8OyCvqyc, https://youtu.be/vmn_iK9X7yA /
- ХАА эрхлэгч нарын тооллогыг дэмжсэн сурталчилгаа
- Урсдаг самбараар хийх сурталчилгаа
- Нийтийг хамарсан цахим зурвас, шуудан
- Телевизийн ярилцлагууд



Түүнчлэн мэдээлэл цуглуулалтын үеэр 7033-1212 утсаар лавлагаа өгч, аймаг, орон нутгийн статистикийн хэлтэстэй шууд холбогдож ажилласан.

### I.3.4. Тооллогын хугацаа

Хуулийн дагуу ээлжит тооллогыг 2022 онд зохион байгуулах тухай Засгийн газрын 2022 оны 74 дүгээр тогтоолоор 5 дугаар сараас 7 дугаар сарын хооронд мэдээлэл цуглуулах тов батлагдсан. Үүний дагуу тооллогыг дараах хугацаанд 3 бүсэд хуваан зохион байгуулсан. Үүнд:




1-р бүс: 2022 оны 5 дугаар сарын 21-нээс 2022 оны 6 дугаар сарын 03-ны хооронд

2-р бүс: 2022 оны 6 дугаар сарын 6-наас 2022 оны 6 дугаар сарын 19-ны хооронд

3-р бүс: 2022 оны 6 дугаар сарын 24-наас 2022 оны 7 дугаар сарын 8-ны хооронд

### I.3.5. Тооллогын хамрах хүрээ, арга зүй

**Хамрах хүрээ:** Тооллогод мал аж ахуй, газар тариалан, ой, загас, ан агнуурын үйл ажиллагаа эрхэлж буй аж ахуйн нэгж, байгууллага, өрхийг хамруулсан.

Эдийн засгийн бүх төрлийн үйл ажиллагааны салбарын ангиллын дагуу “А” салбарын 01, 02, 03 салбарыг хамруулсан.

**Мал аж ахуйн салбар (01):** Мал, тэжээвэр амьтдын 2021 оны жилийн эцсийн тооллогын мэдээлэл нь ХАА-н тооллогын хүрээний үндсэн мэдээллийн нэг хэсэг байсан. Харин дэлгэрэнгүй үзүүлэлтүүдийг цуглуулахаар 2021 оны жилийн эцсийн мал тооллогод хамрагдсан малтай өрхийн тодорхой хувийг түүврийн аргаар сонгон авч ХАА-н тооллогод хамруулсан.

Мал аж ахуйн үйл ажиллагаа эрхэлдэг аж ахуйн нэгж, байгууллага, гахай, шувуу болон бусад тэжээвэр амьтад өсгөн үржүүлэх үйл ажиллагаа эрхэлдэг аж ахуйн нэгж, байгууллага, өрхийг тооллогод нэлэнхүй ажиглалтаар бүрэн хамруулсан.

**Газар тариалангийн салбар (02)**: Газар тариалангийн үйл ажиллагаа эрхэлдэг өрх, аж ахуйн нэгж, байгууллага хамрагдах бөгөөд тооллогыг нэлэнхүй ажиглалтаар бүрэн хамруулсан.

**Загас, ой, ан агнуурын салбар (03):** Эдгээр салбарын үйл ажиллагааг эрхэлж буй аж ахуйн нэгж байгууллага, өрхийг тооллогод бүрэн хамруулсан.

**Засаг захиргааны анхан шатны нэгж**: Уг судалгааг сумын Засаг Даргын Тамгын газраас гаргуулах бөгөөд бүх сумдыг хамруулсан.

ХААТ-д Эдийн засгийн үйл ажиллагааны салбарын ангилал (ЭЗҮАСА-4.0), Бүтээгдэхүүн үйлчилгээний нэгдсэн ангилал (БҮНА-2.0), Засаг захиргаа, нэгжийн ангилалыг ашигласан.

**Арга зүй.** Тооллогод НҮБ-ын ХХААБ-ын зөвлөмжийн дагуу мэдээллийг цуглуулалтад нэлэнхүй ажиглалт болон түүврийн аргыг хослуулан хэрэглэсэн.

Тооллогод хамрагдах салбараас Мал аж ахуйн салбарт үйл ажиллагаа явуулдаг өрхийн мэдээллийг түүврийн аргаар, бусад салбарт нэлэнхүй ажиглалтын аргыг ашиглан мэдээлэл цуглуулсан.

Нэлэнхий ажиглалтын эх олонлогийн хүрээг тодорхойлохдоо 2021 онд ҮСХ-ны тооллого судалгаанд хамрагдсан өрх, ААНБ байгууллагууд, Ойн нөхөрлөл, Загас, ан агнуурын салбарын хувьд хүрээг орон нутгаас тодруулж, холбогдох яамнаас олгосон зөвшөөрлийн бүртгэл зэргийг ашигласан.

**Мал аж ахуйн салбарын үйл ажиллагаа явуулдаг өрхийн түүврийн загвар.** Эх олонлог нь 2021 оны жилийн эцсийн мал, тэжээвэр амьтдын тооллогын малтай болон малчин өрх байсан.

**Түүврийн домэйн:** Судалгааны үр дүнг сумын түвшинд гаргах нь энэхүү тооллогын зорилт байсан. Иймд сумын түвшинд гаргах үр дүнгийн нарийвчлалын түвшин нь хүлээн зөвшөөрөгдөхүйц байна.

**Түүврийн хэмжээг тодорхойлох:** Тодорхой нэг нутаг дэвсгэр (домэйн) эсвэл хүн амын тодорхой бүлгийн хувьд түүвэр судалгааны түүврийн хэмжээг дараах томьёоллын дагуу тооцно. Үүнд:

$$\boldsymbol{n} = \frac{\boldsymbol{Z^2 \times P_0 \times (1-P_0)}}{\boldsymbol{e^2}} \qquad (1)$$

Энд: $z$ = ашиглаж буй итгэх түвшинг харуулсан стандарт хэвийн тархалтын утга

$P_0$= түлхүүр үзүүлэлтийн утга (хувийн жингийн үзүүлэлт)

$e$ = абсолют алдааны хязгаар буюу түлхүүр үзүүлэлтийн утгыг хүлээн зөвшөөрөх харьцангуй алдаагаар үржүүлсэнтэй тэнцүү байна.

Үндэсний хэмжээнд нийт түүврийн хэмжээг тодорхойлох зорилт тавьсан. Дээрх томьёоллын дагуу түүврийн хэмжээг тодорхойлохын тулд эхлээд өгөгдсөн хувьсагчдын утгыг тодорхойлсон. Үүнд:

z– 95 хувийн ач холбогдлын түвшин дэх стандарт хэвийн тархалтын харгалзах утга 1.96

$P_0$ – түлхүүр үзүүлэлтийн хувийн жин. (Энд том малын зүй бус хорогдлын оны эхний эхний нийт малын тоонд эзлэх хувийн жин сүүлийн 3 жилийн дунджаар авсан =0.03)

e – таамаглаж байгаа алдааны хязгаарыг аль болох бага хэмжээтэйгээр авах бөгөөд практикт 5-15 хувийн харьцангуй алдаатай байхад судалгааны үр дүнг ашиглаж болдог. (Бидний тохиолдолд таамаглаж байгаа харьцангуй алдаа 4.1 % буюу абсолют алдаа 0.0012 хувь)

Хувьсагчдын утгыг дээрх байдлаар тодорхойлж, түүврийн хэмжээг тооцоход ойролцоогоор 74400 болсон.

**Түүврийн хуваарилалт:** Нийт түүврийн хэмжээг аймгуудад пропорциональ хуваарилалтын аргын дагуу хуваарилна.

**Түүврийн бүлэглэлт:** Судалгааны үр дүнг сумын түвшинд гаргах зорилтыг хангахын тулд бүлэглэлт түүврийн аргыг сонгосон Судалгааны хүрээнд байгаа Монгол Улсын нийт малчин болон малтай өрхийн 5 хошуу малын тоонд үндэслэн аймаг болгоны хувьд 5-6 түүврийн бүлэг үүсгэсэн.

**Түүврийн сонголт:** Аймгийн түвшинд үүссэн түүврийн бүлэг болгоны хувьд харгалзах түүврийн хэмжээг тогтоосны дараа систем түүврийн аргыг ашиглан түүврийн нэгжийн сонголтыг хийж гүйцэтгэсэн.

### I.3.6. Тооллогын мэдээлэл цуглуулах арга

Энэ удаагийн тооллогод цахим мэдээлэл цуглуулах төхөөрөмж (CAPI-Computer Assisted Personal Interview) ашиглан нүүр тулсан ярилцлага хийх аргаар мэдээлэл цуглуулсан. Төхөөрөмж ашигласнаар өрхийн байршлыг сансрын зурагтай холбож, газар тариалангийн талбайн мэдээллийг тариалсан ургамлын нэр төрөл бүрээр




ангилах боломж бүрдсэн. Түүнчлэн мэдээллийн чанарыг хугацаа, байршил зэргээр давхар хянах, маягтын үзүүлэлтэд уялдаа холбооны шалгалтыг газар дээр нь хийх боломжтой болсон. Зарим аймгуудад гэнэтийн шаардлагаар цаасан маягтаар мэдээллийг цуглуулсан.

### I.3.7. Мэдээлэл боловсруулалт

Тооллогын газрын зургийн хэсэгт ZY хиймэл дагуулын өндөр нарийвчлалтай зургийг ArcGis программ ашиглан боловсруулалт хийж, мэдээлэл цуглуулалтын ажилд CAPI аргыг ашиглахдаа CsPro 7.7 программыг ашигласан. Мэдээлэл цуглуулалтын явцыг хянах цахим хуудсыг хөгжүүлж явцыг хянаж ажилласан. Мэдээллийн нэгтгэл, шалгалт, үр дүнгийн боловсруулалт, статистик дүн шинжилгээг хийхдээ STATA программ ашигласан.

Мэдээлэл цуглуулалтын үед тооллогын асуулт, үзүүлэлт хоорондын уялдаа холбоо, тэнцлийн шалгалтыг тухай бүр хийж, зарим шаардлагатай засвар, агуулгын шалгалтыг  хийж, мэдээллийн санг бүрдүүлсэн.

Хөдөө аж ахуйн тооллогын мэдээллийн сангийн үзүүлэлтийн уялдаа холбоог мал, тэжээвэр амьтдын тооллого, газар тариалангийн жилийн эцсийн мэдээг  ашиглан шалгасан.

II
БҮЛЭГ

# ХӨДӨӨ АЖ АХУЙ, ОЙН АЖ АХУЙ, ЗАГАС, АН АГНУУРЫН АЖ АХУЙН ЭРХЭЛДЭГ ӨРХ, АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГА

## ХӨДӨӨ АЖ АХУЙ, ОЙН АЖ АХУЙ, ЗАГАС, АН АГНУУРЫН АЖ АХУЙН ЭРХЭЛДЭГ ӨРХ, АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГЫН ТОО



МАЛ АЖ АХУЙ
246 227

ГАЗАР ТАРИАЛАН
20 487

ОЙН АЖ АХУЙ
25 776

АН АГНУУРЫН АЖ АХУЙ
1 191

ЗАГАС
3 220

## II. ХӨДӨӨ АЖ АХУЙ, ОЙН АЖ АХУЙ, ЗАГАС, АН АГНУУРЫН АЖ АХУЙ ЭРХЭЛДЭГ ӨРХ, АЖ АХУЙН НЭГЖ БАЙГУУЛЛАГА

ХАА-н тооллогод 2021 онд 297.0 мянган өрх, аж ахуй нэгж бүртгэгдсэн нь 2011 оноос 51.5 мянган өрх, аж ахуй нэгж байгууллага буюу 21.0 хувиар өссөн байна. ХАА-н салбарт үйл ажиллагаа явуулдаг 294.1 мянган өрхийн 245.4 мянган өрх буюу 83.4 хувь нь мал аж ахуй, 18.8 мянган өрх буюу 6.4 хувь нь газар тариалан, 25.5 мянган өрх буюу 8.7 хувь нь ойн аж ахуй[1], 3.2 мянган өрх буюу 1.1 хувь нь загасны аж ахуй, 1.2 мянган өрх  буюу 0.4 хувь нь ан агнуурын аж ахуй эрхэлж байна.

ХАА-н салбарт үйл ажиллагаа явуулсан 2.9 мянган ААНБ-ын 902 ААНБ буюу 31.6 хувь нь мал аж ахуй, 1.6 мянган ААНБ буюу 57.6 хувь нь газар тариалан,  297 ААНБ буюу 10.8 хувь нь ойн аж ахуй, загас , ан агнуурын аж ахуй эрхэлж байна.

ХАА-н тооллогод 294.1 мянган өрх бүртгэгдсэн нь 2011 оноос 51.1 мянган өрх буюу 21.0 хувь, 2854 аж ахуйн нэгж байгууллага тоологдсон нь 2011 оноос 399 буюу 16.3 хувиар тус тус өссөн байна.

ХҮСНЭГТ II.1. ХӨДӨӨ АЖ АХУЙ, ОЙН АЖ АХУЙ, ЗАГАС, АН АГНУУРЫН АЖ АХУЙ ЭРХЭЛДЭГ ӨРХ, АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГЫН ТОО, дүнд эзлэх хувиар, оноор

| | Бүгд | | Өрх | | ААНБ | |
|---|---|---|---|---|---|---|
| | 2011 | 2021 | 2011 | 2021 | 2011 | 2021 |
| **Бүгд** | **245 479** | **296 951** | **243 024** | **294 097** | **2 455** | **2 854** |
| Мал аж ахуй | 210 070 | 246 277 | 209 563 | 245 375 | 507 | 902 |
| Газар тариалан | 35 166 | 20 487 | 33 461 | 18 844 | 1 705 | 1 643 |
| Ойн аж ахуй | 232 | 25 776 | - | 25 479 | 232 | 297 |
| Ан агнуурын аж ахуй | 2 | 1 191 | - | 1 183 | 2 | 8 |
| Загасны аж ахуй | 9 | 3 220 | - | 3 216 | 9 | 4 |
| | Дүнд эзлэх хувь | | | | | |
| **Бүгд** | **100.0** | **100.0** | **100.0** | **100.0** | **100.0** | **100.0** |
| Мал аж ахуй | 85.6 | 82.9 | 86.2 | 83.4 | 20.7 | 31.6 |
| Газар тариалан | 14.3 | 6.9 | 13.8 | 6.4 | 69.5 | 57.6 |
| Ойн аж ахуй | 0.1 | 8.7 | - | 8.7 | 9.5 | 10.4 |
| Ан агнуурын аж ахуй | 0.0 | 0.4 | - | 0.4 | 0.1 | 0.3 |
| Загасны аж ахуй | 0.0 | 1.1 | - | 1.1 | 0.4 | 0.1 |

Хөдөө аж ахуйн эрхэлж буй өрхүүдийг үйл ажиллагааны чиглэл, бүсээр задалж харахад мал аж ахуй эрхэлдэг нийт өрхийн 35.8 хувь буюу 3 өрх тутмын 1 нь, ойн аж ахуй эрхэлж буй өрхүүдийн 45.2 хувь нь Хангайн бүсэд аж ахуй эрхэлж байна.

[1] Ойн аж ахуйн үйл ажиллагаанд мод бэлтгэл, ойн дагалт нөөцийг ашиглах, мод тарих болон ойн аж ахуйн бусад үндсэн болон туслах үйл ажиллагааг авч үзсэн.

Харин газар тариалан эрхэлдэг өрхүүдийн 40.0 хувь нь Төвийн бүсэд, ан агнуурын аж ахуй эрхэлдэг өрхүүдийн 53.0 хувь, загасны аж ахуй эрхэлдэг өрхүүдийн 35.7 хувь нь Баруун бүсэд тус тус үйл ажиллагаа явуулж байна.

### ХҮСНЭГТ II.2. ХӨДӨӨ АЖ АХУЙ, ОЙ, ЗАГАС, АН АГНУУРЫН АЖ АХУЙ ЭРХЭЛДЭГ ӨРХ, АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГЫН ТОО, БҮСЭЭР

| | Бүгд | Баруун бүс | Хангайн бүс | Төвийн бүс | Зүүн бүс | Улаанбаатар |
|---|---|---|---|---|---|---|
| | | | Өрх | | | |
| Мал аж ахуй | **245 375** | 66 135 | 87 826 | 54 306 | 31 768 | 5 340 |
| Газар тариалан | **18 844** | 3 707 | 3 503 | 7 534 | 1 711 | 2 389 |
| Ойн аж ахуй | **25 479** | 5 622 | 11 523 | 5 267 | 2 000 | 1 066 |
| Ан агнуурын аж ахуй | **1 183** | 627 | 345 | 93 | 108 | 11 |
| Загасны аж ахуй | **3 216** | 1 149 | 991 | 737 | 286 | 53 |
| | | | Аж ахуйн нэгж байгууллага | | | |
| Мал аж ахуй | **902** | 94 | 217 | 325 | 222 | 44 |
| Газар тариалан | **1 643** | 258 | 300 | 845 | 161 | 79 |
| Ойн аж ахуй | **297** | 55 | 99 | 92 | 16 | 35 |
| Ан агнуурын аж ахуй | **8** | 4 | - | 4 | - | - |
| Загасны аж ахуй | **4** | 1 | - | - | 1 | 2 |

III БҮЛЭГ

# ХӨДӨӨ АЖ АХУЙ ЭРХЭЛДЭГ ӨРХ, ТҮҮНИЙ ТЭРГҮҮЛЭГЧ БОЛОН АЖ АХУЙН НЭГЖ БАЙГУУЛЛАГА, ТҮҮНИЙ УДИРДЛАГА

**ӨРХИЙН ТЭРГҮҮЛЭГЧИЙН ДААТГАЛД ХАМРАГДСАН БАЙДАЛ, даатгалын төрлөөр, мянган хүн**



# III. ХӨДӨӨ АЖ АХУЙ ЭРХЭЛДЭГ ӨРХ, ТҮҮНИЙ ТЭРГҮҮЛЭГЧ БОЛОН АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГА, ТҮҮНИЙ УДИРДЛАГА

Энэ удаагийн тооллогоор ХАА-н үйл ажиллагаа эрхэлж буй өрх, өрхийн тэргүүлэгч, тэдгээрийн нас, хүйс, боловсролын түвшин, даатгалд хамрагдсан байдал, өрхийн ам бүлийн тоо, амьдарч байгаа сууцны нөхцөл, түүний эзэмшил, цахилгаан, ундны усны эх үүсвэр, ундны болон ахуйн хэрэглээний усаа зөөвөрлөж байгаа байдал зэргийн талаарх мэдээллийг тусгасан. Харин хөдөө аж ахуй эрхэлдэг аж ахуйн нэгж, байгууллагын удирдлагын талаарх мэдээллийг нас, хүйс, боловсролын түвшин гэсэн үзүүлэлтээр мэдээлэл цуглуулж, үр дүнг танилцуулж байна.

## III.1. Хөдөө аж ахуй эрхэлдэг өрх, түүний тэргүүлэгч

### Хөдөө аж ахуй эрхэлдэг өрх, өрхийн тэргүүлэгчийн нас, хүйс

Монгол Улсын хэмжээнд 2021 оны байдлаар 245.4 мянган өрх мал аж ахуй, 18.8 мянган өрх газар тариалангийн үйл ажиллагаа эрхэлж байна. Энэ нь 2011 оны тооллоготой харьцуулахад мал аж ахуй эрхэлдэг өрхийн тоо 35.8 (17.1%) мянган өрхөөр нэмэгдсэн бол газар тариалан эрхэлдэг өрхийн тоо 14.7 (43.7%) мянган өрхөөр буурсан байна.

ХҮСНЭГТ III.1. ХӨДӨӨ АЖ АХУЙ ЭРХЭЛДЭГ ӨРХИЙН ТОО, өрхийн тэргүүлэгчийн хүйсээр, мянган хүнээр

| | Бүгд | | Мал аж ахуй | | Газар тариалан | |
|---|---|---|---|---|---|---|
| | 2011 | 2021 | 2011 | 2021 | 2011 | 2021 |
| Өрхийн тоо, мян.өрх | 243.1 | 264.2 | 209.6 | 245.4 | 33.5 | 18.8 |
| Эрэгтэй тэргүүлэгчтэй | 209.6 | 226.8 | 182.1 | 211.7 | 27.5 | 15.0 |
| Эмэгтэй тэргүүлэгчтэй | 33.5 | 37.5 | 27.5 | 33.6 | 6.0 | 3.8 |
| Дүнд эзлэх хувь | | | | | | |
| Өрхийн тэргүүлэгчийн хүйсээр | 100.0 | 100.0 | 100.0 | 100.0 | 100.0 | 100.0 |
| Эрэгтэй | 86.2 | 85.8 | 86.9 | 86.3 | 82.1 | 79.8 |
| Эмэгтэй | 13.8 | 14.2 | 13.1 | 13.7 | 17.9 | 20.2 |

Мал аж ахуй эрхэлдэг өрхийн 86.3 хувь (211.7 мянга) нь эрэгтэй тэргүүлэгчтэй, 13.1 хувь (33.6 мянга) нь эмэгтэй тэргүүлэгчтэй бол газар тариалан эрхэлдэг өрхийн 79.8 хувь (15.0 мянга) нь эрэгтэй тэргүүлэгчтэй, 20.3 хувь (3.8 мянга) нь эмэгтэй тэргүүлэгчтэй байна.

2011 онтой харьцуулахад 2021 онд мал аж ахуй эрхэлдэг эмэгтэй тэргүүлэгчтэй өрхийн тоо 6.1 мянгаар нэмэгдэхийн зэрэгцээ нийт мал аж ахуй эрхлэгч өрхөд эзлэх хувь 0.6 нэгж хувиар өсжээ. Харин газар тариалан эрхэлдэг эмэгтэй тэргүүлэгчтэй өрхийн тоо 2.2 мянган өрхөөр буурсан хэдий ч нийт өрхөд эзлэх хувь 2.3 нэгж хувиар өссөн байна.

ХҮСНЭГТ III.2. ХӨДӨӨ АЖ АХУЙ ЭРХЭЛДЭГ ӨРХИЙН ТОО, өрхийн тэргүүлэгчийн насны бүлгээр, мянган хүнээр

| | Бүгд | | Мал аж ахуй | | Газар тариалан | |
|---|---|---|---|---|---|---|
| | 2011 | 2021 | 2011 | 2021 | 2011 | 2021 |
| **Бүгд** | **243.1** | **264.2** | **209.6** | **245.4** | **33.5** | **18.8** |
| 15-34 | 64.7 | 51.6 | 59.7 | 49.9 | 5.0 | 1.7 |
| 35-49 | 93.8 | 103.1 | 80.4 | 96.8 | 13.4 | 6.3 |
| 50-иас дээш | 84.6 | 109.5 | 69.5 | 98.7 | 15.1 | 10.9 |
| Дунд эзлэх хувь | | | | | | |
| **Бүгд** | **100.0** | **100.0** | **100.0** | **100.0** | **100.0** | **100.0** |
| 15-34 настай | 26.6 | 19.5 | 28.5 | 20.3 | 14.9 | 9.1 |
| 35-49 настай | 38.6 | 39.0 | 38.4 | 39.5 | 40.0 | 33.3 |
| 50-иас дээш | 34.8 | 41.5 | 33.2 | 40.2 | 45.1 | 57.6 |

Өрхийн тэргүүлэгчдийг насны бүлгээр авч үзэхэд, мал аж ахуй эрхэлдэг өрхийн 40.2 хувь буюу 98.7 мянган өрх 50 ба түүнээс дээш насны өрхийн тэргүүлэгчтэй ба 39.5 хувь болох 96.8 мянган өрх 35-49 насны тэргүүлэгчтэй байна. 2011 онтой харьцуулахад 2021 онд 35-49 насны өрхийн тэргүүлэгчдийн хувь харьцангуй тогтвортой байгаа бол 15-34 насны өрхийн тэргүүлэгчтэй өрхийн хувь 8.2 нэгж хувиар буурч, 50 ба түүнээс дээш насны өрхийн тэргүүлэгчтэй өрхийн хувь 7.1 нэгж хувиар өссөн байна.

Газар тариалан эрхэлдэг өрхийн тэргүүлэгчдийн хувьд 57.6 хувь буюу 10.9 мянган өрхийн тэргүүлэгч 50 ба түүнээс дээш насныхан байгаа бол 33.3 хувь буюу 6.3 мянга нь 35-49 насныхан байна. 2011 онтой харьцуулахад 2021 онд 15-34 насны болон 35-49 насны өрхийн тэргүүлэгчтэй өрхийн хувь 5.8 болон 6.7 нэгж хувиар тус тус буурч, 50 ба түүнээс дээш насны өрхийн тэргүүлэгчтэй өрхийн хувь 12.5 нэгж хувиар өссөн байна.

## <u>Хөдөө аж ахуй эрхэлдэг өрх, өрхийн тэргүүлэгчийн эзэмшсэн боловсролын түвшин</u>

2021 оны байдлаар хөдөө аж ахуй эрхэлдэг өрхийн тэргүүлэгчдийг эзэмшсэн боловсролын түвшнээр үзэхэд нийт 264.2 мянган өрхийн тэргүүлэгчдийн 81.3 (214.8 мянга) нь бүрэн дунд ба түүнээс бага боловсролтой байна. Салбараар нь авч үзвэл мал аж ахуй эрхэлдэг өрхийн 82.5 хувь (202.5 мянга), газар тариалан эрхэлдэг өрхийн 65.0 (12.2 мянга) хувь тус тус бүрэн дунд ба түүнээс бага боловсролтой өрхийн тэргүүлэгчид байна. Харин нийт өрхийн 7.6 (20.2 мянга) хувь нь бакалавраас дээш боловсролтой өрхийн тэргүүлэгчтэй байгаа бөгөөд салбарын хувьд мал аж ахуй эрхэлдэг өрхийн 7.1 (17.3 мянга) хувь, газар тариалан эрхэлдэг өрхийн 14.9 (2.8 мянга) хувь нь бакалавраас дээш боловсрол эзэмшсэн өрхийн тэргүүлэгчидтэй байна.

Мал аж ахуй эрхэлдэг нийт өрхийн тэргүүлэгчдийн 2.8 (6.9 мянга) хувь, газар тариалан эрхэлдэг өрхийн 0.8 (0.2 мянга) хувь буюу нийт ХАА эрхэлдэг өрхийн 2.7 (7.0 мянга) хувь нь огт боловсрол эзэмшээгүй байна.

ХҮСНЭГТ III.3. ХӨДӨӨ АЖ АХУЙ ЭРХЭЛДЭГ ӨРХИЙН ТОО, өрхийн тэргүүлэгчийн эзэмшсэн боловсролын түвшнээр, мянган хүнээр, 2021 он

| | Бүгд | | Мал аж ахуй | | Газар тариалан | |
|---|---|---|---|---|---|---|
| | Тоо | Хувь | Тоо | Хувь | Тоо | Хувь |
| **Бүгд** | **264.2** | **100.0** | **245.4** | **100.0** | **18.8** | **100.0** |
| Боловсролгүй | 7.0 | 2.7 | 6.9 | 2.8 | 0.2 | 0.8 |
| Бага | 49.2 | 18.6 | 48.2 | 19.6 | 1.1 | 5.7 |
| Суурь | 65.2 | 24.7 | 62.4 | 25.4 | 2.8 | 14.8 |
| Бүрэн дунд | 100.4 | 38.0 | 92.0 | 37.5 | 8.4 | 44.5 |
| Техникийн болон мэргэжлийн | 8.7 | 3.3 | 7.5 | 3.0 | 1.2 | 6.6 |
| Тусгай мэргэжлийн дунд | 8.3 | 3.1 | 6.8 | 2.8 | 1.4 | 7.7 |
| Дипломын дээд | 5.3 | 2.0 | 4.3 | 1.8 | 1.0 | 5.0 |
| Бакалаврын дээд | 19.3 | 7.3 | 16.6 | 6.8 | 2.6 | 13.9 |
| Магистр | 0.8 | 0.3 | 0.7 | 0.3 | 0.2 | 0.9 |
| Доктор | 0.1 | 0.03 | 0.05 | 0.02 | 0.02 | 0.1 |

## Өрхийн тэргүүлэгчийн даатгалд хамрагдсан байдал

2021 онд мал аж ахуй эрхэлж буй нийт өрхийн 14.7 хувь буюу 36.2 мянган өрхийн тэргүүлэгч албан журмын даатгалд, 48.4 хувь буюу 118.7 мянган өрхийн тэргүүлэгч сайн дурын даатгалд хамрагддаг байна. Түүнчлэн 1.6 хувь буюу 4.0 мянган өрхийн тэргүүн албан журмын болон сайн дурын даатгалд зэрэг хамрагддаг байна.

Газар тариалан эрхэлж буй нийт өрхийн 19.8 хувь буюу 3.7 мянган өрхийн тэргүүлэгч албан журмын даатгалд, 12.1 хувь буюу 2.3 мянган өрхийн тэргүүлэгч сайн дурын даатгалд хамрагддаг байна.

2011 онтой харьцуулахад нийт 243.1 мянган өрхийн 15.2 хувь буюу 37.0 мянган өрхийн тэргүүлэгч даатгалд хамрагдаагүй байсан бол 2021 оны байдлаар нийт 264.2 мянган өрхийн 37.6 хувь буюу 99.3 мянган өрхийн тэргүүлэгч даатгалд хамрагдаагүй байна.

ХҮСНЭГТ III.4. ӨРХИЙН ТЭРГҮҮЛЭГЧИЙН ДААТГАЛД ХАМРАГДСАН БАЙДАЛ, даатгалын хэлбэрээр, мянган хүнээр, 2021 он

| | Бүгд | Мал аж ахуй | Газар тариалан |
|---|---|---|---|
| Өрхийн тоо | 264.2 | 245.4 | 18.8 |
| Албан журмын даатгал | 39.9 | 36.2 | 3.7 |
| Сайн дурын даатгал | 121.0 | 118.7 | 2.3 |
| Хамрагддаггүй | 99.3 | 86.5 | 12.8 |
| Албан журмын болон сайн дурын даатгал | 4.0 | 4.0 | - |
| Даатгалд хамрагдалтын хувь | | | |
| Өрхийн тоо | 100.0 | 100.0 | 100.0 |
| Албан журмын даатгал | 15.1 | 14.7 | 19.8 |
| Сайн дурын даатгал | 45.8 | 48.4 | 12.1 |
| Хамрагддаггүй | 37.6 | 35.2 | 68.1 |
| Албан журмын болон сайн дурын даатгал | 1.5 | 1.6 | - |

2021 онд даатгалд хамрагдсан мал аж ахуй эрхлэгч өрхийн тэргүүлэгчдийн 35.1 хувь нь нийгмийн болон эрүүл мэндийн даатгалд зэрэг хамрагдаж буй бол зөвхөн эрүүл мэндийн даатгалд 57.0 хувь, нийгмийн даатгалд 4.8 хувь тус тус дангаар хамрагдсан байна.

2021 онд даатгалд хамрагдсан газар тариалан эрхлэгч өрхийн тэргүүлэгчдийн 71.9 хувь нь нийгмийн болон эрүүл мэндийн даатгалд зэрэг хамрагдаж буй бол зөвхөн эрүүл мэндийн даатгалд 16.8 хувь, нийгмийн даатгалд 5.3 хувь тус тус дангаар хамрагдсан байна.

ХҮСНЭГТ III.5. ӨРХИЙН ТЭРГҮҮЛЭГЧИЙН ДААТГАЛД ХАМРАГДСАН БАЙДАЛ, даатгалын төрлөөр, мян хүн

| | Бүгд | | Мал аж ахуй | | Газар тариалан | |
|---|---|---|---|---|---|---|
| | 2011 | 2021 | 2011 | 2021 | 2011 | 2021 |
| **Өрхийн тоо** | **258.2** | **164.9** | **216.8** | **158.9** | **41.4** | **6.0** |
| Эрүүл мэндийн даатгалд | 204.8 | 91.5 | 176.8 | 90.5 | 28.0 | 1.0 |
| Нийгмийн даатгалд | 53.4 | 8.0 | 40.0 | 7.6 | 13.4 | 0.3 |
| Нийгмийн даатгал болон эрүүл мэндийн даатгал | | 60.1 | | 55.7 | | 4.3 |
| Бусад | | 5.4 | | 5.0 | | 0.4 |
| Даатгалд хамрагдалтын хувь | | | | | | |
| **Бүгд** | **100.0** | **100.0** | **100.0** | **100.0** | **100.0** | **100.0** |
| Эрүүл мэндийн даатгалд | 79.3 | 55.5 | 81.5 | 57.0 | 67.6 | 16.8 |
| Нийгмийн даатгалд | 20.7 | 4.8 | 18.5 | 4.8 | 32.4 | 5.3 |
| Нийгмийн даатгал болон эрүүл мэндийн даатгал | | 36.4 | | 35.1 | | 71.9 |
| Бусад | | 3.3 | | 3.2 | | 6.0 |

Бүсээр авч үзвэл мал аж ахуй эрхэлдэг өрхийн тэргүүлэгчдийн эрүүл мэндийн даатгалд хамрагдалт Баруун бүсэд 60.9 хувь, Хангайн бүсэд 64.2 хувьтай байгаа бол Зүүн болон Төвийн бүсэд ерөнхийдөө ойролцоо 54.4 болон 55.7 хувьтай байна. Харин Улаанбаатар хотод 39.6 хувийн хамрагдалттай байна.

Харин нийгмийн даатгалд хамрагдсан байдал нь МАА эрхэлдэг өрхийн тэргүүлэгчдийн хувьд Баруун, Хангайн, Төвийн бүсүүдэд 26.2-27.5 хувьтай байгаа бол Зүүн бүсэд 21.4 хувь, Улаанбаатар хотод 21.3 хувийн хамрагдалттай байна.

Газар тариалан эрхэлдэг өрхийн тэргүүлэгчдийн эрүүл мэндийн даатгалд хамрагдалт Баруун, Төвийн, Зүүн бүсэд 27.6-28.5 хувьтай байгаа бол Хангайн бүсэд 35.3, Улаанбаатар хотод 18.0 хувийн хамрагдалттай байна.

Харин нийгмийн даатгалд хамрагдсан байдал нь газар тариалан эрхэлдэг өрхийн тэргүүлэгчдийн хувьд Баруун, Төвийн, Зүүн бүсэд 23.9-25.3 хувьтай байгаа бол Хангайн бүсэд 31.0, Улаанбаатар хотод 14.2 хувийн хамрагдалттай байна.

## III.2. Хөдөө аж ахуй эрхэлдэг өрхийн ам бүлийн тоо

<u>Хөдөө аж ахуй эрхэлдэг өрхийн ам бүлийн тоо</u>

Мал аж ахуй эрхэлдэг 245.4 мянган өрхөд 688.4 мянган хүн амьдарч, нэг өрх дунджаар 2-3 (2.8) ам бүлтэй байна. 2011 онтой харьцуулахад нийт өрхийн тоо 17.1 хувиар (35.8 мянга) нэмэгдсэн ч малтай өрхийн тоо 13.4 хувиар (107.0 мянга) буурсан байна.

Газар тариалан эрхэлдэг 18.8 мянган өрхөд 48.6 мянган хүн амьдарч, нэг өрх дунджаар 2-3 (2.6) ам бүлтэй байна. 2011 онтой харьцуулахад нийт өрхийн тоо 43.7 хувиар (14.7 мянга) буурч, ам бүлийн тоо 63.7 хувиар (85.2 мянга) буурсан байна.

ХҮСНЭГТ III.6. ХӨДӨӨ АЖ АХУЙ ЭРХЭЛДЭГ ӨРХ, ам бүлийн тоо, мянган хүнээр

| | Бүгд | | Мал аж ахуй | | Газар тариалан | |
|---|---|---|---|---|---|---|
| | 2011 | 2021 | 2011 | 2021 | 2011 | 2021 |
| **Өрх** | **243.1** | **264.2** | **209.6** | **245.4** | **33.5** | **18.8** |
| Өрхийн хүн ам | 929.2 | 737.0 | 795.4 | 688.4 | 133.8 | 48.6 |
| Үүнээс: 16 Хүртэлх насны хүүхэд | 293.2 | 188.2 | 257.9 | 178.1 | 36.0 | 10.1 |
| Нэг өрхийн дундаж ам бүл | 3.8 | 2.8 | 3.8 | 2.8 | 4.0 | 2.6 |

Мал аж ахуй эрхэлдэг өрхөд 16-с доош насны 178.1 мянган хүүхэд, газар тариалан эрхэлдэг өрхөд 10.1 мянган хүүхэд байна.

## III.3. Хөдөө аж ахуй эрхэлдэг өрхийн сууц, цахилгаан хангамж, усны эх үүсвэр

<u>Хөдөө аж ахуй эрхэлдэг өрхийн сууцны төрөл</u>

Тооллогоор ХАА эрхэлдэг өрхийн эзэмшиж буй сууцны төрлийн талаарх мэдээллийг цуглуулав. ХАА эрхэлдэг 264.2 мянган өрхийн 69.2 хувь нь гэрт, 25.6 хувь нь сууцны тусдаа байшинд амьдарч байна. 2011 онтой харьцуулахад гэрт амьдардаг өрхийн тоо 6.5 хувиар (11.1 мянга) өссөн бол сууцны тусдаа байшинд амьдарч буй өрхийн тоо 3.1 хувиар (2.1 мянга) буурсан байна. Түүнчлэн зориулалтын бус сууцанд амьдарч буй өрхийн тоо 77.8 хувиар (0.9 мянга) буурсан байна.

Салбараар авч үзвэл, мал аж ахуй эрхэлдэг 245.4 мянган өрхийн 72.1 хувь нь гэрт, 23.3 хувь нь сууцны тусдаа байшинд, 2.0 хувь нь орон сууцанд, 0.1 хувь нь зориулалтын бус сууцанд мөн 2.0 хувь нь бие даасан тохилог сууцанд амьдарч байна. 2011 онтой харьцуулахад сууцны тусдаа байшинд амьдардаг өрхийн хувь 0.4 нэгж хувиар нэмэгдсэн бол гэрт амьдардаг өрхийн хувь 4.3 нэгж хувиар, зориулалтын бус сууцанд амьдардаг өрхийн хувь 0.4 нэгж хувиар тус тус буурсан байна.

Харин газар тариалан эрхэлдэг 18.8 мянган өрхийн 31.7 хувь нь гэрт, 54.9 хувь нь сууцны тусдаа байшинд, 8.2 хувь нь орон сууцанд, 4.7 хувь нь бие даасан тохилог сууцанд мөн 0.1 хувь нь зориулалтын бус сууцанд амьдарч байна. 2011 онтой харьцуулахад гэрт амьдардаг өрхийн хувь 3.0 нэгж хувиар, сууцны тусдаа байшинд амьдардаг өрхийн хувь 9.9 нэгж хувиар, зориулалтын бус сууцанд амьдардаг өрхийн хувь 0.2 нэгж хувиар тус тус буурсан байна.

Мал аж ахуй эрхэлдэг өрхийн хувьд дийлэнх нь гэрт, харин газар тариалан эрхэлдэг өрхийн хувьд голлон сууцны тусдаа байшинд амьдрах нь сүүлийн 10 жилд хэвээр байна.

ХҮСНЭГТ III.7. ХӨДӨӨ АЖ АХУЙ ЭРХЭЛДЭГ ӨРХИЙН ТОО, сууцны төрлөөр, мянган өрхөөр

| | Бүгд | | Мал аж ахуй | | Газар тариалан | |
|---|---|---|---|---|---|---|
| | 2011 | 2021 | 2011 | 2021 | 2011 | 2021 |
| **Өрхийн тоо** | **243.1** | **264.2** | **209.6** | **245.4** | **33.5** | **18.8** |
| Гэр | 171.8 | 182.9 | 160.2 | 177.0 | 11.6 | 6.0 |
| Орон сууцны байшин | - | 6.6 | - | 5.0 | - | 1.5 |
| Бие даасан тохилог сууц | - | 5.8 | - | 4.9 | - | 0.9 |

| | Бүгд | | Мал аж ахуй | | Газар тариалан | |
|---|---|---|---|---|---|---|
| | 2011 | 2021 | 2011 | 2021 | 2011 | 2021 |
| Сууцны тусдаа байшин | 69.7 | 67.6 | 48.0 | 57.2 | 21.7 | 10.3 |
| Оюутан сурагчдын нийтийн байр | - | 0.0 | - | 0.0 | - | 0.0 |
| Ажиллагчдын нийтийн байр | - | 0.1 | - | 0.1 | - | 0.0 |
| Нийтийн зориулалтын бусад байр | - | 0.3 | - | 0.2 | - | 0.0 |
| Зориулалтын бус сууц | 1.1 | 0.2 | 1.0 | 0.2 | 0.1 | 0.0 |
| Бусад | 0.5 | 0.8 | 0.4 | 0.7 | 0.1 | 0.0 |
| Өрхийн дунд эзлэх хувь | | | | | | |
| **Бүгд** | **100.0** | **100.0** | **100.0** | **100.0** | **100.0** | **100.0** |
| Гэр | 70.7 | 69.2 | 76.4 | 72.1 | 34.6 | 31.7 |
| Орон сууцны байшин | | 2.5 | | 2.0 | | 8.2 |
| Бие даасан тохилог сууц | | 2.2 | | 2.0 | | 4.7 |
| Сууцны тусдаа байшин | 28.7 | 25.6 | 22.9 | 23.3 | 64.8 | 54.9 |
| Оюутан сурагчдын нийтийн байр | | 0.0 | | 0.0 | | 0.0 |
| Ажиллагчдын нийтийн байр | | 0.0 | | 0.0 | | 0.1 |
| Нийтийн зориулалтын бусад байр | | 0.1 | | 0.1 | | 0.2 |
| Зориулалтын бус сууц | 0.5 | 0.1 | 0.5 | 0.1 | 0.3 | 0.1 |
| Бусад | 0.2 | 0.3 | 0.2 | 0.3 | 0.3 | 0.1 |

Бүсээр авч үзвэл Хангайн бүсэд мал аж ахуй эрхэлдэг өрхийн 77.7 хувь нь уламжлалт гэр сууцанд амьдарч байгаа нь бусад бүстэй харьцуулахад өндөр түвшинд байгаа бол Улаанбаатар хотод 33.8 хувь нь байшинд /сууцны тусдаа байшин, бие даасан тохилог сууц, орон сууцны байшин / амьдарч байгаа нь бусад бүсээс өндөр үзүүлэлт юм.

ЗУРАГ III.1. МАЛ АЖ АХУЙ ЭРХЭЛДЭГ ӨРХИЙН СУУЦНЫ ТӨРӨЛ, хувиар, бүсээр




Баруун бүсэд газар тариалан эрхэлдэг өрхийн 54.2 хувь нь уламжлалт гэр сууцанд амьдарч байгаа нь бусад бүстэй харьцуулахад өндөр түвшинд байгаа бол Улаанбаатар хотод 80.0 хувь нь байшинд /сууцны тусдаа байшин, бие даасан тохилог сууц, орон сууцны байшин/ амьдарч байгаа нь бусад бүсээс өндөр хувь байна.

ЗУРАГ III.2. ГАЗАР ТАРИАЛАН ЭРХЭЛДЭГ ӨРХИЙН СУУЦНЫ ТӨРӨЛ, хувиар, бүсээр



## Хөдөө аж ахуй эрхэлдэг өрхийн сууцны эзэмшил

Тооллогоор ХАА эрхэлдэг өрхийн амьдарч буй сууцны эзэмшлийн талаарх мэдээллийг цуглуулав. ХАА эрхэлдэг нийт 264.2 мянган өрхийн 98.2 хувь нь өөрийн эзэмшлийн сууцанд амьдарч байна. Мал аж ахуй эрхэлдэг өрхийн 1.0 хувь, газар тариалан эрхэлдэг өрхийн 1.1 хувь нь бусдын сууцанд түрээс төлөхгүй амьдардаг байна.

ХҮСНЭГТ III.8. ХӨДӨӨ АЖ АХУЙ ЭРХЭЛДЭГ ӨРХИЙН ТОО, сууцны эзэмшлээр, мянган өрхөөр

| Сууцны эзэмшил | Бүгд | | Мал аж ахуй | | Газар тариалан | |
|---|---|---|---|---|---|---|
| | Бүгд | % | Бүгд | % | Бүгд | % |
| **Бүгд** | **264.2** | **100.0** | **245.4** | **100.0** | **18.8** | **100.0** |
| Өөрийн эзэмшлийн | 259.6 | 98.2 | 241.1 | 98.3 | 18.5 | 98.0 |
| Бусдын сууцыг түрээсэлж амьдардаг | 0.5 | 0.2 | 0.5 | 0.2 | 0.1 | 0.4 |
| Бусдын сууцанд түрээсгүй амьдардаг | 2.7 | 1.0 | 2.5 | 1.0 | 0.2 | 1.1 |
| Бусад | 1.4 | 0.5 | 1.3 | 0.5 | 0.1 | 0.5 |

## Хөдөө аж ахуй эрхэлдэг өрхийн цахилгааны эх үүсвэр

Цахилгааны эх үүсвэр нь өрхийн амьжиргаа болон ая тухтай амьдрах орчны нэг чухал үзүүлэлт болдог бөгөөд үүнтэй холбоотойгоор өрхийн цахилгааны эх үүсвэрийн мэдээллийг төвлөрсөн систем, дизель станц, сэргээгдэх эрчим хүчний төхөөрөмж, цахилгааны эх үүсвэргүй, бага оврын цахилгаан үүсгүүр гэж ангилан бүрдүүллээ.

ХАА эрхэлдэг 264.2 мянган өрхийн 38.3 хувь нь төвлөрсөн системд холбогдсон, 50.0 хувь нь нар, салхи зэрэг сэргээгдэх эрчим хүчний төхөөрөмжтэй байна. 2011 онтой харьцуулахад төвлөрсөн системд холбогдсон өрхийн хувь 2.9 нэгж хувиар өссөн бол сэргээгдэх эрчим хүчийг цахилгааны эх үүсвэрээ болгож буй өрхийн хувь 5.7 нэгж хувиар буурсан байна.

Мал аж ахуй эрхэлдэг 245.4 мянган өрхийн 34.7 хувь нь төвлөрсөн системд холбогдсон, 53.0 хувь нь нар, салхи зэрэг сэргээгдэх эрчим хүчний төхөөрөмжтэй байна. 2011 онтой харьцуулахад төвлөрсөн системд холбогдсон өрхийн хувь 6.6 нэгж хувиар өссөн бол сэргээгдэх эрчим хүчийг цахилгааны эх үүсвэрээ болгож буй өрхийн хувь 9.4 нэгж хувиар буурсан байна. Мал аж ахуй эрхэлдэг өрхүүдийн хувьд сүүлийн 10 жилд цахилгааны гол эх үүсвэр нь сэргээгдэх эрчим хүч хэвээр байна.

Мал аж ахуй эрхэлдэг нийт өрхөөс 2.7 хувь буюу 6.7 мянган өрх ямар нэгэн цахилгааны эх үүсвэргүй байна.

ХҮСНЭГТ III.9. ХӨДӨӨ АЖ АХУЙ ЭРХЭЛДЭГ ӨРХИЙН ТОО, цахилгааны эх үүсвэрээр, мянган өрхөөр

| | Бүгд | | Мал аж ахуй | | Газар тариалан | |
|---|---|---|---|---|---|---|
| | 2011 | 2021 | 2011 | 2021 | 2011 | 2021 |
| **Өрхийн тоо** | **243.1** | **264.2** | **209.6** | **245.4** | **33.5** | **18.8** |
| Төвлөрсөн системд холбогдсон | 86.2 | 101.3 | 59.0 | 85.3 | 27.2 | 16.0 |
| Дизель станцад холбогдсон | 4.6 | 0.3 | 3.8 | 0.3 | 0.8 | 0.0 |
| Сэргээгдэх эрчим хүчний төхөөрөмжтэй | 135.4 | 132.1 | 130.7 | 130.0 | 4.7 | 2.1 |
| Бага оврын цахилгаан эх үүсвэртэй | 9.3 | 23.6 | 8.8 | 23.1 | 0.5 | 0.5 |
| Цахилгаангүй | 7.6 | 7.0 | 7.3 | 6.7 | 0.3 | 0.2 |
| Дүнд эзлэх хувь | | | | | | |
| **Бүгд** | **100.0** | **100.0** | **100.0** | **100.0** | **100.0** | **100.0** |
| Төвлөрсөн системд холбогдсон | 35.5 | 38.3 | 28.1 | 34.7 | 81.2 | 85.0 |
| Дизель станцад холбогдсон | 1.9 | 0.1 | 1.8 | 0.1 | 2.4 | 0.1 |
| Сэргээгдэх эрчим хүчний төхөөрөмжтэй | 55.7 | 50.0 | 62.4 | 53.0 | 14.0 | 11.3 |
| Бага оврын цахилгаан эх үүсвэртэй | 3.8 | 8.9 | 4.2 | 9.4 | 1.5 | 2.5 |
| Цахилгаангүй | 3.1 | 2.6 | 3.5 | 2.7 | 0.9 | 1.1 |

Газар тариалан эрхэлдэг 18.8 мянган өрхийн 85.0 хувь нь төвлөрсөн системд холбогдсон, 11.3 хувь нь нар, салхи зэрэг сэргээгдэх эрчим хүчний төхөөрөмжтэй байна. 2011 онтой харьцуулахад төвлөрсөн системд холбогдсон өрхийн хувь 3.8 нэгж хувиар өссөн бол сэргээгдэх эрчим хүчийг цахилгааны эх үүсвэрээ болгож буй өрхийн хувь 2.7 нэгж хувиар буурсан байна.

Газар тариалан эрхэлдэг нийт өрхөөс 1.1 хувь буюу 0.2 мянган өрх ямар нэгэн цахилгааны эх үүсвэргүй байна.

<u>Хөдөө аж ахуй эрхэлдэг өрхийн ундны усны эх үүсвэр</u>

ХАА эрхэлдэг өрхийн 38.6 (97.3 мянга) хувь нь хамгаалагдсан гүний болон гар худгаас, 33.0 (83.2 мянга) хувь нь ундны ил эх үүсвэр болон гол мөрөн, нуур, тойром, цөөрмөөс ундны усаа авч хэрэглэдэг бол 17.5 (44.1 мянга) хувь нь зөөврийн усаар ундны усны хэрэгцээгээ хангадаг байна. 2011 онтой харьцуулахад хамгаалагдсан гүний болон гар худгийг ундны усны эх үүсвэрээ болгодог өрхийн хувь 13.1 нэгж хувиар, төвлөрсөн системд холбогдсон өрхийн хувь 3.8 нэгж хувиар нэмэгдсэн бөгөөд гол мөрөн, нуур, хамгаалагдаагүй худаг, булаг, шандаас ундны усны хэрэгцээгээ хангадаг өрхийн хувь 23.9 нэгж хувиар буурсан үзүүлэлттэй байна.

Мал аж ахуй эрхэлдэг өрхийн 37.9 (88.7 мянга) хувь нь хамгаалагдсан гүний болон гар худгаас, 34.6 (80.9 мянга) хувь нь ундны ил эх үүсвэр болон гол мөрөн, нуур, тойром, цөөрмөөс ундны усаа авч хэрэглэдэг бол 17.4 (40.7 мянга) хувь нь зөөврийн усаар ундны усны хэрэгцээгээ хангадаг байна. 2011 онтой харьцуулахад хамгаалагдсан гүний болон гар худгийг ундны усны эх үүсвэрээ болгодог өрхийн хувь 14.0 нэгж хувиар, төвлөрсөн системд холбогдсон өрхийн хувь 3.8 нэгж хувиар нэмэгдсэн бөгөөд гол мөрөн, нуур, хамгаалагдаагүй худаг, булаг, шандаас ундны усны хэрэгцээгээ хангадаг өрхийн хувь 26.6 нэгж хувиар буурсан байна.

Газар тариалан эрхэлдэг өрхийн 48.7 (8.7 мянга) хувь нь хамгаалагдсан гүний болон гар худгаас, 12.7 (2.3 мянга) хувь нь ундны ил эх үүсвэр болон гол мөрөн, нуур, тойром, цөөрмөөс ундны усаа авч хэрэглэдэг бол 19.4 (3.5 мянга) хувь нь зөөврийн усаар ундны усны хэрэгцээгээ хангадаг байна. 2011 онтой харьцуулахад хамгаалагдсан гүний болон гар худгийг ундны усны эх үүсвэрээ болгодог өрхийн хувь 13.4 нэгж хувиар, төвлөрсөн системд холбогдсон өрхийн хувь 6.7 нэгж хувиар нэмэгдсэн бөгөөд гол мөрөн, нуур, хамгаалагдаагүй худаг, булаг, шандаас ундны усны хэрэгцээгээ хангадаг өрхийн хувь 17.3 нэгж хувиар буурсан байна.

ХҮСНЭГТ III.10. ХӨДӨӨ АЖ АХУЙ ЭРХЭЛДЭГ ӨРХИЙН УНДНЫ УСНЫ ЭХ ҮҮСВЭР, өрхийн дунд эзлэх хувиар

| | Бүгд | | Мал аж ахуй | | Газар тариалан | |
|---|---|---|---|---|---|---|
| | 2011 | 2021 | 2011 | 2021 | 2011 | 2021 |
| Бүгд | 100.0 | 100.0 | 100.0 | 100.0 | 100.0 | 100.0 |
| Төвлөрсөн системд холбогдсон | 1.3 | 5.1 | 1.0 | 4.8 | 3.5 | 10.2 |
| Төвлөрсөн бус системд холбогдсон | - | 0.3 | - | 0.3 | - | 0.8 |
| Төвлөрсөн шугам сүлжээнд холбогдсон ус ус түгээх байр | 2.3 | 1.2 | 1.6 | 1.1 | 6.6 | 3.6 |
| Төвлөрсөн шугам сүлжээнд холбогдоогүй ус түгээх байр | 3.2 | 1.0 | 1.6 | 0.8 | 13.3 | 3.6 |
| Хамгаалагдсан худаг /гүний худаг, гар худаг/ | 25.5 | 38.6 | 23.9 | 37.9 | 35.3 | 48.7 |
| Хамгаалагдсан булаг, шанд | 2.5 | 2.5 | 2.5 | 2.7 | 2.4 | 0.7 |
| Зөөврийн ус | 8.2 | 17.5 | 8.1 | 17.4 | 8.8 | 19.4 |
| Гол мөрөн, нуур, хамгаалагдаагүй худаг, булаг, шанд | 56.9 | 33.0 | 61.2 | 34.6 | 30 | 12.7 |
| Бусад | 0.1 | 0.6 | 0.1 | 0.6 | 0.1 | 0.4 |

## Хөдөө аж ахуй эрхэлдэг өрхийн ундны усны зөөвөрлөж буй дундаж зай

МАА эрхэлдэг өрхүүд нь дунджаар 1.2 км-ийн зайнаас ундны усаа зөөвөрлөн хэрэглэж байна.

Улирлаар авч үзвэл, МАА эрхэлдэг өрх ундны усыг дунджаар зундаа 1.0 км, бусад улиралд 1.2 км-ийн зайнаас зөөвөрлөн хэрэглэж байна. Зуны улиралд ундны усаа бусад улирлынхаас ойр зайнаас зөөвөрлөдөг байна. 2011 онтой харьцуулахад өрхийн ундны усаа зөөвөрлөх дундаж зай 73 метрээр ойртсон бөгөөд улирлаар нь харвал зуны улиралд усаа зөөвөрлөх дундаж зай 232 метрээр нэмэгдэх буюу холдож, намрын улиралд 189 метр, өвлийн улиралд 219 метр, хаврын улиралд 116 метрээр тус тус ундны усаа зөөвөрлөх зай ойртсон байна.

Газар тариалан эрхэлдэг өрхүүд нь дунджаар 463 метрийн зайнаас ундны усаа зөөвөрлөн хэрэглэж байна.

ХҮСНЭГТ III.11. ХӨДӨӨ АЖ АХУЙ ЭРХЭЛДЭГ ӨРХИЙН УНДНЫ УСАА ЗӨӨВӨРЛӨЖ БУЙ ДУНДАЖ ЗАЙ, улирлаар, метрээр

| | Мал аж ахуй | | Газар тариалан | |
|---|---|---|---|---|
| | 2011 | 2021 | 2011 | 2021 |
| Хавар | 1 346 | 1 230 | 439 | 475 |
| Зун | 935 | 1 009 | 376 | 440 |
| Намар | 1 198 | 1 167 | 401 | 458 |
| Өвөл | 1 436 | 1 217 | 458 | 479 |

Улирлаар авч үзвэл, газар тариалан эрхэлдэг өрх ундны усаа зундаа дунджаар 440 метр, намар дунджаар 458 метр, өвөл дунджаар 479 метр, хавар дунджаар 475 метрийн зайнаас тус тус зөөвөрлөж байна. 2011 онтой харьцуулахад өрхийн ундны усаа зөөвөрлөх дундаж зай 45 метрээр нэмэгдсэн бөгөөд улирлаар нь харвал ундны усаа зөөвөрлөх дундаж зай зун, намрын улиралд 57-64 метрээр, өвлийн улиралд 21 метрээр, хаврын улиралд 36 метрээр өрхүүдийн ундны усаа зөөвөрлөх зай холдсон байна.

Төвийн бүс, тэр дундаа говийн аймгуудад мал аж ахуй эрхэлдэг өрхийн ундны усаа зөөвөрлөж буй зай сүүлийн 10 жилд бусад бүсийнхээс өндөр хэвээр байна.

<u>Хөдөө аж ахуй эрхэлдэг өрхийн ундны усны зөөвөрлөж байгаа хэлбэр</u>

Мал аж ахуй эрхэлдэг өрхийн ундны усаа зөөвөрлөж буй хэлбэрийг авч үзвэл, мал аж ахуй эрхэлдэг нийт өрхийн 34.5 хувь нь ундны усаа явганаар, 62.3 хувь нь машин, мотоциклоор, 1.3 хувь нь ердийн хөсгөөр, үлдсэн 1.9 хувь нь дээрхээс бусад хэлбэрээр ундны усаа зөөвөрлөдөг байна. 2011 онтой харьцуулахад ундны усаа явганаар болон ердийн хөсгөөр зөөвөрлөдөг өрхийн хувь 20.9 болон 7.3 нэгж хувиар буурсан байна. Харин машин болон мотоциклоор ундны усаа зөөвөрлөдөг өрхийн хувьд 27.4 нэгж хувиар нэмэгдсэн буюу 2021 оны хувь 32.7 хувь нь машинаар, 29.7 хувь нь мотоциклоор ундны усаа зөөвөрлөдөг байна.

ХҮСНЭГТ III.12. МАЛ АЖ АХУЙ ЭРХЭЛДЭГ ӨРХИЙН УНДНЫ УСАА ЗӨӨВӨРЛӨЖ БУЙ ХЭЛБЭР, дүнд эзлэх хувиар, бүсээр

| | Бүгд | | Баруун бүс | | Хангайн бүс | | Төвийн бүс | | Зүүн бүс | | Улаанбаатар | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | 2011 | 2021 | 2011 | 2021 | 2011 | 2021 | 2011 | 2021 | 2011 | 2021 | 2011 | 2021 |
| **Бүгд** | **100.0** | **100.0** | **100.0** | **100.0** | **100.0** | **100.0** | **100.0** | **100.0** | **100.0** | **100.0** | **100.0** | **100.0** |
| Явганаар | 55.4 | 34.5 | 74.9 | 55.1 | 50.3 | 26.8 | 42.2 | 25.8 | 43.9 | 21.0 | 79.7 | 67.3 |
| Ердийн хөсгөөр | 8.6 | 1.3 | 5.7 | 1.7 | 9.4 | 1.1 | 5.9 | 1.0 | 18.5 | 1.7 | 7.9 | 1.6 |
| Машин /мотоцикл/ | 34.9 | 62.3 | 19 | 42.3 | 39.3 | 69.6 | 50.5 | 71.7 | 35.3 | 74.7 | 12.1 | 29.6 |
| Бусад | 1.1 | 1.9 | 0.4 | 0.9 | 1.0 | 2.6 | 1.4 | 1.5 | 2.3 | 2.6 | 0.3 | 1.6 |

Ундны усаа зөөвөрлөж буй хэлбэрийг бүс бүрээр авч үзвэл мал аж ахуй эрхэлдэг өрхийн хувьд Хангай (69.6 хувь), Төв (71.8 хувь) болон Зүүн (74.7 хувь) бүсийн өрхийн хувьд машин, мотоциклоор ундны усаа зөөвөрлөх нь түгээмэл байгаа бол Баруун бүс (55.1 хувь) болон Улаанбаатарт (37.3 хувь) ундны усаа ундны усаа явганаар зөөвөрлөх хэлбэр зонхилж байна. 2011 онд Төвийн (50.5 хувь) бүсийн өрхийн хувьд

машин, мотоциклоор ундны усаа зөөвөрлөж байгаа нь түгээмэл байсан бол Баруун (74.9 хувь), Хангай (50.3 хувь), Зүүн (43.9 хувь) бүсүүдэд болон Улаанбаатарт (79.7 хувь) явганаар ундны усаа зөөвөрлөх хэлбэр зонхилж байжээ.

Түүнчлэн мал аж ахуй эрхэлдэг өрхийн хувьд Улаанбаатарт (67.3 хувь) ундны усаа явганаар, Зүүн бүсэд (74.7 хувь) машин мотоциклоор зөөвөрлөдөг байхад Баруун бүсэд (1.7 хувь) ердийн хөсгөөр ундны ус зөөвөрлөж байгаа нь бусад бүсийнхтэй харьцуулахад нилээд түгээмэл байна. Харин 2011 онд мал аж ахуй эрхэлдэг өрхийн хувьд Баруун бүсэд (74.9 хувь) ундны усаа явганаар, Төвийн бүсэд (50.5 хувь) машин мотоциклоор зөөвөрлөдөг байхад Зүүн бүсэд (18.5 хувь) ердийн хөсгөөр ундны ус зөөвөрлөх нь бусад бүсийнхтэй харьцуулахад нилээд түгээмэл байсан байна.

Газар тариалан эрхэлдэг өрхийн хувьд Улаанбаатарт ундны усаа явганаар (73.9 хувь), ердийн хөсгөөр (5.5 хувь) зөөвөрлөх нь бусад бүсээс түгээмэл байсан бол Төвийн бүсэд (52.2 хувь) машин мотоциклоор ундны усаа зөөвөрлөх нь бусад бүсийнхтэй харьцуулахад нилээд түгээмэл байна.

ХҮСНЭГТ III.13. ГАЗАР ТАРИАЛАН ЭРХЭЛДЭГ ӨРХИЙН УНДНЫ УСАА ЗӨӨВӨРЛӨЖ БУЙ ХЭЛБЭР, дүнд эзлэх хувиар, бүсээр

| | Бүгд | | Баруун бүс | | Хангайн бүс | | Төвийн бүс | | Зүүн бүс | | Улаанбаатар | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | 2011 | 2021 | 2011 | 2021 | 2011 | 2021 | 2011 | 2021 | 2011 | 2021 | 2011 | 2021 |
| **Бүгд** | **100.0** | **100.0** | **100.0** | **100.0** | **100.0** | **100.0** | **100.0** | **100.0** | **100.0** | **100.0** | **100.0** | **100.0** |
| Явганаар | 85.0 | 63.8 | 88.1 | 68.8 | 76.1 | 45.3 | 85.2 | 67.9 | 82.9 | 60.8 | 96.4 | 73.9 |
| Ердийн хөсгөөр | 2.5 | 2.6 | 1.8 | 4.7 | 4.9 | 1.4 | 1.9 | 1.0 | 3.4 | 3.3 | 0.8 | 5.5 |
| Машин /мотоцикл/ | 11.7 | 32.6 | 8.2 | 26.4 | 18.3 | 52.2 | 12.4 | 30.1 | 12.7 | 34.7 | 2.5 | 19.0 |
| Бусад | 0.8 | 1.0 | 1.9 | 0.2 | 0.7 | 1.1 | 0.5 | 1.1 | 1.0 | 1.2 | 0.3 | 1.6 |

Харин 2011 онд газар тариалан эрхэлдэг өрхийн хувьд Улаанбаатар хотод (96.4 хувь) ундны усаа явганаар, Хангайн бүсэд (18.3 хувь) машин мотоциклоор зөөвөрлөдөг байхад Зүүн бүсэд (18.5 хувь) ердийн хөсгөөр ундны ус зөөвөрлөх нь бусад бүсийнхтэй харьцуулахад нилээд түгээмэл байсан байна.

## III.4. Хөдөө аж ахуйн эрхэлдэг аж ахуйн нэгж, байгууллага, түүний удирдлага

ХАА-н тооллогод хөдөө аж ахуй эрхэлдэг нийт 2545 аж ахуйн нэгж байгууллага тоологдсоноос мал аж ахуй эрхэлдэг 902 ААНБ, газар тариалан эрхэлдэг 1643 аж ахуйн нэгж, байгууллага байна.

<u>Аж ахуй нэгж, байгууллагын удирдлагын тоо, хүйсээр</u>

ХАА эрхэлдэг 2545 аж ахуйн нэгжийн удирдлагын 70.0 хувь нь эрэгтэй, 30.0 хувь нь эмэгтэй байна. Нийт ААНБ-ын удирдлагад эрэгтэйчүүдийн эзлэх хувь 10 жилийн өмнөхтэй харьцуулахад 5.6 нэгж хувиар буурсан байна.

Мал аж ахуй эрхэлдэг ААНБ-ын удирдлагын тоог хүйсээр авч үзвэл, ААНБ-ын 66.5 хувь нь эрэгтэй, үлдсэн 33.5 хувь нь эмэгтэй удирдлагатай байгаа бол газар тариалан эрхэлдэг ААНБ-ын 71.9 хувь нь эрэгтэй, 28.1 хувь нь эмэгтэй удирдлагатай байна. Нийт МАА-н салбарын ААНБ-ын эмэгтэй удирдлагуудын эзлэх хувь 5.3 нэгж

хувиар, газар тариалангийн салбарын ААНБ-ын эмэгтэй удирдлагуудын эзлэх хувь 4.9 нэгж хувиар тус тус өссөн байна.

ХҮСНЭГТ III.14. ХӨДӨӨ АЖ АХУЙ ЭРХЭЛДЭГ ААНБ-ЫН ТОО, удирдлагын хүйсээр

| | Бүгд | | Мал аж ахуй | | Газар тариалан | |
|---|---|---|---|---|---|---|
| | 2011 | 2021 | 2011 | 2021 | 2011 | 2021 |
| **ААНБ-ын тоо** | **2 212** | **2 545** | **507** | **902** | **1 705** | **1 643** |
| Эрэгтэй | 1 673 | 1 781 | 364 | 600 | 1 309 | 1 181 |
| Эмэгтэй | 539 | 764 | 143 | 302 | 396 | 462 |
| | Дунд эзлэх хувь | | | | | |
| **Бүгд** | **100.0** | **100.0** | **100.0** | **100.0** | **100.0** | **100.0** |
| Эрэгтэй | 75.6 | 70.0 | 71.8 | 66.5 | 76.8 | 71.9 |
| Эмэгтэй | 24.4 | 30.0 | 28.2 | 33.5 | 23.2 | 28.1 |

## Аж ахуй нэгж, байгууллагын удирдлагын тоо, насны бүлгээр

ХАА эрхэлдэг ААНБ-ын удирдлагыг насны бүлгээр авч үзвэл, 44.7 хувь нь 50 ба түүнээс дээш насныхан, 48.1 хувь нь 35-49 насныхан үлдсэн 7.2 хувь нь 15-34 насныхан байна. 2011 онтой харьцуулахад 50-аас дээш настай удирдлагын эзлэх хувь 6.9 нэгж хувиар, 35-49 настай удирдлагын эзлэх хувь 0.5 хувиар өссөн бол 15-34 настай удирдлагын эзлэх хувь 7.4 хувиар буурсан үзүүлэлттэй байна.

ХҮСНЭГТ III.15. ХӨДӨӨ АЖ АХУЙ ЭРХЭЛДЭГ ААНБ-ЫН ТОО, удирдлагын насны бүлгээр

| | Бүгд | | Мал аж ахуй | | Газар тариалан | |
|---|---|---|---|---|---|---|
| | 2011 | 2021 | 2011 | 2021 | 2011 | 2021 |
| **Бүгд** | **2 212** | **2 545** | **507** | **902** | **1 705** | **1 643** |
| 15-34 настай | 323 | 184 | 79 | 40 | 244 | 144 |
| 35-49 настай | 1 052 | 1 223 | 248 | 527 | 804 | 696 |
| 50-иас дээш настай | 837 | 1 138 | 180 | 335 | 657 | 803 |
| | Дунд эзлэх хувь | | | | | |
| **Бүгд** | **100.0** | **100.0** | **100.0** | **100.0** | **100.0** | **100.0** |
| 15-34 настай | 14.6 | 7.2 | 15.6 | 4.4 | 14.3 | 8.8 |
| 35-49 настай | 47.6 | 48.1 | 48.9 | 58.4 | 47.2 | 42.4 |
| 50-иас дээш настай | 37.8 | 44.7 | 35.5 | 37.1 | 38.5 | 48.9 |

МАА эрхэлдэг ААНБ-ын удирдлагыг насны бүлгээр авч үзвэл, 58.4 хувь нь 35-49 насныхан, 37.1 хувь нь 50 түүнээс дээш насныхан, үлдсэн 4.4 хувь нь 15-34 насныхан байна. 2011 онтой харьцуулахад 50-аас дээш настай удирдлагын эзлэх хувь 1.6 нэгж хувиар, 35-49 настай удирдлагын эзлэх хувь 9.5 өссөн бол 15-34 настай удирдлагын эзлэх хувь 11.1 нэгж хувиар буурсан байна.

Харин газар тариалан эрхэлдэг ААНБ-ын удирдлагыг насны бүлгээр авч үзвэл, 42.4 хувь нь 35-49 насныхан, 48.9 хувь нь 50 түүнээс дээш насныхан, үлдсэн 8.8 хувь нь 15-34 насныхан байна. 2011 онтой харьцуулахад 50-аас дээш настай удирдлагын эзлэх хувь 10.3 нэгж хувиар өссөн байхад 35-49 настай удирдлагын эзлэх хувь 4.8 нэгж хувь, 15-34 настай удирдлагын эзлэх хувь 5.5 нэгж хувиар тус тус буурсан байна.

IV БҮЛЭГ

# ХӨДӨӨ АЖ АХУЙН САЛБАРЫН АЖИЛЛАГЧИД



# IV. ХӨДӨӨ АЖ АХУЙН САЛБАРЫН АЖИЛЛАГЧИД

Хөдөө аж ахуйн салбарын ажиллах хүчний үндсэн мэдээлэл, тэдгээрт ажиллаж буй байнгын, улирлын, түр болон мэргэжлийн ажиллагчдын тоо, тэдгээрийн боловсрол, насны бүлэг, гэрлэлтийн байдал, тариалалтын болон ургац хураалтын үе дэх ажлын өдрийн үргэлжлэх хугацаа, ажиллах хүчтэй холбоотой тулгарч буй хүндрэл бэрхшээл зэрэг үзүүлэлтийг энэхүү бүлэгт танилцуулллаа. Салбарын ажиллах хүчний бүтэц бүрэлдэхүүн, ажиллах хүчинд тулгарч буй нийтлэг бэрхшээлийг нэгтгэн харуулсан нь бодлого боловсруулагчдад мэдээллийн чухал эх үүсвэр болох юм.

ХАА-н салбарт 2021 оны байдлаар нийт 457.4 мянган хүн мал аж ахуй, газар тариалангийн үйл ажиллагаанд ажилласан байна. Үүнээс 89.9 хувь нь байнгын, 10.1 хувь нь түр ажиллагч байна.

ХАА-ын салбарын өрх, аж ахуйн нэгж, байгууллагын дүнгээр 2021 онд нийтдээ 410.9 мянган байнгын ажиллагчид ажилласан бөгөөд үүний 91.6 хувь нь мал аж ахуйн үйл ажиллагаа эрхэлдэг, 8.4 хувь нь газар тариалангийн үйл ажиллагаа эрхэлдэг байна.

ЗУРАГ IV.1. ХӨДӨӨ АЖ АХУЙ САЛБАРЫН БАЙНГЫН АЖИЛЛАГЧДЫН ТОО, үйл ажиллагааны чиглэлээр, хүйсээр, мянган хүнээр




Хөдөө аж ахуйн салбарт байнгын ажиллагчдаас гадна 46.5 мянган түр ажиллагчид ажилласан байна. Үүнээс 67.5 хувь нь газар тариалангийн салбарт, 32.5 хувь нь мал аж ахуйн салбарт ажиллаж байна.

Хөдөө аж ахуйн салбарт байнгын ажиллагчдыг насны бүлгээр харахад дийлэнх нь 40-өөс дээш насны хүмүүс байна. Тухайлбал, 2011 оны тооллогын байнгын ажиллагчдын 40-өөс доош насны хүмүүсийн нийт байнгын ажиллагчид эзлэх хувь 50.1 хувь нь байсан бол 2021 оны байдлаар 40.2 хувь болж 9.9 нэгж хувиар буурсан байна.

ХҮСНЭГТ IV.1. ХӨДӨӨ АЖ АХУЙН САЛБАРЫН БАЙНГЫН АЖИЛЛАГЧДЫН ТОО, насны бүлгээр, мянган хүнээр

| | Бүгд | | Мал аж ахуй | | Газар тариалан | |
|---|---|---|---|---|---|---|
| | 2011 | 2021 | 2011 | 2021 | 2011 | 2021 |
| **Бүгд** | **400.9** | **410.9** | **342.5** | **376.3** | **58.4** | **34.7** |
| 15 ба түүнээс доош | - | 3.2 | - | 3.1 | - | 0.2 |
| 16-19 | 9.9 | 12.1 | 8.3 | 11.3 | 1.6 | 0.7 |
| 20-29 | 73.5 | 56.7 | 65.7 | 53.7 | 7.8 | 3.0 |
| 30-39 | 117.3 | 93.3 | 104.0 | 86.4 | 13.3 | 6.9 |
| 40-49 | 95.9 | 106.5 | 80.2 | 97.9 | 15.7 | 8.7 |
| 50-54 | 39.6 | 44.9 | 31.6 | 40.7 | 8.0 | 4.3 |
| 55-59 | 26.9 | 34.4 | 21.8 | 30.6 | 5.1 | 3.9 |
| 60-с дээш | 37.8 | 59.8 | 31.0 | 52.7 | 6.9 | 7.1 |
| Дунд эзлэх хувь | | | | | | |
| Бүгд | 100.0 | 100.0 | 100.0 | 100.0 | 100.0 | 100.0 |
| 15 ба түүнээс доош | - | 0.8 | - | 0.8 | - | 0.5 |
| 16-19 | 2.5 | 2.9 | 2.4 | 3.0 | 2.7 | 2.0 |
| 20-29 | 18.3 | 13.8 | 19.2 | 14.3 | 13.4 | 8.7 |
| 30-39 | 29.3 | 22.7 | 30.4 | 23.0 | 22.8 | 19.9 |
| 40-49 | 23.9 | 25.9 | 23.4 | 26.0 | 26.9 | 25.0 |
| 50-54 | 9.9 | 10.9 | 9.2 | 10.8 | 13.7 | 12.3 |
| 55-59 | 6.7 | 8.4 | 6.4 | 8.1 | 8.7 | 11.1 |
| 60-с дээш | 9.4 | 14.5 | 9.0 | 14.0 | 11.7 | 20.5 |

Байнгын ажиллагчдыг насны бүлгээр задалж үзвэл, байнгын ажиллагчдын 0.8 хувь нь 15 ба түүнээс доош насны, 2.9 хувь нь 16-19 насны, 13.8 хувь нь 20-29 насны, 22.7 хувь нь 30-39 насны, 25.9 хувь нь 40-49 насны, 10.9 хувь нь тусгай 50-54 насны, 8.4 хувь нь 55-59 насны ,9.4 хувь нь 60-с дээш насны ажиллагчид эзэлж байна.

Нийт ажиллагчдаас 83.0 хувь нь бага, суурь, бүрэн дунд боловсролтой байна.

Байнгын ажиллагчдыг боловсролын түвшингээр авч үзвэл, байнгын ажиллагчдын 2.7 хувь нь боловсролгүй, 17.3 хувь нь бага, 23.7 хувь нь суурь, 42.0 хувь нь бүрэн дунд, 3.1 хувь нь техникийн болон мэргэжлийн, 2.8 хувь нь тусгай мэргэжлийн дунд, 1.8 хувь нь дипломын дээд боловсролтой, 6.2 хувь нь бакалаврын дээд харин 2.7 хувь нь магистр, докторын зэрэгтэй ажиллагчид эзэлж байна.

Арван жилийн өмнө байнгын ажиллагчдын 4.6 хувь нь боловсролгүй, 23.1 хувь нь бага, 33.1 хувь суурь, 26.0 хувь нь бүрэн дунд, 4.7 хувь нь техникийн болон мэргэжлийн, 3.9 хувь нь тусгай мэргэжлийн дунд, 4.5 хувь нь дипломын болон бакалаврын дээд боловсролтой, харин 0.1 хувь нь магистр, докторын зэрэгтэй ажиллагчид эзэлж байсан ба нийт ажиллагчдаас 82.2 хувь нь бага, суурь, бүрэн дунд боловсролтой байсан байна.

Нийт ажиллагчдын дунд, нарийн мэргэжил эзэмшсэн техникийн болон мэргэжлийн, тусгай мэргэжлийн дунд боловсролтой ажиллагчид дөнгөж 5.9 хувийг эзэлж байгаа бөгөөд үүнийг 2011 оны дүнтэй харьцуулбал техникийн болон мэргэжлийн, тусгай мэргэжлийн дунд боловсролтой ажиллагчид 2.7 нэгж хувиар буурсан байна.

ХҮСНЭГТ IV.2. ХӨДӨӨ АЖ АХУЙН САЛБАРЫН БАЙНГЫН АЖИЛЛАГЧДЫН ТОО, боловсролын түвшингээр, мянган хүнээр

| | Бүгд | | Мал аж ахуй | | Газар тариалан | |
|---|---|---|---|---|---|---|
| | 2011 | 2021 | 2011 | 2021 | 2011 | 2021 |
| **Бүгд** | **400.9** | **410.9** | **342.5** | **376.3** | **58.4** | **34.7** |
| Боловсролгүй | 18.5 | 11.1 | 17.4 | 10.5 | 1.1 | 0.6 |
| Бага | 92.7 | 71.1 | 87.9 | 69.3 | 4.8 | 1.8 |
| Суурь | 132.6 | 97.3 | 120.1 | 92.3 | 12.5 | 5.0 |
| Бүрэн дунд | 104.3 | 172.8 | 83.3 | 157.6 | 21.0 | 15.2 |
| Техникийн болон мэргэжлийн | 18.9 | 12.7 | 13.2 | 10.2 | 5.7 | 2.5 |
| Тусгай мэргэжлийн дунд | 15.4 | 11.5 | 10.2 | 9.2 | 5.2 | 2.3 |
| Дипломын дээд | 17.9 | 7.3 | 10.1 | 5.8 | 7.8 | 1.5 |
| Бакалаврын дээд | - | 25.5 | - | 20.3 | - | 5.2 |
| Магистр | 0.6 | 1.1 | 0.3 | 0.8 | 0.3 | 0.3 |
| Доктор | | 0.6 | | 0.3 | | 0.2 |
| | Дунд эзлэх хувь | | | | | |
| Бүгд | 100.0 | 100.0 | 100.0 | 100.0 | 100.0 | 100.0 |
| Боловсролгүй | 4.6 | 2.7 | 5.1 | 2.8 | 1.9 | 1.8 |
| Бага | 23.1 | 17.3 | 25.7 | 18.4 | 8.2 | 5.2 |
| Суурь | 33.1 | 23.7 | 35.1 | 24.5 | 21.4 | 14.4 |
| Бүрэн дунд | 26.0 | 42.0 | 24.3 | 41.9 | 36.0 | 43.8 |
| Техникийн болон мэргэжлийн | 4.7 | 3.1 | 3.9 | 2.7 | 9.8 | 7.2 |
| Тусгай мэргэжлийн дунд | 3.8 | 2.8 | 3.0 | 2.5 | 8.9 | 6.5 |
| Дипломын дээд | 4.5 | 1.8 | 2.9 | 1.5 | 13.4 | 4.4 |
| Бакалаврын дээд | - | 6.2 | - | 5.4 | - | 15.0 |
| Магистр | 0.1 | 0.3 | 0.1 | 0.2 | 0.5 | 0.9 |
| Доктор | | 0.1 | | 0.1 | | 0.7 |

## IV.1. МАЛ АЖ АХУЙН САЛБАРЫН АЖИЛЛАГЧИД

Тооллогоор мал аж ахуйн салбарт нийт 391.4 мянган хүн бүртгэгдсэнээс, 376.3 мянган байнгын ажиллагч бүртгэгдсэн нь 2011 оны тооллоготой харьцуулахад 33.8 мянган хүнээр буюу 9.9 хувиар буурсан байна. Энэ салбарт нийт 15.1 мянган түр ажиллагчид ажилласны 14.8 мянга нь өрхөд, 0.3 мянга нь аж ахуйн нэгж, байгууллагад ажиллажээ.

ЗУРАГ IV.2. МАЛ АЖ АХУЙН САЛБАРЫН АЖИЛЛАГЧИД, мянган хүнээр



### IV.1.1. МАА-н салбарын байнгын ажиллагчид, хүйсээр

Арван жилийн өмнө өрхөд ажилласан байнгын ажиллагчдын 56.0 хувь нь эрэгтэй, 44.0 хувь нь эмэгтэй, аж ахуйн нэгж, байгууллагад ажилласан байнгын ажиллагчдын 61.3 хувь нь эрэгтэй, 38.7 хувь нь эмэгтэй ажиллагчид байсан бол 2021 онд өрхийн байнгын ажиллагчдын 60.0 хувь нь эрэгтэй, 40.0 хувь нь эмэгтэй, аж ахуйн нэгж, байгууллагын байнгын ажиллагчдын 52.4 хувь нь эрэгтэй, 47.6 хувь нь эмэгтэй ажиллагчид байна. Сүүлийн 10 жилд эмэгтэй ажиллагчдын эзлэх хувь 4.0 нэгж хувиар буурсан байна.

ХҮСНЭГТ IV.3. МАЛ АЖ АХУЙН САЛБАРЫН БАЙНГЫН АЖИЛЛАГЧИД, өрх, аж ахуйн нэгж, байгууллага, хүйсээр, мянган хүн

| | Бүгд | | Өрх | | ААНБ | |
|---|---|---|---|---|---|---|
| | 2011 | 2021 | 2011 | 2021 | 2011 | 2021 |
| **Бүгд** | 342.5 | 376.3 | 340.2 | 373.0 | 2.3 | 3.3 |
| Эрэгтэй | 191.9 | 225.8 | 190.5 | 224.1 | 1.4 | 1.7 |
| Эмэгтэй | 150.6 | 150.5 | 149.7 | 148.9 | 0.9 | 1.6 |
| Дунд эзлэх хувь | | | | | | |
| Бүгд | 100.0 | 100.0 | 100.0 | 100.0 | 100.0 | 100.0 |
| Эрэгтэй | 56.0 | 60.0 | 56.0 | 60.1 | 61.3 | 52.4 |
| Эмэгтэй | 44.0 | 40.0 | 44.0 | 39.9 | 38.7 | 47.6 |

### IV.1.2. МАА-н салбарын байнгын ажиллагчид, бүсээр

Бүсээр авч үзвэл, 2011 онд байнгын ажиллагчдын хувьд өрхийн байнгын ажиллагчдын 39.7 хувь нь Хангайн бүсэд төвлөрч, аж ахуйн нэгж, байгууллагын 33.9 хувь нь Төвийн бүсэд ногдож байсан бол 2021 онд өрхийн байнгын ажиллагчдын 36.4 хувь нь, аж ахуйн нэгж, байгууллагын хувьд 36.0 хувь нь мал аж ахуйн салбарын голлох бүс болох Хангайн бүсэд төвлөрч байна. Түүнчлэн аж ахуйн нэгж байгууллагын байнгын ажилчдыг бүсээр авч үзвэл Баруун бүсийн нэг аж ахуйн нэгж, байгууллага тутамд дунджаар 2 ажиллагчид, Төвийн бүсэд 2, Улаанбаатарт 3, Зүүн бүсэд 5, Хангайн бүсэд 5 ажиллагч ногдож байна.

ХҮСНЭГТ IV.4. МАЛ АЖ АХУЙН САЛБАРЫН БАЙНГЫН АЖИЛЛАГЧИД, өрх, аж ахуйн нэгж, байгууллага, бүсээр, мянган хүнээр

| | Бүгд | | Өрх | | ААНБ | |
|---|---|---|---|---|---|---|
| | 2011 | 2021 | 2011 | 2021 | 2011 | 2021 |
| Бүгд | 342.5 | 376.3 | 340.2 | 373.0 | 2.3 | 3.3 |
| Баруун бүс | 92.1 | 105.7 | 91.6 | 105.5 | 0.5 | 0.1 |
| Хангайн бүс | 135.2 | 137.0 | 134.9 | 135.8 | 0.3 | 1.2 |
| Төв бүс | 68.8 | 79.5 | 68.0 | 78.8 | 0.8 | 0.7 |
| Зүүн бүс | 39.9 | 46.2 | 39.5 | 45.1 | 0.4 | 1.1 |
| Улаанбаатар | 6.5 | 7.9 | 6.1 | 7.8 | 0.4 | 0.2 |
| Дунд эзлэх хувиар | | | | | | |
| Бүгд | 100.0 | 100.0 | 100.0 | 100.0 | 100.0 | 100.0 |
| Баруун бүс | 26.9 | 28.1 | 26.9 | 28.3 | 22.1 | 4.5 |
| Хангайн бүс | 39.5 | 36.4 | 39.7 | 36.4 | 11.8 | 36.0 |
| Төв бүс | 20.1 | 21.1 | 20.0 | 21.1 | 33.9 | 22.3 |
| Зүүн бүс | 11.6 | 12.3 | 11.6 | 12.1 | 17.0 | 32.6 |
| Улаанбаатар | 1.9 | 2.1 | 1.8 | 2.1 | 15.3 | 4.6 |

### IV.1.3. МАА-н салбарын байнгын ажиллагчид, насны бүлгээр

30-49 насны иргэд энэ салбарт түлхүү ажиллаж, өрхөд ажиллагчдын 48.9 хувийг, аж ахуйн нэгж, байгууллагад ажиллагчдын 61.7 хувийг эзэлж байна. Энэ нь нийт дүнгээрээ арван жилийн өмнөх үеэс 4.9 хувиар буурсан үзүүлэлттэй байна.

ХҮСНЭГТ IV.5. МАЛ АЖ АХУЙН САЛБАРЫН БАЙНГЫН АЖИЛЛАГЧИД, насны бүлгээр

| | Бүгд | | Өрх | | ААНБ | |
|---|---|---|---|---|---|---|
| | 2011 | 2021 | 2011 | 2021 | 2011 | 2021 |
| **Бүгд** | **342 466** | **376 268** | **340 156** | **372 957** | **2 310** | **3 311** |
| 15 ба түүнээс доош | - | 2 953 | - | 2 953 | - | - |
| 15-19 | 8 349 | 11 449 | 8 308 | 11 325 | 41 | 124 |
| 20-29 | 65 683 | 53 691 | 65 241 | 53 039 | 442 | 652 |
| 30-39 | 103 995 | 86 402 | 103 225 | 85 287 | 770 | 1 115 |
| 40-49 | 80 157 | 97 863 | 79 500 | 96 936 | 657 | 927 |
| 50-54 | 31 555 | 40 653 | 31 331 | 40 381 | 224 | 272 |
| 55-59 | 21 769 | 30 593 | 21 658 | 30 476 | 111 | 117 |
| 60+ | 30 958 | 52 664 | 30 893 | 52 560 | 65 | 104 |
| Дүнд эзлэх хувиар | | | | | | |
| Бүгд | 100.0 | 100.0 | 100.0 | 100.0 | 100.0 | 100.0 |
| 15 ба түүнээс доош | - | 0.8 | - | 0.8 | - | - |
| 15-19 | 2.4 | 3.0 | 2.4 | 3.0 | 1.8 | 3.7 |
| 20-29 | 19.2 | 14.3 | 19.2 | 14.2 | 19.1 | 19.7 |
| 30-39 | 30.4 | 23.0 | 30.3 | 22.9 | 33.3 | 33.7 |
| 40-49 | 23.4 | 26.0 | 23.4 | 26.0 | 28.4 | 28.0 |
| 50-54 | 9.2 | 10.8 | 9.2 | 10.8 | 9.7 | 8.2 |
| 55-59 | 6.4 | 8.1 | 6.4 | 8.2 | 4.8 | 3.5 |
| 60+ | 9.0 | 14.0 | 9.1 | 14.1 | 2.8 | 3.1 |

Өрх болон аж ахуйн нэгж, байгууллагад ажиллаж буй нийт эрэгтэй ажиллагчдаас 30-49 насны эрэгтэй ажиллагчид 49.0 хувийг, нийт эмэгтэй ажиллагчдад 30-49 насны эмэгтэй ажиллагчид 48.9 хувийг эзэлж байна.

### IV.1.4. МАА-н салбарын байнгын ажиллагчид, гэрлэлтийн байдлаар

Ажиллагчдын гэрлэлтийн байдлыг огт гэрлээгүй, гэрлэсэн (батлуулсан), гэрлэсэн (батлуулаагүй), тусгаарласан болон цуцалсан, бэлэвсэн гэсэн төрлөөр ангилан нэгтгэж, үр дүнг нэгтгэсэн.

Гэрлэлтийн байдлаар харахад байнгын нийт ажиллагчдын 75.5 хувь нь гэрлэсэн(батлуулсан) бөгөөд үүнээс 61.9 хувь нь эрэгтэйчүүд, 38.1 хувь нь эмэгтэйчүүд байна.

ХҮСНЭГТ IV.6. МАЛ АЖ АХУЙН САЛБАРЫН БАЙНГЫН АЖИЛЛАГЧИД, гэрлэлтийн байдлаар, хүйсээр

| | Бүгд | | Эрэгтэй | | Эмэгтэй | |
|---|---|---|---|---|---|---|
| | 2011 | 2021 | 2011 | 2021 | 2011 | 2021 |
| Бүгд | 340 157 | 376 268 | 190 461 | 225 809 | 149 696 | 150 459 |
| Огт гэрлээгүй | 46 217 | 46 646 | 32 625 | 21 887 | 13 592 | 24 759 |
| Гэрлэсэн, батлуулсан | 265 594 | 284 241 | 147 234 | 175 887 | 118 360 | 108 355 |
| Гэрлэсэн,батлуулаагүй | | 21 520 | | 13 545 | | 7 975 |
| Тусгаарласан | 7 035 | 2 731 | 4 328 | 1 686 | 2 707 | 1 045 |
| Цуцалсан | - | 2 841 | - | 1 759 | - | 1 081 |
| Бэлэвсэн | 21 311 | 18 290 | 6 274 | 11 045 | 15 037 | 7 244 |

| | Бүгд | | Эрэгтэй | | Эмэгтэй | |
|---|---|---|---|---|---|---|
| | 2011 | 2021 | 2011 | 2021 | 2011 | 2021 |
| | Дүнд эзлэх хувиар | | | | | |
| Бүгд | 100.0 | 100.0 | 100.0 | 100.0 | 100.0 | 100.0 |
| Огт гэрлээгүй | 13.6 | 12.4 | 17.1 | 9.7 | 9.1 | 16.5 |
| Гэрлэсэн, батлуулсан | 78.1 | 75.5 | 77.3 | 77.9 | 79.1 | 72.0 |
| Гэрлэсэн,батлуулаагүй | | 5.7 | | 6.0 | | 5.3 |
| Тусгаарласан | 2.1 | 0.7 | 2.3 | 0.7 | 1.8 | 0.7 |
| Цуцалсан | - | 0.8 | - | 0.8 | - | 0.7 |
| Бэлэвсэн | 6.3 | 4.9 | 3.3 | 4.9 | 10.0 | 4.8 |

Харин нийт ажиллагчдын 5.7 хувь нь гэрлэсэн(батлуулаагүй) бөгөөд үүнээс 62.9 хувь нь эрэгтэйчүүд, 37.1 хувь нь эмэгтэйчүүд байна. Нийт ажиллагчдын 12.4 хувь нь гэрлээгүй бөгөөд үүнээс 46.9 хувь нь эрэгтэйчүүд, 53.1 хувь нь эмэгтэйчүүд, нийт ажиллагчдын 0.7 хувь нь тусгаарласан, үүнээс 61.5 хувь нь эрэгтэйчүүд, 38.3 хувь эмэгтэйчүүд, мөн нийт ажиллагчдын 4.9 хувь нь бэлэвсэн ба үүнээс 60.4 хувь нь эрэгтэйчүүд, 39.6 хувь нь эмэгтэйчүүд байна.

### IV.1.5. Мал аж ахуйн салбарын байнгын ажиллагчид, боловсролын түвшнээр, бүсээр

Байнгын ажиллагчдын тоог боловсролын түвшингээр нь боловсролгүй бага боловсролтой, суурь боловсролтой, бүрэн дунд боловсролтой, техникийн болон мэргэжлийн боловсролтой, тусгай мэргэжлийн дунд боловсролтой, дээд боловсролтой /диплом, бакалавр, магистр, доктор ба түүнээс дээш/ гэсэн төрлүүдээр нэгтгэсэн.

2011 оны тооллогод мал аж ахуйн салбарын байнгын ажиллагчдын 35.1 хувь нь суурь боловсролтой, 25.6 хувь нь бага, 24.3 хувь нь бүрэн дунд, 5.1 хувь нь боловсролгүй, 3.9 хувь нь техникийн болон мэргэжлийн, 3.0 хувь нь тусгай мэргэжлийн дунд үлдсэн 3.0 хувь нь дээд, магистр, докторын зэрэгтэй ажиллагчид байсан бол 2021 оны тооллогын дүнгээр 24.5 хувь нь суурь боловсролтой, 18.4 хувь нь бага, 41.9 хувь нь бүрэн дунд, 2.8 хувь нь боловсролгүй, 2.7 хувь нь техникийн болон мэргэжлийн, 2.5 хувь нь тусгай мэргэжлийн дунд дээд, 0.1 хувь нь магистр, докторын үлдсэн 2.4 хувь нь зэрэгтэй ажиллагчид байна.

ХҮСНЭГТ IV.7. МАЛ АЖ АХУЙН САЛБАРЫН БАЙНГЫН АЖИЛЛАГЧИД, дүнд эзлэх хувиар, боловсролын түвшнээр, бүсээр

| | Бүгд | | Баруун бүс | | Хангайн бүс | | Төвийн бүс | | Зүүн бүс | | Улаанбаатар | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | 2011 | 2021 | 2011 | 2021 | 2011 | 2021 | 2011 | 2021 | 2011 | 2021 | 2011 | 2021 |
| Бүгд | 100.0 | 100.0 | 100.0 | 100.0 | 100.0 | 100.0 | 100.0 | 100.0 | 100.0 | 100.0 | 100.0 | 100.0 |
| Боловсролгүй | 5.1 | 2.8 | 5.8 | 3.2 | 4.8 | 2.7 | 4.1 | 2.5 | 6.6 | 3.0 | 1.6 | 1.6 |
| Бага | 25.7 | 18.4 | 27.2 | 19.3 | 27.8 | 20.1 | 22.2 | 16.3 | 23.1 | 16.9 | 11.4 | 8.3 |
| Суурь | 35.1 | 24.5 | 33.0 | 22.3 | 36.0 | 24.9 | 35.2 | 26.1 | 38.1 | 27.2 | 24.1 | 16.8 |
| Бүрэн дунд | 24.3 | 41.9 | 23.8 | 43.6 | 23.9 | 41.7 | 26.1 | 40.7 | 21.1 | 38.2 | 40.8 | 54.6 |
| Техникийн болон мэргэжлийн дунд | 3.9 | 2.7 | 4.1 | 2.4 | 2.9 | 2.4 | 4.9 | 3.5 | 4.6 | 3.1 | 4.5 | 3.3 |
| Тусгай мэргэжлийн дунд | 3.0 | 2.5 | 3.1 | 2.1 | 2.1 | 2.1 | 4.0 | 3.2 | 3.2 | 3.0 | 8.6 | 3.5 |
| Дипломын дээд | 2.9 | 1.5 | 2.8 | 1.4 | 2.4 | 1.3 | 3.5 | 1.8 | 3.1 | 1.8 | 8.7 | 2.8 |

| | Бүгд | | Баруун бүс | | Хангайн бүс | | Төвийн бүс | | Зүүн бүс | | Улаанбаатар | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | 2011 | 2021 | 2011 | 2021 | 2011 | 2021 | 2011 | 2021 | 2011 | 2021 | 2011 | 2021 |
| Бакалаврын дээд | | 5.4 | | 5.6 | | 4.7 | | 5.6 | | 6.2 | | 8.5 |
| Магистр | 0.1 | 0.2 | 0.1 | 0.2 | 0.1 | 0.1 | 0.1 | 0.2 | 0.1 | 0.4 | 0.3 | 0.4 |
| Доктор | | 0.1 | | 0.0 | | 0.1 | | 0.1 | | 0.2 | | 0.2 |

Тооллогын дүнгээр мал аж ахуйн салбарт ажиллагчдын 78.8 хувь нь буюу дийлэнх суурь боловсролоос дээш боловсролтой харагдаж байгаа бол арван жилийн өмнө 69.3 хувь нь буюу дийлэнх суурь боловсролоос дээш боловсролтой байсан дүнтэй байна.

### IV.1.6. Мал аж ахуйн салбарт ажиллаж байгаа мэргэжлийн ажиллагчид

МАА-н салбарын ажиллагчдад мэргэжлийн ажиллагчдын тоог тодорхойлох зорилгоор малын эмч, малын бага эмч, хүнсний технологи, био технологи, зоо инженерийн технологи, мал зүйч, мэргэшсэн фермерийн аж ахуйч, тэжээл бэлчээр судлаач, агрономич, мэргэжилгүй болон бусад мэргэжлийн гэсэн төрлөөр авч үзлээ.

Улсын хэмжээнд 2011 онд мал аж ахуйн салбарт 4.9 мянган мэргэжлийн ажиллагчид ажилласан ба үүний 4.7 мянга буюу 95.9 хувь нь өрхөд, 0.2 мянга буюу 4.1 хувь нь аж ахуйн нэгж, байгууллага ажилласан байна. Харин 2021 онд улсын хэмжээнд мал аж ахуйн салбарт 7.8 мянган мэргэжлийн ажиллагчид ажилласан ба үүний 6.2 мянга буюу 78.7 хувь нь өрхөд, 1.7 мянга буюу 21.3 хувь нь аж ахуйн нэгж, байгууллага ажилласан байна.

ХҮСНЭГТ IV.8. МАЛ АЖ АХУЙН САЛБАРЫН МЭРГЭЖЛИЙН АЖИЛЛАГЧИД, мэргэжлийн чиглэлээр

| | Бүгд | | Өрх | | ААНБ | |
|---|---|---|---|---|---|---|
| | 2011 | 2021 | 2011 | 2021 | 2011 | 2021 |
| **Бүгд** | **4 881** | **7 848** | **4 679** | **6 173** | **202** | **1 675** |
| Малын эмч | 438 | 4 080 | 397 | 3 983 | 41 | 97 |
| Малын бага эмч | - | 65 | - | 28 | - | 37 |
| Хүнсний технологи | - | 29 | - | 12 | - | 17 |
| Био технологич | - | 2 | - | 2 | - | - |
| Зоо инженерийн технологи | - | 79 | - | 10 | - | 69 |
| Мал зүйч | 416 | 118 | 365 | 59 | 51 | 59 |
| Мал аж ахуйн фермерийн аж ахуй эрхлэгч | 317 | 17 | 293 | 3 | 24 | 14 |
| Тэжээл бэлчээр судлаач | - | 7 | - | 5 | - | 2 |
| Агрономич | - | 17 | - | 8 | - | 9 |
| Бусад | 3 710 | 3 435 | 3 624 | 2 064 | 86 | 1 371 |
| Дүнд эзлэх хувиар | | | | | | |
| Бүгд | 100.0 | 100.0 | 100.0 | 100.0 | 100.0 | 100.0 |
| Малын эмч | 9.0 | 52.0 | 8.5 | 64.5 | 20.3 | 5.8 |
| Малын бага эмч | - | 0.8 | - | 0.5 | - | 2.2 |
| Хүнсний технологи | - | 0.4 | - | 0.2 | - | 1.0 |
| Био технологич | - | - | - | 0.03 | - | - |
| Зоо инженерийн технологи | - | 1.0 | - | 0.2 | - | 4.1 |
| Мал зүйч | 8.5 | 1.5 | 7.8 | 1.0 | 25.2 | 3.5 |
| Мал аж ахуйн фермерийн аж ахуй эрхлэгч | 6.5 | 0.2 | 6.3 | 0.05 | 11.9 | 0.8 |
| Тэжээл бэлчээр судлаач | - | 0.1 | - | 0.1 | - | 0.1 |
| Агрономич | - | 0.2 | - | 0.1 | - | 0.5 |
| Бусад | 76.0 | 43.8 | 77.5 | 33.4 | 42.6 | 81.9 |

Өмнөх тооллогын хандлагаар мэргэжлийн ажиллагч дотор МАА-н салбарын мэргэжлийн ажиллагчдын тоо харьцангуй бага байсан бол 2021 оны байдлаар малын эмчийн тоо 9.3 дахин нэмэгдсэн байна.

Улсын Их Хурлаас 2017 оны 12 сарын 08 ны өдөр "Малын эрүүл мэндийн тухай хууль" батлагдсантай холбогдон Мал эмнэлгийн үйлчилгээний нэгж, мал эмнэлгийн тасаг, орон нутагт хариуцсан мэргэжилтэнтэй болсон нь орон нутагт малын эмч, салбарын ажилчдыг орон нутагт ажиллах тоог нэмэгдүүлсэн байна. Гэвч мал зүйч, мал аж ахуйн фермерийн аж ахуйн эрхлэгчдийн тоо сүүлийн 10 жилд буурсан байна.

ААНБ-д малын эмч, малын бага эмч, мал зүйч мэргэжлийн ажиллагчид 5.3 хувийг эзэлж байна. Мал зүйч, малын эмч, мэргэшсэн фермерийн аж ахуйч мэргэжилтэй ажиллагчдад эрэгтэй ажиллагчид 50-иас дээш хувийг эзэлж байна.

### IV.1.7. Мал аж ахуйн салбарын ажиллагчдын ажлын өдрийн үргэлжлэх дундаж хугацаа

Байнгын болон түр ажиллагчдын ажлын өдрийн үргэлжлэх дундаж хугацаа дөрвөн улиралд 5 -11 цагийн хооронд үргэлжилдэг байна.

ХҮСНЭГТ IV.9 МАЛ АЖ АХУЙН САЛБАРЫН АЖИЛЛАГЧДЫН АЖЛЫН ӨДРИЙН ҮРГЭЛЖЛЭХ ХУГАЦАА, улирлаар, цагаар

| | Хавар | | Зун | | Намар | | Өвөл | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | 2011 | 2021 | 2011 | 2021 | 2011 | 2021 | 2011 | 2021 |
| | | | | Өрх | | | | |
| Байнгын | 11.0 | 9.7 | 11.0 | 9.6 | 10.0 | 9.1 | 8.0 | 8.3 |
| Түр | 9.0 | 9.0 | 9.0 | 9.0 | 6.0 | 8.4 | 6.0 | 7.8 |
| | | | | Аж ахуйн нэгж, байгууллага | | | | |
| Байнгын | 10.0 | 8.8 | 10.0 | 9.1 | 9.0 | 9.0 | 8.0 | 8.3 |
| Түр | 8.0 | 8.2 | 7.0 | 8.4 | 7.0 | 8.2 | 6.0 | 7.7 |

МАА-н салбарын байнгын ажиллагчид

- Хаврын улиралд ажилладаг дундаж хугацааг авч үзэхэд, байнгын ажиллагчид өрхөд 9.7 цаг, ААНБ-д 8.8 цаг, түр ажиллагчдын ажлын үргэлжлэх дундаж хугацаа 8-9 цаг;
- Зуны ажлын үргэлжлэх хугацааг авч үзэхэд, байнгын ажиллагчид өрхөд 9.6 цаг, ААНБ-д 9.1 цаг, түр ажиллагчдын ажлын үргэлжлэх дундаж хугацаа 8-9 цаг;
- Намрын ажлын үргэлжлэх хугацааг авч үзэхэд, байнгын ажиллагчдынх 9 цаг, түр ажиллагчдын ажлын үргэлжлэх дундаж хугацаа 8.3 цаг;
- Өвлийн ажлын үргэлжлэх хугацааг авч үзэхэд, байнгын ажиллагчдынх 8.3 цаг, түр ажиллагчдын ажлын үргэлжлэх дундаж хугацаа 7.7 цаг байна.

### IV.1.8. Мал аж ахуйн салбарын түр ажиллагчид

Тооллогын үр дүнгээр нийт 15.1 мянган түр ажиллагчид мал аж ахуйн салбарт ажилласан бөгөөд үүнээс 14.8 мянга буюу 97.9 хувь нь өрхөд, 0.3 мянга буюу 2.1 хувь нь аж ахуйн нэгж, байгууллагад ажилласан байна.

ХҮСНЭГТ IV.10. МАЛ АЖ АХУЙН САЛБАРЫН ТҮР АЖИЛЛАГЧИД, бүсээр

| | Бүгд | | Өрх | | ААНБ | |
|---|---|---|---|---|---|---|
| | 2011 | 2021 | 2011 | 2021 | 2011 | 2021 |
| **Бүгд** | **17 182** | **15 113** | **16 823** | **14 795** | **359** | **318** |
| Баруун бүс | 3 830 | 3 006 | 3 716 | 2 995 | 114 | 11 |
| Хангайн бүс | 4 414 | 4 667 | 4 383 | 4 597 | 31 | 70 |
| Төвийн бүс | 5 446 | 4 227 | 5 335 | 4 106 | 111 | 121 |
| Зүүн бүс | 3 169 | 2 963 | 3 136 | 2 867 | 33 | 96 |
| Улаанбаатар | 323 | 250 | 253 | 230 | 70 | 20 |

ХАА-н тооллогод хамрагдсан мал аж ахуй эрхэлдэг нийт өрхийн 3.7 мянган өрх буюу 1.5 хувь нь, аж ахуйн нэгж, байгууллагын 76 буюу 8.4 хувь нь түр ажиллагчид авч ажиллуулсан байна. Мал аж ахуйн үйлдвэрлэлийн салбарын түр ажиллагчид Баруун болон Хангайн бүсэд дийлэнх нь буюу 55.6 хувь нь ажилласан байна.

## IV.1.9. Мал аж ахуйн салбарын ажиллах хүчтэй холбоотой хүндрэл бэрхшээл

МАА-н салбарын ажиллах хүчтэй холбоотой гарч буй хүндрэл бэрхшээлийг 7 төрөлд ангилан авч үзсэн. Хариулагч олон сонголттойгоор хариулсан тул хамгийн их тулгардаг 3 хүртэлх хүндрэл бэрхшээлийг сонгосон. Үр дүнд бэрхшээлтэй гэж хариулсан өрхийн хувьд ажиллах хүч дутагдалтай гэж 69.8 хувь нь, тухайн орон нутагт ажиллах хүч олоход хүндрэлтэй 48.0 хувь нь, өндөр цалин хөлс шаарддаг 34.4 хувь нь, ажлын хариуцлага сул гэж 31.8 хувь нь хариулжээ. Харин ААНБ-ын хувьд ажиллах хүч дутагдалтай гэж 49.1 хувь, тухайн орон нутгаас ажиллах хүч олоход хүндрэлтэй гэж 31.3 хувь, мэргэжлийн ажиллах хүч дутагдалтай гэж 22.3 хувь нь хариулсан байна.

Үндсэндээ ажиллах хүчний хамгийн тулгамдаж буй бэрхшээл нь МАА эрхлэхэд ажиллах хүч олддоггүй гэсэн байна.

ЗУРАГ IV.3. МАЛ АЖ АХУЙН САЛБАРТ АЖИЛЛАХ ХҮЧТЭЙ ХОЛБООТОЙ ХҮНДРЭЛ, БЭРХШЭЭЛ, хувиар



## IV.2. ГАЗАР ТАРИАЛАНГИЙН САЛБАРЫН АЖИЛЛАГЧИД

Тооллогоор 2021 онд газар тариалангийн салбарт нийт 66.0 мянган ажиллагч үйл ажиллагаа эрхэлснээс 52.5 хувь нь байнгын ажиллагч, 47.5 хувь нь түр ажиллагчид байна. Харин нийт газар тариалангийн салбарын ажиллагчдын 76.7 хувийг өрхийн аж ахуй эрхэлсэн тариаланчид, 23.3 хувийг аж ахуйн нэгж байгууллагын ажиллагчид эзэлж байна.

ЗУРАГ IV.4. ГАЗАР ТАРИАЛАНГИЙН САЛБАРЫН АЖИЛЛАГЧИД, мянган хүнээр




### IV.2.1. Газар тариалангийн салбарын байнгын ажиллагчид, хүйсээр

Газар тариалангийн салбарын байнгын ажиллагчдыг хүйсээр авч үзэхэд, өрхөд ажилласан байнгын ажиллагчдын 58.8 хувь нь эрэгтэй, 41.2 хувь нь эмэгтэй байгаа бол аж ахуйн нэгж, байгууллагад ажилласан байнгын ажиллагчдын 61.3 хувь нь эрэгтэй, 38.7 хувь нь эмэгтэй ажиллагчид байна.

ХҮСНЭГТ IV.11. ГАЗАР ТАРИАЛАНГИЙН САЛБАРЫН БАЙНГЫН АЖИЛЛАГЧИД, өрх, аж ахуйн нэгж, байгууллага, хүйсээр, мянган хүнээр

| | Бүгд | | Өрх | | ААНБ | |
|---|---|---|---|---|---|---|
| | 2011 | 2021 | 2011 | 2021 | 2011 | 2021 |
| **Бүгд** | **58.4** | **34.7** | **50.9** | **27.7** | **7.5** | **6.9** |
| Эрэгтэй | 33.1 | 20.5 | 28.1 | 16.3 | 5.0 | 4.2 |
| Эмэгтэй | 25.4 | 14.1 | 22.8 | 11.4 | 2.6 | 2.7 |
| | | | Дунд эзлэх хувь | | | |
| Бүгд | 100.0 | 100.0 | 100.0 | 100.0 | 100.0 | 100.0 |
| Эрэгтэй | 56.6 | 59.3 | 55.2 | 58.8 | 66.1 | 61.3 |
| Эмэгтэй | 43.4 | 40.7 | 44.8 | 41.2 | 33.9 | 38.7 |

### IV.2.2. Газар тариалангийн салбарын байнгын ажиллагчид, бүсээр

Бүсээр авч үзвэл, Төвийн бүсэд газар тариалангийн салбарын өрхийн ажиллагчдын 38.3 хувь, ААНБ-ын ажиллагчдын 44.9 хувь нь ажиллаж байна. 2011 оны газар тариалангийн ажилчдын 24.0 хувь нь Хангайн бүсэд ногдож байсан бол 10 жилийн

дараа 4.7 нэгж хувиар буурч, 19.3 хувь нь ажиллаж байна. Баруун бүсийн ажиллагчид 3.3 нэгж хувиар, Зүүн бүсийн ажиллагчид 2.6 хувиар тус тус өсжээ.

ХҮСНЭГТ IV.12. ГАЗАР ТАРИАЛАНГИЙН САЛБАРЫН БАЙНГЫН АЖИЛЛАГЧИД, өрх, аж ахуйн нэгж, байгууллага, бүсээр, мянган хүнээр

| | Бүгд | | Өрх | | ААНБ | |
|---|---|---|---|---|---|---|
| | 2011 | 2021 | 2011 | 2021 | 2011 | 2021 |
| Бүгд | 58.4 | 34.7 | 50.9 | 27.7 | 7.5 | 6.9 |
| Баруун бүс | 9.5 | 6.8 | 8.0 | 5.7 | 1.5 | 1.2 |
| Хангайн бүс | 14.0 | 6.7 | 12.3 | 5.3 | 1.7 | 1.4 |
| Төв бүс | 23.0 | 13.7 | 19.5 | 10.6 | 3.5 | 3.1 |
| Зүүн бүс | 4.4 | 3.5 | 4.1 | 2.5 | 0.3 | 0.9 |
| Улаанбаатар | 7.6 | 4.0 | 7.0 | 3.6 | 0.6 | 0.4 |
| Дүнд эзлэх хувиар | | | | | | |
| Бүгд | 100.0 | 100.0 | 100.0 | 100.0 | 100.0 | 100.0 |
| Баруун бүс | 16.3 | 19.6 | 15.7 | 20.6 | 20.0 | 17.4 |
| Хангайн бүс | 24.0 | 19.3 | 24.2 | 19.1 | 22.7 | 20.3 |
| Төв бүс | 39.4 | 39.5 | 38.3 | 38.3 | 46.7 | 44.9 |
| Зүүн бүс | 7.5 | 10.1 | 8.1 | 9.0 | 4.0 | 13.0 |
| Улаанбаатар | 13.0 | 11.5 | 13.8 | 13.0 | 8.0 | 5.8 |

### IV.2.3. Газар тариалангийн салбарын байнгын ажиллагчид, насны бүлгээр

Газар тариалангийн салбарын байнгын ажиллагчдын тоог насны бүлгээр авч үзвэл, 30-49 насны иргэд энэ салбарт түлхүү ажиллаж, өрхөд ажиллагчдын 40.0 хувийг, аж ахуйн нэгж, байгууллагад ажиллагчдын 64.1 хувийг эзэлж байна. Арван жилийн өмнө 30-49 насны иргэд 48.2 хувийг, аж ахуйн нэгж, байгууллагад ажиллагчдын 60.4 хувийг эзэлж байсан байна.

ХҮСНЭГТ IV.13. ГАЗАР ТАРИАЛАНГИЙН САЛБАРЫН БАЙНГЫН АЖИЛЛАГЧИД, насны бүлгээр

| | Бүгд | | Өрх | | ААНБ | |
|---|---|---|---|---|---|---|
| | 2011 | 2021 | 2011 | 2021 | 2011 | 2021 |
| **Бүгд** | **58 447** | **34 662** | **50 915** | **27 732** | **7 532** | **6 930** |
| 15 ба түүнээс доош | - | 186 | - | 167 | - | 19 |
| 15-19 | 1 573 | 708 | 1 473 | 674 | 100 | 34 |
| 20-29 | 7 822 | 3 001 | 6 406 | 1 983 | 1 416 | 1 018 |
| 30-39 | 13 345 | 6 881 | 11 009 | 4 515 | 2 336 | 2 366 |
| 40-49 | 15 735 | 8 665 | 13 520 | 6 589 | 2 215 | 2 076 |
| 50-54 | 8 026 | 4 274 | 7 174 | 3 441 | 852 | 833 |
| 55-59 | 5 084 | 3 853 | 4 717 | 3 525 | 367 | 328 |
| 60+ | 6 862 | 7 094 | 6 616 | 6 838 | 246 | 256 |
| Дүнд эзлэх хувиар | | | | | | |
| Бүгд | 100.0 | 100.0 | 100.0 | 100.0 | 100.0 | 100.0 |
| 15 ба түүнээс доош | - | 0.5 | - | 0.6 | - | 0.3 |
| 15-19 | 2.7 | 2.0 | 2.9 | 2.4 | 1.3 | 0.5 |
| 20-29 | 13.4 | 8.7 | 12.6 | 7.2 | 18.8 | 14.7 |
| 30-39 | 22.8 | 19.9 | 21.6 | 16.3 | 31.0 | 34.1 |
| 40-49 | 26.9 | 25.0 | 26.6 | 23.8 | 29.4 | 30.0 |
| 50-54 | 13.7 | 12.3 | 14.1 | 12.4 | 11.3 | 12.0 |
| 55-59 | 8.7 | 11.1 | 9.3 | 12.7 | 4.9 | 4.7 |
| 60+ | 11.7 | 20.5 | 13.0 | 24.7 | 3.3 | 3.7 |

Газар тариалангийн салбарын ажиллагчдыг хүйсээр авч үзвэл 2011 онд өрх болон аж ахуйн нэгж, байгууллагад ажиллаж буй нийт эрэгтэй ажиллагчдад 30-49 насны эрэгтэй ажиллагчид 38.7 хувийг, нийт эмэгтэй ажиллагчдад 30-49 насны эмэгтэй ажиллагчид 50.4 хувийг эзэлж байсан бол 2021 онд өрх болон аж ахуйн нэгж, байгууллагад ажиллаж буй нийт эрэгтэй ажиллагчдад 30-49 насны эрэгтэй ажиллагчид 45.7 хувийг, нийт эмэгтэй ажиллагчдаас 30-49 насны эмэгтэй ажиллагчид 42.2 хувийг эзэлж байна.

### IV.2.4. Газар тариалангийн салбарын байнгын ажиллагчид, гэрлэлтийн байдлаар

2021 оны тооллогын дүнгээр газар тариалангийн салбарын ажиллагчдын гэрлэлтийн байдлыг харахад байнгын ажиллагчдын 79.4 хувь нь гэрлэсэн (батлуулсан) ба үүнээс 62.1 хувь нь эрэгтэйчүүд, 37.9 хувь нь эмэгтэйчүүд байхад 4.6 хувь нь гэрлэсэн (батлуулаагүй) бөгөөд үүнээс 48.5 хувь нь эрэгтэйчүүд, 51.5 хувь нь эмэгтэйчүүд байна. Нийт ажиллагчдын 13.8 хувь нь гэрлээгүй бөгөөд үүнээс 49.9 хувь нь эрэгтэйчүүд, 50.1 хувь нь эмэгтэйчүүд, 0.8 хувь нь тусгаарласан бөгөөд үүнээс 61.4 хувь нь эрэгтэйчүүд, 38.6 хувь нь эмэгтэйчүүд, 0.4 хувь нь бэлэвсэн бөгөөд үүнээс 42.9 хувь нь эрэгтэйчүүд, 57.1 хувь нь эмэгтэйчүүд, 2.1 хувь нь бэлэвсэн бөгөөд үүнээс 40.7 хувь нь эрэгтэйчүүд, 59.3 хувь нь эмэгтэйчүүд эзэлж байна.

ХҮСНЭГТ IV.14. ГАЗАР ТАРИАЛАНГИЙН САЛБАРЫН БАЙНГЫН ГЭРЛЭЛТИЙН БАЙДАЛ, хүйсээр

| | Бүгд | | Эрэгтэй | | Эмэгтэй | |
|---|---|---|---|---|---|---|
| | 2011 | 2021 | 2011 | 2021 | 2011 | 2021 |
| **Бүгд** | **58 447** | **34 662** | **33 085** | **20 549** | **25 362** | **14 113** |
| Огт гэрлээгүй | 7 090 | 4 784 | 4 700 | 2 387 | 2 390 | 2 397 |
| Гэрлэсэн, батлуулсан | 46 494 | 27 163 | 27 013 | 16 874 | 19 481 | 10 289 |
| Гэрлэсэн, батлуулаагүй | | 1 595 | | 773 | | 822 |
| Тусгаарласан | 1 206 | 272 | 512 | 167 | 694 | 105 |
| Цуцалсан | - | 126 | - | 54 | - | 72 |
| Бэлэвсэн | 3 657 | 722 | 860 | 294 | 2 797 | 428 |
| Дунд эзлэх хувиар | | | | | | |
| Бүгд | 100.0 | 100.0 | 100.0 | 100.0 | 100.0 | 100.0 |
| Огт гэрлээгүй | 12.1 | 13.8 | 14.2 | 11.6 | 9.4 | 17.0 |
| Гэрлэсэн, батлуулсан | 79.5 | 78.4 | 81.6 | 82.1 | 76.8 | 72.9 |
| Гэрлэсэн, батлуулаагүй | | 4.6 | | 3.8 | | 5.8 |
| Тусгаарласан | 2.1 | 0.8 | 1.5 | 0.8 | 2.7 | 0.7 |
| Цуцалсан | - | 0.4 | - | 0.3 | - | 0.5 |
| Бэлэвсэн | 6.3 | 2.1 | 2.6 | 1.4 | 11.0 | 3.0 |

### IV.2.5. Газар тариалангийн салбарын байнгын ажиллагчид, боловсролын түвшнээр, бүсээр

Газар тариалангийн салбарын байнгын ажиллагчдын 43.8 хувь нь бүрэн дунд, 15.0 хувь нь бакалаврын дээд, 14.4 хувь нь суурь, 7.2 хувь нь техникийн болон мэргэжлийн, 6.5 хувь нь тусгай мэргэжлийн дунд, 5.2 хувь бага, 4.4 хувь нь

дипломын, 1.8 хувь нь боловсролгүй, харин 1.5 хувь нь магистр, 0.4 хувь нь докторын зэрэгтэй ажиллагчид байна.

ХҮСНЭГТ IV.15. ГАЗАР ТАРИАЛАНГИЙН САЛБАРЫН БАЙНГЫН АЖИЛЛАГЧИД, боловсролын түвшингээр, хүйсээр

| | Бүгд | | Эрэгтэй | | Эмэгтэй | |
|---|---|---|---|---|---|---|
| | 2011 | 2021 | 2011 | 2021 | 2011 | 2021 |
| **Бүгд** | **58.3** | **34.7** | **33.1** | **20.5** | **25.4** | **14.1** |
| Боловсролгүй | 1.1 | 0.6 | 0.7 | 0.4 | 0.4 | 0.2 |
| Бага | 4.8 | 1.8 | 2.8 | 1.2 | 2.0 | 0.6 |
| Суурь | 12.6 | 5.0 | 7.3 | 3.2 | 5.2 | 1.8 |
| Бүрэн дунд | 21.0 | 15.2 | 11.7 | 8.9 | 9.3 | 6.3 |
| Техникийн болон мэргэжлийн дунд | 5.7 | 2.5 | 3.7 | 1.6 | 2.0 | 0.9 |
| Тусгай мэргэжлийн дунд | 5.2 | 2.3 | 2.5 | 1.2 | 2.7 | 1.1 |
| Дипломын дээд | 7.8 | 1.5 | 4.2 | 1.0 | 3.6 | 0.6 |
| Бакалаврын дээд | - | 5.2 | - | 2.7 | - | 2.5 |
| Магистр | 0.2 | 0.4 | 0.2 | 0.2 | 0.2 | 0.2 |
| Доктор | | 0.1 | | 0.1 | | 0.1 |
| Дунд эзлэх хувь | | | | | | |
| **Бүгд** | **100.0** | **100.0** | **100.0** | **100.0** | **100.0** | **100.0** |
| Боловсролгүй | 1.8 | 1.8 | 2.0 | 2.1 | 1.6 | 1.5 |
| Бага | 8.2 | 5.2 | 8.5 | 5.7 | 7.7 | 4.4 |
| Суурь | 21.6 | 14.4 | 22.2 | 15.8 | 20.6 | 12.4 |
| Бүрэн дунд | 36.1 | 43.8 | 35.3 | 43.5 | 36.8 | 44.3 |
| Техникийн болон мэргэжлийн дунд | 9.8 | 7.2 | 11.1 | 8.0 | 8.0 | 6.2 |
| Тусгай мэргэжлийн дунд | 8.9 | 6.5 | 7.6 | 5.8 | 10.5 | 7.6 |
| Дипломын дээд | 13.4 | 4.4 | 12.7 | 4.7 | 14.2 | 4.0 |
| Бакалаврын дээд | - | 15.0 | - | 13.2 | - | 17.6 |
| Магистр | 0.3 | 1.2 | 0.6 | 1.0 | 0.6 | 1.6 |
| Доктор | | 0.4 | | 0.3 | | 0.5 |

Газар тариалангийн салбарт ажиллагчдын 30.8 хувь нь суурь болон бүрэн дунд боловсролтой ажиллагчид байна.

### IV.2.6. Газар тариалангийн салбарт ажиллаж байгаа мэргэжлийн ажиллагчид

Мэргэжлийн ажиллагчдын тоог тодорхойлох зорилгоор жимс болон ногооны агрономич, усалгаатай тариалангийн агрономич, бусад агрономич, мэргэшсэн фермерийн аж ахуйч, ХАА-н инженер, механикч, механикжуулагч болон бусад гэсэн мэргэжлийн төрлүүдээр нэгтгэсэн.

2011 онд газар тариалангийн салбарт 5.9 мянган мэргэжлийн ажиллагчид ажилласан ба үүний 4.4 мянга буюу 74.1 хувь нь өрхөд, 1.5 мянга буюу 25.9 хувь аж ахуйн нэгж, байгууллагад ажилласан байна. Улсын хэмжээнд 2021 онд газар тариалангийн салбарт 7.8 мянган мэргэжлийн ажиллагчид ажилласан ба үүний 0.7 мянга буюу 9.5 хувь нь өрхөд, 7.1 мянга буюу 90.5 хувь аж ахуйн нэгж, байгууллагад ажилласан байна.

ХҮСНЭГТ IV.16. ГАЗАР ТАРИАЛАНГИЙН САЛБАРЫН МЭРГЭЖЛИЙН АЖИЛЛАГЧИД, мэргэжлийн чиглэлээр

| | Бүгд | | Өрх | | ААНБ | |
|---|---|---|---|---|---|---|
| | 2011 | 2021 | 2011 | 2021 | 2011 | 2021 |
| **Бүгд** | **5 905** | **7 825** | **4 375** | **743** | **1 530** | **7 082** |
| Агрономич | - | 679 | - | 83 | - | 596 |
| Усалгаатай газар тариалангийн агрономич (гидротехникч) | 146 | 37 | 103 | 3 | 43 | 34 |
| Жимс, ногооны агрономич | 271 | 65 | 188 | 6 | 83 | 59 |
| Бусад агрономич | 417 | 80 | 265 | 9 | 152 | 71 |
| ХАА-н инженер | 340 | 306 | 176 | 92 | 164 | 214 |
| Бусад инженер | - | 418 | - | 96 | - | 322 |
| Газар тариалангийн фермерийн аж ахуй эрхлэгч | 247 | 131 | 151 | 77 | 96 | 54 |
| Механикч | - | 910 | - | 216 | - | 694 |
| Механикжуулагч, операторч | 1 542 | 705 | 913 | 161 | 629 | 544 |
| Бусад | 2 942 | 4 494 | 2 579 | - | 363 | 4 494 |
| Дүнд эзлэх хувиар | | | | | | |
| **Бүгд** | **100.0** | **100.0** | **100.0** | **100.0** | **100.0** | **100.0** |
| Агрономич | - | 8.7 | - | 11.2 | - | 8.4 |
| Усалгаатай газар тариалангийн агрономич (гидротехникч) | 2.5 | 0.5 | 2.4 | 0.4 | 2.8 | 0.5 |
| Жимс, ногооны агрономич | 4.6 | 0.8 | 4.3 | 0.8 | 5.4 | 0.8 |
| Бусад агрономич | 7.1 | 1.0 | 6.1 | 1.2 | 9.9 | 1.0 |
| ХАА-н инженер | 5.8 | 3.9 | 4.0 | 12.4 | 10.7 | 3.0 |
| Бусад инженер | - | 5.3 | - | 12.9 | - | 4.5 |
| Газар тариалангийн фермерийн аж ахуй эрхлэгч | 4.2 | 1.7 | 3.5 | 10.4 | 6.3 | 0.8 |
| Механикч | - | 11.6 | - | 29.1 | - | 9.8 |
| Механикжуулагч, операторч | 26.1 | 9.0 | 20.9 | 21.7 | 41.1 | 7.7 |
| Бусад | 49.8 | 57.4 | 58.9 | - | 23.7 | 63.5 |

Хүснэгтээс харахад мэргэжлийн ажиллагчдаас ХАА-н чиглэлийн мэргэжлийн ажиллагчдын тоо өрхөд 0.7 мянга буюу 9.5 хувь, аж ахуйн нэгж, байгууллагад 7.1 мянга буюу 90.5 хувьтай байна. Аж ахуйн нэгж, байгууллагад ажиллаж буй ХАА-н чиглэлийн ажиллагчид нь өрхтэй харьцуулахад өндөр байна. Мөн эмч, эдийн засагч, сантехникч, тогооч, жолооч мэргэжилтэй ажиллагчид бусад төрлийн мэргэжлийн ажиллагчдын дийлэнх хувийг эзэлж байгаа юм.

### IV.2.7. Газар тариалангийн салбарын түр ажиллагчид

Улсын хэмжээнд тооллогын үр дүнгээр 31.4 мянган газар тариалангийн түр ажиллагчид 2021 онд ажилласан нь өмнөх тооллогоос 6.5 мянгаар буурсан үзүүлэлт байна. Энэхүү бууралт өрх, ААНБ, бүсүүдэд ижил хандлагатай байна. Харин Зүүн бүсэд ААНБ-ын түр ажиллагчид нэмэгдсэн байна. Түр ажиллагчид мөн газар тариалангийн зонхилох бүс болох Төвийн бүсэд төвлөрч, 63.0 хувь нь энэ бүсэд ногдож байна.

ХҮСНЭГТ IV.17. ГАЗАР ТАРИАЛАНГИЙН САЛБАРЫН ТҮР АЖИЛЛАГЧИД, бүсээр

| | Бүгд | | Өрх | | ААНБ | |
|---|---|---|---|---|---|---|
| | 2011 | 2021 | 2011 | 2021 | 2011 | 2021 |
| Бүгд | 37 871 | 31 377 | 28 298 | 22 896 | 9 573 | 8 481 |
| Баруун бүс | 3 978 | 2 469 | 2 887 | 1 604 | 1 091 | 865 |
| Хангайн бүс | 7 910 | 4 882 | 6 404 | 3 798 | 1 506 | 1 084 |
| Төвийн бүс | 23 861 | 22 237 | 17 610 | 16 901 | 6 251 | 5 336 |
| Зүүн бүс | 764 | 1 100 | 493 | 309 | 271 | 791 |
| Улаанбаатар | 1 358 | 689 | 904 | 284 | 454 | 405 |

ХАА-н тооллогод хамрагдсан газар тариалан эрхэлдэг нийт өрхийн 11.7 хувь нь буюу 2.2 мянган өрх, аж ахуйн нэгж, байгууллагын 59.0 хувь нь 1.0 мянган ААНБ түр ажиллагчид авч ажиллуулсан байна.

### IV.2.8. Газар тариалангийн салбарын ажиллагчдын ажлын өдрийн үргэлжлэх дундаж хугацаа

Газар тариалангийн салбарын ажиллах хугацааг ургац тариалалтаас хураалт, хураалтын дараах үе шат бүрт дунджаар нэг ажиллагчдын өдрийн дундаж цагийг тооцлоо. Өрхийн тариалалт хийдэг байнгын ажиллагч дунджаар борлуулалтын үе шатанд 7 цагийг, ургацын арчилгаа, хураасны дараах тээвэрлэлтийн үе шатанд 8 цаг, ургац тариалалтын үед 9 цаг, хураалтын үе шатанд 10 цаг зарцуулдаг байна. Энэ хандлага ААНБ-ын ажиллагчийн хувьд ойролцоо байна.

ХҮСНЭГТ IV.18. ГАЗАР ТАРИАЛАНГИЙН САЛБАРЫН АЖИЛЛАГЧДЫН АЖЛЫН ӨДРИЙН ҮРГЭЛЖЛЭХ ХУГАЦАА, тариалалтын үе шатаар, цагаар

| | Өрх | | | | ААНБ | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | Байнгын | | Түр | | Байнгын | | Түр | |
| | 2011 | 2021 | 2011 | 2021 | 2011 | 2021 | 2011 | 2021 |
| Арчилгааны үе | - | 8 | - | 6 | - | 8 | - | 8 |
| Борлуулалтын үе | - | 7 | - | 7 | - | 8 | - | 8 |
| Тариалалтын үе | 8 | 9 | 9 | 8 | 10 | 9 | 10 | 9 |
| Ургац тээвэрлэлт | - | 8 | - | 7 | - | 8 | - | 8 |
| Ургац хураалтын | 8 | 10 | 10 | 9 | 11 | 9 | 10 | 10 |

Харин түр ажиллагчийн хувьд өрхийн үйл ажиллагаанд оролцоход бусад байнгын болон, ААНБ-д ажиллахаас арай бага цагаар ажилладаг байна. Ургац хураалтын болон тариалалтын үе шатанд хамгийн их цагийг зарцуулж байгаа бол ААНБ-ууд дээрх 2 үе шатанд түр ажиллагчийг их цагаар авч ажиллуулах хандлага ажиглагдаж байна.

### IV.2.9. Газар тариалангийн салбарын ажиллах хүчтэй холбоотой хүндрэл, бэрхшээл

Газар тариалангийн салбарын ажиллах хүчтэй холбоотой гарч буй хүндрэл бэрхшээлийг 7 төрөлд ангилан авч үзсэн. Хариулагч олон сонголттойгоор хариулсан тул хамгийн их тулгардаг 3 хүртэлх хүндрэл бэрхшээлийг сонгосон.

Газар тариалангийн салбарт үйл ажиллагаа явуулахад хамгийн их хүндрэл ажиллах хүч дутагдалтай, тухайн орон нутагт ажиллах хүч олоход хүндрэлтэй, өндөр цалин хөлс шаарддаг гэж хариулсан байна. Дээрх хүндрэлүүдээс гадна ААНБ-ын хувьд мэргэжлийн ажиллах хүч дутагдалтай, ажиллагчдын хариуцлага сул, ажиллах хүчний тогтвор суурьшил муу байдаг нь нэмэгдэж байна.

ЗУРАГ IV.5. ГАЗАР ТАРИАЛАНГИЙН САЛБАРТ АЖИЛЛАХ ХҮЧТЭЙ ХОЛБООТОЙ ХҮНДРЭЛ, БЭРХШЭЭЛ, хувиар



V БҮЛЭГ

# ХӨДӨӨ АЖ АХУЙН, БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ҮЙЛДВЭРЛЭЛ, БОРЛУУЛАЛТ

ГАЗАР ТАРИАЛАНГИЙН САЛБАРТ ҮЙЛДВЭРЛЭСЭН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ХЭМЖЭЭ, мянган тонн

549.1
ҮР ТАРИА

185.2
ТӨМС

146.0
ХҮНСНИЙ НОГОО

369.8
ТЭЖЭЭЛИЙН УРГАМАЛ

48.9
ТЕХНИКИЙН УРГАМАЛ

# V. ХӨДӨӨ АЖ АХУЙН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ҮЙЛДВЭРЛЭЛ, БОРЛУУЛАЛТ

Мал аж ахуйн салбарт 2021 онд нядалгааны жингээр 557.0 мянган тонн мах, 434.2 мянган литр сүү, 40.2 мянган тонн хонины ноос, 10.8 мянган тонн ноолуур, 18.0 сая ширхэг арьс, шир үйлдвэрлэв.

Үйлдвэрлэсэн нийт махны 99.2 хувь, сүүний 99.2 хувь, ноосны 99.3 хувь, ноолуурын 99.7 хувь, арьс, ширний 99.4 хувийг өрхөд, харин махны 0.8 хувь, сүүний 0.8 хувь, ноосны 0.7 хувь, ноолуурын 0.3 хувь, арьс, ширний 0.6 хувийг ААНБ-д үйлдвэрлэжээ.

Мал аж ахуй эрхэлдэг нэг өрх дунджаар, нядалгааны жингээр 2.3 тонн мах, 1.8 мянган литр сүү, 162.8 кг ноос, 44.0 кг ноолуур, 73.0 ширхэг арьс, шир; ААНБ дунджаар, нядалгааны жингээр 4.8 тонн мах, 3.7 мянган литр сүү, 294.6 кг ноос, 37.4 кг ноолуур, 115 ширхэг арьс, шир үйлдвэрлэжээ.

Газар тариалангийн салбарт 2021 онд 550.7 мянган тонн үр тариа, 192.1 мянган тонн төмс, 150.1 мянган тонн хүнсний ногоо хурааж авсан байна. Үр тарианы 9.9 хувь, төмсний 79.7 хувь, хүнсний ногооны 75.9 хувийг өрхийн аж ахуйд хурааж авсан байна. Харин ААНБ-ын хураасан үр тарианы 90.1 хувь, төмсний 20.3 хувь, хүнсний ногооны 24.1 хувь нь ногдож байна.

Газар тариалангийн үйл ажиллагаа эрхэлдэг нэг өрх дунджаар 2.9 тонн үр тариа, 8.1 тонн төмс, 6.0 тонн хүнсний ногоо хураасан байна. Харин газар тариалангийн үйл ажиллагаа эрхэлдэг нэг ААНБ 302.1 тонн үр тариа, 23.7 тонн төмс, 22.0 тонн хүнсний ногоо хураан авчээ.

## V.1. Мал аж ахуйн салбарын бүтээгдэхүүн үйлдвэрлэл, борлуулалт

Мал аж ахуйн салбарын бүтээгдэхүүн үйлдвэрлэл 2021 оны урьдчилсан гүйцэтгэлээр, оны үнээр 7.2 их наяд төгрөг, 2015 оны зэрэгцүүлэх үнээр 4.8 их наяд төгрөгт хүрч, өмнөх онтой харьцуулахад оны үнээр 14.2 хувиар өсөж, зэрэгцүүлэх үнээр 8.1 хувиар буурсан байна (Үндэсний статистикийн хороо, 2022).

Мал аж ахуйн салбарт 2021 онд нядалгааны жингээр 557.0 мянган тонн мах үйлдвэрлэсэн байна. Махны үйлдвэрлэлийг төрлөөр авч үзэхэд, хонины мах 162.3 мянган тонн, үхрийн мах 116.2 мянган тонн, ямааны мах 109.7 мянган тонн, адууны мах 64.1 мянган тонн, тэмээний мах 13.2 мянган тонн үйлдвэрлэжээ.

ХҮСНЭГТ V.1. МАЛ АЖ АХУЙН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ҮЙЛДВЭРЛЭЛ, 2021 суурьтай тооцсон, биет хэмжээгээр

| | 2020 | 2021 |
|---|---|---|
| **Малын мах, нядалгааны жингээр[1] мянган тонн** | **822.4** | **557.0** |
| Адууны | 105.3 | 64.1 |
| Үхрийн | 167.9 | 116.2 |
| Тэмээний | 17.3 | 13.2 |
| Хонины | 247.1 | 162.3 |
| Ямааны | 150.8 | 109.7 |
| **Сүү, сая литр** | **479.9** | **434.2** |
| Гүүний | 35.7 | 35.3 |
| Үнээний | 208.0 | 201.4 |
| Ингэний | 2.9 | 2.0 |
| Хонины | 87.4 | 73.4 |
| Ямааны | 145.9 | 122.0 |
| **Ноос, ноолуур, тонн** | | |
| Тэмээний ноос | 2 101.6 | 2 031.5 |
| Хонины ноос | 36 386.8 | 33 748.7 |
| Ямааны ноолуур | 11 576.6 | 10 840.5 |
| **Арьс, шир, мянган ширхэг[2]** | **24 407.1** | **17 984.7** |
| Тэмээний | 74.9 | 65.5 |
| Адууны | 917.7 | 577.2 |
| Үхрийн | 1 271.8 | 919.6 |
| Хонины | 11 853.4 | 8 129.6 |
| Ямааны | 9 202.7 | 7 322.5 |

[1] дайвар бүтээгдэхүүн, гахайн мах, тахианы мах, борцыг оруулж тооцсон.
[2] хурга, ишигний арьс оруулж тооцсон.

Сүүний үйлдвэрлэл 2021 онд 434.2 сая литр, үүнээс үнээний сүүний үйлдвэрлэл 201.4 сая литр, ингэний сүү 2.0 литр, гүүний сүү 73.4 сая литр, ямааны сүү 122.0 сая литр, хонины сүү 73.4 сая литр байна.

Хонины ноосны үйлдвэрлэл 33.7 мянган тонн, ноолуур үйлдвэрлэл 10.8 мянган тонн, тэмээний ноосны үйлдвэрлэл 2.0 мянган тонн, арьс, ширний үйлдвэрлэл 18.0 сая ширхэг байна.

## V.2. Малын тоо, сүргийн бүтэц

Мал аж ахуйн салбарын үндсэн үзүүлэлтүүд болон үйлдвэрлэлийн мэдээллийг "мал, тэжээвэр амьтдын жилийн эцсийн тооллого[2]"-ын дүнгээр тайланд тусгалаа (Үндэсний статистикийн хороо, 2022). Мал тооллогын 2021 оны жилийн эцсийн дүнгээр малын тоо толгой 67.3 сая болж, төрлөөр нь авч үзвэл, адуу 4.3 сая, үхэр 5 сая, тэмээ 454 мянга, хонь 31.1 сая, ямаа 26.5 сая толгой тоологдсон.

[2] Хөдөө аж ахуйн тооллогын асуулгад малын тоо, малчдын мэдээлэл зэрэг жилийн эцсийн тооллогын мэдээллийг давхардуулан цуглуулаагүй болно.

ХҮСНЭГТ V.2. МАЛЫН ТОО, төрлөөр, мянган толгой

| Он | Бүгд | Адуу | Үхэр | Тэмээ | Хонь | Ямаа |
|---|---|---|---|---|---|---|
| 1930 | 23 676.2 | 1 566.9 | 1 887.3 | 480.9 | 15 660.3 | 4 080.8 |
| 1940 | 26 204.8 | 2 358.1 | 2 722.8 | 643.4 | 15 384.2 | 5 096.3 |
| 1950 | 22 702.2 | 2 317.0 | 1 987.8 | 844.2 | 12 574.6 | 4 978.6 |
| 1960 | 23 000.5 | 2 502.7 | 1 905.5 | 859.1 | 12 101.9 | 5 631.3 |
| 1970 | 22 574.9 | 2 317.9 | 2 107.8 | 633.5 | 13 311.7 | 4 204.0 |
| 1980 | 23 771.4 | 1 985.4 | 2 397.1 | 591.5 | 14 230.7 | 4 566.7 |
| 1990 | 25 856.9 | 2 262.0 | 2 848.7 | 537.5 | 15 083.0 | 5 125.7 |
| 2000 | 30 227.5 | 2 660.8 | 3 097.6 | 322.9 | 13 876.3 | 10 269.8 |
| 2010 | 32 729.5 | 1 920.3 | 2 176.0 | 269.6 | 14 480.4 | 13 883.2 |
| **2021** | **67 343.8** | **4 324.4** | **5 022.2** | **454.0** | **31 087.0** | **26 456.1** |

Нийт сүрэгт таван төрлийн малын эзлэх хувийн жинг 2021 оны байдлаар авч үзвэл, хонь 46.2 хувь, ямаа 39.3 хувь, үхэр 7.5 хувь, адуу 6.4 хувь, тэмээ 0.7 хувийг эзэлж байна. Монгол Улсын мал тооллогын 1926-1992 оны 66 жилийн үр дүнгээс үзэхэд сүрэгт бод мал дунджаар 21.7 хувь, бог мал дунджаар 78.3 хувийг эзэлдэг байсан бол 2021 оны байдлаар бод мал дунджаар 14.6 хувь, бог мал дунджаар 85.4 хувийг эзэлж байгаа нь бод малын хувийн жин 7.1 нэгж хувиар буурч, бог малынх 7.1 нэгж хувиар нэмэгдсэн байна.

ЗУРАГ V.1. СҮРГИЙН БҮТЭЦ




Сүргийн бүтцийг 2021 оны байдлаар авч үзвэл, нийт сүргийн 28.8 хувь буюу 19.4 сая толгой нь төл, өсвөр насны мал; 24.8 хувь буюу 16.6 сая толгой нь нас гүйцсэн эр мал; 45.7 хувь буюу 30.8 сая толгой нь хээлтэгч мал, 0.9 хувь буюу 587.5 мянган толгой нь хээлтүүлэгч мал байна.

ХҮСНЭГТ V.3. МАЛЫН ТОО, төрлөөр, мянган толгой

| | Бүгд | Төл, өсвөр насны мал | Нас гүйцсэн эр мал | Хээлтэгч | Хээлтүүлэгч |
|---|---|---|---|---|---|
| **Бүгд** | **67 343.8** | **19 386.7** | **16 585.1** | **30 784.5** | **587.5** |
| Адуу | 4 324.4 | 1 778.5 | 901.2 | 1 481.8 | 162.9 |
| Үхэр | 5 022.2 | 2 193.4 | 725.3 | 2 035.2 | 68.3 |
| Тэмээ | 454.0 | 190.6 | 88.6 | 169.5 | 5.4 |
| Хонь | 31 087.0 | 9 189.9 | 6 949.8 | 14 752.2 | 195.0 |
| Ямаа | 26 456.1 | 6 034.3 | 7 920.2 | 12 345.7 | 155.9 |
| | | дүнд эзлэх хувь | | | |
| **Бүгд** | **100.0** | **28.8** | **24.6** | **45.7** | **0.9** |
| Адуу | 100.0 | 41.1 | 20.8 | 34.3 | 3.8 |
| Үхэр | 100.0 | 43.7 | 14.4 | 40.5 | 1.4 |
| Тэмээ | 100.0 | 42.0 | 19.5 | 37.3 | 1.2 |
| Хонь | 100.0 | 29.6 | 22.4 | 47.5 | 0.6 |
| Ямаа | 100.0 | 22.8 | 29.9 | 46.8 | 0.6 |

Хөдөө аж ахуйн 2022 оны улсын тооллогод мал аж ахуйн үйл ажиллагаа эрхэлдэг нийт 245.4 мянган өрх, 902 ААНБ хамрагдлаа.

Эдгээр өрх, ААНБ нийт 557.0 мянган тонн мах, 434.2 мянган литр сүү, 40.2 мянган тонн ноос, 10.8 мянган тонн ноолуур, 18.0 сая ширхэг арьс шир үйлдвэрлэжээ.

ХҮСНЭГТ V.4. МАЛ АЖ АХУЙН САЛБАРТ ҮЙЛДВЭРЛЭСЭН БҮТЭЭГДЭХҮҮН, бүтээгдэхүүний нэр төрлөөр

| | Бүгд | | Өрх | | ААНБ | | Дүнд эзлэх хувиар | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Бүгд | | Өрх | | ААНБ | |
| | 2011 | 2021 | 2011 | 2021 | 2011 | 2021 | 2011 | 2021 | 2011 | 2021 | 2011 | 2021 |
| Өрх, ААНБ-ын тоо | 210.1 | 246.3 | 209.6 | 245.4 | 0.5 | 0.9 | 100.0 | 100.0 | 99.8 | 99.6 | 0.2 | 0.4 |
| Үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний хэмжээ | | | | | | | | | | | | |
| Мах, мян.т | 202.1 | 557.0 | 188.7 | 552.7 | 13.4 | 4.3 | 100.0 | 100.0 | 93.4 | 99.2 | 6.6 | 0.8 |
| Сүү, мян.л | 520.0 | 434.2 | 513.0 | 430.8 | 6.9 | 3.4 | 100.0 | 100.0 | 98.7 | 99.2 | 1.3 | 0.8 |
| Ноос, мян.т | 19.0 | 40.2 | 18.7 | 39.9 | 0.3 | 0.3 | 100.0 | 100.0 | 98.6 | 99.3 | 1.4 | 0.7 |
| Ноолуур, мян.т | 5.5 | 10.8 | 5.4 | 10.8 | 0.03 | 0.03 | 100.0 | 100.0 | 99.4 | 99.7 | 0.6 | 0.3 |
| Арьс, сая.шир | 8.7 | 18.0 | 8.5 | 17.9 | 0.2 | 0.1 | 100.0 | 100.0 | 97.4 | 99.4 | 2.6 | 0.6 |

Мал аж ахуйн салбарт үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний дийлэнхийг буюу 99.2-99.7 хувийг өрхийн аж ахуйд үйлдвэрлэсэн бөгөөд үлдсэн хэсгийг ААНБ-ууд үйлдвэрлэжээ.

Мал аж ахуйн салбарын үйлдвэрлэлийг бүсээр авч үзвэл, бүтээгдэхүүн бүрийн гуравны нэгээс дээш хувийг Хангайн бүсэд үйлдвэрлэсэн байна. Хангайн бүс нь манай улсын мал аж ахуйн гол бүс бөгөөд малын тоогоор улсад эхний байруудад ордог Архангай, Өвөрхангай, Хөвсгөл, Булган, Баянхонгор, Орхон зэрэг аймгууд энэ бүсэд байдагтай холбоотой.

## ХҮСНЭГТ V.5. МАЛ АЖ АХУЙН САЛБАРТ ҮЙЛДВЭРЛЭСЭН БҮТЭЭГДЭХҮҮН, бүтээгдэхүүний нэр төрөл, бүсээр

| | Бүгд | | Баруун бүс | | Хангайн бүс | | Төвийн бүс | | Зүүн бүс | | Улаанбаатар | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | 2011 | 2021 | 2011 | 2021 | 2011 | 2021 | 2011 | 2021 | 2011 | 2021 | 2011 | 2021 |
| Мах, мян.т | 202.1 | 557.0 | 34.2 | 129.8 | 69.5 | 181.0 | 54.0 | 142.9 | 37.7 | 93.9 | 6.7 | 9.4 |
| Сүү, мян.л | 519.9 | 434.2 | 111.1 | 132.0 | 181.4 | 130.5 | 119.5 | 100.2 | 94.3 | 51.2 | 13.7 | 20.3 |
| Ноос, мян.т | 19.0 | 40.2 | 4.7 | 9.7 | 6.5 | 12.9 | 4.9 | 10.6 | 2.8 | 6.6 | 0.1 | 0.3 |
| Ноолуур, мян.т | 5.5 | 10.8 | 1.6 | 3.0 | 1.9 | 3.3 | 1.3 | 3.2 | 0.6 | 1.3 | 0.0 | 0.1 |
| Арьс, сая.шир | 8.7 | 18.0 | 1.9 | 4.1 | 3.1 | 5.9 | 2.0 | 4.7 | 1.7 | 3.0 | 0.1 | 0.2 |

Манай улсын хүн амын хүнсний гол хэрэгцээ болох махыг Хангайн бүсэд 181.0 (32.5%) мянган тонн, Төвийн бүсэд 142.9 (25.7%) мянган тонн, Баруун бүсэд 129.8 (23.3%) мянган тонн, Зүүн бүсэд 92.8 (16.9%) мянган тонн, Улаанбаатар хотод 9.4 (1.7%) мянган тонныг үйлдвэрлэжээ.

Мал сүргийн тоо 2011 оноос адуу 2.2 (2.0 дахин) сая толгой, үхэр 2.7 (2.1 дахин) сая толгой, тэмээ 173.9 (62.1%) мянган толгой, хонь 15.4 сая толгой (98.4%), ямаа 10.5 (66.0%) сая толгойгоор тус тус өссөн байна.

## ХҮСНЭГТ V.6. МАЛЫН ТОО ТОЛГОЙ, малын төрлөөр

| | Бүгд | | Адуу | Үхэр | Тэмээ | Хонь | Ямаа |
|---|---|---|---|---|---|---|---|
| | 2011 | 2021 | 2021 | 2021 | 2021 | 2021 | 2021 |
| **Нийт малын тоо** | 36 335.8 | 67 343.7 | 4 324.4 | 5 022.2 | 454.0 | 31 087.0 | 26 456.1 |
| **Бойжуулсан төл** | 12 504.7 | 20 321.7 | 919.3 | 1 378.0 | 64.9 | 10 457.5 | 7 502.0 |
| **Зүй бусаар хорогдсон** | 651.3 | 3 012.3 | 118.4 | 188.4 | 22.2 | 1 123.5 | 1 559.9 |
| **Хэрэглээнд зарцуулсан** | 8 283.2 | 17 034.0 | 570.3 | 899.4 | 61.6 | 8 296.5 | 7 206.2 |
| Хувийн хэрэглээнд | 8 038.9 | 13 285.4 | 444.4 | 672.1 | 50.1 | 6 505.5 | 5 613.4 |
| Дотоодын үйлдвэрлэлд | 190.6 | 3 748.6 | 125.9 | 227.3 | 11.5 | 1 791.0 | 1 592.8 |
| Экспортод | 53.7 | - | - | - | - | - | - |

Оны эхний эх малын 74.1 хувь буюу 22.9 сая эх мал 2021 онд төллөж, гарсан төлийн 92.3 хувь буюу 20.3 сая төл бойжуулжээ.

Харин оны эхний малын 4.5 хувьтай тэнцэх 3.0 сая толгой ма зүй бусаар хорогдсон байна.

Оны эхний малын 25.3 хувьтай тэнцэх 17.0 сая толгой малыг хэрэглээнд зарцуулжээ. Хэрэглээндээ зарцуулсан малыг төрлөөр авч үзвэл, 13.3 (78.0%) сая толгой малыг хувийн хэрэглээнд, 3.7 (22.0%) сая толгой малыг дотоодын үйлдвэрлэлд хэрэглэсэн байна.

ЗУРАГ V.2. МАЛ АЖ АХУЙН САЛБАРЫН ҮЙЛДВЭРЛЭСЭН МАХНЫ ҮЙЛДВЭРЛЭЛ




Мал аж ахуйн салбарын үйлдвэрлэсэн мах үйлдвэрлэлийн 34.0 хувь нь Архангай, Төв, Өвөрхангай, Хөвсгөл аймгуудад байна.

ЗУРАГ V.3. МАЛ АЖ АХУЙН САЛБАРЫН ҮЙЛДВЭРЛЭСЭН СҮҮНИЙ ҮЙЛДВЭРЛЭЛ




Мал аж ахуйн салбарын үйлдвэрлэсэн сүүний үйлдвэрлэлийн 34.7 хувь нь Архангай, Увс, Төв, Ховд аймгуудад байна.

## V.3. Жишсэн хүн амын жилийн мах, сүүний хэрэгцээ

Эрүүл мэндийн сайдын 2017 оны 2 сарын 23-ны өдрийн А/74 дугаар тушаалын дагуу жишсэн хүнд шилжүүлэх итгэлцүүр болон жишсэн нэг хүний хоногийн болон жилийн хүнсний хэрэгцээний нормыг ашиглан гол нэр төрлийн хүнсний бүтээгдэхүүний жилийн хэрэгцээг улсын хэмжээнд тооцлоо. Манай улсын хүн амын хүнсний гол

нэрийн бүтээгдэхүүн болох мах, сүүний 2021 оны хэрэгцээг жишсэн хүн амд шилжүүлэн тооцож үзэхэд улсын хэмжээнд жилд 117.5 мянган тонн мах, 156.7 мянган литр сүүний хэрэгцээтэй байна.

ХҮСНЭГТ V.7. МАХ, СҮҮНИЙ ДОТООДЫН ҮЙЛДВЭРЛЭЛ, ХАНГАМЖИЙН ХУВЬ

| Төрөл | Жишсэн дундаж нэг хүний жилийн хүнсний хэрэгцээ*, кг | | Жишсэн хүн амын жилийн хүнсний хэрэгцээээ, мян.т | | Дотоодын үйлдвэрлэл, мян.т | | Хангамжийн хувь | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | 2011 | 2021 | 2011 | 2021 | 2011 | 2021 | 2011 | 2021 |
| Мах | 63.9 | 43.8 | 172.7 | 117.5 | 202.1 | 557.0 | 117.0 | 99.6 |
| Сүү | 63.9 | 58.4 | 172.7 | 156.7 | 520.0 | 434.2 | 301.0 | 100.0 |

Жишсэн хүн амын жилийн махны хэрэгцээг 2021 онд 99.6 хувь, сүүний 100.0 хувийг дотоодын үйлдвэрлэлээр хангасан байна.

## V.4. Мал аж ахуйн бүтээгдэхүүнээ борлуулж байгаа байдал

МАА-н үйл ажиллагаа эрхэлдэг өрх, ААНБ-ын үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнээ хэрхэн борлуулдаг, бүтээгдэхүүний борлуулалттай холбоотой ямар хүндрэл, гардаг, бүтээгдэхүүний үнийг хэрхэн тогтоодог зэргийн талаарх мэдээллийг ХАА-н тооллогоор цуглуулж үр дүнг гаргалаа.

ХАА-н үйлдвэрлэл эрхлэгчид бүтээгдэхүүнээ хэрхэн борлуулж буй хэлбэрийг “Худалдаа эрхлэгчдэд шууд борлуулдаг”, “Аж ахуйн нэгж, байгууллагад борлуулдаг”, “Зах зээлд өөрсдөө борлуулдаг”, “Бусад” гэсэн ангиллаар судалсан.

Тооллогод МАА эрхэлдэг нийт 245.4 мянган өрх хамрагдсаны 213.5 мянган өрх нь бүтээгдэхүүн борлуулсан байна. Үүнээс 114.6 мянга буюу 53.7 хувь нь үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнээ зах зээлд өөрсдөө борлуулдаг, 111.0 мянга буюу 52.0 хувь нь үйлдвэрлэлийн нэгжээсээ худалдаа эрхлэгчдэд шууд худалддаг, 52.5 мянга буюу 2.5 хувь нь ААНБ-д бүтээгдэхүүнээ борлуулдаг байна. Харин 2.0 мянга буюу 0.9 хувь нь бусад хэлбэрээр борлуулж байна.

ХҮСНЭГТ V.8. МАЛ АЖ АХУЙ ЭРХЭЛДЭГ ӨРХИЙН БҮТЭЭГДЭХҮҮНЭЭ БОРЛУУЛДАГ ХЭЛБЭР, хувиар

| | Бүгд | | Худалдаа эрхлэгчдэд шууд | | ААНБ-д | | Зах зээлд өөрсдөө | | Бусад | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | 2011 | 2021 | 2011 | 2021 | 2011 | 2021 | 2011 | 2021 | 2011 | 2021 |
| Бүгд | 100.0 | 100.0 | 37.2 | 52.0 | 5.8 | 2.5 | 76.8 | 53.7 | 3.5 | 0.9 |
| Баруун бүс | 100.0 | 100.0 | 44.2 | 68.1 | 6.1 | 2.0 | 77.7 | 40.3 | 1.9 | 0.4 |
| Хангайн бүс | 100.0 | 100.0 | 34.1 | 48.3 | 5.0 | 0.6 | 78.6 | 57.9 | 3.2 | 0.7 |
| Төвийн бүс | 100.0 | 100.0 | 31.0 | 41.0 | 7.4 | 3.6 | 77.6 | 62.5 | 5.5 | 1.6 |
| Зүүн бүс | 100.0 | 100.0 | 44.4 | 46.9 | 3.5 | 4.3 | 69.2 | 58.1 | 3.0 | 1.0 |
| Улаанбаатар | 100.0 | 100.0 | 26.5 | 39.6 | 11.1 | 19.8 | 67.8 | 41.9 | 10.7 | 3.7 |

Тооллогод хамрагдсан МАА-н үйл ажиллагаа эрхэлдэг 407 ААНБ-ын 130 буюу 54.6 хувь нь зах зээлд өөрсдөө борлуулдаг, 81 буюу 34.0 хувь нь худалдаа эрхлэгчдэд борлуулдаг, 21 буюу 8.8 хувь нь ААНБ-д борлуулдаг байна. Харин 25 буюу 10.5 хувь нь бусад хэлбэрээр борлуулалт хийжээ.

ХҮСНЭГТ V.9. МАЛ АЖ АХУЙ ЭРХЭЛДЭГ ААНБ-ЫН БҮТЭЭГДЭХҮҮНЭЭ БОРЛУУЛДАГ ХЭЛБЭР, бүс, хувиар

| | Бүгд | | Худалдаа эрхлэгчдэд шууд | | ААНБ-д | | Зах зээлд өөрсдөө | | Бусад | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | 2011 | 2021 | 2011 | 2021 | 2011 | 2021 | 2011 | 2021 | 2011 | 2021 |
| Бүгд | 100.0 | 58.5 | 19.7 | 34.0 | 11.8 | 8.8 | 71.6 | 54.6 | 14.8 | 10.5 |
| Баруун бүс | 100.0 | 73.7 | 27.6 | 42.9 | 11.4 | 0.0 | 84.8 | 57.1 | 6.7 | 0.0 |
| Хангайн бүс | 100.0 | 44.4 | 11.0 | 35.4 | 7.6 | 6.3 | 78.0 | 52.1 | 14.4 | 10.4 |
| Төвийн бүс | 100.0 | 60.9 | 23.6 | 38.1 | 13.7 | 14.3 | 63.4 | 52.4 | 16.8 | 10.7 |
| Зүүн бүс | 100.0 | 63.3 | 25.6 | 30.9 | 20.9 | 3.7 | 65.1 | 60.5 | 11.6 | 9.9 |
| Улаанбаатар | 100.0 | 78.6 | 11.3 | 9.1 | 10.0 | 27.3 | 65.0 | 36.4 | 23.8 | 27.3 |

МАА-н үйл ажиллагаа эрхэлдэг өрхийн бүтээгдэхүүнээ борлуулдаг хэлбэрийг бүсээр авч үзэхэд Төвийн болон Баруун, бүсэд 38.1-42.9 хувь байгаа нь бүстэй харьцуулахад худалдаа эрхлэгчид газар дээр нь очиж бүтээгдэхүүнийг худалдан авах нь өндөр байна.  ААНБ-ын хувьд үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнээ зах зээлд өөрсдөө борлуулдаг хэлбэр өндөр буюу 36.4-60.5 хувийг бүсүүдэд эзэлж байна.

## V.5. Мал аж ахуйн үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний борлуулалттай холбоотой гардаг хүндрэл, бэрхшээл

МАА-н үйлдвэрлэл эрхэлдэг өрх, ААНБ-ын хувьд бүтээгдэхүүний борлуулалттай холбоотой хүндрэл, бэрхшээл ихээхэн гардаг нь тооллогын дүнгээр харагдаж байна. Хэрэглэгч цөөн, бүтээгдэхүүн хадгалах зоорь, агуулах дутагдалтай, зах зээлээс алслагдсан байдаг зэрэг хүндрэлүүд 13.4-74.5 хувь байгаа нь 2011 оныхоос 6.3-27.1 нэгж хувиар өссөн байна.

ХҮСНЭГТ V.10. МАЛ АЖ АХУЙ ЭРХЭЛДЭГ ӨРХИЙН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ БОРЛУУЛТТАЙ ХОЛБООТОЙ ГАРДАГ ХҮНДРЭЛ, БЭРХШЭЭЛ, бүс, хувиар

| | Бүгд | | Баруун бүс | | Хангайн бүс | | Төвийн бүс | | Зүүн бүс | | Улаанбаатар | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | 2011 | 2021 | 2011 | 2021 | 2011 | 2021 | 2011 | 2021 | 2011 | 2021 | 2011 | 2021 |
| Бүгд | 100.0 | 100.0 | 100.0 | 100.0 | 100.0 | 100.0 | 100.0 | 100.0 | 100.0 | 100.0 | 100.0 | 100.0 |
| Борлуулалттай удаашралтай | 11.7 | 0.0 | 14.0 | 0.0 | 9.6 | 0.0 | 13.8 | 0.0 | 10.8 | 0.0 | 10.0 | 0.0 |
| Хэрэглэгч цөөн | 7.1 | 13.4 | 7.9 | 12.2 | 6.7 | 10.6 | 6.8 | 19.4 | 6.1 | 14.8 | 12.0 | 30.1 |
| Өрсөлдөгч олон | 13.8 | 0.0 | 11.3 | 0.0 | 13.8 | 0.0 | 16.2 | 0.0 | 12.3 | 0.0 | 28.7 | 0.0 |
| Үнэ хямд | 61.5 | 0.0 | 62.5 | 0.0 | 62.7 | 0.0 | 64.8 | 0.0 | 51.0 | 0.0 | 51.9 | 0.0 |
| Бүтээгдэхүүнээ хадгалах зоорь, агуулах дутагдалтай | 10.8 | 18.0 | 8.1 | 12.3 | 11.0 | 21.0 | 13.4 | 21.6 | 11.3 | 18.9 | 13.4 | 27.4 |
| Зах зээлээс алслагдсан | 47.4 | 74.5 | 63.8 | 85.8 | 44.1 | 73.0 | 30.8 | 57.8 | 51.1 | 72.6 | 37.9 | 60.6 |
| Бусад | 3.5 | 7.4 | 1.3 | 2.5 | 3.3 | 7.7 | 5.7 | 15.2 | 4.0 | 7.1 | 10.8 | 19.9 |

Мал аж ахуйн салбарт үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний зах зээлээс алслагдсан байгаа нь борлуулалтад гол хүндрэл  болж байна.

ХҮСНЭГТ V.11. МАЛ АЖ АХУЙ ЭРХЭЛДЭГ ААНБ-ЫН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ БОРЛУУЛТТАЙ ХОЛБООТОЙ ГАРДАГ ХҮНДРЭЛ, БЭРХШЭЭЛ, бүс, хувиар

| | Бүгд | | Баруун бүс | | Хангайн бүс | | Төвийн бүс | | Зүүн бүс | | Улаанбаатар | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | 2011 | 2021 | 2011 | 2021 | 2011 | 2021 | 2011 | 2021 | 2011 | 2021 | 2011 | 2021 |
| Бүгд | 100.0 | 100.0 | 100.0 | 100.0 | 100.0 | 100.0 | 100.0 | 100.0 | 100.0 | 100.0 | 100.0 | 100.0 |
| Борлуулалттай удаашралтай | 15.4 | 0.0 | 19.0 | 0.0 | 11.9 | 0.0 | 14.3 | 0.0 | 25.6 | 0.0 | 12.5 | 0.0 |
| Хэрэглэгч цөөн | 7.3 | 28.6 | 6.7 | 0.0 | 11.0 | 0.0 | 3.1 | 40.0 | 20.9 | 20.0 | 3.8 | 50.0 |
| Өрсөлдөгч олон | 15.8 | 25.0 | 14.3 | 0.0 | 18.6 | 20.0 | 16.1 | 33.3 | 4.7 | 20.0 | 18.8 | 0.0 |
| Үнэ хямд | 51.5 | 0.0 | 57.1 | 0.0 | 45.8 | 0.0 | 58.4 | 0.0 | 48.8 | 0.0 | 40.0 | 0.0 |
| Бүтээгдэхүүнээ хадгалах зоорь, агуулах дутагдалтай | 16.4 | 35.7 | 14.3 | 0.0 | 22.9 | 20.0 | 11.8 | 46.7 | 18.6 | 40.0 | 17.5 | 0.0 |
| Зах зээлээс алслагдсан | 29.6 | 0.0 | 50.5 | 0.0 | 22.0 | 0.0 | 24.2 | 0.0 | 23.3 | 0.0 | 27.5 | 0.0 |
| Бусад | 12.0 | 28.6 | 5.7 | 100.0 | 7.6 | 60.0 | 13.0 | 13.3 | 16.3 | 20.0 | 22.5 | 50.0 |

ААНБ-ын хувьд МАА-н бүтээгдэхүүнээ хадгалах зоорь, агуулах байхгүй байгаа нь бүх бүсийн хувьд гол хүндрэл бэрхшээл байгаа бол Хангайн бүсэд бүтээгдэхүүн хадгалах зоорь, агуулах дутагдалтай, Төвийн бүсэд өрсөлдөгч олонтой, Зүүн бүсэд борлуулалт удаашралтай зэрэг нь бүс тус бүрийн байгалийн болоод газар зүйн онцлогтой салшгүй холбоотой юм.

## V.6. Мал аж ахуйн салбарын бүтээгдэхүүнийхээ үнийг тогтоодог хэлбэр

Бүтээгдэхүүнийхээ үнийг тогтоодог хэлбэрийг зардал дээр ашгийг нэмэх замаар, хэрэглэгчтэй харилцан тохиролцсоны үндсэн дээр, өрсөлдөгчийн үнээс хамаарч, зах зээлийн үнэ ханшаар, бусад гэсэн үзүүлэлтүүдээр нэгтгэж гаргасан.

ХҮСНЭГТ V.12. МАЛ АЖ АХУЙ ЭРХЭЛДЭГ ӨРХИЙН БҮТЭЭГДЭХҮҮНИЙХЭЭ ҮНИЙГ ТОГТООДОГ ХЭЛБЭР, бүс, хувиар

| | Бүгд | | Баруун бүс | | Хангайн бүс | | Төвийн бүс | | Зүүн бүс | | Улаанбаа-тар | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | 2011 | 2021 | 2011 | 2021 | 2011 | 2021 | 2011 | 2021 | 2011 | 2021 | 2011 | 2021 |
| Бүгд | 100.0 | 100.0 | 100.0 | 100.0 | 100.0 | 100.0 | 100.0 | 100.0 | 100.0 | 100.0 | 100.0 | 100.0 |
| Зардал дээр ашиг нэмэх замаар | 4.6 | 2.3 | 7.2 | 3.3 | 3.2 | 1.6 | 4.2 | 1.7 | 4.1 | 3.0 | 2.3 | 2.9 |
| Хэрэглэгчтэй харилцан тохиролцож | 30.5 | 16.2 | 31.4 | 17.8 | 31.1 | 14.9 | 29.6 | 15.8 | 28.0 | 16.1 | 30.1 | 22.2 |
| Өрсөлдөгчийн үнээс хамаарч | 9.5 | 1.3 | 10.8 | 1.4 | 8.7 | 0.8 | 9.6 | 1.9 | 7.8 | 1.1 | 14.5 | 2.8 |
| Зах зээлийн үнэ ханшаар | 86.3 | 86.9 | 87.8 | 85.9 | 86.6 | 88.6 | 84.8 | 86.3 | 87.4 | 86.6 | 72.8 | 79.1 |
| Бусад | 2.1 | 0.6 | 1.0 | 0.1 | 1.8 | 0.5 | 3.6 | 1.4 | 1.7 | 0.4 | 8.6 | 1.8 |

Мал аж ахуйн үйл ажиллагаа эрхэлдэг өрхийн 185.6 мянга буюу 86.9 хувь нь бүтээгдэхүүнийхээ үнийг зах зээлийн үнэ ханшаар тогтоодог байна. 2011 оноос 0.6 хувь өссөн байна.

ХҮСНЭГТ V.13. МАЛ АЖ АХУЙ ЭРХЭЛДЭГ ААНБ-ЫН БҮТЭЭГДЭХҮҮНИЙХЭЭ ҮНИЙГ ТОГТООДОГ ХЭЛБЭР, бүсээр

| | Бүгд | | Баруун бүс | | Хангайн бүс | | Төвийн бүс | | Зүүн бүс | | Улаанбаатар | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | 2011 | 2021 | 2011 | 2021 | 2011 | 2021 | 2011 | 2021 | 2011 | 2021 | 2011 | 2021 |
| Бүгд | 100.0 | 100.0 | 100.0 | 100.0 | 100.0 | 100.0 | 100.0 | 100.0 | 100.0 | 100.0 | 100.0 | 100.0 |
| Өртөг ашгийн нийлбэрээр | 9.3 | 5.5 | 10.5 | 0.0 | 6.8 | 6.3 | 8.7 | 4.8 | 14.0 | 6.2 | 10.0 | 9.1 |
| Худалдан авагчтай тохиролцсоны үндсэн дээр | 18.5 | 9.2 | 14.3 | 21.4 | 20.3 | 4.2 | 19.9 | 6.0 | 20.9 | 11.1 | 17.5 | 27.3 |
| Өрсөлдөгчийн үнээс хамаарч | 7.9 | 1.7 | 13.3 | 0.0 | 9.3 | 0.0 | 5.6 | 4.8 | 7.0 | 0.0 | 3.8 | 0.0 |
| Зах зээлийн үнэ, ханшаар | 81.3 | 84.0 | 86.7 | 92.9 | 83.1 | 87.5 | 82.6 | 86.9 | 83.7 | 81.5 | 67.5 | 54.5 |
| Бусад | 8.9 | 3.8 | 2.9 | 0.0 | 5.9 | 4.2 | 10.6 | 3.6 | 7.0 | 3.7 | 18.8 | 9.1 |

Мал аж ахуй эрхэлдэг ААНБ-ын 200 буюу 84.0 хувь нь зах зээлийн үнэ ханшаар бүтээгдэхүүнийхээ үнийг тогтоодог байдал бүх бүсүүдэд давамгайлжээ.

## V.7. Газар тариалангийн салбарын бүтээгдэхүүн үйлдвэрлэл, борлуулалт

Тооллогын үндсэн үр дүнгээр 2021 онд нийт 550.7 мянган тонн үр тариа, 192.1 мянган тонн төмс, 150.1 мянган тонн хүнсний ногоо, 378.0 мянган тонн тэжээлийн ургамал, 49.3 мянган тонн техникийн ургамал хураан авсан байна. Аж ахуйн нэгж байгууллагын хураасан ургац нийт хураасан үр тарианы 90.1 хувь, төмсний 20.3 хувь, хүнсний ногооны 24.1 хувь, тэжээлийн ургамлын 52.4 хувь, техникийн ургамлын 90.0 хувийг тус тус эзэлж байна. Харин иргэд, өрхийн аж ахуйн хураасан ургац нийт хураасан үр тарианы 9.9 хувь, төмсний 79.7 хувь, хүнсний ногооны 75.9 хувь, тэжээлийн ургамлын 47.6 хувь, техникийн ургамлын 10.0 хувийг тус тус эзэлж байна.

Аж ахуйн нэгж байгууллага үр тариа, техник, тэжээлийн ургамал дийлэнхдээ тариалж байгаа бол төмс, хүнсний ногоог өрхийн тариалалтаар хангаж байна.

ХҮСНЭГТ V.14. ХУРААСАН УРГАЦ, төрлөөр, мянган тонноор

| | Бүгд | | Үүнээс | | | | Дунд эзлэх хувь | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Өрх | | ААНБ | | Өрх | | ААНБ | |
| | 2011 | 2021 | 2011 | 2021 | 2011 | 2021 | 2011 | 2021 | 2011 | 2021 |
| Өрх, ААНБ-ын тоо | 35 166 | 20 487 | 33 461 | 18 844 | 1705 | 1 643 | 95.2 | 92.0 | 4.8 | 8.0 |
| Хураасан ургац, мянган тонн | | | | | | | | | | |
| Үр тариа | 457.2 | 550.7 | 43.4 | 54.3 | 413.8 | 496.4 | 9.5 | 9.9 | 90.5 | 90.1 |
| Төмс | 223.3 | 192.1 | 158.4 | 153.2 | 65.0 | 38.9 | 70.9 | 79.7 | 29.1 | 20.3 |
| Хүнсний ногоо | 109.7 | 150.1 | 92.1 | 113.9 | 17.6 | 36.2 | 83.9 | 75.9 | 16.1 | 24.1 |
| Тэжээлийн ургамал | 42.4 | 378.0 | 18.8 | 180.0 | 23.5 | 198.0 | 44.4 | 47.6 | 55.6 | 52.4 |
| Техникийн ургамал | 6.6 | 49.3 | 1.7 | 4.9 | 4.9 | 44.4 | 25.6 | 10.0 | 74.4 | 90.0 |

Хураасан ургацыг бүсээр авч үзвэл, нийт хураасан үр тарианы 66.6 хувь, төмсний 76.3 хувь, хүнсний ногооны 66.8 хувь, тэжээлийн ургамлын 59.3 хувь, техникийн ургамлын 86.2 хувийг Төвийн бүсэд үйлдвэрлэсэн байна. Төвийн бүс нь манай улсын газар тариалангийн гол бүс бөгөөд Сэлэнгэ, Төв аймгууд энэ бүсэд багтдагтай холбогдолтой.

Хураасан ургацыг бүсээр задалж харвал, Төвийн бүсэд 366.5 (66.6%) мянган тонн, Хангайн бүсэд 88.9 (16.2%) мянган тонн, Зүүн бүсэд 53.3 (9.7%) мянган тонн, Баруун бүсэд 41.9 (7.6%) мянган тонныг хураасан байна.

Хураасан төмс Төвийн бүсэд 146.6 (76.3%) мянган тонн, Баруун бүсэд 19.7 (10.2%) мянган тонн, Хангайн бүсэд 18.9 (9.8%) мянган тонн, Зүүн бүсэд 5.5 (2.9%) мянган тонн, Улаанбаатарт 1.5 (0.8%) мянган тонныг хураасан байна.

ХҮСНЭГТ V.15. ХУРААСАН УРГАЦ, нэр төрөл, бүсээр, мянган тонн

| | Бүгд | | Баруун бүс | | Хангайн бүс | | Төвийн бүс | | Зүүн бүс | | Улаанбаатар | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | 2011 | 2021 | 2011 | 2021 | 2011 | 2021 | 2011 | 2021 | 2011 | 2021 | 2011 | 2021 |
| Үр тариа | 457.2 | 550.7 | 10.7 | 41.9 | 79.6 | 88.9 | 347.3 | 366.5 | 19.6 | 53.3 | - | 0.02 |
| Төмс | 253.3 | 192.1 | 28.0 | 19.7 | 64.5 | 18.9 | 144.6 | 146.6 | 7.6 | 5.5 | 8.7 | 1.52 |
| Хүнсний ногоо | 109.7 | 150.1 | 19.1 | 19.8 | 15.3 | 16.3 | 67.5 | 100.3 | 3.5 | 5.8 | 4.3 | 7.99 |
| Тэжээлийн ургамал | 42.4 | 378.0 | 19.6 | 40.6 | 8.8 | 66.3 | 9.7 | 224.2 | 3.1 | 43.9 | 1.2 | 2.90 |
| Техникийн ургамал | 6.6 | 49.3 | 0.0 | 1.0 | 0.7 | 2.6 | 5.8 | 42.5 | 0.1 | 3.2 | - | - |

Харин хураасан хүнсний ногоо Төвийн бүсэд 100.6 (66.8%) мянган тонн, Баруун бүсэд 19.8 (13.2%) мянган тонн, Хангайн бүсэд 16.3 (10.8%) мянган тонн, Улаанбаатарт 8.0 (5.3%) мянган тонн, Зүүн бүсэд 5.8 (3.8%) мянган тонныг хураасан байна.

Хураасан үр тариа 2011 оноос 93.4 (20.4%) мянган тонноор нэмэгдсэн байна. Үр тарианы 92.1 хувийг буудай эзэлж байгаа бөгөөд нийт буудайн 66.6 хувийг Төвийн бүсээс, 16.8 хувийг Хангайн бүсээс, 9.2 хувийг Зүүн бүсээс, 7.3 хувийг Баруун бүсээс хураасан авсан байна.

ЗУРАГ V.4. ГАЗАР ТАРИАЛАНГИЙН САЛБАРЫН ҮЙЛДВЭРЛЭСЭН ҮР ТАРИА



ЗУРАГ V.5. ГАЗАР ТАРИАЛАНГИЙН САЛБАРЫН ҮЙЛДВЭРЛЭСЭН ТӨМС




## V.8. Жишсэн хүн амын жилийн төмс, хүнсний ногооны хэрэгцээ

Эрүүл мэндийн сайдын 2017 оны 2 сарын 23-ны өдрийн А/74 дугаар тушаалын дагуу жишсэн хүнд шилжүүлэх итгэлцүүр болон жишсэн нэг хүний хоногийн болон жилийн хүнсний хэрэгцээний нормыг ашиглан гол нэр төрлийн хүнсний бүтээгдэхүүний жилийн хэрэгцээг улсын хэмжээнд тооцлоо. Манай улсын хүн амын хүнсний гол нэрийн бүтээгдэхүүн болох төмс, хүнсний ногооны 2021 оны хэрэглээг жишсэн хүн амд шилжүүлэн тооцож үзэхэд улсын хэмжээнд жилд нийт 117.5 мянган тонн төмс, 254.6 мянган тонн хүнсний ногоо хэрэгцээтэй байна.

ХҮСНЭГТ V.16. ТӨМС, ХҮНСНИЙ НОГООНЫ ДОТООДЫН ҮЙЛДВЭРЛЭЛ, ХАНГАМЖИЙН ХУВЬ

| Төрөл | Жишсэн дундаж нэг хүний жилийн хүнсний хэрэгцээ*, кг | | Жишсэн хүн амын жилийн хүнсний хэрэгцээ, мян.тн | | Дотоодын үйлдвэрлэл, мян.тн | | Хангамжийн хувь | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | 2011 | 2021 | 2011 | 2021 | 2011 | 2021 | 2011 | 2021 |
| Төмс | 51.1 | 43.8 | 142.4 | 117.5 | 223.3 | 192.1 | 156.8 | 99.9 |
| Хүнсний ногоо | 73.0 | 94.9 | 203.4 | 254.6 | 109.7 | 150.1 | 53.9 | 66.5 |

Жишсэн хүн амын жилийн төмсний хэрэгцээг 2021 онд 99.9 хувь, хүнсний ногооны 66.5 хувийг дотоодын үйлдвэрлэлээр хангасан байна.

## V.9. Га-гийн ургац

Газар тариалан эрхэлдэг өрх, ААНБ нь нэг га талбайгаас дунджаар 14.1 центнер үр тариа, 99.7 центнер төмс, 43.1 центнер тэжээлийн ургамал, 5.3 центнер техникийн ургамал хураан авсан байна.

ЗУРАГ V.6. НЭГ ГА ТАЛБАЙГААС ХУРААН АВСАН УРГАЦЫН ХЭМЖЭЭ, центнерээр




Нэг га талбайгаас хураан авсан үр тариа Төвийн бүсэд хамгийн өндөр буюу 14.6 центнер байгаа нь 2011 оноос 0.7 центнерээр буурсан байна.

Төмсний га-гийн ургац Төвийн бүс, Зүүн бүс, Баруун бүсэд улсын дунджаас 0.6-8.2 центнерээр их, Хангайн бүс болон Улаанбаатарт 4.0-15.0 центнерээр бага байна.

ХҮСНЭГТ V.17. НЭГ ГА ТАЛБАЙГААС ХУРААН АВСАН УРГАЦЫН ХЭМЖЭЭ, бүсээр, центнер

| | Улсын дундаж | | Баруун бүс | | Хангайн бүс | | Төвийн бүс | | Зүүн бүс | | Улаанбаатар | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | 2011 | 2021 | 2011 | 2021 | 2011 | 2021 | 2011 | 2021 | 2011 | 2021 | 2011 | 2021 |
| Үр тариа | 14.9 | 14.1 | 12.3 | 13.3 | 14.6 | 15.0 | 15.3 | 14.6 | 10.9 | 10.4 | - | - |
| Буудай | 15.0 | 14.0 | 11.4 | 11.7 | 14.7 | 16.1 | 15.5 | 14.9 | 11.0 | 10.7 | - | - |
| Төмс | 118.4 | 99.7 | 117.2 | 108.0 | 111.7 | 95.7 | 120.0 | 100.3 | 118.5 | 100.7 | 124.5 | 84.7 |

## V.10. Ургац хураалтын дараах боловсруулалтын үе шат бүрийн алдагдал/хорогдол

Ургац хураалтын дараах алдагдал/хорогдлын мэдээллийг хураах, бутлах, цайруулах, хатаах, цэвэрлэх, шигших, тээвэрлэх, хадгалах гэсэн үе шатаар, ургамлын төрлөөр, алдагдал/хорогдол үүссэн шалтгаанаар дэлгэрүүлэн цуглуулж, үр дүнг харууллаа.

Ургац хураасны дараа гарсан алдагдал/хорогдол нь нийт хураасан ургацын 1.6 хувийг эзэлж байна. Ургац хураалтын дараах алдагдал/хорогдлын 0.5 хувь нь хураах үед, 0.1 хувь нь бутлах, цайруулах үед, 0.1 хувь нь хатаах үед, 0.2 хувь нь цэвэрлэх, шигших үед, 0.4 хувь нь тээвэрлэх үед, 0.7 хувь нь хадгалалтын үед тус тус гарсан байна.

ХҮСНЭГТ V.18. УРГАЦ ХУРААЛТЫН ДАРААХ АЛДАГДАЛ/ХОРОГДЛЫН ХУВЬ, үе шат, ургамлын төрлөөр

| | Нийт хорогдол | Хураах үе | Бутлах, цайруулах | Хатаах | Цэвэрлэх, шигших | Тээвэрлэх | Хадгалах |
|---|---|---|---|---|---|---|---|
| Үр тариа | **0.3** | 0.1 | 0.0 | 0. 0 | 0.1 | 0.0 | 0.1 |
| Төмс | **3.6** | 1.1 | 0.4 | 0.1 | 0.4 | 0.0 | 1.6 |
| Хүнсний ногоо | **2.7** | 0.9 | 0.2 | 0.4 | 0.2 | 0.1 | 0.9 |
| Тэжээлийн ургамал | **2.1** | 0.8 | 0.0 | 0.2 | 0.1 | 0.1 | 1.0 |
| Техникийн ургамал | **0.8** | 0.3 | 0.1 | 0.0 | 0.3 | 0.0 | 0.1 |
| **Нийт** | **1.6** | **0.5** | **0.1** | **0.1** | **0.2** | **0.4** | **0.7** |

## V.11. Газар тариалангийн салбарт үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн, хэрэглээний зориулалтаар

Газар тариалан эрхэлдэг өрх, ААНБ-ын нийт үйлдвэрлэсэн/хураасан ургацын хэмжээг нэр төрлөөр нь үрэнд хадгалсан, өөрийн үйлдвэрлэлд хэрэглэсэн, өөртөө хүнсэнд хэрэглэсэн, борлуулсан, ажиллагчдад цалин хөлсөнд олгосон, нөөцөлсөн, бусад гэсэн ангиллаар үр дүнг нэгтгэн гаргалаа.

ХҮСНЭГТ V.19. ГАЗАР ТАРИАЛАНГИЙН САЛБАРТ ҮЙЛДВЭРЛЭСЭН БҮТЭЭГДЭХҮҮН, хэрэглээний зориулалтаар, мянган тонн

| | Нийт үйлдвэрлэсэн/ хураасан | | Үрэнд | | Өөртөө хэрэглэсэн | | | | Борлуулсан | | Бусад | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | Үйлдвэрлэлд | | Хүнсэнд | | | | | |
| | 2011 | 2021 | 2011 | 2021 | 2011 | 2021 | 2011 | 2021 | 2011 | 2021 | 2011 | 2021 |
| Үр тариа | 457.2 | 549.1 | 41.6 | 4.7 | 26.7 | 14.4 | 23.3 | 0.2 | 331.7 | 494.4 | 34.0 | 35.4 |
| Төмс | 223.3 | 185.2 | 35.5 | 31.9 | 1.2 | - | 41.2 | 9.6 | 127.9 | 132.2 | 17.6 | 11.5 |
| Хүнсний ногоо | 109.7 | 146.0 | 1.6 | 0.9 | 6.2 | - | 27.4 | 15.1 | 69.6 | 118.2 | 4.8 | 11.7 |
| Тэжээлийн ургамал | 42.4 | 369.8 | - | 1.4 | 9.5 | - | - | - | 28.8 | 283.6 | 4.0 | 84.7 |
| Техникийн ургамал | 6.6 | 48.9 | - | 0.1 | 0.3 | - | - | - | 5.1 | 48.5 | 1.3 | 0.3 |

Газар тариалан эрхэлдэг өрх, ААНБ нь үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнээ голчлон зах зээлд борлуулдаг байна. тухайлбал, үйлдвэрлэсэн үр тарианы 90.0 хувийг борлуулж, 4.7 хувийг үрэнд хадгалж, үйлдвэрлэсэн төмсний 71.4 хувийг борлуулж, 17.2 хувийг үрэнд хадгалж, 5.2 хувийг хүнсэнд хэрэглэсэн байна. Харин үйлдвэрлэсэн хүнсний ногооны 81.0 хувийг борлуулж, 10.3 хувийг хүнсэндээ хэрэглэсэн байна.

## V.12. Газар тариалангийн бүтээгдэхүүнээ борлуулж байгаа байдал

Газар тариалан эрхэлдэг өрх, ААНБ-ын үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнээ хэрхэн борлуулдаг, бүтээгдэхүүний борлуулалттай холбоотой ямар хүндрэл, гардаг бүтээгдэхүүний үнийг хэрхэн тогтоодог талаарх мэдээллийг энэ хэсэгт авч үзье.

ХАА-н үйлдвэрлэл эрхлэгчид бүтээгдэхүүнээ хэрхэн борлуулж буй хэлбэрийг "Худалдаа эрхлэгчдэд шууд борлуулдаг", "Аж ахуйн нэгж, байгууллагад борлуулдаг", "Зах зээлд өөрсдөө борлуулдаг", "Бусад" гэсэн ангиллаар судалсан.

Тооллогод газар тариалан эрхэлдэг нийт 18.8 мян.өрх хамрагдсаны 9.2 мянга буюу 48.7 хувь нь үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнээ зах зээлд борлуулсан байна.

Үүнээс 6.8 мянга буюу 74.1 хувь нь  зах зээлд өөрсдөө, 3.4 мянга буюу 36.6 хувь нь худалдаа эрхлэгчдэд шууд, 476 буюу 5.2 хувь нь ААНБ-д, 123 буюу 1.3 хувь нь бусад хэлбэрээ тус тус борлуулж байна.

ЗУРАГ V.7. ӨРХИЙН БҮТЭЭГДЭХҮҮНЭЭ БОРЛУУЛДАГ ХЭЛБЭР, хувиар




Газар тариалан эрхэлдэг өрхийн бүтээгдэхүүнээ борлуулдаг хэлбэрийг бүсээр авч үзвэл Баруун бүсэд 39.5 хувь нь, Зүүн бүсэд 44.0 хувь байгаа нь бусад бүстэй харьцуулахад худалдаа эрхлэгчид газар дээр нь очиж бүтээгдэхүүнийг худалдан авах нь өндөр байна. Харин зах зээлд өөрсдөө борлуулах нь Зүүн бүсэд хамгийн бага буюу 68.5 хувь Улаанбаатарт хамгийн өндөр буюу 76.3 хувь байна. Энэ нь Улаанбаатарт өөрсдөө бүтээгдэхүүнээ борлуулах сонирхол өндөр байгааг харуулж байна.

Бүх бүс нутгийн хувьд ААНБ-д болон бусад хэлбэрээр бүтээгдэхүүнээ борлуулах сонирхол маш бага байна.

ХҮСНЭГТ V.20. ГАЗАР ТАРИАЛАН ЭРХЭЛДЭГ ӨРХИЙН БҮТЭЭГДЭХҮҮНЭЭ БОРЛУУЛДАГ ХЭЛБЭР, бүс, хувиар

| | Бүгд | | Худалдаа эрхлэгчдэд шууд | | ААНБ-д | | Зах зээлд өөрсдөө | | Бусад | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | 2011 | 2021 | 2011 | 2021 | 2011 | 2021 | 2011 | 2021 | 2011 | 2021 |
| Бүгд | 100.0 | 100.0 | 25.8 | 36.6 | 6.8 | 5.2 | 57.9 | 74.1 | 28.4 | 1.3 |
| Баруун бүс | 100.0 | 100.0 | 44.6 | 39.5 | 8 | 1.8 | 69.5 | 72.0 | 10.2 | 0.5 |
| Хангайн бүс | 100.0 | 100.0 | 21.1 | 33.9 | 8.8 | 4.9 | 54.1 | 74.4 | 31.2 | 1.6 |
| Төвийн бүс | 100.0 | 100.0 | 26.4 | 35.7 | 5.6 | 7.6 | 63.0 | 75.9 | 24.8 | 1.2 |
| Зүүн бүс | 100.0 | 100.0 | 34.9 | 44.0 | 7.9 | 3.4 | 49.8 | 68.5 | 26.6 | 3.9 |
| Улаанбаатар | 100.0 | 100.0 | 8.2 | 26.7 | 4.6 | 5.0 | 42.3 | 76.3 | 52.7 | 3.3 |

Хөдөө аж ахуй эрхэлдэг өрх, ААНБ-ын хувьд бүтээгдэхүүний борлуулалттай холбоотой хүндрэл ихээхэн гардаг нь тооллогын дүнгээр харагдаж байна. Бүтээгдэхүүний борлуулалттай холбоотой хүндрэл, бэрхшээлд борлуулалт

удаашралтай, хэрэглэгч цөөн, өрсөлдөгч олон, үнэ хямд, бүтээгдэхүүн хадгалах зоорь, агуулах дутагдалтай, зах зээлээс алслагдсан зэрэг борлуулалттай холбоотой хүндрэлийг багтаан авч үзсэн. Эдгээр хүндрэл бэрхшээлүүд нь 2011 оноос сайжирсан гэх зүйл харагдахгүй байна. ААНБ-ийн хувьд мөн адил зах зээлд өөрсдөө борлуулах сонирхол өндөр байна.

ЗУРАГ V.8. ААНБ-ЫН БҮТЭЭГДЭХҮҮНЭЭ БОРЛУУЛДАГ ХЭЛБЭР, хувиар




ХҮСНЭГТ V.21. ГАЗАР ТАРИАЛАН ЭРХЭЛДЭГ ААНБ-ЫН БҮТЭЭГДЭХҮҮНЭЭ БОРЛУУЛДАГ ХЭЛБЭР, бүс, хувиар

| | Бүгд | | Худалдаа эрхлэгчдэд шууд | | ААНБ-д | | Зах зээлд өөрсдөө | | Экспортод гаргадаг | | Бусад | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | 2011 | 2021 | 2011 | 2021 | 2011 | 2021 | 2011 | 2021 | 2011 | 2021 | 2011 | 2021 |
| Бүгд | 100.0 | 100.0 | 22.9 | 35.2 | 33.5 | 34.3 | 63.9 | 66.7 | 0.0 | 1.9 | 14.8 | 2.7 |
| Баруун бүс | 100.0 | 100.0 | 40.2 | 37.7 | 20.7 | 6.9 | 75.3 | 82.3 | 0.0 | 0.6 | 8.2 | 3.4 |
| Хангайн бүс | 100.0 | 100.0 | 27.3 | 31.3 | 42.6 | 34.1 | 62.4 | 63.6 | 0.0 | 0.9 | 13.8 | 0.9 |
| Төвийн бүс | 100.0 | 100.0 | 15.0 | 36.6 | 40.1 | 45.2 | 63.0 | 62.5 | 0.0 | 2.8 | 13.3 | 1.6 |
| Зүүн бүс | 100.0 | 100.0 | 22.9 | 31.4 | 41.7 | 18.6 | 54.2 | 74.4 | 0.0 | 2.3 | 12.5 | 10.5 |
| Улаанбаатар | 100.0 | 100.0 | 16.9 | 32.6 | 14.8 | 32.6 | 50.8 | 58.1 | 0.0 | 0.0 | 36.5 | 7.0 |

Газар тариалан эрхэлдэг ААНБ-ийн бүтээгдэхүүнээ борлуулдаг хэлбэрийг бүсээр авч үзвэл Баруун бүсэд 37.7 хувь нь, төвийн бүсэд 36.6 хувь байгаа нь бусад бүстэй харьцуулахад худалдаа эрхлэгчид газар дээр нь очиж бүтээгдэхүүнийг худалдан авах нь өндөр байна. Харин зах зээлд өөрсдөө борлуулах нь Улаанбаатарт хамгийн бага буюу 58.1 хувь Баруун бүсэд хамгийн их буюу 82.3 хувь байна. Энэ нь Баруун бүсийн ААНБ-ууд өөрсдөө зах зээлд бүтээгдэхүүнээ борлуулах сонирхол өндөр байгааг харуулж байна.

## V.13. Газар тариалангийн салбарын бүтээгдэхүүний борлуулалттай холбоотой тулгардаг хүндрэл, бэрхшээл

Газар тариалангийн бүтээгдэхүүний үнэ хямд байдал нь хүндрэл болдоггүй хэрэглэгч цөөн, өрсөлдөгч олон, зах зээлээс алслагдмал байдал, түүнчлэн бүх бүсийн өрхүүдэд бүтээгдэхүүн хадгалах зоорь, агуулах дутагдалтай байдаг нь мөн харагдаж байна.

ЗУРАГ V.9. ГАЗАР ТАРИАЛАН ЭРХЭЛДЭГ ӨРХИЙН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ БОРЛУУЛТТАЙ ХОЛБООТОЙ ГАРДАГ ХҮНДРЭЛ, БЭРХШЭЭЛ, хувиар




Хэрэглэгч цөөн, өрсөлдөгч олон, зах зээлээс алслагдмал байдал, түүнчлэн бүтээгдэхүүн хадгалах зоорь, агуулах дутагдалтай байгаа нь өрхийн хувьд бүтээгдэхүүнээ борлуулах гол хүндрэл бэрхшээл нь болж байна.

ХҮСНЭГТ V.22. ГАЗАР ТАРИАЛАН ЭРХЭЛДЭГ ӨРХИЙН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ БОРЛУУЛТТАЙ ХОЛБООТОЙ ГАРДАГ ХҮНДРЭЛ, БЭРХШЭЭЛ, бүс, хувиар

| | Бүгд | | Баруун бүс | | Хангайн бүс | | Төвийн бүс | | Зүүн бүс | | Улаанбаатар | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | 2011 | 2021 | 2011 | 2021 | 2011 | 2021 | 2011 | 2021 | 2011 | 2021 | 2011 | 2021 |
| Бүгд | 100.0 | 100.0 | 100.0 | 100.0 | 100.0 | 100.0 | 100.0 | 100.0 | 100.0 | 100.0 | 100.0 | 100.0 |
| Хэрэглэгч цөөн | 10.2 | 26.3 | 16.8 | 28.6 | 8.7 | 27.7 | 7.6 | 24.2 | 12.6 | 28.0 | 12.0 | 24.7 |
| Өрсөлдөгч олон | 26.5 | 45.7 | 30.6 | 39.3 | 22.0 | 52.7 | 29.1 | 49.4 | 20.3 | 26.4 | 25.4 | 32.9 |
| Бүтээгдэхүүнээ хадгалах зоорь, агуулах дутагдалтай | 19.7 | 47.7 | 22.3 | 40.2 | 22.7 | 51.2 | 19.0 | 50.2 | 23.5 | 51.3 | 12.3 | 45.2 |
| Зах зээлээс алслагдсан | 18.3 | 39.4 | 28.8 | 52.5 | 16.0 | 34.2 | 18.5 | 36.3 | 21.3 | 23.8 | 9.0 | 23.3 |
| Бусад | 22.2 | 2.9 | 6.3 | 2.1 | 24.8 | 2.8 | 20.9 | 2.7 | 21.4 | 4.6 | 38.1 | 16.4 |

Хангайн бүс өрсөлдөгч олон 52.7 хувь, Зүүн бүс бүтээгдэхүүн хадгалах зоорь, агуулах дутагдалтай 51.3 хувь, Баруун бүсийн зах зээлээс хол 52.5 хувь байгаа нь гол хүндрэл бэрхшээл болж байна.

ЗУРАГ V.10. ГАЗАР ТАРИАЛАН ЭРХЭЛДЭГ ААНБ-ЫН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ БОРЛУУЛТТАЙ ХОЛБООТОЙ ГАРДАГ ХҮНДРЭЛ, БЭРХШЭЭЛ, хувиар



Хэрэглэгч цөөн, өрсөлдөгч олон, зах зээлээс алслагдмал байдал, түүнчлэн бүтээгдэхүүн хадгалах зоорь, агуулах дутагдалтай байгаа нь бүтээгдэхүүнээ борлуулахад гол хүндрэл бэрхшээл болж байна.

ХҮСНЭГТ V.23. ГАЗАР ТАРИАЛАН ЭРХЭЛДЭГ ААНБ-ЫН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ БОРЛУУЛТТАЙ ХОЛБООТОЙ ГАРДАГ ХҮНДРЭЛ, БЭРХШЭЭЛ, бүс, хувиар

| | Бүгд | | Баруун бүс | | Хангайн бүс | | Төвийн бүс | | Зүүн бүс | | Улаанбаатар | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | 2011 | 2021 | 2011 | 2021 | 2011 | 2021 | 2011 | 2021 | 2011 | 2021 | 2011 | 2021 |
| Бүгд | 100.0 | 100.0 | 100.0 | 100.0 | 100.0 | 100.0 | 100.0 | 100.0 | 100.0 | 100.0 | 100.0 | 100.0 |
| Хэрэглэгч цөөн | 10.2 | 34.3 | 16.8 | 29.7 | 8.7 | 36.3 | 7.6 | 36.1 | 12.6 | 32.1 | 12.0 | 22.2 |
| Өрсөлдөгч олон | 26.5 | 43.9 | 30.6 | 31.7 | 22.0 | 56.0 | 29.1 | 45.0 | 20.3 | 39.3 | 25.4 | 44.4 |
| Бүтээгдэхүүнээ хадгалах зоорь, агуулах дутагдалтай | 19.7 | 54.8 | 22.3 | 71.3 | 22.7 | 42.9 | 19.0 | 54.4 | 23.5 | 46.4 | 12.3 | 55.6 |
| Зах зээлээс алслагдсан | 18.3 | 34.8 | 28.8 | 53.5 | 16.0 | 35.2 | 18.5 | 26.6 | 21.3 | 53.6 | 9.0 | 27.8 |
| Бусад | 22.2 | 5.4 | 6.3 | 0.0 | 24.8 | 6.6 | 20.9 | 7.2 | 21.4 | 1.8 | 38.1 | 5.6 |

Хангайн бүс өрсөлдөгч олон 56.0 хувь, Баруун бүс бүтээгдэхүүн хадгалах зоорь, агуулах дутагдалтай 71.3 хувь, зүүн бүсийн зах зээлээс хол 53.6 хувь байгаа нь гол хүндрэл бэрхшээл болж байна.

## V.14. Газар тариалангийн бүтээгдэхүүний үнийг тогтоодог хэлбэр

Бүтээгдэхүүнийхээ үнийг тогтоодог хэлбэрийг зардал дээр ашгийг нэмэх замаар, хэрэглэгчтэй харилцан тохиролцсоны үндсэн дээр, өрсөлдөгчийн үнээс хамаарч, зах зээлийн үнэ ханшаар, бусад гэсэн үзүүлэлтүүдээр мэдээллийг танилцуулж байна.

ЗУРАГ V.11. ГАЗАР ТАРИАЛАН ЭРХЭЛДЭГ ӨРХИЙН БҮТЭЭГДЭХҮҮНИЙХЭЭ ҮНИЙГ ТОГТООДОГ ХЭЛБЭР, хувиар




Газар тариалан эрхэлдэг өрхийн дийлэнх нь буюу 88.2 хувь нь зах зээлийн үнэ, ханшаар бүтээгдэхүүнээ борлуулдаг байна. Түүнчлэн хэрэглэгчтэй харилцан тохиролцсоны үндсэн дээр бүтээгдэхүүнээ борлуулдаг хэлбэр давамгайлж байна. Энэ нь 2011 оноос 20 хувь өссөн байна.

ХҮСНЭГТ V.24. ГАЗАР ТАРИАЛАН ЭРХЭЛДЭГ ӨРХ, БҮТЭЭГДЭХҮҮНИЙХЭЭ ҮНИЙГ ТОГТООДОГ ХЭЛБЭР, бүс, хувиар

| | Бүгд | | Баруун бүс | | Хангайн бүс | | Төвийн бүс | | Зүүн бүс | | Улаанбаатар | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | 2011 | 2021 | 2011 | 2021 | 2011 | 2021 | 2011 | 2021 | 2011 | 2021 | 2011 | 2021 |
| Бүгд | 100.0 | 100.0 | 100.0 | 100.0 | 100.0 | 100.0 | 100.0 | 100.0 | 100.0 | 100.0 | 100.0 | 100.0 |
| Өртөг ашгийн нийлбэрээр | 5.4 | 4.3 | 12.4 | 5.6 | 4.2 | 5.5 | 4.2 | 2.8 | 4.0 | 7.1 | 3.6 | 1.3 |
| Худалдан авагчтай тохиролцсоны үндсэн дээр | 23.5 | 17.0 | 27.9 | 21.4 | 21.0 | 15.4 | 26.4 | 16.0 | 21.8 | 14.8 | 16.5 | 10.8 |
| Өрсөлдөгчийн үнээс хамаарч | 15.6 | 5.5 | 18.3 | 4.1 | 14.0 | 5.2 | 18.0 | 5.9 | 13.2 | 10.7 | 10.1 | 1.3 |
| Зах зээлийн үнэ, ханшаар | 68.2 | 88.2 | 79.6 | 87.2 | 67.4. | 89.9 | 72.7 | 88.5 | 67.1 | 83.1 | 46.9 | 90.0 |
| Бусад | 21.2 | 0.5 | 5.8 | 0.3 | 23.6 | 0.4 | 20.1 | 0.4 | 18.8 | 1.0 | 37.2 | 2.1 |

Газар тариалан эрхэлдэг өрхийн 8.1 мянган өрх буюу 88.2 хувь нь бүтээгдэхүүнийхээ үнийг үндсэн арга хэлбэр болох зах зээлийн үнэ ханшаар тогтоодог байна.

ЗУРАГ V.12. ГАЗАР ТАРИАЛАН ЭРХЭЛДЭГ ААНБ-ЫН БҮТЭЭГДЭХҮҮНИЙХЭЭ ҮНИЙГ ТОГТООДОГ ХЭЛБЭР, хувиар




Газар тариалан эрхэлдэг ААНБ-ын дийлэнх нь буюу 86.5 хувь нь зах зээлийн үнэ, ханшаар бүтээгдэхүүнээ борлуулдаг байна. Түүнчлэн хэрэглэгчтэй харилцан тохиролцсоны үндсэн дээр бүтээгдэхүүнээ борлуулдаг хэлбэр давамгайлж байна. Энэ нь 2011 оноос 6.6 хувь өссөн байна.

ХҮСНЭГТ V.25. ГАЗАР ТАРИАЛАН ЭРХЭЛДЭГ ААНБ-ЫН БҮТЭЭГДЭХҮҮНИЙХЭЭ ҮНИЙГ ТОГТООДОГ ХЭЛБЭР, бүс, хувиар

| | Бүгд | | Баруун бүс | | Хангайн бүс | | Төвийн бүс | | Зүүн бүс | | Улаанбаатар | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | 2011 | 2021 | 2011 | 2021 | 2011 | 2021 | 2011 | 2021 | 2011 | 2021 | 2011 | 2021 |
| Бүгд | 100.0 | 100.0 | 100.0 | 100.0 | 100.0 | 100.0 | 100.0 | 100.0 | 100.0 | 100.0 | 100.0 | 100.0 |
| Өртөг ашгийн нийлбэрээр | 12.8 | 4.3 | 16.0 | 3.4 | 16.3 | 7.9 | 9.4 | 3.5 | 20.8 | 3.5 | 13.8 | 2.3 |
| Худалдан авагчтай тохиролцсоны үндсэн дээр | 31.6 | 24.5 | 36.4 | 30.3 | 32.3 | 23.4 | 32.6 | 23.6 | 39.6 | 26.7 | 14.8 | 14.0 |
| Өрсөлдөгчийн үнээс хамаарч | 19.4 | 9.5 | 23.4 | 5.7 | 23.4 | 7.9 | 18.6 | 9.1 | 12.5 | 25.6 | 10.6 | 4.7 |
| Зах зээлийн үнэ, ханшаар | 79.9 | 86.5 | 75.0 | 84.6 | 81.9 | 86.9 | 86.3 | 86.2 | 70.8 | 91.9 | 60.8 | 86.0 |
| Бусад | 8.2 | 1.3 | 4.6 | 0.6 | 6.7 | 1.4 | 6.1 | 1.2 | 4.2 | 3.5 | 27.0 | 0.0 |

VI БҮЛЭГ

# ХӨДӨӨ АЖ АХУЙН ЗОРИУЛАТТАЙ МАШИН ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ

| МАЛ АЖ АХУЙН | | ГАЗАР ТАРИАЛАН | |
|---|---|---|---|
| Трактор | 5 257 | Гинжит трактор | 241 |
| Мотоцикл | 72 504 | Үр тарианы комбайн | 1 018 |
| Суудлын машин | 50 057 | Зээтүү | 1 331 |
| Ачааны машин | 40 444 | Төмсний үрлүүр | 619 |

# VI. ХӨДӨӨ АЖ АХУЙН САЛБАРТ АШИГЛАГДАЖ БУЙ МАШИН, ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ

ХАА-н салбарт ашиглагдаж байгаа машин, тоног төхөөрөмжийн ашиглалтыг судлах зорилгоор тооллогын асуулгад тусгайлан бүлэг асуулга боловсруулж, мэдээллийг цуглуулсан. Тооллогод хамрагдсан газар тариалан эрхэлдэг 18.8 мянган өрх, 1.6 мянган ААНБ хамрагдаж, тэдгээрээс 9.4 мянган өрх, 879 ААНБ газар тариалангийн машин, тоног төхөөрөмжийг үйл ажиллагаандаа ашиглаж байна.

Харин МАА эрхэлдэг 902 ААНБ-аас нэлэнхий судалгаагаар, 245.4 мянган өрхийн 81.4 мянган өрхөөс түүвэр судалгаагаар мэдээлэл цуглуулж, үр дүнгийн тархаалтыг хийсэн. Тооллогын асуулгад МАА-н зориулалттай машин, тоног төхөөрөмжийг 29 нэр төрөлд, газар тариалангийн үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа тоног төхөөрөмжийг 70 нэр төрөлд ангилан авч үзлээ.

ХҮСНЭГТ VI.1. ХӨДӨӨ АЖ АХУЙН ЗОРИУЛАЛТТАЙ МАШИН, ТОНОГ ТӨХӨӨРӨМЖИЙН ТОО

| | | Нийт | | Ашиглаж байгаа | |
|---|---|---|---|---|---|
| | | 2011 | 2021 | 2011 | 2021 |
| **Бүгд** | | **234 636** | **212 929** | **232 603** | **209 923** |
| Мал аж ахуй | ААНБ | 952 | 453 | 929 | 448 |
| | Өрх | 193 218 | 174 501 | 191 577 | 172 917 |
| Газар тариалан | ААНБ | 14 143 | 16 353 | 13 987 | 15 952 |
| | Өрх | 26 323 | 21 622 | 26 110 | 20 606 |

ХАА эрхэлдэг өрх, ААНБ-ын өөрийн эзэмшлийн 212.9 мянган машин, тоног төхөөрөмжтэй байна. Үүний 209.9 мянга буюу 98.6 хувийг ашиглаж, 1.4 хувийг ашиглаагүй байна. 2011 онтой тооллогын дүнтэй харьцуулахад нийт машин, тоног төхөөрөмжийн тоо 9.3 (21.7 мянга) хувиар буурсан байна.

Нийт ашиглаж байгаа машин тоног, төхөөрөмжийн 173.4 мянга буюу 82.6 хувь нь МАА-н салбарт, 36.6 мянга буюу 17.4 хувь нь газар тариалангийн салбарт байна.

ХАА-н салбарын нийт өрхийн 92.9 хувь нь мал аж ахуйн салбарт байна. Эдгээр өрхөд ашиглаж байгаа машин, тоног төхөөрөмжийн 89.4 хувь нь ногдож байна. Газар тариалан эрхэлдэг өрх, нийт ХАА-н салбарын өрхийн 7.1 хувийг эзэлж, ашиглаж байгаа машин, тоног төхөөрөмжийн 10.6 хувийг эзэлж байна.

## VI.1. Мал аж ахуйн салбарын машин, тоног төхөөрөмж

Тооллогод МАА-н зориулалттай 175.0 мянган ширхэг машин, тоног төхөөрөмж бүртгэгджээ. Тэдгээрийг ашиглалтын байдлаар авч үзвэл 99.1 хувь нь өдөр тутмын үйл ажиллагаандаа ашигладаг байна. Мал аж ахуйн салбарын машин, тоног төхөөрөмж 2021 онд өмнөх тооллогын дүнгээс 11.6 (22.9 мянга) хувиар буурсан байна. Өдөр тутмын үйл ажиллагаандаа ашигладаг тоног төхөөрөмжийн тоо 1.8 нэгж хувиар өссөн байна.

Мал аж ахуй эрхэлдэг нийт өрхийн 35.8 хувь, машин, тоног төхөөрөмжийн 40.8 хувь нь Хангайн бүсэд, нийт өрхийн 27.0 хувь, машин, тоног төхөөрөмжийн 22.5 хувь нь Баруун бүсэд, нийт өрхийн 22.1 хувь, машин, тоног төхөөрөмжийн 23.8 нь Төвийн

бүсэд ногдож байна. Эндээс харахад дээрх бүсүүдэд машин, тоног төхөөрөмжийн хэрэглээ Зүүн болон Улаанбаатар хоттой харьцуулахад өндөр байна.

ХҮСНЭГТ VI.2. МАЛ АЖ АХУЙН ЗОРИУЛАЛТТАЙ МАШИН, ТОНОГ ТӨХӨӨРӨМЖИЙН ТОО, бүсээр

| | Нийт | | | Ашиглаж байгаа | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | Өрх | ААНБ | | Өрх | ААНБ |
| **Бүгд** | **174 954** | **174 501** | **453** | **173 365** | **172 917** | **448** |
| Баруун бүс | 39 466 | 39 249 | 217 | 38 478 | 38 264 | 214 |
| Хангайн бүс | 71 268 | 71 213 | 55 | 70 977 | 70 922 | 55 |
| Төвийн бүс | 41 607 | 41 474 | 133 | 41 460 | 41 329 | 131 |
| Зүүн бүс | 20 914 | 20 879 | 35 | 20 879 | 20 764 | 35 |
| Улаанбаатар | 1 699 | 1 686 | 13 | 1 651 | 1 638 | 13 |

2011 онтой харьцуулахад мал аж ахуй эрхэлдэг нийт өрх Хангайн бүсэд 1.3 нэгж хувиар буурч, машин, тоног төхөөрөмжийн хэрэглээ 7.6 нэгж хувиар өссөн байна. Баруун бүсэд нийт өрх 0.6 нэгж хувиар, машин, тоног төхөөрөмж 2.2 нэгж хувиар тус тус буурсан байна. Харин Төвийн бүсэд нийт өрх 0.7 нэгж хувиар өссөн бол машин, тоног төхөөрөмж 2.3 нэгж хувиар буурсан байна.

ХҮСНЭГТ VI.3. МАЛ АЖ АХУЙН ЗОРИУЛАЛТТАЙ МАШИН, ТОНОГ ТӨХӨӨРӨМЖИЙН ТОО

| | | Нийт | | Ашиглаж байгаа | |
|---|---|---|---|---|---|
| | | 2011 | 2021 | 2011 | 2021 |
| Бүх төрлийн трактор | Өрх | 8 014 | 5 403 | 7 924 | 5 306 |
| | ААНБ | 171 | 214 | 166 | 214 |
| Суудлын машин | Өрх | 25 256 | 49 979 | 25 079 | 48 524 |
| | ААНБ | 132 | 78 | 131 | 78 |
| Ачааны машин | Өрх | 25 332 | 40 341 | 25 167 | 39 278 |
| | ААНБ | 119 | 103 | 118 | 102 |
| Мотоцикл | Өрх | 68 658 | 72 465 | 68 305 | 73 546 |
| | ААНБ | 74 | 39 | 71 | 35 |

2021 онд мал аж ахуйн зориулалттай машин, тоног төхөөрөмжийн 96.4 хувийг дээрх 4 төрлийн машин, тоног төхөөрөмж эзэлж байна. Үүнийг 2011 онтой харьцуулахад 17.4 нэгж хувиар өссөн үзүүлэлттэй байна.

2011 оны тооллогын дүнтэй харьцуулж авч үзэхэд, Хангайн бүсэд нийт мал 3.8 нэгж хувиар буурч, нийт машин, тоног төхөөрөмж 7.5 нэгж хувиар нэмэгдэж; Баруун бүсэд нийт мал 1.0 нэгж хувиар нэмэгдэж, нийт машин, тоног төхөөрөмж 2.1 хувиар буурч; Төвийн бүсэд нийт мал 0.1 нэгж хувиар, нийт машин, тоног төхөөрөмж 2.3 нэгж хувиар тус тус буурсан байна. Харин Зүүн бүсэд нийт мал 3.0 нэгж хувиар нэмэгдэж, нийт машин, тоног төхөөрөмж 1.8 нэгж хувиар буурч, Улаанбаатар хотод нийт машин, тоног төхөөрөмж 1.1 нэгж хувиар буурсан байна.

## VI.2. Газар тариалангийн салбарын машин, тоног төхөөрөмж

Газар тариалангийн салбарын өрх, ААНБ-уудад 38.0 мянган машин, тоног төхөөрөмж байна. Эдгээрийн 36.6 мянга буюу 96.3 хувийг үйл ажиллагаандаа ашиглаж байна. 2011 оны тооллогын дүнтэй харьцуулахад нийт газар тариалангийн салбарын өрх, ААНБ-ын машин, тоног төхөөрөмж 2.5 мянгаар буурсан байна. Өдөр

тутмын үйл ажиллагаандаа ашиглаж буй машин, тоног төхөөрөмж 3.5 нэгж хувиар буурсан байна.

ХҮСНЭГТ VI.4. ГАЗАР ТАРИАЛАНГИЙН ЗОРИУЛАЛТТАЙ МАШИН, ТОНОГ ТӨХӨӨРӨМЖИЙН ТОО, бүсээр, 2021 он

| | Нийт | Өрх | ААНБ | Ашиглаж байгаа | Өрх | ААНБ |
|---|---|---|---|---|---|---|
| **Бүгд** | **37 975** | **21 622** | **16 353** | **36 558** | **20 606** | **15 952** |
| Баруун бүс | 5 171 | 3 653 | 1 518 | 5 104 | 3 599 | 1 505 |
| Хангайн бүс | 5 665 | 3 244 | 2 421 | 5 448 | 3 135 | 2 313 |
| Төвийн бүс | 23 424 | 12 875 | 10 549 | 22 359 | 12 053 | 10 306 |
| Зүүн бүс | 2 710 | 980 | 1 730 | 2 663 | 967 | 1 696 |
| Улаанбаатар | 1 005 | 870 | 135 | 984 | 852 | 132 |

Төвийн бүсэд газар тариалан эрхлэгч нийт өрхийн 40.0 хувь, машин, тоног төхөөрөмжийн 58.5 хувь нь ногдож байна.

Төвийн бүсэд газар тариалан эрхэлдэг өрхийн дийлэнх хэсэг ногдож байгаа бөгөөд машин, тоног төхөөрөмжийн хэрэглээ өндөр, харин Улаанбаатар хот болон Зүүн бүсийн өрхийн машин, тоног төхөөрөмжийн хэрэглээ бага байна.

2011 оны тооллогын дүнтэй харьцуулахад Төвийн бүсийн тариаланч өрх 0.6 нэгж хувиар нэмэгдэж, машин, тоног төхөөрөмж 1.4 нэгж хувиар; Баруун бүсийн тариаланч өрх 4.5 нэгж хувиар нэмэгдэж, машин, тоног төхөөрөмж 0.6 нэгж хувиар тус тус буурсан байна. Хангайн бүсийн тариаланч өрх 5.1 нэгж хувиар буурч, машин, тоног төхөөрөмж 2.1 нэгж хувиар нэмэгдэж; Улаанбаатар хотын тариаланч өрх 2.1 нэгж хувиар буурч, машин, тоног төхөөрөмж 0.1 нэгж хувиар нэмэгдсэн байна. Зүүн бүсэд нийт өрх 2.2 нэгж хувиар нэмэгдэж, машин, тоног төхөөрөмж 0.1 нэгж хувиар буурсан байна.

Нийт машин тоног төхөөрөмжийн 31.6 хувь 6-10 жил, 26.4 хувь 0-5 жил, 23.2 хувь 11-15 жил, 10.3 хувь 16-20 жил, 3.8 хувь 26-30 жил, 2.5 хувь 21-25 жил, 2.2 хувь нь 30-аас дээш жилийн насжилттай байна.

ЗУРАГ VI.1. ГАЗАР ТАРИАЛАНГИЙН МАШИН, МАШИН, ТОНОГ ТӨХӨӨРӨМЖИЙН ТОО, ашигласан жилээр




2011 оны тооллогын машин, тоног төхөөрөмжийн ашигласан хугацааг харьцуулж авч үзэхэд 6-10 жил 10.0 нэгж хувиар, 11-15 жил 14.8 нэгж хувиар, 16-20 жил нь 3.1 нэгж хувиар, 21-25 жил ашигласан нь 0.5 нэгж хувиар, 26-30 жил ашигласан нь 2.8 нэгж хувиар, 30-аас олон жил

ашигласан нь 1.9 нэгж хувиар тус, тус өссөн байна. 0-5 жил ашигласан нь 33.1 хувиар, буурсан байна.

Газар тариалангийн үндсэн тоног төхөөрөмжийг дэлгэрүүлэн 10 жилийн өмнөх тооллогын дүнтэй харьцуулав.

ХҮСНЭГТ VI.5. ГАЗАР ТАРИАЛАНГИЙН ҮНДСЭН ТОНОГ ТӨХӨӨРӨМЖИЙН ТОО

| | Бүгд | | Өрх | | ААНБ | |
|---|---|---|---|---|---|---|
| | 2011 | 2021 | 2011 | 2021 | 2011 | 2021 |
| Сийрүүлэгч, зээтүү культиватор | 1 789 | 1 331 | 1 085 | 353 | 704 | 978 |
| Үр тарианы үрлүүр | 1 806 | 2 174 | 320 | 710 | 1 486 | 1 464 |
| Төмсний үрлүүр | 1 882 | 619 | 1 658 | 519 | 224 | 100 |
| Үр тарианы комбайн | 1 173 | 1 018 | 261 | 96 | 912 | 922 |
| Төмсний комбайн | 351 | 122 | 252 | 83 | 99 | 39 |
| Нэг эгнээний төмс ухагч | 185 | 135 | 145 | 91 | 40 | 44 |
| Хос эгнээний төмс ухагч | 1 263 | 1 391 | 1 134 | 1 257 | 129 | 134 |
| Механикжсан үтрэм | 80 | 55 | 10 | - | 70 | 77 |
| Гинжит трактор | 294 | 141 | 45 | 56 | 249 | 85 |
| Бага оврын дугуйт трактор (10-20 м.х) | 1 463 | 1 879 | 1 219 | 1 565 | 244 | 314 |
| Дунд оврын дугуйт трактор (25-60 м.х) | 1 418 | 1 666 | 1 121 | 480 | 297 | 1 186 |
| Зүтгэх хүчний дугуйт трактор (80-130 м.х) | 2 715 | 2 747 | 2 085 | 2 104 | 630 | 643 |
| Дугуйт трактор (139-275 м.х) | 800 | 891 | 418 | 221 | 382 | 670 |
| Дугуйт трактор (275-аас дээш м.х) | 333 | 353 | 153 | 56 | 180 | 297 |

Дээрх хүснэгтээс харахад сүүлийн 10 жилд газар тариалангийн тоног төхөөрөмж дорвитой шинэчлэгдээгүй, уламжлалт тоног төхөөрөмж ашиглан тариалан эрхэлсээр байна.

ЗУРАГ VI.2. ГАЗАР ТАРИАЛАНГИЙН ЗОРИУЛАЛТТАЙ МАШИН, ТОНОГ ТӨХӨӨРӨМЖИЙН АШИГЛАСАН ХУГАЦАА, бүсээр




Газар тариалангийн зориулалттай машин, тоног төхөөрөмжийн ихэнх нь өртөг өндөр, ашиглалтын хугацаа урт байдаг. Тоног төхөөрөмжийн ашиглалтын хугацаа улсын дунджаар 10.8 жил байна. Төвийн бүсэд хамгийн өндөр буюу ашиглалтын хугацаа 11.4 жил байна. Хангайн бүс, Улаанбаатар хот болон Улсын дундаж нь Баруун болон Зүүн бүсийн дунджаас дээгүүр байна.

Энэ удаагийн тооллогоор газар тариалан эрхэлдэг өрхийн аж ахуйдаа хэрэглэдэг тоног төхөөрөмжөөс гадна, суудлын болон ачааны машин, мотоциклын талаарх мэдээллийг цуглуулсан.

Давхардсан тоогоор 6.1 мянган өрхөд 6.2 мянган суудлын болон ачааны машин, мотоциклийг өрхийн аж ахуйдаа ашиглаж байна. Нийт өрхөөс 4.9 мянган өрх нь 1 төрлийн моторт тээврийн хэрэгсэлтэй, 860 өрх нь 2 төрлийн моторт тээврийн хэрэгсэлтэй, 336 өрх нь 3 төрлийн буюу суудлын болон ачааны машин, мотоциклтой байна.

ХҮСНЭГТ VI.6. СУУДЛЫН БОЛОН АЧААНЫ МАШИН, МОТОЦИКЛТОЙ ӨРХ, бүсээр, хувиар

| | Суудлын болон ачааны машин, мотоциклтой өрх | | Дүнд эзлэх хувиар | |
|---|---|---|---|---|
| | 2011 | 2021 | 2011 | 2021 |
| **Бүгд** | **9 441** | **6 063** | **100.0** | **100.0** |
| Баруун бүс | 1 760 | 1 275 | 18.7 | 21.0 |
| Хангайн бүс | 1 952 | 1 053 | 20.7 | 17.4 |
| Төвийн бүс | 4 762 | 2 669 | 50.4 | 44.0 |
| Зүүн бүс | 739 | 498 | 7.8 | 8.2 |
| Улаанбаатар | 228 | 568 | 2.4 | 9.4 |

Суудлын болон ачааны машин, мотоциклтой өрхийн 44.0 хувь нь Төвийн бүсэд, 21.0 хувь нь Баруун бүсэд, 17.4 хувь нь Хангайн бүсэд, 9.4 хувь нь Улаанбаатар хотод, 8.2 хувь нь Зүүн бүсэд байна.

VII БҮЛЭГ

# ХӨДӨӨ АЖ АХУЙН ЗОРИУЛАЛТТАЙ БАРИЛГА, БАЙГУУЛАМЖ

5 715

ГАЗАР ТАРИАЛАН

166 334

МАЛ АЖ АХУЙ

**172.0 мянга**

ХӨДӨӨ АЖ АХУЙН ЗОРИУЛАЛТТАЙ БАРИЛГА, БАЙГУУЛАМЖТАЙ ӨРХ, АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГЫН ТОО

## ГАЗАР ТАРИАЛАН

ӨРХ

5 028

ААНБ

687

## МАЛ АЖ АХУЙ

ӨРХ

166 117

ААНБ

217

## VII. ХӨДӨӨ АЖ АХУЙН ЗОРИУЛАЛТТАЙ БАРИЛГА, БАЙГУУЛАМЖ

Энэ бүлэгт өрх болон аж ахуйн нэгж, байгууллагад тоологдсон хөдөө аж ахуйн зориулалттай барилга, байгууламж, тэдгээрийн багтаамж болон үнэлгээний талаар танилцууллаа.

Энэ удаагийн тооллогоор өрх, аж ахуйн нэгж, байгууллагын ХАА-н зориулалттай барилга, байгууламжийн тоо, багтаамж, үнэлгээ зэргийг бүртгэсэн. Тухайн өрх, ААНБ-ын хөдөө аж ахуйгаас бусад зориулалттай барилга, байгууламжийг энэ бүлэгт хамааруулаагүй болно.

2021 оны байдлаар газар тариалан эрхэлж буй 5028 өрх, 687 ААНБ хөдөө аж ахуйн зориулалттай нэг ба түүнээс дээш барилга, байгууламжтай байна. Харин мал аж ахуйн салбарыг авч үзвэл 166.1 мянган өрх, 217 ААНБ хөдөө аж ахуйн зориулалттай нэг ба түүнээс дээш барилга, байгууламжтай байна.

ЗУРАГ VII.1. ХӨДӨӨ АЖ АХУЙН ЗОРИУЛАЛТТАЙ БАРИЛГА, БАЙГУУЛАМЖТАЙ ӨРХ, АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГЫН ТОО




Өмнөх тооллогын дүнтэй харьцуулахад ХАА-н зориулалттай барилга, байгууламжтай өрх 21.9 хувиар өсөж, аж ахуйн нэгж 18.7 хувиар тус тус буурсан байна.

2011 онд улсын хэмжээнд ХАА-н зориулалттай барилга, байгууламжтай 127.0 мянган өрх байснаас 95.0 хувь нь МАА эрхэлдэг өрх, 5.0 хувь нь газар тариалан эрхэлдэг өрх байсан бол 2021 оны тооллогоор ХАА-н зориулалттай барилга, байгууламжтай 171.2 мянган өрх байснаас 97.1 хувь нь МАА эрхэлдэг өрх, 2.9 хувь нь газар тариалан эрхэлдэг өрх байна.

Түүнчлэн 2011 онд ХАА-н зориулалттай барилга, байгууламжтай 1.1 мянган ААНБ байгаа бөгөөд үүний 72.3 хувь нь газар тариалан, 27.7 хувь нь мал аж ахуй эрхэлдэг аж ахуйн нэгж, байгууллага байсан. Харин энэ удаагийн тооллогоор ХАА-н зориулалттай барилга, байгууламжтай 904 ААНБ байгаа бөгөөд үүний 76.0 хувь нь газар тариалан, 24.0 хувь нь мал аж ахуй эрхэлдэг аж ахуйн нэгж, байгууллага байна.

МАА эрхэлдэг өрх, аж ахуйн нэгж, байгууллага нь ихэнхдээ мал, тэжээвэр амьтад өсгөн үржүүлэх зориулалтын технологийн байр, фермтэй байгаа бол газар тариалан эрхэлдэг өрх, аж ахуйн нэгж, байгууллага нь ихэнхдээ үр тариа, төмс, хүнсний ногооны хүлэмж, агуулах, зоорьтой байна.

## VII.1. ГАЗАР ТАРИАЛАНГИЙН ЗОРИУЛАЛТТАЙ БАРИЛГА, БАЙГУУЛАМЖ

### VII.1.1.Газар тариалан эрхэлдэг, ХАА-н зориулалттай барилга, байгууламжтай өрх

Тооллогод газар тариалан эрхэлдэг нийт 18.8 мянган өрх хамрагдсанаас 5.0 мянган өрх буюу 26.7 хувь нь нэг буюу түүнээс дээш хэд хэдэн төрлийн хөдөө аж ахуйн зориулалттай барилга, байгууламжтай байна. Энэ нь 2011 оны тооллогын дүнгээс 43.7 хувиар буурсан байна.

Хөдөө аж ахуйн зориулалттай барилга, байгууламжтай газар тариалан эрхэлдэг өрхүүдийн 79.6 хувь нь зоорьтой, 61.2 хувь нь хүлэмжтэй, 3.6 хувь нь агуулахтай, 4.0 хувь нь ХАА-н зориулалтай бусад барилга байгууламжтай байна.

ХАА-н барилга, байгууламжтай өрхийн 45.4 хувь нь Төвийн бүсэд, 21.2 хувь нь Хангайн бүсэд, 16.7 хувь нь Улаанбаатар хотод, 9.6 хувь нь Баруун бүсэд, 7.1 хувь нь Зүүн бүсэд байна. Төвийн бүсэд ХАА-н барилга байгууламжтай өрхийн тоо нь бусад бүсээс их байгаа бөгөөд газар тариалангийн голлох аймгууд болох Сэлэнгэ, Төв, Дархан-Уул аймгууд энэ бүсэд багтдаг.

ХҮСНЭГТ VII.1. ХӨДӨӨ АЖ АХУЙН ЗОРИУЛАЛТТАЙ БАРИЛГА, БАЙГУУЛАМЖТАЙ ГАЗАР ТАРИАЛАН ЭРХЭЛДЭГ ӨРХИЙН ТОО, барилга, байгууламжийн төрөл, бүсээр

| | Бүгд | | Баруун бүс | | Хангайн бүс | | Төвийн бүс | | Зүүн бүс | | Улаанбаатар | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | 2011 | 2021 | 2011 | 2021 | 2011 | 2021 | 2011 | 2021 | 2011 | 2021 | 2011 | 2021 |
| **Бүгд** | **6 437** | **5 028** | **740** | **484** | **668** | **1 067** | **4 108** | **2 281** | **312** | **356** | **609** | **840** |
| Хүлэмжтэй | 1 428 | 3 078 | 182 | 227 | 224 | 757 | 337 | 998 | 184 | 333 | 501 | 763 |
| Агуулахтай | 125 | 183 | 59 | 33 | 22 | 43 | 35 | 88 | 2 | 9 | 7 | 10 |
| Зоорьтой | 5 421 | 4 002 | 539 | 434 | 510 | 729 | 4 004 | 1 944 | 182 | 264 | 186 | 631 |
| Бусад | 226 | 203 | 28 | 34 | 30 | 35 | 153 | 113 | 2 | 10 | 13 | 11 |

ХАА-н зориулалттай барилга, байгууламжтай газар тариалан эрхэлдэг өрхийг барилга, байгууламжийн төрлөөр ангилан үзвэл улсын хэмжээнд зоорьтой болон хүлэмжтэй өрхийн тоо харьцангуй өндөр байна. Үүнийг 2011 оны тооллогын дүнтэй харьцуулан авч үзвэл хүлэмжтэй өрх 2 дахин өссөн бол зоорьтой өрх 19.4 хувиар буурсан байна.

Зоорьтой өрхийг бүсээр авч үзвэл  нийт зоорьтой өрхийн 48.6 хувь нь Төвийн бүсэд, 18.2 хувь нь Хангайн бүсэд, 15.8 хувь нь Улаанбаатар хотод, 10.8 хувь нь Баруун бүсэд, үлдсэн 6.6 хувь Зүүн бүсэд харьяалагдаж байна.

### VII.1.2.Газар тариалан эрхэлдэг өрхийн ХАА-н зориулалттай барилга байгууламж

Энэ удаагийн тооллогоор газар тариалан эрхэлдэг өрхөд ХАА-н зориулалттай 8 төрлийн нийт 10 673 барилга, байгууламж тоологдсоноос 60.7 хувь нь зоорь, 35.7

хувь нь хүлэмж, 1.7 хувь нь агуулах, 1.9 хувь нь ХАА-н зориулалттай бусад барилга байгууламж байна.

ЗУРАГ VII.2. ХӨДӨӨ АЖ АХУЙН ЗОРИУЛАЛТТАЙ БАРИЛГА, БАЙГУУЛАМЖИЙН ТОО, эзэмшлийн төрлөөр




Мөн нийт барилга, байгууламжийн 53.1 хувь нь Төвийн бүсэд байна. 2011 оны тооллогын үр дүнд газар тариалан эрхэлдэг өрхөд ХАА-н зориулалттай 8 төрлийн нийт 8732 барилга, байгууламж тоологдсоноос 74.9 хувь нь зоорь, нийт барилга, байгууламжийн 65.1 хувь нь Төвийн бүсэд тоологдсон байна.

ХҮСНЭГТ VII.2. ГАЗАР ТАРИАЛАН ЭРХЭЛДЭГ ӨРХИЙН ХАА-Н ЗОРИУЛАЛТТАЙ БАРИЛГА, БАЙГУУЛАМЖИЙН ТОО, бүсээр

| | Бүгд | | Баруун бүс | | Хангайн бүс | | Төвийн бүс | | Зүүн бүс | | Улаанбаатар | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | 2011 | 2021 | 2011 | 2021 | 2011 | 2021 | 2011 | 2021 | 2011 | 2021 | 2011 | 2021 |
| **Бүгд** | **8 732** | **10 673** | **879** | **847** | **878** | **1 823** | **5 690** | **5 671** | **399** | **664** | **890** | **1 668** |
| Хүлэмж | 1 747 | 3 805 | 208 | 290 | 247 | 980 | 418 | 1 150 | 203 | 379 | 671 | 1 006 |
| Агуулах | 140 | 184 | 65 | 33 | 26 | 43 | 39 | 89 | 2 | 9 | 8 | 10 |
| Зоорь | 6 542 | 6 479 | 558 | 490 | 557 | 764 | 5 046 | 4 318 | 187 | 266 | 194 | 641 |
| Бусад | 303 | 205 | 48 | 34 | 48 | 36 | 187 | 114 | 7 | 10 | 17 | 11 |

### VII.1.3.Газар тариалан эрхэлдэг өрхийн ХАА-н зориулалттай голлох барилга байгууламжийн багтаамж

Тооллогоор газар тариалан эрхэлдэг өрхөд нийт 492.4 мянган тонн багтаамж бүхий 6.5 мянган ширхэг зоорь тоологдсон байна. 2011 оны тооллогоор нийт 68.4 мянган тонн багтаамж бүхий 6.5 мянган ширхэг зоорь тоологдож байжээ. Тооллогоор тоологдсон зоорины тоо болон багтаамжийн дийлэнх нь Төвийн бүсэд байна. Зоорины дундаж багтаамж 76.0 тонн байгаа нь өмнөх тооллогоос 7 дахин нэмэгдсэн үзүүлэлт юм.

ХҮСНЭГТ VII.3. ГАЗАР ТАРИАЛАН ЭРХЭЛДЭГ ӨРХИЙН ГОЛЛОХ БАРИЛГА, БАЙГУУЛАМЖИЙН ДУНДАЖ БАГТААМЖ, бүсээр

| | | Бүгд | | Баруун бүс | | Хангайн бүс | | Төвийн бүс | | Зүүн бүс | | Улаанбаа-тар | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | 2011 | 2021 | 2011 | 2021 | 2011 | 2021 | 2011 | 2021 | 2011 | 2021 | 2011 | 2021 |
| Зоорь | Тоо, ш | 6 542 | 6 479 | 558 | 490 | 557 | 764 | 5 046 | 4 318 | 187 | 266 | 194 | 641 |
| | Багтаамж, мян.тн | 68.4 | 492.4 | 9.8 | 24.7 | 10.8 | 25.1 | 41.5 | 434.4 | 3.9 | 2.2 | 2.4 | 6.0 |
| | Дундаж багтаамж, тн | 10.5 | 76.0 | 17.6 | 50.4 | 19.4 | 32.9 | 8.2 | 100.6 | 20.9 | 8.3 | 12.4 | 9.4 |
| Агуулах | Тоо, ш | 140 | 184 | 65 | 33 | 26 | 43 | 39 | 89 | 2 | 9 | 8 | 10 |
| | Багтаамж, мян.тн | 3.0 | 5.9 | 0.8 | 0.2 | 0.7 | 1.7 | 1.2 | 3.8 | 0.1 | 0.01 | 0.3 | 0.2 |
| | Дундаж багтаамж, тн | 21.4 | 32.1 | 12.3 | 6.1 | 26.9 | 39.5 | 30.8 | 42.7 | 50.0 | 1.1 | 37.5 | 20.0 |

Агуулахын хувьд газар тариалан эрхэлдэг өрхөд нийт 5.9 мянган тонн багтаамж бүхий 184 агуулах тоологдсон бөгөөд энэ нь 2011 оноос агуулахын тоо 31.4 хувиар, багтаамж нь 2 дахин нэмэгдсэн байна. Төвийн бүсэд нийт агуулахын 48.4 хувь нь байгаа бөгөөд нийт агуулахын багтаамжийн 64.3 хувь нь байна. Нэг агуулахын дундаж багтаамж нь 32.1 тонн байна.

### VII.1.4.Газар тариалан эрхэлдэг өрхийн ХАА-н зориулалттай голлох барилга байгууламжийн үнэлгээ

Тооллогын дүнгээр газар тариалан эрхэлдэг өрхүүд нийт 20 668.9 сая төгрөгийн зоорь, 6 302.2 сая төгрөгийн хүлэмж, 1 029.0 сая төгрөгийн агуулах, 1 524.0 сая төгрөгийн үнэлгээ бүхий ХАА-н бусад барилга байгууламжтай байна. ХАА-н зориулалттай барилга, байгууламжийн үнэлгээг тооллогод хамрагдаж буй өрх өөрөө өнөөгийн зах зээлийн үнэлгээгээр үнэлсэн. ХАА-н зориулалттай барилга, байгууламжийн үнэлгээ нь бүсүүдэд эрс ялгаатай байгаа нь барилга, байгууламжийн төрөл, хийц, багтаамж зэргээс хамааралтай

ХҮСНЭГТ VII.4. ГАЗАР ТАРИАЛАН ЭРХЭЛДЭГ ӨРХИЙН ГОЛЛОХ БАРИЛГА, БАЙГУУЛАМЖИЙН ҮНЭЛГЭЭ, бүсээр, сая төгрөгөөр

| | Бүгд | | Баруун бүс | | Хангайн бүс | | Төвийн бүс | | Зүүн бүс | | Улаанбаатар | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | 2011 | 2021 | 2011 | 2021 | 2011 | 2021 | 2011 | 2021 | 2011 | 2021 | 2011 | 2021 |
| Хүлэмж | 1 898.2 | 6 302.2 | 175.4 | 134.7 | 282.1 | 556.9 | 667.4 | 2307.2 | 190.1 | 877.1 | 632.8 | 1 426.4 |
| Агуулах | 611.5 | 1 029.0 | 145.1 | 32.0 | 155.7 | 379.7 | 230.2 | 608.3 | 15.0 | 9.0 | 65.5 | 0.0 |
| Зоорь | 12 597.7 | 20 668.9 | 1 491.5 | 2 923.0 | 1 751.3 | 3 454.8 | 8 072.1 | 13 492.3 | 582.1 | 288.7 | 700.7 | 510.1 |
| Бусад | 738.8 | 1 524.0 | 66.3 | 67.6 | 255.0 | 294.3 | 375.6 | 1028.3 | 2.5 | 43.8 | 39.5 | 90.0 |

### VII.1.5.Газар тариалан эрхэлдэг, хөдөө аж ахуйн зориулалттай барилга, байгууламжтай ААНБ-ын тоо

Тооллогод газар тариалан эрхэлдэг нийт 1643 ААНБ хамрагдаж, үүнээс 687 ААНБ буюу 41.8 хувь нь нэг буюу түүнээс дээш төрлийн ХАА-н зориулалттай барилга, байгууламжтай байна. ХАА-н зориулалттай барилга байгууламжтай ААНБ-ын тоо 2011 оны дүнгээс 5.2  хувиар буурсан байна.

Хөдөө аж ахуйн зориулалттай барилга, байгууламжтай газар тариалан эрхэлдэг ААНБ-ын 42.4 хувь нь агуулахтай, 26.3 хувь нь зоорьтой, 26.2 хувь нь хүлэмжтэй, 30.9 хувь нь ХАА-н зориулалтай бусад барилга байгууламжтай байна.

ХАА-н зориулалттай барилга, байгууламжтай ААНБ-ын 62.2 хувь нь Төвийн бүсэд, 17.9 хувь нь Хангайн бүсэд, 8.0 хувь нь Зүүн бүсэд, 6.8 хувь нь Баруун бүсэд, 5.1 хувь нь Улаанбаатар хотод байгаа бол 2011 оны тооллогоор ХАА-н зориулалттай барилга, байгууламжтай ААНБ-ын 54.9 хувь нь Төвийн бүсэд, 14.7 хувь нь Хангайн бүсэд, 10.7 хувь нь Зүүн бүсэд, 7.0 хувь нь Улаанбаатар хотод, Баруун бүсэд 4.5 хувь нь тоологдсон байна.

ХҮСНЭГТ VII.5. ХӨДӨӨ АЖ АХУЙН ЗОРИУЛАЛТТАЙ БАРИЛГА, БАЙГУУЛАМЖТАЙ ААНБ-ЫН ТОО, барилга, байгууламжийн төрөл, бүсээр

| | Бүгд | | Баруун бүс | | Хангайн бүс | | Төвийн бүс | | Зүүн бүс | | Улаанбаатар | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | 2011 | 2021 | 2011 | 2021 | 2011 | 2021 | 2011 | 2021 | 2011 | 2021 | 2011 | 2021 |
| **Бүгд** | **804** | **687** | **152** | **47** | **130** | **123** | **441** | **427** | **21** | **55** | **60** | **35** |
| Хүлэмжтэй | 199 | 180 | 55 | 5 | 29 | 22 | 69 | 97 | 3 | 27 | 43 | 29 |
| Агуулахтай | 305 | 291 | 36 | 22 | 63 | 53 | 189 | 193 | 12 | 22 | 5 | 1 |
| Зоорьтой | 395 | 181 | 95 | 18 | 60 | 36 | 214 | 103 | 9 | 9 | 17 | 15 |
| Үтрэмтэй | 142 | 132 | 3 | 4 | 30 | 16 | 102 | 100 | 7 | 12 | - | 0 |
| ХАА-н техник хадгалах байгууламж (гарааш)-тай | 109 | 80 | 14 | 2 | 20 | 12 | 74 | 52 | 1 | 10 | - | 4 |

Төвийн бүсэд ХАА-н зориулалттай барилга, байгууламжтай ААНБ-ын тоо бусад бүсээс өндөр байгаа бөгөөд газар тариалангийн голлох аймгууд болох Сэлэнгэ, Төв, Дархан-Уул аймгууд энэ бүсэд байдагтай холбоотой.

Улсын хэмжээнд ААНБ нь зоорь болон агуулах зэрэг байгууламжтай байх нь давамгайлж байгаа бөгөөд арван жилийн өмнөх үетэй харьцуулж авч үзвэл зоорьтой ААНБ 54.2 хувиар, хүлэмжтэй ААНБ 9.5 хувиар, агуулахтай ААНБ 4.6 хувиар тус тус буурсан үзүүлэлттэй байна. Түүнчлэн 2011 онд агуулахтай ААНБ-ын 62.0 хувь, зоорьтой ААНБ-ын 54.2 хувь нь Төвийн бүсэд байрлаж байсан бол энэ удаагийн тооллогоор агуулахтай ААНБ-ын 62.2 хувь, зоорьтой ААНБ-ын 56.9 хувь нь Төвийн бүсэд байрлаж байна.

### VII.1.6.Газар тариалан эрхэлдэг ААНБ-ын хөдөө аж ахуйн зориулалттай барилга, байгууламж

Тооллогоор газар тариалан эрхэлдэг ААНБ-д ХАА-н зориулалттай 8 төрлийн буюу нийт 2911 барилга, байгууламж тоологдсон нь сүүлийн 10 жилд 40.0 хувиар нэмэгдсэн үзүүлэлт юм. Барилга байгууламжийн төрлөөр авч үзвэл 2011 оны тооллогын дүнгээс агуулах 21.9 хувиар буурсан бол хүлэмж 52.9 хувь, зоорь 16.7 хувь, бусад барилга, байгууламж 26.2 хувиар өссөн байна.

Газар тариалан эрхэлдэг ААНБ-ын нийт хөдөө аж ахуйн зориулалттай барилга, байгууламжийн 27.9 хувь нь хүлэмж, 24.9 хувь нь зоорь, 12.4 хувь нь агуулах, 34.7 хувь нь ХАА-н зориулалттай бусад барилга, байгууламж байна.

Нийт газар тариалан эрхэлдэг ААНБ-ын хөдөө аж ахуйн зориулалттай барилга, байгууламжийн 64.9 хувь нь Төвийн бүсэд, 18.1 хувь нь Хангайн бүсэд, 7.3 хувь нь Улаанбаатар хотод, 7.0 хувь нь Зүүн бүсэд, үлдсэн 2.7 хувь нь Баруун бүсэд байна.

ХҮСНЭГТ VII.6. ГАЗАР ТАРИАЛАНГ ЭРХЭЛДЭГ ААНБ-ЫН ХӨДӨӨ АЖ АХУЙН ЗОРИУЛАЛТТАЙ БАРИЛГА, БАЙГУУЛАМЖИЙН ТОО, бүсээр

| | Бүгд | | Баруун бүс | | Хангайн бүс | | Төвийн бүс | | Зүүн бүс | | Улаанбаатар | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | 2011 | 2021 | 2011 | 2021 | 2011 | 2021 | 2011 | 2021 | 2011 | 2021 | 2011 | 2021 |
| **Бүгд** | **2 079** | **2 911** | **300** | **79** | **306** | **528** | **1 255** | **1 888** | **59** | **203** | **159** | **213** |
| Хүлэмж | 392 | 813 | 85 | 12 | 49 | 113 | 119 | 469 | 8 | 48 | 131 | 171 |
| Агуулах | 407 | 362 | 51 | 23 | 87 | 60 | 249 | 250 | 15 | 28 | 5 | 1 |
| Зоорь | 659 | 725 | 119 | 24 | 67 | 42 | 442 | 631 | 13 | 12 | 18 | 16 |
| Бусад | 621 | 1 011 | 45 | 20 | 103 | 313 | 445 | 538 | 23 | 115 | 5 | 25 |

### VII.1.7.Газар тариалан эрхэлдэг ААНБ-ын хөдөө аж ахуйн зориулалттай барилга, байгууламжийн багтаамж

Тооллогоор газар тариалан эрхэлдэг ААНБ-д нийт 72.5 мянган тонн багтаамж бүхий 725 зоорь тоологдсон байна. 2011 оны тооллоготой харьцуулахад багтаамж нь 30.8 мянган тонноор нэмэгдсэн байна. Газар тариалан эрхэлдэг ААНБ-ын зоорь дунджаар 100.0 тонн багтаамжтай байгаа нь 2011 оны тооллогын дүнгээс 58.0 хувиар өссөн үзүүлэлт юм.

Газар тариалан эрхэлдэг ААНБ- бүртгэгдсэн нийт зоорины багтаамжийн 86.4 хувь нь Төвийн бүсэд, 8.8 хувь нь Хангайн бүсэд, 2.2 хувь нь Баруун бүсэд, 1.9 хувь нь Зүүн бүсэд, үлдсэн 0.7 хувь нь Улаанбаатарт байна.

ХҮСНЭГТ VII.7. ГАЗАР ТАРИАЛАН ЭРХЭЛДЭГ ААНБ-ЫН ГОЛЛОХ БАРИЛГА, БАЙГУУЛАМЖИЙН ДУНДАЖ БАГТААМЖ, бүсээр

| | Бүгд | | Баруун бүс | | Хангайн бүс | | Төвийн бүс | | Зүүн бүс | | Улаанбаатар | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | 2011 | 2021 | 2011 | 2021 | 2011 | 2021 | 2011 | 2021 | 2011 | 2021 | 2011 | 2021 |
| Зоорь | | | | | | | | | | | | |
| Тоо, ш | 659 | 725 | 119 | 24 | 67 | 42 | 442 | 631 | 13 | 12 | 18.0 | 16 |
| Багтаамж, мян.тн | 41.7 | 72.5 | 4.5 | 1.6 | 3.6 | 6.4 | 32.1 | 62.6 | 0.3 | 1.4 | 1.2 | 0.5 |
| Дундаж багтаамж, тн | 63.3 | 100.0 | 37.7 | 66.2 | 54.1 | 152.2 | 72.6 | 99.2 | 24.3 | 115.4 | 64.1 | 33.1 |

| | Бүгд | | Баруун бүс | | Хангайн бүс | | Төвийн бүс | | Зүүн бүс | | Улаанбаатар | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | 2011 | 2021 | 2011 | 2021 | 2011 | 2021 | 2011 | 2021 | 2011 | 2021 | 2011 | 2021 |
| Агуулах | | | | | | | | | | | | |
| Тоо, ш | 407 | 362 | 51 | 23 | 87 | 60 | 249 | 250 | 15 | 28 | 5 | 1 |
| Багтаамж, мян.тн | 149.2 | 376.1 | 10.8 | 120.7 | 20.6 | 37.6 | 114.3 | 193.9 | 3.5 | 22.4 | 0.03 | 1.5 |
| Дундаж багтаамж, тн | 366.7 | 1 038.8 | 211.0 | 5 248.9 | 237.2 | 626.1 | 459.1 | 775.4 | 231.3 | 800.5 | 6.2 | 1 485.5 |

2021 онд газар тариалан эрхэлдэг өрх, ААНБ-ын зоорины нийт багтаамж нь 563.8 мянган тонн байгаа ба үүний 87.1 хувийг өрхийн, үлдсэн 12.9 хувийг ААНБ-ын зоорины багтаамж эзэлж байна. Харин агуулахын нийт багтаамж нь 381.6 мянган тонн байгаа бөгөөд 98.5 хувийг ААНБ, үлдсэн хувийг нь өрхийн агуулахын багтаамж эзэлж байна. Зоорь нь өрхийн хэрэглээнд, агуулах нь ААНБ-ын хэрэгцээнд илүү ашиглагддаг нь харагдаж байна.

### VII.1.8.Газар тариалан эрхэлдэг ААНБ-ын хөдөө аж ахуйн зориулалттай голлох барилга байгууламжийн үнэлгээ

Тооллогын дүнгээр газар тариалан эрхэлдэг ААНБ-ын хөдөө аж ахуйн зориулалттай барилга, байгууламж нь төрөл, хийц, багтаамж зэргээс шалтгаалж үнэлгээ нь харьцангүй ялгаатай бөгөөд тайланд барилга, байгууламжийн дундаж үнэлгээг танилцууллаа. Улсын дунджаар газар тариалан эрхэлдэг ААНБ-ын хүлэмжийн дундаж үнэлгээ нь 25.8 сая төгрөгт хүрч, Улаанбаатар хотод хүлэмжийн дундаж үнэлгээ хамгийн өндөр буюу улсын дунджаас 30.2 хувиар илүү байна. Харин Хангайн бүсэд хүлэмжийн дундаж үнэлгээ хамгийн бага буюу 63.1 хувиар бага байна.

Газар тариалан эрхэлдэг ААНБ-ын агуулахын хувьд улсын дундаж үнэлгээ нь 30.8 сая байгаа бөгөөд бүсүүдэд ойролцоо үнэлгээтэй байна.

ХҮСНЭГТ VII.8. ГАЗАР ТАРИАЛАН ЭРХЭЛДЭГ ААНБ-ЫН ХӨДӨӨ АЖ АХУЙН ЗОРИУЛАЛТТАЙ БАРИЛГА, БАЙГУУЛАМЖИЙН ДУНДАЖ ҮНЭЛГЭЭ, бүсээр, сая төгрөгөөр

| | Бүгд | | Баруун бүс | | Хангайн бүс | | Төвийн бүс | | Зүүн бүс | | Улаанбаатар | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | 2011 | 2021 | 2011 | 2021 | 2011 | 2021 | 2011 | 2021 | 2011 | 2021 | 2011 | 2021 |
| Хүлэмж | 6.0 | 25.8 | 2.4 | 15.3 | 4.9 | 9.5 | 5.4 | 25.9 | 4.0 | 31.7 | 12.5 | 33.6 |
| Агуулах | 30.8 | 30.8 | 15.2 | 29.0 | 18 | 31.4 | 38.9 | 30.5 | 26.3 | 33.2 | 5.6 | 31.4 |
| Зоорь | 13.3 | 23.5 | 5.4 | 34.4 | 15.9 | 22.0 | 15.7 | 22.9 | 16.9 | 25.0 | 15.8 | 16.7 |
| Бусад | 16.2 | 29.5 | 9.4 | 36.0 | 14.4 | 28.7 | 18.2 | 32.1 | 5.0 | 23.8 | - | 9.8 |

## VII.2. МАЛ АЖ АХУЙН ЗОРИУЛАЛТТАЙ ХӨДӨӨ АЖ АХУЙН БАРИЛГА, БАЙГУУЛАМЖ

### VII.2.1.Мал аж ахуй эрхэлдэг, ХАА-н зориулалттай барилга, байгууламжтай өрх

Тооллогод мал аж ахуй эрхэлдэг нийт 245.4 мянган өрх хамрагдсанаас 166.1 мянган өрх буюу 67.7 хувь нь нэг буюу түүнээс дээш төрлийн хөдөө аж ахуйн зориулалттай барилга, байгууламжтай байна. ХАА-н барилга, байгууламжтай өрхийн тоо 2011 оноос 35.5 мянган өрхөөр нэмэгдсэн байна.

ХҮСНЭГТ VII.9. МАЛ АЖ АХУЙ ЭРХЭЛДЭГ ХӨДӨӨ АЖ АХУЙН ЗОРИУЛАЛТТАЙ БАРИЛГА, БАЙГУУЛАМЖТАЙ ӨРХИЙН ТОО, бүсээр, мянган өрх

| | Улсын дундаж | | Баруун бүс | | Хангайн бүс | | Төвийн бүс | | Зүүн бүс | | Улаанбаатар | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | 2011 | 2021 | 2011 | 2021 | 2011 | 2021 | 2011 | 2021 | 2011 | 2021 | 2011 | 2021 |
| Өрхийн тоо | 120.6 | 166.1 | 29.6 | 38.9 | 44.1 | 64.4 | 30.0 | 40.6 | 12.4 | 17.6 | 4.5 | 4.7 |

МАА эрхэлдэг ХАА-н зориулалттай барилга, байгууламжтай өрхийн 38.8 хувь нь Хангайн бүсэд, 24.4 хувь нь Төвийн бүсэд, 23.4 хувь нь Баруун бүсэд, 10.6 хувь нь Зүүн бүсэд, үлдсэн 2.8 хувь нь Улаанбаатар хотод байна.

### VII.2.2.Мал аж ахуй эрхэлдэг өрхийн ХАА-н зориулалттай барилга, байгууламжийн тоо

МАА эрхэлдэг өрхөд 3141 зориулалтын технологийн байр, ферм, 130 зоорь, 402 агуулах тоологдсон байна[3]. МАА эрхэлдэг өрхийн зориулалтын технологийн байр, фермийн тоо 2011 оноос 4.4 дахин нэмэгдсэн бөгөөд нийт тоологдсон фермийн 53.6 хувь нь Төвийн бүсэд, 14.8 хувь Улаанбаатар хотод байна.

ХҮСНЭГТ VII.10. МАЛ АЖ АХУЙ ЭРХЭЛДЭГ ӨРХИЙН ХАА-Н ЗОРИУЛАЛТТАЙ БАРИЛГА, БАЙГУУЛАМЖИЙН ТОО, бүсээр

| | Улсын дундаж | | Баруун бүс | | Хангайн бүс | | Төвийн бүс | | Зүүн бүс | | Улаанбаатар | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | 2011 | 2021 | 2011 | 2021 | 2011 | 2021 | 2011 | 2021 | 2011 | 2021 | 2011 | 2021 |
| Зориулал-тын технологийн байр, ферм | 712 | 3 141 | 38 | 270 | 33 | 577 | 335 | 1 683 | 52 | 147 | 254 | 464 |
| Зоорь | 3 054 | 130 | 353 | 8 | 199 | 65 | 2 244 | 50 | 208 | - | 50 | 7 |
| Агуулах | 221 | 402 | 65 | 85 | 44 | 216 | 61 | 75 | 28 | 4 | 23 | 23 |

### VII.2.3.Мал аж ахуй эрхэлдэг өрхийн ХАА-н зориулалттай барилга, байгууламжийн багтаамж

2021 онд МАА эрхэлдэг өрхийн зориулалтын технологийн байр, фермийн нийт багтаамж хонин толгойд шилжүүлснээр 435.1 мянган толгой байсан ба дунджаар 138.5 толгойн багтаамжтай байна. 2011 оны тооллогын дүнд МАА эрхэлдэг өрхийн зориулалтын технологийн байр, фермийн нийт багтаамж хонин толгойд шилжүүлснээр 71.1 мянган толгой, дундаж багтаамж нь 99.9 толгой байсан байна.

Бүсээр авч үзвэл МАА эрхэлдэг өрхийн зориулалтын технологийн байр, фермийн нийт багтаамжийн 72.5 хувь буюу 315.4 мянган толгой багтаамж нь Төвийн бүсэд байна.

[3] Малын хашааг энэ бүлэгт оруулаагүй бөгөөд БҮЛЭГ 8. МАЛЫН ХАШАА бүлгээс үзнэ үү.

ХҮСНЭГТ VII.11. МАЛ АЖ АХУЙ ЭРХЭЛДЭГ ӨРХИЙН БАРИЛГА, БАЙГУУЛАМЖИЙН ДУНДАЖ БАГТААМЖ, бүсээр

| Зориулалтын технологийн байр, ферм | Бүгд | | Баруун бүс | | Хангайн бүс | | Төвийн бүс | | Зүүн бүс | | Улаанбаатар | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | 2011 | 2021 | 2011 | 2021 | 2011 | 2021 | 2011 | 2021 | 2011 | 2021 | 2011 | 2021 |
| Тоо, ш | 712 | 3 141 | 38 | 270 | 33 | 577 | 335 | 1 683 | 52 | 147 | 254 | 464 |
| Багтаамж, мян.толгой | 71.1 | 435.1 | 4.0 | 7.2 | 2.5 | 40.1 | 33.6 | 315.4 | 9.8 | 20.0 | 21.2 | 52.3 |
| Дундаж багтаамж, толгой | 99.9 | 138.5 | 105.1 | 26.6 | 75.5 | 69.6 | 100.3 | 187.4 | 187.9 | 136.1 | 83.6 | 112.7 |

### VII.2.4.Мал аж ахуй эрхэлдэг, ХАА-н зориулалттай барилга, байгууламжтай ААНБ

Тооллогод МАА эрхэлдэг нийт 902 ААНБ хамрагдсанаас 415 ААНБ буюу 46.0 хувь нь нэг болон түүнээс дээш төрлийн ХАА-н зориулалттай барилга, байгууламжтай байна. ХАА-н зориулалттай барилга, байгууламжтай ААНБ-ын 43.1 хувь нь Төвийн бүсэд, 20.5 хувь нь Хангайн бүсэд, 15.2 хувь нь Зүүн бүсэд, 13.0 хувь нь Улаанбаатар хотод, 8.2 хувь нь Баруун бүсэд байна.

ХҮСНЭГТ VII.12. ХӨДӨӨ АЖ АХУЙН ЗОРИУЛТТАЙ БАРИЛГА, БАЙГУУЛАМЖТАЙ ААНБ-ЫН ТОО, барилга, байгууламжийн төрөл, бүсээр

| | Бүгд | | Баруун бүс | | Хангайн бүс | | Төвийн бүс | | Зүүн бүс | | Улаанбаатар | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | 2011 | 2021 | 2011 | 2021 | 2011 | 2021 | 2011 | 2021 | 2011 | 2021 | 2011 | 2021 |
| **Бүгд** | **308** | **415** | **67** | **34** | **60** | **85** | **108** | **179** | **22** | **63** | **51** | **54** |
| Зориулалтын технологийн байр, ферм | 60 | 60 | 4 | 4 | 3 | 5 | 18 | 17 | 4 | 2 | 31 | 32 |
| Зоорьтой | 56 | 45 | 9 | 8 | 13 | 15 | 23 | 18 | 3 | 2 | 8 | 2 |
| Агуулахтай | 39 | 37 | 9 | 10 | 6 | 6 | 17 | 17 | 3 | 2 | 4 | 2 |
| Малын хашаа | - | 226 | - | 10 | - | 53 | - | 100 | - | 51 | - | 12 |
| Ажиллагчдын байр | - | 14 | - | - | - | 1 | - | 9 | - | 2 | - | 2 |
| ХАА-н техник хадгалах байгууламж (гарааш)-тай | 25 | - | 4 | - | 5 | - | 13 | - | 1 | - | 2 | - |
| Бусад | 128 | 14 | 3 | - | 1 | 1 | 14 | 9 | 4 | 2 | 3 | 2 |

МАА эрхэлдэг ХАА-н зориулалтай барилга, байгууламжтай ААНБ-д барилга, байгууламжийн төрлөөр ангилан үзвэл зориулалтын технологийн байр, фермтэй нийт ААНБ-ын 53.3 хувь нь Улаанбаатар хотын ойр орчимд үйл ажиллагаа явуулж байгаа нь фермерийн аж ахуйг суурин газар эрхлэхэд тохиромжтой, дэд бүтэц, зах зээлийн байршилтай холбоотой.

### VII.2.5.Мал аж ахуй эрхэлдэг ААНБ-ын хөдөө аж ахуйн зориулалттай барилга, байгууламжийн тоо

МАА эрхэлдэг ААНБ-д ХАА-н зориулалттай 7 төрлийн 415 барилга, байгууламж тоологдсон.

МАА эрхэлдэг ААНБ-ын хувьд зориулалтын технологийн байр буюу фермийн 60.8 хувь нь Улаанбаатар хотод, 22.8 хувь нь Төвийн бүсэд байгаа нь өмнөх тооллогын дүнтэй харьцуулахад хандлага ижил байна.

ХҮСНЭГТ VII.13. МАЛ АЖ АХУЙ ЭРХЭЛДЭГ ААНБ-ЫН ХАА-Н ЗОРИУЛАЛТТАЙ ГОЛЛОХ БАРИЛГА, БАЙГУУЛАМЖИЙН ТОО, бүсээр

| | Улсын дундаж | | Баруун бүс | | Хангайн бүс | | Төвийн бүс | | Зүүн бүс | | Улаанбаатар | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | 2011 | 2021 | 2011 | 2021 | 2011 | 2021 | 2011 | 2021 | 2011 | 2021 | 2011 | 2021 |
| Зориулалтын технологийн байр, ферм | 94 | 79 | 4 | 4 | 4 | 5 | 20 | 18 | 7 | 4 | 59 | 48 |
| Зоорь | 80 | 54 | 22 | 8 | 15 | 15 | 31 | 24 | 3 | 4 | 9 | 3 |
| Агуулах | 67 | 68 | 17 | 10 | 7 | 6 | 33 | 45 | 5 | 4 | 5 | 3 |

## VII.2.6.Мал аж ахуй эрхэлдэг ААНБ-ын хөдөө аж ахуйн зориулалттай барилга, байгууламжийн багтаамж

МАА эрхэлдэг ААНБ-ын хувьд зориулалтын технологийн байр буюу фермийн нийт багтаамжийн 98.9 мянган хонин толгой байгаа бөгөөд дунджаар нэг ферм 2 041 хонин толгойн багтаамжтай байна. Нийт багтаамжийн 74.4 хувь нь Улаанбаатар хотод байна. Улаанбаатар хотын нэг фермийн дундаж багтаамж нь 1533 толгой буюу улсын дунджаас 22.4 хувиар өндөр байна. 2011 онд фермийн нийт багтаамж 191.8 мянган толгой байсан бөгөөд үүний 87.8 хувь нь Улаанбаатар хотод байсан.

ХҮСНЭГТ VII.14. МАЛ АЖ АХУЙ ЭРХЭЛДЭГ ААНБ-ЫН ГОЛЛОХ БАРИЛГА, БАЙГУУЛАМЖИЙН БАГТААМЖ, бүсээр

| Ферм | Бүгд | | Баруун бүс | | Хангайн бүс | | Төвийн бүс | | Зүүн бүс | | Улаанбаатар | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | 2011 | 2021 | 2011 | 2021 | 2011 | 2021 | 2011 | 2021 | 2011 | 2021 | 2011 | 2021 |
| Тоо, ш | 94 | 79 | 0.9 | 2.0 | 4 | 5 | 20 | 18 | 7 | 4 | 59 | 48 |
| Багтаамж, мян.толгой | 191.8 | 98.9 | 236.3 | 511 | 0.1 | 3.6 | 10.1 | 14.8 | 12.3 | 4.9 | 168.4 | 73.6 |
| Дундаж багтаамж, толгой | 2 041.2 | 1 252.4 | 0.9 | 2.0 | 30.0 | 713 | 615.8 | 824 | 1 759.6 | 1225 | 2 854.9 | 1 533.3 |

VIII БҮЛЭГ

# МАЛЫН ХАШАА



## МАЛЫН ХАШААНЫ ТОО

263 251 | ӨРХ

1 422 | ААНБ

ӨРХ | 94 8874.1

ААНБ | 1 028.1

## МАЛЫН ХАШААНЫ БАГТААМЖ, мян.тол

# VIII. МАЛЫН ХАШАА

ХАА-н тооллогоор мал аж ахуй эрхэлдэг өрх, аж ахуйн нэгж, байгууллагын өөрийн эзэмшилд байгаа бүх төрлийн малын хашаа[4], хашааны төрөл, багтаамжийн талаарх мэдээллийг цуглуулсан. Мал аж ахуй эрхэлдэг өрх, аж ахуйн нэгж, байгууллагын өөрийн эзэмшилд байгаа бүх төрлийн малын хашаа 264.7 мянга тоологдсон бөгөөд бүсээр авч үзвэл 112.3 мянга буюу 42.6 хувь нь Хангайн бүс, 66.8 мянга буюу 25.4 хувь нь Баруун бүс, 54.4 мянга буюу 20.3 хувь нь Төвийн бүс, 24.2 мянга буюу 9.1 хувь нь Зүүн бүс,  үлдсэн 7.0 мянга буюу 2.6 хувь нь Улаанбаатарт байна.

ХҮСНЭГТ VIII.1. МАЛЫН ХАШААНЫ ТОО, ХАШААНЫ БАГТААМЖ, төрөл, бүсээр

| | Хашаа, бүгд | Хашаа | | Багтаамж, мян.толгой | |
|---|---|---|---|---|---|
| | | Өрх | ААНБ | Өрх | ААНБ |
| **Бүгд** | **264 673** | **263 251** | **1 422** | **94 774.1** | **1 028.4** |
| Баруун бүс | 66 792 | 66 739 | 53 | 19 431.6 | 32.2 |
| Хангайн бүс | 112 344 | 112 141 | 203 | 35 749.8 | 194.9 |
| Төвийн бүс | 54 365 | 53 546 | 819 | 25 775.0 | 484.1 |
| Зүүн бүс | 24 190 | 24 044 | 146 | 12 840.0 | 277.7 |
| Улаанбаатар | 6 981 | 6 780 | 201 | 977.6 | 39.5 |

Хонин толгойд шилжүүлснээр 94.8 сая толгой малын багтаамж бүхий 264.7 мянган хашаа тоологдсон байна. Өрхийн эзэмшлийн нийт тоологдсон малын хашааг 2011 оны дүнтэй харьцуулахад 34.9 хувиар өссөн бөгөөд бүсээр авч үзвэл Төвийн бүсэд 44.0 хувиар, Зүүн бүсэд 40.8 хувиар, Баруун бүсэд 40.0 хувиар, Хангайн бүсэд 29.1 хувиар, Улаанбаатар хотод 26.9 хувиар тус тус өссөн байна.

Нийт мал аж ахуйн эрхэлдэг өрхийн 67.5 хувь, аж ахуйн нэгж байгууллагын 38.6 хувь нь өөрсдийн эзэмшлийн малын хашаатай байна.

Мал аж ахуй эрхэлдэг нийт өрхийн 165.7 мянга буюу 67.5 хувь нь, аж ахуйн нэгж, байгууллагын 391 буюу 43.3 хувь нь малын хашаатай байна. Малын хашаатай өрхийн тоо арван жилийн өмнө үетэй харьцуулахад 39.1 хувиар, малын хашаатай аж ахуйн нэгж, байгууллагын хувьд 68.5 хувиар өсжээ.

ХҮСНЭГТ VIII.2. МАЛЫН ХАШААНЫ ТОО, эзэмшлийн хэлбэрээр

| | Өрх, ААНБ-ын тоо | | Үүнээс: Малын хашаатай | | Дунд эзлэх хувь | |
|---|---|---|---|---|---|---|
| | 2011 | 2021 | 2011 | 2021 | 2011 | 2021 |
| **Бүгд** | 210 070 | 246 277 | 119 379 | 166 117 | 103 | 111 |
| Өрх | 209 563 | 245 375 | 119 147 | 165 726 | 56.9 | 67.5 |
| ААНБ | 507 | 902 | 232 | 391 | 45.8 | 43.3 |

[4] Баригдаж дуусаагүй, хөрзөнгөөр баригдсан, түр зуурын ашиглалттай буюу нүүдлийн чанартай хашааг малын хашаанд хамруулаагүй болно.

# ХУДАГ, УСАН САН

## Худаг, усан сангийн тоо, төрлөөр



# IX. ХУДАГ, УСАН САН

2021 оны ХАА-н тооллогод хүн, мал ундаалах зориулалт бүхий 75.7 мянган худаг, 509 усан сан тоологдлоо. 2011 онтой харьцуулахад нийт худаг, усан сангийн тоо 2.0 дахин нэмэгдсэн байна. Худгийн төрлөөр авч үзвэл богино яндант 1.3 хувиар, гүний өрөмдмөл 18.5 хувиар, энгийн уурхай 25.8 хувиар бусад төрлийн худаг 6.0 нэгж хувиар тус тус өссөн үзүүлэлттэй байна.

Тоологдсон худгийн 37.8 мянга буюу 49.9 хувь нь энгийн уурхайн, 25.1 мянга буюу 33.3 хувь нь гүний өрөмдмөл, 4.6 мянга буюу 6.1 хувь нь богино яндант, 8.1 мянга буюу 10.7 хувь нь бусад төрлийн худаг байна.

ХҮСНЭГТ IX.1. ХУДАГ, УСАН САНГИЙН ТОО, бүсээр

| | Бүгд | | Баруун бүс | | Хангайн бүс | | Төвийн бүс | | Зүүн бүс | | Улаанбаатар | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | 2011 | 2021 | 2011 | 2021 | 2011 | 2021 | 2011 | 2021 | 2011 | 2021 | 2011 | 2021 |
| **Худаг, бүгд** | **38 417** | **75 665** | **6 705** | **13 796** | **5 090** | **15 320** | **18 696** | **28 649** | **6 556** | **15 403** | **1 370** | **2 497** |
| Гүний өрөмдмөл | 5 655 | 25 161 | 589 | 2 746 | 946 | 5 860 | 2 361 | 8 422 | 994 | 6 296 | 765 | 1 837 |
| Богино яндант | 1 869 | 4 637 | 301 | 1 320 | 294 | 448 | 789 | 1 573 | 437 | 1 253 | 48 | 42 |
| Энгийн уурхай | 29 082 | 37 755 | 5 505 | 8 159 | 3 626 | 6 216 | 14 505 | 16 474 | 4 919 | 6 806 | 527 | 100 |
| Бусад | 1 811 | 8 111 | 309 | 1 571 | 224 | 2 795 | 1 041 | 2 180 | 207 | 1 047 | 30 | 518 |
| **Зохиомол хөв цөөрөм** | **-** | **36** | **-** | **12** | **-** | **7** | **-** | **14** | **-** | **2** | **-** | **1** |
| **Усан сан** | **282** | **509** | **58** | **63** | **29** | **210** | **75** | **202** | **65** | **27** | **55** | **6** |

Бүсээр авч үзвэл нийт худгийн 3.3 хувь нь Улаанбаатарт, 18.2 хувь нь Баруун бүсэд, 20.2 хувь нь Хангайн бүсэд, 20.4 хувь нь Зүүн бүсэд байршиж байгаа бол 37.9 хувь нь буюу нийт тоологдсон худгийн ихэнх нь Төвийн бүсэд байршиж байна.

ХҮСНЭГТ IX.2. БЭЛЧЭЭРТ БАЙРШДАГ ХУДГИЙН ТОО, бүсээр

| | Бүгд | | Баруун бүс | | Хангайн бүс | | Төвийн бүс | | Зүүн бүс | | Улаанбаатар | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | 2011 | 2021 | 2011 | 2021 | 2011 | 2021 | 2011 | 2021 | 2011 | 2021 | 2011 | 2021 |
| **Худаг, бүгд** | **28 290** | **35 716** | **5 173** | **3 064** | **4 715** | **7 377** | **12 505** | **14 833** | **5 354** | **9 853** | **543** | **589** |
| Гүний өрөмдмөл | 4 278 | 12 492 | 480 | 1 284 | 881 | 2 856 | 1 714 | 4 179 | 911 | 3 753 | 292 | 420 |
| Богино яндант | 1 582 | 2 275 | 261 | 366 | 274 | 288 | 618 | 715 | 409 | 894 | 20 | 12 |
| Энгийн уурхай | 21 318 | 18 796 | 4 212 | 1 224 | 3 361 | 3 573 | 9 657 | 9 269 | 3 870 | 4 685 | 218 | 45 |
| Бусад | 1 112 | 2 154 | 220 | 190 | 199 | 660 | 516 | 671 | 164 | 521 | 13 | 112 |

2011 онд нийт худгийн 28.3 мянга буюу 73.6 хувь нь бэлчээрт байршилтай байсан бол энэ удаагийн тооллогод 35.7 мянга буюу 47.2 хувь нь бэлчээрт байршилтай байна. Түүнчлэн бэлчээрт байршдаг худаг 35.7 мянга тоологдсоноос 41.5 хувь нь Төвийн бүсэд, 27.6 хувь нь Зүүн бүсэд, 20.7 хувь нь Хангайн бүсэд, 8.6 хувь нь Баруун бүсэд, 1.6 хувь нь Улаанбаатар хотод хамрагдаж байна.

## IX.1. Мал аж ахуйн салбарт ашиглаж байгаа худаг, усан сан

Хөдөө орон нутаг болон хот суурин газрын хүн, малын ундны эх үүсвэр болсон худгийг эзэмшлийн төрлөөр нь авч үзвэл, мал аж ахуй эрхэлдэг өрхийн эзэмшилд 73.1 мянган худаг байгаагаас 24.1 мянга буюу 33.0 хувь нь гүний өрөмдмөл, 4.5 мянга буюу 6.2 хувь нь богино яндант, 7.9 мянга буюу 10.8 хувь нь бусад төрлийн худаг байгаа бөгөөд энгийн уурхайн худаг дийлэнх буюу 36.6 мянга буюу 50.0 хувь нь байгаа бол аж ахуйн нэгж, байгууллагын эзэмшилд гүний өрөмдлийн худаг 78.0 хувь буюу дийлэнх хувийг эзэлж байна.

Харин мал аж ахуй эрхэлдэг аж ахуйн нэгж, байгууллагын эзэмшилд нийт 277 худаг байгаагаас 101 буюу 78.0 хувь нь гүний өрөмдмөл, богино яндант 4 буюу 1.4 хувь байгаа бол 36 буюу 13.0 хувь нь энгийн уурхайн худаг байна.

Мал аж ахуй эрхэлдэг өрхийн эзэмшилд нийт 73.1 мянган худаг тоологдсоноос баруун бүсэд 18.5 (13.6 мянга) хувь, Хангайн бүсэд 20.5 (15.0 мянга) хувь, зүүн бүсэд 20.7 (15.1 мянга) хувь, Улаанбаатарт 2.9 (2.1 мянга) хувь байгаа бөгөөд өрхийн эзэмшилд байгаа нийт худгийн 27.3 мянга буюу 37.4 хувь нь Төвийн бүсэд давамгайлж байна.

Мал аж ахуй эрхэлдэг аж ахуйн нэгж, байгууллагын эзэмшилд байгаа худаг, усан сангийн тоог 2011 оны дүнтэй харьцуулахад харьцангуй өссөн дүнтэй харагдаж байна. Усан сангийн хувьд улсын хэмжээнд тоологдсон нийт дүнгийн 487 буюу 99.8 хувь нь мал аж ахуй эрхэлдэг өрхөд ногдож байна.

ХҮСНЭГТ IX.3. ХУДАГ, УСАН САНГИЙН ТОО, эзэмшлээр

| | Бүгд | | Өрхийн эзэмшлийн | | ААНБ-ын эзэмшлийн | | Дүнд эзлэх хувь | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Бүгд | | Өрхийн эзэмшлийн | | ААНБ-ын эзэмшлийн | |
| | 2011 | 2021 | 2011 | 2021 | 2011 | 2021 | 2011 | 2021 | 2011 | 2021 | 2011 | 2021 |
| **Худаг, бүгд** | **29 531** | **73 384** | **29 091** | **73 107** | **440** | **277** | **100.0** | **100.0** | **100.0** | **100.0** | **100.0** | **100.0** |
| Гүний өрөмдмөл | 4 131 | 24 312 | 3 869 | 24 096 | 262 | 216 | 14.0 | 33.1 | 13.3 | 33.0 | 59.5 | 78.0 |
| Богино яндант | 1 601 | 4 517 | 1 558 | 4 513 | 43 | 4 | 5.4 | 6.2 | 5.4 | 6.2 | 9.8 | 1.4 |
| Энгийн уурхай | 22 543 | 36 606 | 22 442 | 36 570 | 101 | 36 | 76.3 | 49.9 | 77.1 | 50.0 | 23.0 | 13.0 |
| Бусад | 1 256 | 7 948 | 1 222 | 7 927 | 31 | 21 | 4.3 | 10.8 | 4.2 | 10.8 | 7.7 | 7.6 |
| Зохиомол хөв цөөрөм | - | 25 | - | 24 | - | 1 | - | - | - | - | - | - |
| Усан сан | 141 | 488 | 137 | 487 | 4 | 1 | - | - | - | - | - | - |

## IX.2. Газар тариалангийн салбарт ашиглаж байгаа худаг, усан сан

Газар тариалан эрхэлдэг өрхийн эзэмшилд 2.0 мянган худаг байгаагаас 1.1 буюу 55.6 хувь нь энгийн уурхайн, 625 буюу 31.1 хувь нь гүний өрөмдмөл, 112 буюу 5.6 хувь нь богино яндант, 156 мянга буюу 7.8 хувь нь бусад төрлийн худаг байна.

Түүнчлэн газар тариалан эрхэлдэг аж ахуйн нэгж, байгууллагын хувьд нийт 269 худаг байгаагаас 224 буюу 83.3 хувь нь гүний өрөмдмөл, 30 буюу 11.2 хувь нь энгийн

уурхайн, 8 буюу 3.0 хувь нь богино яндант, 7 буюу 2.6 хувь нь бусад төрлийн худаг байна.

Газар тариалан эрхэлдэг өрхийн эзэмшилд энгийн уурхайн буюу гар худаг дийлэнх нь байгаа бол аж ахуйн нэгж, байгууллагын эзэмшилд гүний өрөмдмөл худаг дийлэнх хувийг эзэлж байна. Арван жилийн өмнөх үетэй харьцуулахад аж ахуйн нэгж, байгууллагын хувьд гүний өрөмдмөл 57.7 хувиар, богино яндант 83.3 хувиар, энгийн уурхай 84.7 хувиар тус тус буурсан үзүүлэлттэй байна.

Бүсээр авч үзвэл, газар тариалан эрхэлдэг өрх, аж ахуйн нэгж, байгууллагын эзэмшилд байгаа бүх төрлийн худгийн дийлэнх нь Төвийн бүсэд байршиж байна. Тоологдсон нийт усан сангийн 14 буюу 66.7 хувь нь газар тариалан эрхэлдэг өрхийн эзэмшилд байгаа бол 7 буюу 33.3 хувь нь газар тариалан эрхэлдэг аж ахуйн нэгж, байгууллагын эзэмшилд байна.

ХҮСНЭГТ IX.4. ХУДАГ, УСАН САНГИЙН ТОО, эзэмшлийн төрлөөр

| | Бүгд | | Өрхийн эзэмшлийн | | ААНБ-ын эзэмшлийн | | Дүнд эзлэх хувь | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Бүгд | | Өрхийн эзэмшлийн | | ААНБ-ын эзэмшлийн | |
| | 2011 | 2021 | 2011 | 2021 | 2011 | 2021 | 2011 | 2021 | 2011 | 2021 | 2011 | 2021 |
| **Худаг, бүгд** | 8 885 | 2 281 | 8 097 | 2 012 | 788 | 269 | 100.0 | 100.0 | 100.0 | 100.0 | 100.0 | 100.0 |
| Гүний өрөмдмөл | 1 524 | 849 | 994 | 625 | 530 | 224 | 17 | 37.2 | 12.3 | 31.1 | 67.3 | 83.3 |
| Богино яндант | 267 | 120 | 219 | 112 | 48 | 8 | 3 | 5.3 | 2.7 | 5.6 | 6.1 | 3.0 |
| Энгийн уурхай | 6 535 | 1 149 | 6 343 | 1 119 | 196 | 30 | 73.7 | 50.4 | 78.3 | 55.6 | 24.9 | 11.2 |
| Бусад | 559 | 163 | 541 | 156 | 14 | 7 | 6.3 | 7.1 | 6.7 | 7.8 | 1.8 | 2.6 |
| Зохиомол хөв цөөрөм | - | 11 | - | 8 | - | 3 | - | - | - | - | - | - |
| Усан сан | 140 | 21 | 113 | 14 | 27 | 7 | - | - | - | - | - | - |

# ХӨДӨӨ АЖ АХУЙН ҮЙЛДВЭРЛЭЛД ҮЗҮҮЛСЭН ҮЙЛЧИЛГЭЭ

## СҮҮЛИЙН 5 ЖИЛД ХАА-Н ЗОРИУЛАЛТТАЙ ЗЭЭЛ АВСАН БОЛОН ДААТГАЛД ХАМРАГДСАН ӨРХ, ААНБ-ЫН ТОО

### Зээл авсан

| | ӨРХ | ААНБ |
|---|---|---|
| Мал аж ахуй | 35 198 | 107 |
| Газар тариалан | 5 233 | 747 |

### Даатгалд хамрагдсан

| | ӨРХ | ААНБ |
|---|---|---|
| Мал аж ахуй | 18 584 | 40 |
| Газар тариалан | 547 | 119 |

# X. ХӨДӨӨ АЖ АХУЙН ҮЙЛДВЭРЛЭЛД ҮЗҮҮЛСЭН ҮЙЛЧИЛГЭЭ

Хөдөө аж ахуйн салбарын үндсэн үзүүлэлтүүдээс гадна энэ салбарт үзүүлж буй нийгмийн зарим төрлийн үйлчилгээ, даатгал, санхүүгийн үйлчилгээ түүний хүртээмжтэй байдлын үзүүлэлтүүдийн мэдээллийг ХАА-н тооллогоор анхан шатны нэгжээс цуглуулан, энэ бүлэгт танилцуулж байна.

## X.1. Даатгалд хамрагдсан өрх, ААНБ

Цаг уурын эрс, тэс уур амьсгалтай, байгаль цаг, уурын эрсдэлд байнга өртөх магадлалтай, сүүлийн жилүүдэд байгалийн бэрхшээлд олон удаа өртөж байсан манай орны хувьд даатгалын үйлчилгээ нь эрсдэлээс хамгаалах арга хэрэгсэл болж малчид, тариаланчдын амьжиргаанд бодит дэмжлэг болох боломжтой.

Тооллогод хамрагдсан мал аж ахуйн эрхэлдэг өрхийн 19.0 хувь буюу 46.6 мянган өрх малын индексжүүлсэн даатгал, арилжааны даатгал болон бусад төрлийн даатгалд хамрагдсан байгаа бол газар тариалан эрхэлдэг өрхийн 1.1 хувь нь үр тарианы болон арилжааны бусад даатгалуудад хамрагдсан байна. Харин мал аж ахуй эрхлэгч ААНБ-ын 24.1 хувь, газар тариалан эрхлэгч ААНБ-ын 3.6 хувь нь даатгалд хамрагдсан гэж хариулжээ.

Өмнөх тооллогын хугацаанд буюу 2011 оны байдлаар мал аж ахуй эрхлэгчдийн даатгалд хамрагдсан байдал 9.0 хувьтай байсантай харьцуулахад 10 нэгж хувиар даатгалд хамрагдалт өссөн байна. Харин газар тариаланчдын даатгалд хамрагдалт 10 жилийн дараагаар 0.6 нэгж хувиар буурсан буюу хамрагдалт маш бага түвшинд хэвээр байна.

ХҮСНЭГТ X.1. ӨРХ, ААНБ-ЫН ДААТГАЛД ХАМРАГДСАН БАЙДАЛ, даатгалын төрлөөр

| | Өрх | | | | ААНБ | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | Мал аж ахуй | | Газар тариалан | | Мал аж ахуй | | Газар тариалан | |
| | 2011 | 2021 | 2011 | 2021 | 2011 | 2021 | 2011 | 2021 |
| Өрх, ААНБ-ын тоо | 209 563 | 245 375 | 33 461 | 18 844 | 507 | 407 | 1 705 | 1 643 |
| **Даатгалд хамрагдсан өрх[1], ААНБ-ын тоо** | **18 584** | **46 555** | **547** | **199** | **40** | **98** | **119** | **59** |
| Малын индексжүүлсэн даатгал | 14 387 | 42 191 | - | - | 28 | 98 | - | - |
| Үрийн тариалангийн даатгал | - | - | 100 | 163 | - | - | 30 | 56 |
| Арилжааны бусад даатгал | 3 647 | 1 077 | 256 | 25 | 10 | 1 | 32 | 2 |
| Бусад | 944 | 4 056 | 138 | 21 | 4 | 11 | 45 | 2 |

[1] Нэгээс дээш төрлийн даатгалд хамрагдсан байж болно.

Даатгалд хамрагдсан өрхийг салбараар авч үзвэл, мал аж ахуй эрхэлдэг өрхийн 90.6 хувь нь малын индексжүүлсэн даатгалд, газар тариалан эрхэлдэг өрхийн 81.9 хувь нь үрийн даатгалд хамрагдсан байна. 2011 онтой харьцуулахад даатгуулсан мал аж

ахуй эрхэлдэг өрхийн малын индексжүүлсэн даатгалд хамрагдалтын хувь 2.9 дахин нэмэгдсэн байна. Арилжааны даатгалын хамрагдалт 2011 оноос буурсан байна.

## X.2. Зээл авсан өрх, ААНБ, зээлийн хугацаа, барьцаа хөрөнгө

Санхүүгийн дэмжлэг, зээлийн үйлчилгээ нь өрхийн амьжиргаа, аж ахуйн нэгжид хөрөнгө оруулалтын эх үүсвэр, санхүүгийн хэрэгцээт үйлчилгээ болдог тул ХАА-н салбарт сүүлийн 10 жилийн зээлийн хүртээмжийн өөрчлөлтийг судлахаар тус тооллогод зээлийн мэдээллийг цуглуулсан.

Зээл авсан өрх, зээлийн тоон мэдээллээс харахад өрхийн хувьд мал аж ахуйн үйлдвэрлэл эрхэлдэг өрхүүд нь зээлийн үйлчилгээнд түлхүү хамрагдсан бол ААНБ-ын хувьд газар тариалангийн үйлдвэрлэл эрхэлдэг ААНБ-ууд зээлийн үйлчилгээнд түлхүү хамрагдсан байна. Тухайлбал мал аж ахуй, газар тариалангийн үйлдвэрлэл эрхэлдэг нийт өрхийн 42.6 хувь буюу 112.7 мянган өрх сүүлийн 5 жилд ХАА-н үйлдвэрлэлдээ зориулж зээл авсан байна. 2011 онтой харьцуулахад зээл авсан өрхийн тоо 2.6 дахин нэмэгдсэн байна.

Түүнчлэн мал аж ахуй, газар тариалан эрхэлдэг ААНБ-ын 35.2 хувь буюу 895 аж ахуйн нэгж сүүлийн 5 жилд ХАА-н үйлдвэрлэлдээ зориулж зээл авсан байна. ХАА-н салбарт үйл ажиллагаа явуулж байгаа ААНБ-ын тоо төдийлөн хурдацтай нэмэгдэхгүй байгаа бөгөөд зээлтэй ААНБ-ын тоо өмнөх 10 жилтэй харьцуулахад 4.8 хувиар өссөн ч ААНБ-ын тоотой харьцуулахад зээл авсан ААНБ-ын тоо 3.4 нэгж хувиар буурсан байна.

ХҮСНЭГТ X.2. СҮҮЛИЙН 5 ЖИЛД ХАА-Н ЗОРИУЛАЛТТАЙ ЗЭЭЛ АВСАН ӨРХ, ААНБ-ЫН ЗЭЭЛ АВСАН ТОО, зээлийн хугацаагаар

| | Өрх | | | | ААНБ | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | Мал аж ахуй | | Газар тариалан | | Мал аж ахуй | | Газар тариалан | |
| | 2011 | 2021 | 2011 | 2021 | 2011 | 2021 | 2011 | 2021 |
| Өрх, ААНБ-ын тоо | 209 563 | 245 375 | 33 461 | 18 844 | 507 | 902 | 1 705 | 1 643 |
| Зээл авсан өрх, ААНБ-ын тоо[1] | 35 198 | 107 615 | 5 233 | 5 035 | 107 | 211 | 747 | 684 |
| Зээлийн тоо, хугацаагаар | | | | | | | | |
| 1 жилийн хугацаатай | 65 281 | 99 886 | 9 675 | 7 771 | 96 | 19 | 922 | 701 |
| 1-3 жилийн хугацаатай | 7 483 | 73 318 | 1 277 | 1 950 | 70 | 163 | 298 | 311 |
| 3 ба түүнээс дээш жилийн хугацаатай | 3 649 | 49 712 | 256 | 1 105 | 33 | 44 | 358 | 181 |

[1] Нэгээс дээш төрлийн зээл авсан байж болно.

Зээлд хамрагдсан ХАА-н үйлдвэрлэл эрхэлдэг өрхүүдээс давхардсан тоогоор богино хугацааны буюу 1 жил хүртэлх хугацаатай зээлийг сүүлийн 5 жилд ойролцоогоор 1 удаа, 1-3 жилийн хугацаатай зээлийг 10 өрх тутмын 7 нь авсан бол 2 өрх тутмын нэг нь 3 ба түүнээс дээш жилийн хугацаатай зээлд хамрагдсан байна. 2011 онтой харьцуулахад ХАА-н үйлдвэрлэл эрхэлдэг өрхийн дунд 1 жилийн хугацаатай зээл авсан хувь 39.5 нэгж хувиар буурсан бол 1-3 жилийн хугацаатай болон 3 ба түүнээс дээш жилийн хугацаатай зээлд хамрагдсан хувь 22.2 болон 17.3

нэгж хувиар нэмэгдсэн үзүүлэлттэй байна. Эндээс харахад зээлийн үйлчилгээг урт хугацаатайгаар авах сонирхол нэмэгдсэн харагдаж байна.

Газар тариалангийн үйл ажиллагаа эрхэлдэг өрх, ААНБ-ын хувьд зээлийн хугацааг нэг хүртэлх жилийн хугацаатай авч байгаа нь тариалан эрхлэгчдэд жил бүрийн эргэлтийн хөрөнгийн хэрэгцээт богино хугацаат зээлийн эх үүсвэр санхүүгийн чухал хэрэгсэл болж байгааг харуулж байна.

ХАА-н үйлдвэрлэл эрхэлдэг өрх, ААНБ-ын хувьд зээлийн үндсэн эх үүсвэр нь арилжааны банк болж байгаа нь сүүлийн 10 жилийн хугацаанд хандлага хэвээр хадгалагдсаар байна.

Зээлийн эх үүсвэрийг судлахад, өрхүүд нийт зээлийнхээ 98.6 хувийг арилжааны банкнаас, 0.6 хувийг банк бус санхүүгийн байгууллагаас авсан байна. Харин аж ахуйн нэгж, байгууллагын хувьд зээлийн эх үүсвэрийн 94.0 хувийг арилжааны банк, 1.7 хувийг банк бус санхүүгийн байгууллага бүрдүүлж байна. 2011 онтой харьцуулахад өрхийн зээлийн эх үүсвэрт төдийлөн өөрчлөлт гараагүй бол аж ахуйн нэгж, байгууллагын хувьд арилжааны банкнаас зээл авах хувь 29.7 нэгж хувиар нэмэгдсэн байна.

ХҮСНЭГТ X.3. ХӨРӨНГӨ БАРЬЦААЛЖ ХАА-Н ЗОРИУЛАЛТТАЙ ЗЭЭЛ АВСАН ӨРХ, ААНБ-ЫН ТОО, барьцаалсан хөрөнгийн төрлөөр

| | Өрх | | | | ААНБ | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | Мал аж ахуй | | Газар тариалан | | Мал аж ахуй | | Газар тариалан | |
| | 2011 | 2021 | 2011 | 2021 | 2011 | 2021 | 2011 | 2021 |
| Өрх, ААНБ-ын тоо | 34 200 | 104 905 | 4 983 | 4 905 | 101 | 73 | 701 | 677 |
| Барьцаалсан хөрөнгийн төрөл | | | | | | | | |
| Мал | 32 254 | 104 008 | 1 921 | 489 | 44 | 47 | 127 | 30 |
| Газар | 4 210 | 3 498 | 3 240 | 4 404 | 39 | 33 | 448 | 619 |
| Барилга байгууламж | - | 1 009 | - | 310 | - | 34 | - | 165 |
| Байшин, гэр, орон сууц | - | 10 161 | - | 1 195 | - | 23 | - | 186 |
| Машин, тоног төхөөрөмж | 9 610 | 4 437 | 1 798 | 678 | 43 | 6 | 383 | 196 |
| Малын хашаа | - | 4 117 | - | - | - | 6 | - | - |
| Бусад | 5 234 | 289 | 1 495 | 20 | 44 | 1 | 231 | 2 |

Зээлийн үйлчилгээ авахад хөрөнгө барьцаалж, хөдөө аж ахуйн зориулалттай зээл авсан өрх, ААНБ-ын хөрөнгийн талаарх судлахад өрх, ААНБ-ууд дийлэх тохиолдолд нэгээс олон төрлийн хөрөнгийг барьцаалж байна. Тухайлбал, мал аж ахуй эрхэлж буй өрхүүдийн дийлэнх нь буюу 99.1 хувь нь малыг барьцаалж байхад газар тариалан эрхэлж буй өрхүүдийн 89.8 хувь нь газар барьцаалж байна. МАА эрхэлж буй өрхүүдийн барьцаалж буй малаас бусад хөрөнгө нь байшин, гэр, орон сууц (9.7 хувь), машин, тоног төхөөрөмж (4.2 хувь), газар (3.3 хувь) зэрэг байгаа бол газар тариалан эрхэлдэг өрхүүдийн газраас бусад барьцаалж буй хөрөнгө нь байшин, гэр, орон сууц (24.4 хувь), машин, тоног төхөөрөмж (13.8 хувь), мал (10.0 хувь), барилга байгууламж (6.3 хувь) зэрэг багтаж байна.

Мал аж ахуй эрхэлдэг ААНБ-ын зээлийн барьцаанд мал 64.4 хувь, барилга байгууламж 46.6 хувь, газар 45.2 хувь, байшин, гэр орон сууц 31.5 хувь, машин, тоног төхөөрөмж 8.2 хувийг эзэлж байгаа бол газар тариалан эрхэлдэг ААНБ-ын зээлийн барьцаанд газар 91.4 хувь, машин тоног төхөөрөмж 29.0 хувь, байшин, гэр, орон сууц 27.5 хувь, барилга байгууламж 24.4 хувь, мал 4.4 хувийг эзэлж байна.

## X.3. ХАА-н бүтээгдэхүүн борлуулалтын орчин

### Мал аж ахуй эрхэлдэг өрхийн ХАА-н бүтээгдэхүүн борлуулдаг зах зээл хүртэлх зай

Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн үйлдвэрлэж, борлуулдаг нэгжийн хувьд зах зээл хүртэлх зай бүтээгдэхүүний өртөгт шууд нөлөөлж байна.

МАА эрхэлдэг өрхийн 28.9 хувь нь 20-49 км зайд бүтээгдэхүүнээ борлуулдаг байна. Бүсээр авч үзвэл Хангайн бүс, Төвийн бүс болон Зүүн бүсийн өрхүүдэд 20-49 км зайд борлуулалт хийх хандлага зонхилж байгаа бол Баруун бүс болон Улаанбаатар хотын өрхүүд хамгийн ойрын зайнд буюу 4 хүртэлх км зайд бүтээгдэхүүнээ борлуулдаг байна. 2011 онтой харьцуулахад МАА эрхэлдэг өрхийн хувьд зах зээлээс алслагдмал байдал буурч илүү зах зээлтэй ойртсон дүр зураг харагдаж байна.

2011 онд нийт өрхийн 34.3 хувь нь ХАА-н бүтээгдэхүүнээ 100 ба түүнээс дээш км алслагдмал газраас зах зээлд борлуулдаг байсан бол 2021 оны байдлаар бүтээгдэхүүнээ борлуулдаг нийт өрхийн 17.8 хувь нь тус зайнаас бага зайд зах зээлд борлуулсан бөгөөд 100 ба түүнээс дээш км зайнаас бүтээгдэхүүнээ борлуулдаг өрхийн хувь 16.5 нэгж хувиар буурсан байна.

Мөн 50-99 км зайнаас бүтээгдэхүүнээ борлуулдаг байдал Улаанбаатар хотод 11.1 нэгж хувиар буурч, Зүүн бүсэд 4.6 нэгж хувиар нэмэгдсэн бол бусад бүсийн хувьд зах зээлтэй ойртсон байдалд төдийлөн өөрчлөлт гараагүй байна.

ХҮСНЭГТ X.4. МАЛ АЖ АХУЙ ЭРХЭЛДЭГ ӨРХИЙН ХАА-Н БҮТЭЭГДЭХҮҮН БОРЛУУЛДАГ ДУНДАЖ ЗАЙ, км-ээр

| | Бүгд | Баруун бүс | Хангайн бүс | Төвийн бүс | Зүүн бүс | Улаанбаатар |
|---|---|---|---|---|---|---|
| Бүгд | 100.0 | 100.0 | 100.0 | 100.0 | 100.0 | 100.0 |
| 4 хүртэлх км | 18.8 | 28.9 | 16.2 | 12.9 | 12.4 | 31.1 |
| 5-19 км | 12.6 | 10.2 | 13.7 | 12.9 | 12.7 | 24.7 |
| 20-49 км | 28.9 | 26.7 | 31.3 | 28.2 | 28.6 | 29.1 |
| 50-99 км | 21.9 | 22.4 | 21.9 | 21.2 | 23.0 | 13.4 |
| 100-199 км | 11.2 | 8.7 | 8.0 | 18.8 | 15.0 | 1.2 |
| 200 ба түүнээс дээш км | 6.5 | 3.1 | 9.0 | 6.1 | 8.3 | 0.6 |

### Мал аж ахуй эрхэлдэг ААНБ-ын ХАА-н бүтээгдэхүүн борлуулдаг зах зээл хүртэлх зай

Мал аж ахуй эрхэлдэг ААНБ-ын 22.7 хувь нь 20-49 км зайд бүтээгдэхүүнээ борлуулдаг байна. Бүсээр авч үзвэл Хангайн бүс болон Зүүн бүсийн өрхүүдэд 20-49

км зайд борлуулалт хийх хандлага зонхилж байгаа бол Баруун бүс болон Улаанбаатар хотын ААНБ-ууд ойрхон зайнд буюу 20 хүртэлх км зайд бүтээгдэхүүнээ борлуулдаг байна.

ХҮСНЭГТ Х.5. МАЛ АЖ АХУЙ ЭРХЭЛДЭГ ААНБ-ЫН ХАА-Н БҮТЭЭГДЭХҮҮН БОРЛУУЛДАГ ДУНДАЖ ЗАЙ, км-ээр

| | Бүгд | Баруун бүс | Хангайн бүс | Төвийн бүс | Зүүн бүс | Улаанбаатар |
|---|---|---|---|---|---|---|
| Бүгд | **100.0** | 100.0 | 100.0 | 100.0 | 100.0 | 100.0 |
| 4 хүртэлх км | **19.8** | 64.3 | 29.2 | 9.5 | 17.3 | 18.2 |
| 5-19 км | **16.8** | 7.1 | 20.8 | 14.3 | 14.8 | 45.5 |
| 20-49 км | **22.7** | - | 29.2 | 20.2 | 25.9 | 18.2 |
| 50-99 км | **20.6** | 7.1 | 12.5 | 26.2 | 22.2 | 18.2 |
| 100-199 км | **10.5** | 14.3 | 4.2 | 19.1 | 6.2 | - |
| 200 ба түүнээс дээш км | **9.7** | 7.1 | 4.2 | 10.7 | 13.6 | - |

Харин Төвийн бүсийн хувьд зонхилох хэсэг нь 55-99 км зайд борлуулалт хийж байна. 2011 онтой харьцуулахад МАА эрхэлдэг ААНБ-ын хувьд зах зээлээс алслагдмал байдал буурч, зах зээлтэй ойртсон дүр зураг харагдаж байна. Тухайлбал, 2011 онд нийт ААНБ-ын 33.9 хувь нь ХАА-н бүтээгдэхүүнээ 100 ба түүнээс дээш км алслагдмал газраас зах зээлд борлуулдаг байсан бол 2021 оны байдлаар бүтээгдэхүүнээ борлуулдаг нийт ААНБ-ын 20.2 хувь нь тус зайнаас зах зээлд борлуулсан бөгөөд 100 ба түүнээс дээш км зайнаас бүтээгдэхүүнээ борлуулдаг ААНБ -ын хувь 16.5 нэгж хувиар буурсан байна. Мөн 50-99 км зайнаас бүтээгдэхүүнээ борлуулдаг байдал Баруун бүсэд 15.8 нэгж хувиар буурч, Зүүн бүсэд 15.2 нэгж хувиар нэмэгдсэн бол бусад бүсийн хувьд тус хэлбэрт төдийлөн өөрчлөлт гараагүй байна.

<u>Газар тариалан эрхэлдэг өрхийн ХАА-н бүтээгдэхүүн борлуулдаг зах зээл хүртэлх зай</u>

Газар тариалан эрхэлдэг өрхийн 24.6 хувь нь 4 хүртэл км зайд бүтээгдэхүүнээ борлуулдаг байна. Бүсээр авч үзвэл Хангайн бүс, Зүүн бүсийн болон Улаанбаатар хотын өрхүүд 4 хүртэл км зайд борлуулалт хийх хандлага зонхилж байгаа бол Баруун бүсийн хувьд 20-49 км, Төвийн бүсийн хувьд 100-199 км зайд бүтээгдэхүүнээ ихэвчлэн борлуулдаг байна.

Нийт газар тариалан эрхэлдэг өрхийн 30.8 хувь нь ХАА-н бүтээгдэхүүнээ 100 ба түүнээс дээш км алслагдмал газраас зах зээлд борлуулсан бөгөөд 2011 оныхоос 4.1 нэгж хувиар нэмэгдсэн байна. Бүсээр нь авч үзвэл 100 ба түүнээс км зайнаас бүтээгдэхүүнээ борлуулдаг өрхийн хувь Баруун бүсэд 1.8 нэгж хувиар, Хангайн бүсэд 2.9 нэгж хувиар, Зүүн бүсэд 17.6 нэгж хувиар, Улаанбаатар хотод 4.4 нэгж хувиар буурсан бол Төвийн бүсэд 9.5 нэгж хувиар нэмэгдсэн байна. Түүнчлэн, 50-99 км зайнаас бүтээгдэхүүнээ борлуулдаг байдал Баруун бүсэд 6.7 нэгж хувиар, Зүүн бүсэд 1.9 нэгж хувиар буурсан бол Хангайн бүсэд 1.5 нэгж хувиар, Төвийн бүсэд 1.9 нэгж хувиар мөн Улаанбаатар хотод 1.6 нэгж хувиар нэмэгдсэн үзүүлэлттэй байна.

ХҮСНЭГТ X.6. ГАЗАР ТАРИАЛАН ЭРХЭЛДЭГ ӨРХИЙН ХАА-Н БҮТЭЭГДЭХҮҮН БОРЛУУЛДАГ ДУНДАЖ ЗАЙ, км-ээр

| | Бүгд | Баруун бүс | Хангайн бүс | Төвийн бүс | Зүүн бүс | Улаанбаатар |
|---|---|---|---|---|---|---|
| Бүгд | **100.0** | 100.0 | 100.0 | 100.0 | 100.0 | 100.0 |
| 4 хүртэлх км | **24.6** | 24.4 | 29.0 | 18.0 | 49.4 | 36.2 |
| 5-19 км | **12.3** | 16.6 | 12.2 | 8.1 | 18.5 | 26.8 |
| 20-49 км | **20.4** | 32.4 | 26.6 | 10.0 | 21.6 | 23.1 |
| 50-99 км | **11.9** | 10.0 | 14.1 | 13.3 | 4.2 | 11.5 |
| 100-199 км | **21.2** | 12.4 | 10.4 | 35.7 | 2.0 | 2.5 |
| 200 ба түүнээс дээш км | **9.6** | 4.26 | 7.9 | 14.9 | 4.2 | 0.0 |

<u>Газар тариалан эрхэлдэг ААНБ-ын ХАА-н бүтээгдэхүүн борлуулдаг зах зээл хүртэлх зай</u>

Газар тариалан эрхэлдэг ААНБ-ын 26.3 хувь нь 100-199 км зайд бүтээгдэхүүнээ борлуулдаг байна. Бүсээр авч үзвэл Баруун бүс, Хангайн бүс болон Зүүн бүсийн ААНБ-уудад 200 ба түүнээс дээш км зайд борлуулалт хийх хандлага зонхилж байгаа бол Төвийн бүсийн хувьд 100-199 км, Улаанбаатар хотын хувьд 20-49 км зайд бүтээгдэхүүнээ ихэвчлэн борлуулдаг байна.

Нийт газар тариалан эрхэлдэг ААНБ-ын 51.2 хувь нь ХАА-н бүтээгдэхүүнээ 100 ба түүнээс дээш км алслагдмал газраас зах зээлд борлуулсан бөгөөд 2011 оныхоос 1.4 нэгж хувиар нэмэгдсэн байна.

ХҮСНЭГТ X.7. ГАЗАР ТАРИАЛАН ЭРХЭЛДЭГ ӨРХИЙН ААНБ-ЫН БҮТЭЭГДЭХҮҮН БОРЛУУЛДАГ ДУНДАЖ ЗАЙ, км-ээр

| | Бүгд | Баруун бүс | Хангайн бүс | Төвийн бүс | Зүүн бүс | Улаанбаатар |
|---|---|---|---|---|---|---|
| Бүгд | **100.0** | 100.0 | 100.0 | 100.0 | 100.0 | 100.0 |
| 4 хүртэлх км | **10.0** | 17.6 | 13.2 | 4.9 | 16.5 | 16.3 |
| 5-19 км | **11.2** | 27.3 | 15.5 | 3.7 | 17.6 | 11.6 |
| 20-49 км | **14.5** | 9.7 | 21.0 | 11.5 | 13.2 | 44.2 |
| 50-99 км | **13.1** | 8.0 | 11.9 | 15.9 | 4.4 | 20.9 |
| 100-199 км | **26.3** | 8.0 | 6.9 | 44.8 | 1.1 | 7.0 |
| 200 ба түүнээс дээш км | **24.9** | 29.6 | 31.5 | 19.3 | 47.3 | 0.0 |

Бүсээр нь авч үзвэл 100 ба түүнээс км зайнаас бүтээгдэхүүнээ борлуулдаг ААНБ-ын хувь Хангайн бүсэд 14.8 нэгж хувиар, Зүүн бүсэд 5.9 нэгж хувиар, Улаанбаатар хотод 20.0 нэгж хувиар буурсан бол Баруун бүсэд 10.3 нэгж хувиар, Төвийн бүсэд 0.3 нэгж хувиар нэмэгдсэн байна. Түүнчлэн, 50-99 км зайнаас бүтээгдэхүүнээ борлуулдаг байдал Баруун бүсэд 8.7 нэгж хувиар, Хангайн бүсэд 1.6 нэгж хувиар, Зүүн бүсэд 3.9 нэгж хувиар буурсан бол, Төвийн бүсэд 1.6 нэгж хувиар мөн Улаанбаатар хотод 10.3 нэгж хувиар нэмэгдсэн үзүүлэлттэй байна.

XI БҮЛЭГ

# ГАЗАР ТАРИАЛАНГИЙН САЛБАРЫН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

**УСАЛГААТАЙ ТАЛБАЙ, төрлөөр, дүнд эзлэх хувиар**




## УСАЛГААТАЙ ТАЛБАЙ

Хөдөө аж ахуйн тооллогоор усалгаатай тариалан эрхэлсэн 6.5 мянган өрх, 606 ААНБ бүртгэгдсэн байна.

# XI. ГАЗАР ТАРИАЛАНГИЙН САЛБАРЫН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Хөдөө аж ахуйн тооллогоор газар тариалангийн салбарын үндсэн үзүүлэлтүүд болох газар, түүний ашиглалт, ойн зурвасаар хүрээлж, хамгаалагдсан талбайн хэмжээ, усжуулалттай тариалангийн талбай, тариалангийн талбайн хөрсний элэгдэл, эвдрэл, хүлэмжийн тариалалт зэргийн талаарх мэдээллийг цуглуулж, үр дүнг нийтийн хүртээл болгож байна.

**Газар түүний ашиглалт.** Газар тариалангийн ААНБ нийт 598.2 мянган га өөрийн эзэмшилд ашиглаж байна.

**Ойн зурвасаар хүрээлж, хамгаалсан талбай.** ХАА-н тооллогоор 175.6 мянган км ойн зурвас бүхий 503 өрх, 102 ААНБ бүртгэгдлээ. Нийт байгуулсан ойн зурвасын 62.3 хувь нь өрхөд, 37.7 хувь нь ААНБ-д байна.

Ойн зурвас байгуулсан нэг өрхөд дунджаар 217.5 мянган км, ААНБ-д дунджаар 648.9 мянган километр ойн зурвас ногдож байна.

**Усалгаатай талбай.** ХАА-н тооллогоор усалгаатай тариалан эрхэлсэн 6.5 мянган өрх, 606 ААНБ бүртгэгдсэн байна.

Усалгаатай тариалан эрхэлсэн өрх, ААНБ нь нийтдээ 47.9 мянган га тариалангийн талбайд усжуулалт хийсэн бөгөөд усалгаатай талбайн 32.6 хувь нь өрхөд, 67.4 хувь нь ААНБ-д ногдож байна.

Усалгаатай тариалан эрхэлсэн нэг өрхөд дунджаар 2.4 га, нэг аж ахуйн нэгж байгууллагад 53.2 га усалгаатай талбай ногдож байна

**Хүлэмжийн аж ахуй.** ХАА-н тооллогоор 4468.4 мянган га-д хүлэмжийн аж ахуй эрхэлсэн 3.1 мянган өрх, 242 ААНБ бүртгэгдлээ. Хүлэмжийн тариалалт хийсэн талбайн 78.3 хувийг өрх, 21.7 хувийг ААНБ эзэлж байна.

**Хөрсний доройтол.** Газар тариалан эрхэлдэг өрх, аж ахуйн нэгж байгууллага нь (тариалангийн газрыг өмчлөгч, эзэмшигч, ашиглагч) тариалангийн газрын хөрсний чанар байдлыг агрохимийн шинжилгээгээр хөрсний 0-40 см гүний ялзмаг, нитратын азот, хөдөлгөөнт фосфор, хөдөлгөөнт кали, хөрсний бүхэлшил, хөрсний эвдрэл, элэгдлийн зэрэг, усалгаатай тариалангийн газрын хөрсний намагжилт, давсжилт гэсэн үзүүлэлтүүдээр 5 жил тутам хийлгэх үүрэгтэй байдаг.

ХАА-н тооллогоор агрохимийн шинжилгээг газар тариалан эрхэлдэг өрхийн 3.6 хувь буюу 0.7 мянган өрх хийлгэжээ. Харин газар тариалан эрхэлдэг ААНБ-ын 14.9 хувь буюу 244 ААНБ уг шинжилгээг хийлгэсэн байна.

**Бордоо, ургамал хамгааллын бодис/пестицид хэрэглэсэн талбай**. ХАА-н тооллогоор бордоо ургамал хамгааллын бодис/пестицид ашигласан 5.5 мянган өрх, 739 ААНБ бүртгэгдсэн байна. Бордоо хэрэглэсэн талбайн 7.3 хувь нь өрхөд, 92.7 хувь нь ААНБ-д байна. Харин ургамал хамгааллын бодис/пестицид хэрэглэсэн талбайн 6.9 хувь нь өрхөд, 93.1 хувь нь ААНБ-д байна.

Нэг га талбайд дунджаар 6.4 тонн бордоо, 19.8 кг ургамал хамгааллын бодис/пестицид ногдож байна.

## XI.1. Газар түүний ашиглалт

Газар тариалангийн аж ахуйн нэгж байгууллагууд нийт 598.2 мянган га талбайг өөрийн эзэмшилд ашиглаж байна. Өөрийн эзэмшилд буй газрыг бүсээр авч үзвэл дийлэнхийг буюу 352.3 мянган га буюу 58.9 хувийг Төвийн бүсийн ААНБ -ууд ашигласан байна.

ХҮСНЭГТ XI.1. ААНБ-ЫН ЭДЭЛБЭР ГАЗРЫН ТАЛБАЙН ХЭМЖЭЭ, эзэмшлийн төрлөөр бүсээр, га-гаар

| | Бүгд | Баруун бүс | Хангайн бүс | Төвийн бүс | Зүүн бүс | Улаанбаатар |
|---|---|---|---|---|---|---|
| **Өөрийн эзэмшилд буй газар** | **598 235.1** | **47 769.4** | **85 074.2** | **352 268.9** | **109 682.1** | **3 440.5** |
| Бусдаас түрээсэлсэн газар | 57 255.6 | 9 027.4 | 9 607.5 | 32 091.9 | 6 492.4 | 36.3 |
| Иргэд | 33 767.2 | 7 196.5 | 2 519.9 | 22 154.7 | 1 859.9 | 36.3 |
| Төрийн, ОНӨГ | 12 597.4 | 724.9 | 5 815.8 | 3 225.7 | 2 831.0 | 0.02 |
| ААНБ | 10 890.9 | 1 106.0 | 1 271.9 | 6 711.5 | 1 801.5 | - |

Газар тариалан эрхэлдэг ААНБ-ын бусдаас түрээсэлсэн эдэлбэр газрын хэмжээ 2021 онд нийт 57.3 мянган га байна. Хангайн бүсийн ААНБ-ууд төрийн болон, ОНӨГ-аас 46.2 хувь буюу 5.8 мянган га талбай түрээсэлсэн бол Төвийн бүсийн ААНБ-ууд иргэдээс 65.6 хувь буюу 22.2 мянган га, ААНБ-аас 61.6 хувийг буюу 6.7 мянган га талбай түрээсэлсэн байна.

ХҮСНЭГТ XI.2. БУСДААС ГАЗАР ТҮРЭЭСЭЛСЭН ААНБ-ЫН ТОО, бүсээр

| | Бүгд | | Баруун бүс | | Хангайн бүс | | Төвийн бүс | | Зүүн бүс | | Улаанбаатар | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | 2011 | 2021 | 2011 | 2021 | 2011 | 2021 | 2011 | 2021 | 2011 | 2021 | 2011 | 2021 |
| ААНБ-ын тоо | 131 | 327 | 11 | 72 | 33 | 57 | 72 | 149 | 6 | 34 | 9 | 15 |
| ГТ эрхэлдэг ААНБ-д эзлэх хувь | 100.0 | 100.0 | 8.4 | 22.0 | 25.1 | 17.4 | 55.0 | 45.6 | 4.6 | 10.4 | 6.9 | 4.6 |

Тооллогын дүнгээр 327 ААНБ бусдын газрыг түрээслэн тариалан эрхэлж байгаа нь тариалан эрхэлдэг нийт ААНБ-ын 19.9 хувийг эзэлж байна.

Бүсээр авч үзвэл, бусдаас газар түрээсэлсэн ААНБ-ын 45.6 хувь нь Төвийн бүсэд, 22.0 хувь нь Баруун бүсэд байгаа нь газар түрээсэлсэн нийт ААНБ-ын 67.6 хувийг эзэлж байна.

ХҮСНЭГТ XI.3. ААНБ-ЫН ХӨДӨӨ АЖ АХУЙ ЭДЭЛБЭР ГАЗАР, бүсээр

| | Бүгд | Баруун бүс | Хангайн бүс | Төвийн бүс | Зүүн бүс | Улаанбаатар |
|---|---|---|---|---|---|---|
| ХАА-н эдэлбэр газар | 655 290.7 | 56 796.8 | 94 681.7 | 384 160.8 | 116 174.6 | 3 476.9 |
| Хадлан | 1 703.3 | 1 196.3 | 110.0 | 397.0 | - | - |
| Тариалан | 622 504.0 | 42 901.1 | 92 360.1 | 377 830.0 | 108 637.2 | 775.6 |
| Атаршсан | 17 411.2 | 12 698.2 | 655.0 | - | 4 058.0 | - |
| Бусад | 13 672.2 | 1.2 | 1 556.6 | 5 933.8 | 3 479.3 | 2 701.3 |

ХАА-н эдэлбэр газрыг бүсээр авч үзвэл Зүүн, Хангайн, Баруун бүс 8.7-17.7 хувийг эзэлж байгаа бол Төвийн бүс 58.6 хувийг эзэлж байна. Харин Улаанбаатар хот дөнгөж 0.5 хувийг эзэлдэг байна.

Хадлангийн талбайн 70.2 хувь, атаршсан талбайн 72.9 хувь нь Баруун бүсэд байна. Тариалангийн талбайн 60.7 хувь нь, бусад талбайн 43.4 хувь нь Төвийн бүсэд байна.

## XI.2. Ойн зурвас байгуулалт

Тооллогоор газар тариалан эрхэлдэг өрх, аж ахуйн нэгж, байгууллагуудын тариалангийн талбайгаа мал, амьтан, элс, шорооны нүүдэл, хуурайшил, салхинаас хамгаалах зорилгоор тойруулан тарьсан мод, бут бүхий ойн зурвасын уртын талаарх мэдээллийг цуглуулж, танилцуулж байна.

ОЙН ЗУРВАС БАЙГУУЛСАН ӨРХ, АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГА

Газар тариалан эрхэлдэг өрхийн 2.7 хувь (503), ААНБ-ын 6.2 хувь (102) нь тариалангийн талбайгаа хамгаалж ойн зурвас байгуулсан байна. 2011 онтой харьцуулахад ойн зурвас байгуулсан өрхийн хувь 0.9 нэгж хувиар, ААНБ-ын хувь 6.2 нэгж хувиар буурсан байна. Үүнээс үзэхэд тариалангийн талбайд хамгаалалт хийх, байгаль орчныг нөхөн сэргээх үүднээс холбогдох байгууллагууд энэ талын үйл ажиллагаанд илүү анхаарал хандуулах, дэмжих бодлого явуулах шаардлага байгааг харуулж байна.

Ойн зурвас байгуулсан өрхийн 31.2 хувь нь Баруун бүсэд, 30.0 хувь нь Төвийн бүсэд, 16.7 хувь нь Хангайн бүсэд, 13.5 хувь нь Улаанбаатар хотод, 8.5 хувь нь Зүүн бүсэд байршиж байна.

Харин ойн зурвас байгуулсан ААНБ-ын 40.2 хувь нь Төвийн бүсэд, 23.5 хувь нь Баруун бүсэд, 17.6 хувь нь Хангайн бүсэд, 11.8 хувь нь Улаанбаатар хотод, 6.9 хувь нь Зүүн бүсэд бүсэд оршиж байна.

ХҮСНЭГТ XI.4. ОЙН ЗУРВАСААР ХҮРЭЭЛЭГДСЭН ТАРИАЛАНГИЙН ТАЛБАЙТАЙ ӨРХ, ААНБ -ЫН ТОО, бүсээр

| | Бүгд | | Баруун бүс | | Хангайн бүс | | Төвийн бүс | | Зүүн бүс | | Улаанбаатар | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | 2011 | 2021 | 2011 | 2021 | 2011 | 2021 | 2011 | 2021 | 2011 | 2021 | 2011 | 2021 |
| Өрх | 1 213 | 503 | 313 | 157 | 165 | 84 | 479 | 151 | 58 | 43 | 198 | 68 |
| ААНБ | 212 | 102 | 85 | 24 | 25 | 18 | 73 | 41 | 9 | 7 | 20 | 12 |
| Дүнд эзлэх хувь | | | | | | | | | | | | |
| Өрх | 100.0 | 100.0 | 25.8 | 31.2 | 13.6 | 16.7 | 39.5 | 30.0 | 4.8 | 8.5 | 16.3 | 13.5 |
| ААНБ | 100.0 | 100.0 | 40.1 | 23.5 | 11.8 | 17.6 | 34.5 | 40.2 | 4.2 | 6.9 | 9.4 | 11.8 |

Газар тариалан эрхэлдэг ойн зурвастай ААНБ-ын 40.2 хувь нь Төвийн бүсэд, өрхийн 31.2 хувь нь Баруун бүсэд оршиж байгаа нь бусад бүсүүдтэй харьцуулахад өндөр байна.

### XI.3. Усалгаатай тариалан

НҮБ-ын ХАА-н байгууллагаас гишүүн улс орнууддаа усалгаатай тариалан, усжуулалт, усжуулалтын системийн талаарх статистик мэдээллийг тооллогын асуулгад тусган, мэдээлэл цуглуулахыг зөвлөмж болгосон байдаг.

Монгол Улсын Засгийн газраас усалгаатай тариаланг хөгжүүлэх, дэмжих, түүнд тулгуурлаж газрын хэрэглээг сайжруулах, га-гаас хураах ургацын хэмжээг нэмэгдүүлэх, ингэснээр дотооддоо үйлдвэрлэсэн, эрүүл ахуйн шаардлага хангасан газар тариалангийн бүтээгдэхүүнээр хүн амын хүнсний хэрэгцээг хангахад анхаарал хандуулж ирсэн.

Үүнтэй уялдан тооллогын асуулгад усалгаатай тариалан эрхэлж байгаа өрх, аж ахуйн нэгж, байгууллагын тоо, усалгаатай талбай, усжуулалтын системийн төрөл, усалгааны аргууд, усжуулалтын эх үүсвэр зэрэг мэдээллийг цуглуулсан. Усжуулалт гэж үр тариа, төмс, хүнсний ногоо зэрэг таримал ургамлын ургалт, га-гаас хураах ургацыг нэмэгдүүлэх зорилгоор хөрсийг зохиомлоор усжуулах үйл ажиллагаа юм.

УСАЛГААТАЙ ГАЗАР ТАРИАЛАН ЭРХЭЛДЭГ ӨРХ, ААНБ

Газар тариалан эрхэлдэг нийт өрхийн 34.4 хувь (6.5 мянга), ААНБ-ын 36.9 хувь (606) нь усалгаатай тариалан эрхэлж байна.

Улаанбаатар хотод газар тариалангийн үйлдвэрлэл эрхэлдэг өрхийн 45.2 хувь, Баруун бүсэд 39.8 хувь, Хангайн бүсэд 34.9 хувь, Зүүн бүсэд 33.7 хувь, Төвийн бүсэд 28.3 хувь нь усалгаатай тариалан эрхэлжээ.

Улаанбаатар хотод газар тариалангийн үйлдвэрлэл эрхэлдэг ААНБ-ын 82.3 хувь, Зүүн бүсэд 42.2 хувь, Баруун бүсэд 40.3 хувь, Хангайн бүсэд 35.2 хувь, Төвийн бүсэд 31.0 хувь нь усалгаатай газар тариалан эрхэлсэн дүнтэй байна.

ХҮСНЭГТ XI.5. УСАЛГААТАЙ ГАЗАР ТАРИАЛАН ЭРХЭЛДЭГ ӨРХ, ААНБ -ЫН ТОО, бүсээр

| | Бүгд | | Баруун бүс | | Хангайн бүс | | Төвийн бүс | | Зүүн бүс | | Улаанбаатар | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | 2011 | 2021 | 2011 | 2021 | 2011 | 2021 | 2011 | 2021 | 2011 | 2021 | 2011 | 2021 |
| Өрх | 27 078 | 6 485 | 4 816 | 1 475 | 6 034 | 1 222 | 10 534 | 2 133 | 1 402 | 576 | 4 292 | 1 079 |
| ААНБ | 906 | 606 | 316 | 116 | 144 | 95 | 328 | 262 | 26 | 68 | 92 | 65 |
| Дүнд эзлэх хувь | | | | | | | | | | | | |
| Өрх | 100.0 | 100.0 | 17.8 | 22.7 | 22.3 | 18.8 | 38.9 | 32.9 | 5.2 | 8.9 | 15.9 | 16.6 |
| ААНБ | 100.0 | 100.0 | 34.9 | 19.1 | 15.9 | 15.7 | 36.2 | 43.2 | 2.9 | 11.2 | 10.2 | 10.7 |

Усалгаатай тариалан эрхэлсэн өрхийн 32.9 хувь нь Төвийн бүсэд, 22.7 хувь нь Баруун бүсэд, 18.8 хувь нь Хангайн бүсэд, 16.6 хувь нь Улаанбаатар хотод, 8.9 хувь нь Зүүн бүсэд байна. 2011 оны тооллогын дүнтэй харьцуулж авч үзэхэд Баруун бүсэд 4.9 нэгж хувиар, Улаанбаатар хотод 0.7 нэгж хувиар, Зүүн бүсэд 3.7 нэгж

хувиар, тус тус нэмэгдсэн бол Төвийн бүсэд 6.0 нэгж хувиар, Хангайн бүсэд хотод 3.5 нэгж хувиар тус тус буурсан байна.

Харин усалгаатай тариалан эрхэлдэг ААНБ-ын 43.2 хувь нь Төвийн бүсэд, 19.1 хувь нь Баруун бүсэд, 15.7 хувь нь Хангайн бүсэд, 11.2 хувь нь Зүүн бүсэд 10.7 хувь нь Улаанбаатар хотод байна. 2011 оны тооллогын дүнгээс Хангайн бүс 0.2 нэгж хувиар, 15.8 нэгж хувиар тус тус буурсан байна. Харин Төвийн бүс 7.0 нэгж хувиар, Улаанбаатар хотод 0.5 нэгж хувиар, Зүүн бүсэд 8.3 нэгж хувиар тус, тус нэмэгдсэн байна.

Улсын хэмжээнд усалгаатай газар тариаланг Баруун болон Төвийн бүсийн газар тариалангийн үйлдвэрлэл эрхэлдэг өрх, ААНБ-ууд бусад бүсийнхтэй харьцуулахад илүү давамгай эрхэлсэн байна.

УСАЛГААТАЙ ТАРИАЛАН ЭРХЛЭЭГҮЙ ШАЛТГААН

Газар тариалан эрхэлдэг 18.8 мянган өрхийн 12.4 мянга нь буюу 65.6 хувь, 1643 ААНБ -ын 1037 буюу 63.1 хувь нь усалгаатай газар тариалан эрхлээгүй байна.

ХҮСНЭГТ XI.6. УСАЛГААТАЙ ТАРИАЛАН ЭРХЛЭЭГҮЙ ӨРХ, ААНБ -ЫН ТОО, шалтгаанаар

| | Өрх | | | | ААНБ | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | Бүгд | | Дунд эзлэх хувь | | Бүгд | | Дунд эзлэх хувь | |
| | 2011 | 2021 | 2011 | 2021 | 2011 | 2021 | 2011 | 2021 |
| Бүгд | 6 383 | 12 359 | 100.0 | 100.0 | 799 | 1 037 | 100.0 | 100.0 |
| Усны эх үүсвэр дутмаг | 2 871 | 3 870 | 45.0 | 31.3 | 398 | 543 | 49.8 | 52.4 |
| Санхүүгийн боломжгүй | 2 149 | 2 466 | 33.7 | 20.0 | 311 | 348 | 38.9 | 33.6 |
| Ажиллах хүч дутмаг | 512 | 892 | 8.0 | 7.2 | 40 | 105 | 5.0 | 10.1 |
| Техник эвдэрсэн | 71 | 111 | 1.1 | 0.9 | 12 | 5 | 1.5 | 0.5 |
| Услах шаардлагагүй | 1 609 | 1731 | 25.2 | 14.0 | 157 | 189 | 19.6 | 18.2 |
| Бусад | 426 | 1462 | 6.7 | 11.8 | 49 | 61 | 6.1 | 5.9 |

Усалгаатай тариалан эрхлээгүй шалтгааныг усны эх үүсвэр дутмаг, санхүүгийн боломж муу, ажиллах хүч дутмаг, техник эвдэрсэн, услах шаардлагагүй, бусад гэсэн шалтгаанаар авч үзлээ.

Усалгаатай газар тариалан эрхлээгүй өрхийн 31.3 хувь нь усны эх үүсвэр дутмагаас, 20.0 хувь нь санхүүгийн боломжгүйгээс, 14.0 хувь нь услах шаардлагагүйгээс, 11.8 хувь нь бусад, 7.2 хувь нь ажиллах хүч дутмагаас, 0.9 хувь нь техник эвдэрсэн шалтгаантай байгаа бол усалгаатай тариалан эрхлээгүй ААНБ -ын хувьд 52.4 хувь нь усны эх үүсвэр дутмагаас, 33.6 хувь нь санхүүгийн боломжгүйгээс, 18.2 хувь нь услах шаардлагагүйгээс, 10.1 хувь нь ажиллах хүч дутмагаас, 0.5 хувь нь техник эвдэрсэн, 5.9 хувь нь бусад шалтгаантай байна.

Өрх, ААНБ -ууд усалгаатай тариалан эрхлэхгүй байгаа гол шалтгаан нь усны эх үүсвэр болон хөрөнгө санхүүгийн боломж дутмагаас болжээ.

УСАЛГААТАЙ ТАЛБАЙН ХЭМЖЭЭ

Газар тариалан эрхэлдэг өрх, ААНБ нь нийт 609.8 мянган га-д үр тариа, төмс, хүнсний ногоо, тэжээлийн ургамал, бусад төрлийн ургамлыг тариалснаас 47.9 мянган га-д буюу 7.9 хувьд нь усжуулалт хийсэн байна.

2011 онтой харьцуулахад нийт тариалсан талбай 242.6 мянган га-аар, нийт усалгаатай талбай 1.7 мянган га-аар өссөн байна.

Ургамлыг төрлөөр авч үзвэл, усалгаатай талбайн 29.9 хувь нь үр тарианы, 22.5 хувь нь тэжээлийн таримал, 18.0 хувь нь төмсний, 13.8 хувь нь хүнсний ногооны, 12.7 хувь нь техникийн, 3.0 хувь нь жимс, жимсгэнэ, 0.1 хувь нь эмийн ургамал, үлдсэн талбайг цэцэг, гоёл чимэглэлийн таримал болон бусад төрлийн ургамал эзэлж байна. 2011 оны тооллогын дүнтэй харьцуулахад үр тариа 10.6 нэгж хувиар, төмс 5.5 нэгж хувиар тус тус буурсан байна. Хүнсний ногоо 0.2 нэгж хувиар, техникийн ургамал 11.0 нэгж хувиар, тэжээлийн ургамал 14.4 нэгж хувиар тус тус өссөн байна.

Өрхийн хувьд төмс, хүнсний ногооны усалгаатай тариаланг голчлон эрхэлсэн бол, ААНБ -ын хувьд үр тариа болон тэжээлийн ургамал усалгаатай тариаланг голчлон эрхэлсэн байна. Усалгаатай газар тариалан эрхэлсэн нэг өрхөд 2.4 га талбай ногдож байгаа бол аж ахуйн нэгж, байгууллагад 53.2 га талбай ногдож байна. 2011 онтой харьцуулахад нэг өрхөд ногдох талбай 1.6 га талбайгаар, 21.6 га талбайгаар өссөн байна.

Усалгаатай газар тариалан эрхэлсэн өрхийн 99.1 хувь буюу 6.4 мянга нь 10 хүртэлх га-д тариалалт эрхэлсэн бол 56 өрх буюу 0.9 хувь нь 10 ба түүнээс дээш га-д усалгаатай тариалалт эрхэлжээ.

ХҮСНЭГТ XI.7. УСАЛГААТАЙ ТАЛБАЙ, төрлөөр

| | Бүгд | | | | | | Дунд эзлэх хувь | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Өрх | | ААНБ | | Бүгд | | Өрх | | ААНБ | |
| | 2011 | 2021 | 2011 | 2021 | 2011 | 2021 | 2011 | 2021 | 2011 | 2021 | 2011 | 2021 |
| Нийт усалгаатай талбай | 49 641.4 | 47 866.8 | 21 017.4 | 15 616.1 | 28 624.0 | 32 250. 8 | 100.0 | 100.0 | 100.0 | 100.0 | 100.0 | 100.0 |
| Үр тариа | 20 110.8 | 14 305.9 | 2 088.5 | 2 300.5 | 18 022.3 | 12 005.4 | 40.5 | 29.9 | 9.9 | 14.7 | 63.0 | 37.2 |
| Төмс | 11 642.4 | 8 593.7 | 8 172.3 | 4 911.6 | 3 470.1 | 3 682.1 | 23.5 | 18.0 | 38.9 | 31.5 | 12.1 | 11.4 |
| Хүнсний ногоо | 6 735.6 | 6 627.4 | 5 598.4 | 4 307.2 | 1 137.2 | 2 320.2 | 13.6 | 13.8 | 26.6 | 27.6 | 4.0 | 7.2 |
| Цэцэг, гоёл чимэглэлийн таримал | - | 0.1 | - | 0.1 | - | - | - | 0.0 | - | 0.0 | - | - |
| Тэжээлийн ургамал | 4 021.9 | 10 772.3 | 1 349.9 | 3 649.4 | 2 672.0 | 7 122.9 | 8.1 | 22.5 | 6.4 | 23.4 | 9.3 | 22.1 |
| Техникийн ургамал | 831.8 | 6 081.2 | 40.9 | 120.2 | 790.9 | 5 961.0 | 1.7 | 12.7 | 0.2 | 0.8 | 2.8 | 18.5 |
| Эмийн ургамал | - | 50.1 | - | 0.1 | - | 50 | - | 0.1 | - | 0.0 | - | 0.2 |
| Жимс, жимсгэнэ | - | 1 433.9 | - | 326.5 | - | 1 107.4 | - | 3.0 | - | 2.1 | - | 3.4 |
| Бусад | 6 298.9 | 2.3 | 3 767.4 | 0.5 | 2 531.5 | 1.8 | 12.7 | 0.0 | 17.9 | 0.0 | 8.8 | 0.0 |

Усалгаатай газар тариалан эрхэлдэг өрхийн тоог усжуулалт хийж байгаа талбайн хэмжээгээр бүлэглэн авч үзэхэд, талбайн хэмжээ багасах тусам усжуулалт хийсэн өрхийн тоо нэмэгдэж байгаа нь газар тариалан эрхэлдэг өрхүүд усалгааг ихэвчлэн 10 га хүртэлх хэмжээний талбайд хийж байгааг харуулж байна.

ХҮСНЭГТ XI.8. УСАЛГААТАЙ ГАЗАР ТАРИАЛАН ЭРХЭЛСЭН ӨРХИЙН ТОО, талбайн бүлгээр

| | Өрхийн тоо | | Талбайн хэмжээ | | Нэг өрхөд ногдох талбайн хэмжээ | |
|---|---|---|---|---|---|---|
| | 2011 | 2021 | 2011 | 2021 | 2011 | 2021 |
| **Бүгд** | **27 078** | **6 485** | **21 017.5** | **15 616.1** | **0.8** | **2.4** |
| 10 хүртэл га | 26 907 | 6 429 | 14 160.2 | 10 297.4 | 0.5 | 1.6 |
| 10-50 хүртэл га | 134 | 51 | 2 589.8 | 2 741.1 | 19.3 | 53.7 |
| 50-100 хүртэл га | 24 | 2 | 1 718.0 | 890.9 | 71.6 | 445.5 |
| 100 га-с дээш га талбайтай | 13 | 3 | 2 549.3 | 1 686.6 | 196.1 | 562.2 |

ААНБ -ын 76.9 хувь нь буюу 466 нь 10 хүртэлх га -д, 9.2 хувь нь 10-50 хүртэлх га-д, 5.1 хувь нь 50-100 хүртэлх га-д, 8.7 хувь нь 100 га-аас дээш га-д усалгаатай газар тариалан эрхэлсэн байна. 2011 онтой харьцуулахад 10 хүртэлх га 1.6 нэгж хувиар, 50-100 хүртэлх га 0.1 нэгж хувиар, 100 га-с дээш га талбайтай ААНБ 3.4 нэгж хувиар өссөн байна. Харин 10-50 хүртэлх га талбайтай ААНБ 5.4 нэгж хувиар буурсан байна.

ХҮСНЭГТ XI.9. УСАЛГААТАЙ ГАЗАР ТАРИАЛАН ЭРХЭЛСЭН ААНБ -ЫН ТОО, талбайн бүлгээр

| | ААНБ-ын тоо | | Талбайн хэмжээ | | Нэг ААНБ-д ногдох талбайн хэмжээ | |
|---|---|---|---|---|---|---|
| | 2011 | 2021 | 2011 | 2021 | 2011 | 2021 |
| **Бүгд** | **906** | **606** | **28 624.0** | **32 250.8** | **31.6** | **53.2** |
| 10 хүртэл га | 682 | 466 | 1 976.5 | 1 848.4 | 2.9 | 4.0 |
| 10-50 хүртэл га | 132 | 56 | 3 146.3 | 4 275.2 | 23.8 | 76.3 |
| 50-100 хүртэл га | 44 | 31 | 3 446.2 | 3 772.1 | 78.3 | 121.7 |
| 100 га-с дээш га талбайтай | 48 | 53 | 20 055.0 | 22 355.1 | 417.8 | 421.8 |

Мөн усалгаатай газар тариалан эрхэлдэг ААНБ -ын тоог усжуулалт хийж байгаа талбайн хэмжээгээр бүлэглэн авч үзэхэд, талбайн хэмжээ багасах тусам усжуулалт хийсэн ААНБ -ын тоо нэмэгдэж байгаа нь газар тариалангийн үйлдвэрлэл эрхэлдэг ААНБ нь өрхийн адил усалгааг ихэвчлэн бага хэмжээний талбайд хийдгийг харуулж байна.

Усалгаатай тариалангийн талбай өрх, ААНБ -ын аль алинд нь бага байгаа нь газрын ашиглалтыг сайжруулах, га-гаас авах ургацын хэмжээг нэмэгдүүлэхийн тулд усалгаатай тариаланг нэмэгдүүлэх, дэмжих бодлого зайлшгүй хэрэгтэйг харуулж байна.

## УСАЛГААТАЙ ТАРИАЛАНД АШИГЛАЖ БУЙ УСЖУУЛАЛТЫН СИСТЕМ

Усалгаатай тариаланг эрхлэхэд ашиглаж байгаа усжуулалтын системийн талаарх мэдээллийг инженерийн хийцтэй, энгийн хийцтэй гэсэн төрлөөр ангилав.

Усжуулалтын системд бэлчээр, хадлан, тариаланг услах зорилгоор гадаргын болон газрын доорх усыг хуримтлуулах, дамжуулах, хуваарилах, түгээх, илүүдэл усыг зайлуулах зориулалт бүхий усны барилга байгууламж, тоног төхөөрөмжийг багтаасан иж бүрэн цогцолбор зэргийг хамруулсан.

Усалгаатай тариалан эрхэлсэн 6.5 мянган өрхийн 402 нь инженерийн хийцтэй усжуулалтын төхөөрөмжийг ашигласан бол 6.0 мянга нь энгийн хийцтэй усжуулалтын төхөөрөмж ашигласан байна.

Усалгаатай тариалан эрхэлсэн 606 ААНБ-ын 116 нь инженерийн хийцтэй усжуулалтын төхөөрөмжийг ашигласан бол 490 нь энгийн хийцтэй усжуулалтын төхөөрөмж ашиглажээ.

Усалгаатай тариалан эрхэлдэг өрхийн хувьд дийлэнх хувь нь гар аргаар усжуулалт хийх буюу хувин сав зэргээр усалж байгаа ба энгийн усжуулалтын эх үүсвэртэй байна.

ХҮСНЭГТ XI.10. УСЖУУЛАЛТЫН СИСТЕМ АШИГЛАСАН ӨРХ, ААНБ -ЫН ТОО, усжуулалтын системийн төрлөөр

| | Өрх | | ААНБ | |
|---|---|---|---|---|
| | 2011 | 2021 | 2011 | 2021 |
| Бүгд | 18 465 | 6 485 | 691 | 606 |
| Инженерийн хийцтэй төхөөрөмж ашигладаг | 2 241 | 402 | 209 | 116 |
| Энгийн хийцтэй төхөөрөмж ашигладаг | 16 224 | 6 083 | 482 | 490 |
| Дунд эзлэх хувь | | | | |
| Инженерийн хийцтэй төхөөрөмж ашигладаг | 12.1 | 6.2 | 30.2 | 19.1 |
| Энгийн хийцтэй төхөөрөмж ашигладаг | 87.9 | 93.8 | 69.8 | 80.9 |

Энгийн хийцтэй усжуулалтын төхөөрөмжийг илүү ашиглаж байгаа ба бүсээр авч үзвэл, газар тариалангийн гол бүс болох Төвийн бүсэд усжуулалтын систем ашигладаг өрхийн тоо бусад бүстэй харьцуулахад харьцангуй өндөр байгаа бөгөөд инженерийн хийцтэй усжуулалтын төхөөрөмж ашигласан өрхийн 56.7 хувь, энгийн хийцтэй усжуулалтын төхөөрөмж ашигласан өрхийн 29.8 хувь нь энэ бүсэд байна.

Түүнчлэн төвийн бүсэд буюу газар тариалангийн гол бүсэд инженерийн хийцтэй усжуулалтын төхөөрөмж ашигласан ААНБ -ын 57.8 хувь, энгийн хийцтэй усжуулалтын төхөөрөмж ашигласан ААНБ -ын 39.8 хувь нь энэ бүсэд байна.

Усалгаатай тариалан эрхэлсэн 6.5 мянган өрхийн 241 буюу 3.7 хувь нь усжуулалтын систем ашиглах зорилгоор төрөөс дэмжлэг, туслалцаа авсан байна. Усжуулалтын системийг ажиллуулахад төрөөс дэмжлэг туслалцаа авсан өрхийн 52.3 хувь буюу 126 нь Хангайн бүсэд байна.

ЗУРАГ XI.1. УСЖУУЛАЛТЫН СИСТЕМ АШИГЛАХАД ТӨРӨӨС ДЭМЖЛЭГ АВСАН ӨРХ, ААНБ-ЫН ДҮНД ЭЗЛЭХ ХУВЬ, бүсээр




Түүнчлэн усалгаатай тариалан эрхэлсэн 606 ААНБ -ын 40 буюу 6.6 хувь нь усжуулалтын систем ашиглах зорилгоор төрөөс дэмжлэг, туслалцаа авсан байна. Усжуулалтын системийг ажиллуулахад төрөөс дэмжлэг туслалцаа авсан ААНБ-ын 45.0 хувь нь буюу 18 ААНБ нь мөн Төвийн бүсэд байна.

УСАЛГААТАЙ ГАЗАР ТАРИАЛАН ЭРХЭЛДЭГ ӨРХ, ААНБ -ЫН УСНЫ ТӨЛБӨР

Усалгаатай газар тариалан эрхэлдэг өрхийн 28.3 хувь буюу 1.8 мянга нь усжуулалт хийхдээ усны төлбөр төлдөг бол үлдсэн 71.7 хувь буюу 4.6 мянган өрх усны төлбөр төлөөгүй байна.

Харин усалгаатай газар тариалан эрхэлдэг ААНБ -ын 45.2 хувь буюу 274 ААНБ усжуулалт хийхдээ усны төлбөр төлдөг бол үлдсэн 54.8 хувь буюу 332 ААНБ усны төлбөр төлдөггүй байна.

ХҮСНЭГТ XI.11. УСНЫ ТӨЛБӨР ТӨЛДӨГ ӨРХ, ААНБ -ЫН ТОО

| | Өрх | | | | ААНБ | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | Бүгд | | Дүнд эзлэх хувь | | Бүгд | | Дүнд эзлэх хувь | |
| | 2011 | 2021 | 2011 | 2021 | 2011 | 2021 | 2011 | 2021 |
| Бүгд | 27 078 | 6 485 | 100.0 | 100.0 | 906 | 606 | 100.0 | 100.0 |
| Усны төлбөр төлдөг | 9 119 | 1 836 | 33.7 | 28.3 | 181 | 274 | 20.0 | 45.2 |

Усны төлбөр төлж усжуулалт хийдэг ААНБ-ын ашигласан усны 1 литрийн үнэ дунджаар 2.4 төгрөг, өрхийн хувьд 2.8 төгрөг байна.

ХҮСНЭГТ XI.12. УСНЫ ТӨЛБӨР ТӨЛДӨГ ӨРХ, ААНБ-ЫН АШИГЛАСАН УСНЫ 1 ЛИТРИЙН ДУНДАЖ ҮНЭ, төгрөгөөр, бүсээр

| | Өрх | ААНБ |
|---|---|---|
| Баруун бүс | 1.9 | 2.3 |
| Хангайн бүс | 3.3 | 2.6 |
| Төвийн бүс | 3.2 | 2.3 |
| Зүүн бүс | 3.1 | 2.5 |
| Улаанбаатар | 2.7 | 2.4 |

## УСАЛГААТАЙ ГАЗАР ТАРИАЛАН ЭРХЭЛДЭГ ӨРХ, ААНБ-ЫН УСАЛГААНЫ АРГА

Усалгаатай газар тариалан эрхэлж буй өрх, ААНБ нь усжуулалт хийхдээ ямар төрлийн усалгааны аргыг голчлон хэрэглэж байгааг авч үзье.

Усалгаатай тариалан эрхэлсэн 6.5 мянган өрхийн (давхардсан тоогоор) 64.6 хувь буюу 4.2 мянган өрх гадаргуугаар урсгах аргыг, 23.7 хувь буюу 1.5 мянган өрх гар аргыг хэрэглэж байна. ААНБ-ын хувьд (давхардсан тоогоор) 43.9 хувь буюу 266 ААНБ гадаргуугаар урсгах аргаар, 24.6 хувь буюу 149 ААНБ бороожуулах аргаар усалж байна.

Усалгаатай тариалан эрхэлдэг өрхүүдийн хувьд усжуулалт хийхдээ гадаргуугаар урсгах арга буюу усыг талбай дээгүүр энгийн хүчний нөлөөгөөр урсган, хөрсийг чийглэн, түүнд шингээх аргыг түгээмэл хэрэглэдэг байна.

ХҮСНЭГТ XI.13. УСАЛГААТАЙ ТАРИАЛАН ЭРХЭЛСЭН ӨРХ, ААНБ -ЫН ТОО, усалгааны аргаар

| | Бүгд | | | | Дунд эзлэх хувь | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | Өрх | | ААНБ | | Өрх | | ААНБ | |
| | 2011 | 2021 | 2011 | 2021 | 2011 | 2021 | 2011 | 2021 |
| Гадаргуугаар урсгах арга хэрэглэсэн | 25 033 | 4 192 | 705 | 266 | 92.4 | 64.6 | 77.8 | 43.9 |
| Бороожуулах арга хэрэглэсэн | 1 764 | 603 | 213 | 149 | 6.5 | 9.3 | 23.5 | 24.6 |
| Мананжуулах арга хэрэглэсэн | 248 | 48 | 37 | 9 | 0.9 | 0.7 | 4.1 | 1.5 |
| Дуслын системийн арга хэрэглэсэн | 351 | 83 | 49 | 88 | 1.3 | 1.3 | 5.4 | 14.5 |
| Хөрсөн доороос нэвчүүлэх арга хэрэглэсэн | 633 | 21 | 15 | 12 | 2.3 | 0.3 | 1.7 | 2.0 |
| Гар аргаар услах (хувин, сав зэрэг) | - | 1 538 | - | 141 | - | 23.7 | - | 23.3 |

## УСАЛГААТАЙ ТАРИАЛАН ЭРХЛЭЛТИЙН УСЖУУЛАХ ЭХ ҮҮСВЭР

Усалгаатай тариалан эрхэлсэн 6.5 мянган өрхийн (давхардсан тоогоор) 65.5 хувь буюу 4.2 мянга нь өрмийн худгаар, 32.2 хувь буюу 2.1 мянга нь бороо цасны ус хуримтлуулж, 3.7 хувь буюу 158 өрх энгийн уурхайн худгаар усжуулж байна.

Усалгаатай газар тариалан эрхэлсэн 606 ААНБ-ын (давхардсан тоогоор) усжуулалтын эх үүсвэр нь 51.8 хувь буюу 314 ААНБ өрмийн худгаар, 25.9 хувь буюу 157 нь бороо цасны ус хуримтлуулж, 9.9 хувь буюу 60 нь энгийн уурхайн худгаар байна.

ХҮСНЭГТ XI.14. УСАЛГААТАЙ ТАРИАЛАН ЭРХЭЛСЭН ӨРХ, ААНБ-ЫН ТОО, усжуулалтын эх үүсвэрээр

| | Бүгд | | | | Дунд эзлэх хувь | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | Өрх | | ААНБ | | Өрх | | ААНБ | |
| | 2011 | 2021 | 2011 | 2021 | 2011 | 2021 | 2011 | 2021 |
| Өрмийн худгаар | 3 542 | 4 248 | 238 | 314 | 13.1 | 65.5 | 26.3 | 51.8 |
| Энгийн уурхайн худгаар | 8 169 | 237 | 158 | 60 | 30.2 | 3.7 | 17.4 | 9.9 |
| Нуур, цөөрөм, булаг, шанд | 9 822 | 264 | 496 | 57 | 36.3 | 4.1 | 54.7 | 9.4 |
| Бороо цасны ус хуримтлуулж | 3 085 | 2 091 | - | 157 | 11.4 | 32.2 | - | 25.9 |
| Бусад | 1 348 | 48 | - | 53 | 5 | 0.7 | - | 8.7 |

2011 оны тооллоготой харьцуулахад өрмийн худгаас усжуулалтын эх үүсвэр авдаг өрх 52.4 нэгж хувиар, ААНБ 38.7 нэгж хувиар тус, тус өссөн байна. Бороо цасны ус хуримтлуулж усалдаг өрх 20.8 нэгж хувиар өссөн байна.

## XI.4. Хөрсний доройтол

Тооллогоор тариалангийн талбайн болон хадлан бэлчээрийн талбайн хөрсний элэгдэл, эвдрэлийг ямар зэрэглэлд байгааг тодорхойлох зорилгоор тусгайлсан асуултыг тооллогын асуулгад тусгасан.

Газар тариалан эрхэлдэг өрх, аж ахуйн нэгж, байгууллага нь (тариалангийн газрыг өмчлөгч, эзэмшигч, ашиглагч) тариалангийн газрын хөрсний чанар байдлыг агрохимийн шинжилгээгээр хөрсний 0-40 см гүний ялзмаг, нитратын азот, хөдөлгөөнт фосфор, хөдөлгөөнт кали, хөрсний бүхэлшил, хөрсний эвдрэл, элэгдлийн зэрэг, усалгаатай тариалангийн газрын хөрсний намагжилт, давсжилт гэсэн үзүүлэлтээр 5 жил тутамд тодорхойлох үүрэгтэй байдаг бөгөөд энэ үүргээ биелүүлж, агрохимийн шинжилгээ хийлгэсэн эсэх, эдгээр үзүүлэлт нь ямар түвшинд байгааг тодорхойлох үзүүлэлтийг энэ бүлэгт авч үзье.

Тариалангийн талбайн хөрсний доройтлын зэрэглэлийг сул, дунд, хүчтэй, хэвийн гэсэн ангиллаар ангилж үзсэн.

“Хөрсний доройтлын сул зэрэглэл”-д тухайн газар нутгийн хөрсний талбайн 5 хувиас бага бохирдсон, эсхүл хөрсний өнгөн хэсэг бага зэрэг элэгдсэн, ялзмагийн нөөцийн багасалт 25 хувиас бага талбайг хэлнэ.

“Хөрсний доройтлын дунд зэрэглэл”-д тухайн газар нутгийн хөрсний талбайн 5-20 хувь бохирдсон, эсхүл хөрсний өнгөн хэсэг эвдрэлд орсон, ялзмагийн нөөцийн багасалт 25-50 хувьд хүрсэн талбайг хамарна.

“Хөрсний доройтлын хүчтэй зэрэглэл”-д тухайн газар нутгийн хөрсний талбайн 20-50 хувь бохирдсон, эсхүл хөрс гүн эвдрэлд орсон, үржил шимт чанараа алдаж ялзмагийн нөөцийн багасалт 50-иас дээш хувьд хүрсэн талбайг хамруулж авч үзсэн.

АГРОХИМИЙН ШИНЖИЛГЭЭ ХИЙЛГЭСЭН ӨРХИЙН ТОО

Газар тариалангийн үйл ажиллагаа эрхэлдэг өрхийн 3.6 хувь буюу 0.7 мянган өрх тариалангийн талбайдаа агрохимийн шинжилгээ хийлгэсэн байна. 2011 онтой харьцуулахад хөрсний агрохимийн шинжилгээ хийлгэсэн өрхийн хувь 0.2 нэгж хувиар буурсан байна. Хөрсний агрохимийн шинжилгээ хийлгэсэн өрхийн хувь Хангайн бүсэд 5.8 нэгж хувиар нэмэгдсэн бол Төвийн бүсэд 4.0 нэгж хувиар буурсан байна.

ХҮСНЭГТ XI.15. АГРОХИМИЙН ШИНЖИЛГЭЭ ХИЙЛГЭСЭН ӨРХИЙН ТОО, бүсээр

| | Бүгд | | Баруун бүс | | Хангайн бүс | | Төвийн бүс | | Зүүн бүс | | Улаанбаатар | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | 2011 | 2021 | 2011 | 2021 | 2011 | 2021 | 2011 | 2021 | 2011 | 2021 | 2011 | 2021 |
| Бүгд | 33 461 | 18 844 | 5 076 | 3 707 | 7 917 | 3 503 | 13 190 | 7 534 | 2 307 | 1 711 | 4 971 | 2 389 |
| Өрхийн тоо | 1 286 | 675 | 119 | 135 | 93 | 246 | 1 002 | 228 | 24 | 18 | 5 | 48 |
| Дунд эзлэх хувь | 3.8 | 3.6 | 2.3 | 3.6 | 1.2 | 7.0 | 7.0 | 3.0 | 1.0 | 1.1 | 1.0 | 2.0 |

2011 онд хөрсний агрохимийн шинжилгээ хийлгэсэн өрхийн дийлэнх хувь (77.9%) нь Төвийн бүсэд байсан бол 2021 оны тооллогын дүнгээс харахад Хангайн (29.2 нэгж хувь) болон Баруун (10.7 нэгж хувь) бүсийн хөрсний агрохимийн шинжилгээнд хамрагдсан өрхөд эзлэх хувь нэмэгдсэн үзүүлэлттэй байна.

ЗУРАГ XI.2. АГРОХИМИЙН ШИНЖИЛГЭЭ ХИЙЛГЭСЭН ӨРХИЙН БҮТЭЦ, бүсээр, хувиар




## АГРОХИМИЙН ШИНЖИЛГЭЭНИЙ ҮР ДҮН

Хөрсний агрохимийн шинжилгээ хийлгэсэн газар тариалан эрхэлдэг өрхийн хувьд хөрсний агрохимийн шинжилгээний үр дүнг авч үзвэл хөрсний 0-40 см гүний ялзмаг нь хэвийн өрх нь шинжилгээ хийлгэсэн нийт өрхийн 27.9 хувийг, сул зэрэглэлтэй өрх 22.4 хувь, дундаж зэрэглэлтэй өрх 47.0 хувь, хүчтэй зэрэглэлтэй өрх 2.8 хувийг эзэлж байна. 2011 онд хөрсний 0-40 см гүний ялзмагийн эвдрэл, элэгдлийн зэрэглэл хэвийн өрхийн хувь 21.0 нэгж хувиар буурч, дундаж зэрэглэлтэй өрхийн хувь 14.1 нэгж хувиар нэмэгдсэн байна. Сүүлийн 10 жилд Монгол оронд болсон байгаль цаг уураас шалтгаалах үер, хүчтэй бороо, салхи болон бусад хүчин зүйлс нь хөрсний 0-40 см гүний ялзмагийн бууралт нэмэгдэхэд нөлөөлсөн байх боломжтой.

Хөрсний нитратын азот нь хэвийн байгаа өрх шинжилгээ хийлгэсэн өрхийн 27.9 хувь, хөрс нь сул зэрэглэлд хамаарах өрх 23.1 хувь, дундаж зэрэглэлд хамаарах өрх 46.4 хувь, хүчтэй зэрэглэлд хамаарах өрх 2.7 хувийг эзэлж байна. 2011 онд хөрсний нитратын азотын эвдрэл, элэгдлийн зэрэглэл хэвийн өрхийн хувь 15.1 нэгж хувиар буурч, дундаж зэрэглэлтэй өрхийн хувь 10.1 нэгж хувиар нэмэгдсэн байна.

Хөрсний 0-40 см гүний ялзмаг, нитратын азот нь хүчтэй зэрэглэлд өрхийн эзлэх хувь нь бусад үзүүлэлтийнхээс өндөр хувийн үзүүлэлттэй байна.

Хөрсний хөдөлгөөнт фосфор нь хэвийн өрх шинжилгээ хийлгэсэн өрхийн 28.4 хувь, сул зэрэглэлд хамаарах өрх 22.8 хувь, дундаж зэрэглэлд хамаарах өрх 46.8 хувь, хүчтэй зэрэглэлд хамаарах өрх 1.9 хувийг эзэлж байна. 2011 онд хөрсний хөдөлгөөнт фосфорын эвдрэл, элэгдлийн зэрэглэл хэвийн өрхийн хувь 15.6 нэгж хувиар буурч, дундаж зэрэглэлтэй өрхийн хувь 13.6 нэгж хувиар нэмэгдсэн байна.

Хөрсний хөдөлгөөнт кали нь хэвийн өрх шинжилгээ хийлгэсэн өрхийн 28.9 хувь, сул зэрэглэлтэй өрх 22.2 хувь, дундаж зэрэглэлд байгаа өрх 47.1 хувь, хүчтэй зэрэглэлд байгаа өрх 1.8 хувийг эзэлж байна. 2011 онд хөрсний хөдөлгөөнт калийн эвдрэл, элэгдлийн зэрэглэл хэвийн өрхийн хувь 16.4 нэгж хувиар буурч, дундаж зэрэглэлтэй өрхийн хувь 14.1 нэгж хувиар нэмэгдсэн байна. Үүнээс үзэхэд тариалангийн талбай тэжээл болон органик бодис, давслаг, ислэг, шүлтлэгээ алдсантай холбоотой хөрсний химийн чанар болох хөрсний нитратын азот, хөрсний хөдөлгөөнт фосфор, хөрсний хөдөлгөөнт кали буурах буюу бохирдох үзэгдэл нэмэгдэж байгааг харж болно.

ХҮСНЭГТ XI.16. АГРОХИМИЙН ШИНЖИЛГЭЭ ХИЙЛГЭСЭН ӨРХ, ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТЭЭР, хувиар

| | Бүгд | | Элэгдэл, эвдрэлийн зэрэглэл | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Хэвийн | | Сул | | Дундаж | | Хүчтэй | |
| | 2011 | 2021 | 2011 | 2021 | 2011 | 2021 | 2011 | 2021 | 2011 | 2021 |
| Хөрсний 0-40 см гүний ялзмаг | 100.0 | 100.0 | 48.8 | 27.9 | 13.0 | 22.4 | 32.9 | 47.0 | 5.3 | 2.8 |
| Хөрсний нитратын азот | 100.0 | 100.0 | 42.9 | 27.9 | 14.5 | 23.1 | 36.3 | 46.4 | 6.2 | 2.7 |
| Хөрсний хөдөлгөөнт фосфор | 100.0 | 100.0 | 44.0 | 28.4 | 12.6 | 22.8 | 33.2 | 46.8 | 10.2 | 1.9 |
| Хөрсний хөдөлгөөнт кали | 100.0 | 100.0 | 45.2 | 28.9 | 11.4 | 22.2 | 33.0 | 47.1 | 10.3 | 1.8 |
| Хөрсний бүхэлшил | 100.0 | 100.0 | 46.3 | 29.5 | 19.0 | 4.7 | 33.1 | 64.3 | 1.6 | 1.5 |
| Хөрсний намагжилт, давсжилт | 100.0 | 100.0 | 48.1 | 31.7 | 18.1 | 4.7 | 32.7 | 61.6 | 1.1 | 1.9 |

Хөрсний бүхэлшил нь хэвийн байгаа өрх шинжилгээ хийлгэсэн өрхийн 29.5 хувь, сул зэрэглэлтэй өрх 4.7 хувь, дундаж зэрэглэлтэй өрх 64.3 хувь, хүчтэй зэрэглэлд байгаа өрх 1.5 хувийг эзэлж байна. 2011 онд хөрсний бүхэлшлийн элэгдэл, эвдрэлийн зэрэглэл хэвийн өрхийн хувь 16.8 нэгж хувиар буурч, дундаж зэрэглэлтэй өрхийн хувь 31.2 нэгж хувиар нэмэгдсэн байна.

Хөрсний намагжилт, давсжилт нь хэвийн өрх шинжилгээ хийлгэсэн өрхийн 31.7 хувь, сул зэрэглэлтэй өрх 4.7 хувь, дундаж зэрэглэлтэй өрх 61.6 хувь, хүчтэй зэрэглэлтэй өрх 1.9 хувийг эзэлж байна. 2011 онд хөрсний намагжилт, давсжилтын эвдрэл, элэгдлийн зэрэглэл хэвийн өрхийн хувь 16.4 нэгж хувиар буурч, дундаж зэрэглэлтэй өрхийн хувь 28.9 нэгж хувиар нэмэгдсэн байна.

Хөрсний биет доройтол болох хөрсний бүхэлшил, намагжилт, давсжилтын дутагдал сүүлийн 10 жилийн хугацаанд мөн л нэмэгдсэн үзүүлэлттэй байна.

АГРОХИМИЙН ШИНЖИЛГЭЭ ХИЙЛГЭСЭН ААНБ

Газар тариалангийн үйлдвэрлэл эрхэлдэг ААНБ-ын 14.9 хувь буюу 244 ААНБ тариалангийн талбайдаа агрохимийн шинжилгээ хийлгэсэн байна. 2011 онтой харьцуулахад хөрсний агрохимийн шинжилгээ хийлгэсэн ААНБ-ын хувь 18.9 нэгж хувиар буурсан байна. Бүсээр авч үзвэл хөрсний агрохимийн шинжилгээ хийлгэсэн ААНБ-ын хувь Баруун бүсэд 4.0 нэгж хувиар нэмэгдсэн бөгөөд бусад бүсийн хувьд буурсан үзүүлэлттэй байна. Хөрсний агрохимийн шинжилгээ хийлгэсэн ААНБ-ын хувийн бууралтад Төвийн (38.7%) болон Зүүн (23.2%) бүсийн ААНБ-ын бууралт голлон нөлөөлсөн байна.

ХҮСНЭГТ XI.17. АГРОХИМИЙН ШИНЖИЛГЭЭ ХИЙЛГЭСЭН ААНБ-ЫН ТОО, бүсээр

| | Бүгд | | Баруун бүс | | Хангайн бүс | | Төвийн бүс | | Зүүн бүс | | Улаанбаатар | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | 2011 | 2021 | 2011 | 2021 | 2011 | 2021 | 2011 | 2021 | 2011 | 2021 | 2011 | 2021 |
| Бүгд | 1 705 | 1 643 | 368 | 258 | 282 | 300 | 818 | 845 | 48 | 161 | 189 | 79 |
| ААНБ-ын тоо | 577 | 244 | 41 | 39 | 67 | 62 | 421 | 108 | 18 | 23 | 30 | 12 |
| Дунд эзлэх хувь | 33.8 | 14.9 | 11.1 | 15.1 | 23.8 | 20.7 | 51.5 | 12.8 | 37.5 | 14.3 | 15.9 | 15.2 |

Бүсээр авч үзвэл, тариалангийн талбайдаа шинжилгээ, хөрсний агрохимийн шинжилгээ хийлгэсэн ААНБ-ын 44.3 хувь нь буюу 108 ААНБ нь Хангайн бүсэд, 25.4 хувь нь Төвийн бүсэд, 16.0 хувь нь Баруун бүсэд, 9.4 хувь нь Зүүн бүсэд үлдсэн 4.9 хувь нь Улаанбаатар хотод байршиж байна. 2011 онд хөрсний агрохимийн шинжилгээ хийлгэсэн ААНБ-ын дийлэнх хувь (73.0%) нь Төвийн бүсэд байсан бол 2021 оны тооллогын дүнгээс харахад Хангайн (13.8 нэгж хувь) болон Баруун (8.9 нэгж хувь) бүсийн хөрсний агрохимийн шинжилгээнд хамрагдсан ААНБ-д эзлэх хувь нэмэгдсэн үзүүлэлттэй байна.

ЗУРАГ XI.3. АГРОХИМИЙН ШИНЖИЛГЭЭ ХИЙЛГЭСЭН ӨРХИЙН БҮТЭЦ, бүсээр, хувиар




АГРОХИМИЙН ШИНЖИЛГЭЭНИЙ ҮР ДҮН

Хөрсний агрохимийн шинжилгээ хийлгэсэн газар тариалан эрхэлдэг ААНБ-ын хувьд шинжилгээний үр дүнг авч үзвэл хөрсний 0-40 см гүний ялзмаг нь хэвийн ААНБ нь шинжилгээ хийлгэсэн нийт ААНБ-ын 27.1 хувийг, сул зэрэглэлтэй ААНБ 16.4 хувь, дундаж зэрэглэлтэй ААНБ 54.9 хувь, хүчтэй зэрэглэлтэй ААНБ 1.6 хувийг эзэлж байна. 2011 онд хөрсний 0-40 см гүний ялзмагийн эвдрэл, элэгдлийн зэрэглэл сул ААНБ-ын хувь 8.1 нэгж хувиар буурч, дундаж зэрэглэлтэй ААНБ-ын хувь 15.6 нэгж хувиар нэмэгдсэн байна.

Хөрсний нитратын азот нь хэвийн байгаа ААНБ шинжилгээ хийлгэсэн ААНБ-ын 26.2 хувь, хөрс нь сул зэрэглэлд хамаарах өрх 19.7 хувь, дундаж зэрэглэлд хамаарах ААНБ 52.9 хувь, хүчтэй зэрэглэлд хамаарах ААНБ 1.2 хувийг эзэлж байна. 2011 онд хөрсний нитратын азотын эвдрэл, элэгдлийн зэрэглэл сул ААНБ-ын хувь 10.5 нэгж хувиар буурч, дундаж зэрэглэлтэй ААНБ-ын хувь 14.6 нэгж хувиар нэмэгдсэн байна.

Хөрсний хөдөлгөөнт фосфор нь хэвийн ААНБ шинжилгээ хийлгэсэн ААНБ-ын 25.4 хувь, сул зэрэглэлд хамаарах ААНБ 18.9 хувь, дундаж зэрэглэлд хамаарах ААНБ 53.7 хувь, хүчтэй зэрэглэлд хамаарах ААНБ 2.1 хувийг эзэлж байна. 2011 онд хөрсний хөдөлгөөнт фосфорын эвдрэл, элэгдлийн зэрэглэл хэвийн ААНБ-ын хувь 6.0 нэгж хувиар буурч, дундаж зэрэглэлтэй ААНБ-ын хувь 12.1 нэгж хувиар нэмэгдсэн байна.

Хөрсний хөдөлгөөнт кали нь хэвийн ААНБ шинжилгээ хийлгэсэн ААНБ-ын 25.0 хувь, сул зэрэглэлтэй ААНБ 19.7 хувь, дундаж зэрэглэлд байгаа ААНБ 53.7 хувь, хүчтэй зэрэглэлд байгаа ААНБ 1.6 хувийг эзэлж байна. 2011 онд хөрсний хөдөлгөөнт калийн эвдрэл, элэгдлийн зэрэглэл сул ААНБ-ын хувь 6.3 нэгж хувиар буурч, дундаж зэрэглэлтэй ААНБ-ын хувь 13.5 нэгж хувиар нэмэгдсэн байна.

ХҮСНЭГТ XI.18. АГРОХИМИЙН ШИНЖИЛГЭЭ ХИЙЛГЭСЭН ААНБ, шалгуур үзүүлэлтээр, хувиар

| | Бүгд | | Элэгдэл, эвдрэлийн зэрэглэл | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Хэвийн | | Сул | | Дундаж | | Хүчтэй | |
| | 2011 | 2021 | 2011 | 2021 | 2011 | 2021 | 2011 | 2021 | 2011 | 2021 |
| Хөрсний 0-40 см гүний ялзмаг | 100.0 | 100.0 | 33.8 | 27.1 | 24.45 | 16.4 | 39.3 | 54.9 | 2.4 | 1.6 |
| Хөрсний нитратын азот | 100.0 | 100.0 | 27.2 | 26.2 | 30.2 | 19.7 | 38.3 | 52.9 | 4.3 | 1.2 |
| Хөрсний хөдөлгөөнт фосфор | 100.0 | 100.0 | 31.4 | 25.4 | 23.7 | 18.9 | 41.6 | 53.7 | 3.3 | 2.1 |
| Хөрсний хөдөлгөөнт кали | 100.0 | 100.0 | 30.2 | 25.0 | 26.0 | 19.7 | 40.2 | 53.7 | 3.6 | 1.6 |
| Хөрсний бүхэлшил | 100.0 | 100.0 | 30.3 | 27.1 | 25.8 | 11.9 | 40.7 | 57.4 | 3.1 | 3.7 |
| Хөрсний намагжилт, давсжилт | 100.0 | 100.0 | 34.8 | 33.6 | 25.6 | 12.3 | 37.4 | 50.4 | 2.1 | 3.7 |

Хөрсний бүхэлшил нь хэвийн байгаа ААНБ шинжилгээ хийлгэсэн өрхийн 27.1 хувь, сул зэрэглэлтэй ААНБ 11.9 хувь, дундаж зэрэглэлтэй ААНБ 57.4 хувь, хүчтэй зэрэглэлд байгаа ААНБ 3.7 хувийг эзэлж байна. 2011 онд хөрсний бүхэлшлийн элэгдэл, эвдрэлийн зэрэглэл сул ААНБ-ын хувь 13.9 нэгж хувиар буурч, дундаж зэрэглэлтэй ААНБ-ын хувь 16.7 нэгж хувиар нэмэгдсэн байна.

Хөрсний намагжилт, давсжилт нь хэвийн ААНБ шинжилгээ хийлгэсэн өрхийн 33.6 хувь, сул зэрэглэлтэй өрх 12.3 хувь, дундаж зэрэглэлтэй ААНБ 50.4 хувь, хүчтэй зэрэглэлтэй ААНБ 3.7 хувийг эзэлж байна. 2011 онд хөрсний намагжилт, давсжилтын эвдрэл, элэгдлийн зэрэглэл сул ААНБ-ын хувь 13.3 нэгж хувиар буурч, дундаж зэрэглэлтэй ААНБ-ын хувь 13.0 нэгж хувиар нэмэгдсэн байна.

Хөрсний биет доройтол болох хөрсний бүхэлшил, намагжилт, давсжилтын хүчтэй доройтлын зэрэглэл нь бусад доройтлын үзүүлэлтүүдээс өндөр дүнтэй байна.

2011 онтой харьцуулахад хөрсний доройтлын түвшин хэвийн болон сул түвшнээс дундаж түвшинд шилжих буюу хөрсний элэгдлийн түвшин нэмэгдсээр байна.

## XI.5. Бордоо, бодис ашиглалт

НҮБ-ын ХХААБ-аас хөдөө аж ахуйн тооллогоор бордоо, бодис, түүний ашиглалтын талаарх мэдээллийг цуглуулах, тооллогын асуулгад өөрийн орны нөхцөл байдал, онцлогт тохирсон асуултуудыг тусгалаа. Бордоо гэж эрдэс болон органик бодисыг хэлэх бөгөөд бордоог тэжээллэг ургац авах болон ургацын өсөлтийг нэмэгдүүлэхэд

хэрэглэдэг. "Бордоо"-ны нөхцөл нь дор хаяж 5 хувийн N, P2O5 болон K20 гэсэн 3 анхдагч тэжээллэгийн бүрдлийг агуулсан ургацын тэжээллэгийн эх үүсвэр болно. Дээрх 3-ын 5 хувиас доош тэжээллэг агуулсан бүтээгдэхүүнийг ургамлын өсөлтийг нэмэгдүүлдэг бусад органик бодист оруулдаг.

Бордоог дээрх ангиллын дагуу байгалийн гаралтай органик бордоо; ургацын өсөлтийг нэмэгдүүлдэг бусад органик бордоо; эрдэс бордоо гэсэн төрлийн хувааж мэдээлэл цуглуулсан.

Бодис нь тариалангийн газарт хортон шавж устгах зорилгоор ашигласан бодис юм. Бодисыг пестицид, гербицид, инсектицид, фунгицид, родентицид, биохимийн бэлдмэл гэсэн төрлөөр ангилан мэдээлэл цуглуулав.

<u>БОДИС АШИГЛАСАН ӨРХ, ААНБ-ЫН ТОО</u>

Газар тариалан эрхэлдэг нийт 18.8 мянган өрх хамрагдсаны 5.5 мянган өрх буюу 29.3 хувь нь бордоо, бодис ашигласан байна. 2011 онтой харьцуулахад бордоо, бодис ашигласан өрхийн хувь 1.8 нэгж хувиар өссөн байна.

ЗУРАГ XI.4. НИЙТ ӨРХ БОЛОН БОРДОО, БОДИС АШИГЛАСАН ӨРХИЙН ТОО, бүсээр




Бордоо, бодис ашигласан нийт өрхийн 1.8 мянга буюу 32.8 хувь нь Төвийн, 1.5 мянга буюу 26.4 хувь нь Баруун, 1.1 мянга буюу 20.8 хувь нь Хангайн, 0.7 мянга буюу 12.4 хувь нь Улаанбаатар хотод, үлдсэн 0.4 мянган өрх буюу 7.5 хувь нь Зүүн бүсэд байна. 2011 онтой харьцуулахад Хангайн бүсийн бордоо, бодис ашигласан өрхийн хувь 16.4 нэгж хувиар нэмэгдсэн бол Төвийн бүсийн бордоо, бодис ашигласан өрхийн хувь 9.5 нэгж хувиар буурсан байна.

Тооллогод хамрагдсан газар тариалан эрхэлдэг 1643 ААНБ-ын 739 буюу 45.0 хувь нь бордоо, бодис ашигласан байна. 2011 онтой харьцуулахад бордоо, бодис ашигласан ААНБ-ын хувь 0.2 нэгж хувиар буурсан үзүүлэлттэй байна.

Бордоо, бодис ашигласан ААНБ-ыг бүсээр авч үзвэл 414 буюу 56.0 хувь нь Төвийн бүсэд, 107 буюу 14.5 хувь нь Баруун бүсэд, 122 буюу 16.5 хувь нь Хангайн бүсэд, 62 буюу 8.4 хувь нь Зүүн бүсэд байгаа бол үлдсэн 34 буюу 4.6 хувь нь Улаанбаатарт байна. 2011 онтой харьцуулахад Улаанбаатар хотын бордоо, бодис ашигласан

өрхийн хувь 14.5 нэгж хувиар нэмэгдсэн бол Зүүн бүсийн бордоо, бодис ашигласан өрхийн хувь 3.2 нэгж хувиар буурсан байна.

ЗУРАГ XI.5. БОРДОО, БОДИС АШИГЛАСАН ААНБ-ЫН ТОО, бүсээр




ХЭРЭГЛЭСЭН БОРДОО, БОРДСОН ТАЛБАЙ

Газрын үржил шим нь газар тариалангийн үйл ажиллагаанд олон жил ашигласнаас шалтгаалан буурдаг. Газрын хөрс олон төрлийн химийн элементүүдээс бүрддэг учраас ашиглаж байгаа хугацаандаа эдгээр элементүүдээ алддаг байна. Иймд хураан авсан ургацыг нэмэгдүүлэх зорилгоор бордоог хэрэглэдэг.

Газар тариалан эрхэлдэг өрх, ААНБ нийт тариалсан талбай 609.8 мянган га болж 10 жилийн өмнөхөөс 1.7 дахин (242.5 мянган га) өссөн байна. Тариалсан талбайн өсөлттэй зэрэгцэн газар тариалан эрхэлж буй өрх, аж ахуйн нэгж, байгууллагууд ургацын хэмжээг нэмэгдүүлж, шим тэжээлийг хадгалах зорилгоор бордоо, ургамлын өсөлт дэмжих бодисыг хэрэглэх хандлага нэмэгдсэн байна.

2021 оны тооллогоор газар эрхэлдэг өрх, ААНБ-ууд нь нийт талбайнхаа 56.4 хувь буюу 343.9 мян.га-г бордсон байна. 10 жилийн өмнөхтэй харьцуулахад бордсон талбайн хэмжээ 4.3 дахин (263.6 мянган га) нэмэгдэж, нийт хэрэглэсэн бордооны хэмжээ 25.4 дахин (2129.7 мянган тонн) өссөн байна.

Нийт бордсон талбайг өрх, ААНБ-ын түвшинд авч үзвэл өрхүүд тариалсан талбайнхаа 21.1 хувьд, ААНБ 65.1 хувьд бордоо хэрэглэсэн байна. 2011 онтой харьцуулахад бордсон талбайн эзлэх хувь өрхөд 4.7 нэгж хувь, ААНБ-д 42.0 нэгж хувиар нэмэгджээ.

Нийт 343.9 мянган га талбайд бордоо ашигласны 92.7 хувийг (318.7 мянган га) ААНБ, 7.3 хувийг (25.3 мянган га) өрх эзэлж байна. Нийт хэрэглэсэн бордоог өрх, ААНБ-ын түвшинд харвал нийт ашигласан бордооны 95.9 хувийг (2126.2 мянган тонн) ААНБ, 4.1 хувийг (90.7 мянган тонн) өрх эзэлж байна.

ХҮСНЭГТ XI.19. БОРДСОН ТАЛБАЙ, ХЭРЭГЛЭСЭН БОРДОО ХЭРЭГЛЭСЭН БОРДОО

| | Бүгд | | Өрх | | ААНБ | |
|---|---|---|---|---|---|---|
| | 2011 | 2021 | 2011 | 2021 | 2011 | 2021 |
| Нийт тариалсан талбай, га | 367 222.4 | 609 759.5 | 58 768.0 | 119 927.6 | 308 454.4 | 489 831.9 |
| Нийт бордсон талбай, га | 80 334.4 | 343 916.6 | 9 616.1 | 25 253.6 | 71 218.3 | 318 663.0 |
| Нийт хэрэглэсэн бордоо, тн | 87 397.3 | 2 216 947.1 | 36 700.0 | 90 699.9 | 50 697.3 | 2 126 247.2 |
| Нийт тариалсан талбайд бордсон талбайн эзлэх хувь, га | 22.0 | 56.4 | 16.4 | 21.1 | 23.1 | 65.1 |
| Нэг га талбайд хэрэглэж буй бордоо, тн | 1.1 | 6.4 | 3.8 | 3.6 | 0.7 | 6.7 |

Өрхийн хэрэглэсэн бордоог төрлөөр авч үзэхэд нийт 90.7 мянган тонн бордоо хэрэглэснээс 20.9 хувийг байгалийн гаралтай бордоо, 75.2 хувийг бусад органик, 2.9 хувийг эрдэс бордоо, 1.0 хувийг ургамлын өсөлт идэвхжүүлэгч бордоо эзэлж байна.

ХҮСНЭГТ XI.20. ГАЗАР ТАРИАЛАН ЭРХЭЛДЭГ ӨРХ, ААНБ-ЫН ХЭРЭГЛЭСЭН БОРДОО, БОРДООНЫ ТӨРЛӨӨР, бүсээр, тонноор

| | Өрх | | ААНБ | |
|---|---|---|---|---|
| | 2011 | 2021 | 2011 | 2021 |
| **Бүгд** | **36 700.0** | **90 699.9** | **50 697.3** | **2 126 247.2** |
| Байгалийн гаралтай | 23 863.0 | 18 924.5 | 38 009.6 | 2 124 072.6 |
| Бусад органик | 12 770.4 | 68 234.1 | 11 028.2 | 160.6 |
| Эрдэс | 66.5 | 2 584.6 | 1 659.5 | 1 630.1 |
| Азотын | 42.8 | 1 629.1 | 915.5 | 231.0 |
| Фосфорын | 7.2 | 1.6 | 152.4 | 301.7 |
| Калийн | 1.1 | 1.7 | 88.1 | 2.9 |
| Нийлмэл | 15.4 | 952.2 | 503.5 | 1 094.5 |
| Ургамлын өсөлт идэвхжүүлэгч | - | 913.8 | - | 378.3 |
| Биохимийн гаралтай | - | 32.7 | - | 5.6 |

Эндээс харахад өрх нь өөрсдийн гарын дор бэлэн байдаг, хямд үнэтэй бусад органик бордоо буюу өтөг бууц, малын үлдэц, холимог бордоо, шавар, зэрлэг жимс, үртэс, ургамлын үлдэгдэл, нийлэг хөрсний ангижруулагч зэргийг газар тариаланд өргөн хэрэглэдэг байна. 2011 онтой харьцуулахад бусад органик бордоо хэрэглэсэн хувь 40.4 нэгж хувиар нэмэгдсэн бол байгалийн гаралтай органик бордоо хэрэглэсэн хувь 44.2 нэгж хувиар буурсан байна. Мөн эрдэс бордооны хэрэглэсэн хувь 2.7 нэгж хувиар өссөн үзүүлэлт харагдаж байна.

ААНБ-ын хэрэглэсэн бордоог төрлөөр авч үзэхэд нийт хэрэглэсэн бордооны 99.9 хувийг байгалийн гаралтай бордоо, 0.08 хувийг эрдэс бордоо, 0.02 хувийг ургацын өсөлт идэвхжүүлэгч бордоо эзэлж байна. 2011 онтой харьцуулахад байгалийн гаралтай органик бордоо хэрэглэсэн хувь 24.9 нэгж хувиар өссөн бол бусад органик бордоо хэрэглэсэн хувь 21.7 нэгж хувиар, эрдэс бордоо хэрэглэсэн хувь 3.2 нэгж хувиар буурсан үзүүлэлттэй байна.

БОРДСОН ТАЛБАЙ

Өрхийн бордсон талбайг бордооны төрлөөр авч үзэхэд нийт бордсон талбайн 34.1 хувийг байгалийн гаралтай бордоо, 36.3 хувийг эрдэс бордоо, (27.0 хувийг нийлмэл

бордоо) 17.1 хувийг бусад органик бордоо, 6.8 хувийг ургамлын өсөлт идэвхжүүлэгч бордоо, 5.8 хувийг биохимийн гаралтай бордоогоор бордсон талбай эзэлж байна. 2011 онтой харьцуулахад байгалийн гаралтай органик бордоогоор бордсон талбайн хувь 19.0 нэгж хувь, бусад органик бордоогоор бордсон талбайн хувь 7.3 нэгж хувиар тус тус буурсан бол эрдэс бордоогоор бордсон талбайн хувь 13.7 нэгж хувиар (нийлмэл бордоогоор бордсон талбайн хувь 22.9 нэгж хувиар) нэмэгдсэн байна.

ХҮСНЭГТ XI.21. ГАЗАР ТАРИАЛАН ЭРХЭЛДЭГ ӨРХ, ААНБ-ЫН БОРДСОН ТАЛБАЙ, БОРДООНЫ ТӨРЛӨӨР, бүсээр, га

| | Өрх | | ААНБ | |
|---|---|---|---|---|
| | 2011 | 2021 | 2011 | 2021 |
| **Бүгд** | **9 616.2** | **25 253.6** | **71 218.3** | **318 663.0** |
| Байгалийн гаралтай | 5 106.9 | 8 607.2 | 19 307.5 | 158 176.8 |
| Бусад органик | 2 339.6 | 4 306.4 | 4 855.5 | 21 190.3 |
| Эрдэс | 2 169.7 | 9 157.8 | 47 055.3 | 110 390.8 |
| Азотын | 1 402.5 | 2 313.5 | 26 604.9 | 12 896.7 |
| Фосфорын | 324.0 | 6.0 | 4 350.4 | 1 938.0 |
| Калийн | 46.8 | 12.6 | 2 205.5 | 806.0 |
| Нийлмэл | 396.4 | 6 825.6 | 13 894.5 | 94 750.1 |
| Ургамлын өсөлт идэвхжүүлэгч | - | 1 723.8 | - | 25 713.9 |
| Биохимийн гаралтай | - | 1 458.4 | - | 3 191.2 |

Төвийн бүсэд бусад бүстэй харьцуулахад эрдэс бордоогоор бордсон талбай дийлэнх хувийг эзэлж байна. Үүнд, Төв аймгийнх 2.7 мянган га буюу 40.2 хувь, Сэлэнгэ аймгийн бордсон талбай 1.7 мянган га буюу 25.1 хувийг эзэлж байгаа нь нөлөөлсөн байна.

ААНБ-ын бордсон талбайг бордооны төрлөөр авч үзэхэд нийт бордсон талбайн 49.6 хувийг байгалийн гаралтай органик бордоо, 34.6 хувийг эрдэс бордоо (29.7 хувийг нийлмэл бордоо), 8.1 ургамлын өсөлт идэвхжүүлэгч бордоо, 6.7 хувийг бусад органик бордоогоор бордсон талбай эзэлж байна. 2011 онтой харьцуулахад байгалийн гаралтай органик бордоогоор бордсон талбайн хувь 22.5 нэгж хувиар нэмэгдсэн бол эрдэс бордоогоор бордсон талбайн хувь 31.4 нэгж хувиар буурсан байна. Эрдэс бордоогоор бордсон талбайн хувь буурахад азотын бордоогоор бордсон талбайн хувь 33.3 нэгж хувиар буурсан нь нөлөөлсөн байна.

Эрдэс бордоогоор бордсон нийт талбайн 79.6 хувь нь Төвийн бүсэд байгаа бөгөөд тус бүсийн нийт бордсон талбайн 40.9 хувьд эрдэс бордоо ашигласан нь улсын дунджаар 6.2 нэгж хувиар өндөр үзүүлэлттэй харагдаж байна.

НЭГ ГА ТАЛБАЙД ХЭРЭГЛЭЖ БУЙ БОРДОО

Өрх, ААНБ нэг га талбайд дунджаар 6.4 тонн бордоо хэрэглэжээ. Өрх дунджаар 3.6 тонн, ААНБ-ууд 6.7 тонн бордоо хэрэглэсэн байна. 2011 онтой харьцуулахад нэг га талбайд хэрэглэж буй бордоо хэмжээ 5.3 тонноор нэмэгдсэн бол энэ үзүүлэлт өрхөд 0.2 тонноор буурч, ААНБ-ын хувьд 6.0 тонноор өссөн байна. Үүнээс газар

тариалан эрхэлдэг ААНБ-уудын бордооны хэрэглээ сүүлийн 10 жилд эрчимтэй өссөн байгаа нь харагдаж байна.

ХҮСНЭГТ XI.22. ӨРХ, ААНБ-ЫН НЭГ ГА ТАЛБАЙД ХЭРЭГЛЭЖ БУЙ БОРДОО, бордооны төрлөөр, тонноор

| | Өрх | | ААНБ | |
|---|---|---|---|---|
| | 2011 | 2021 | 2011 | 2021 |
| Нэг га талбайд хэрэглэж буй бордоо | 3.8 | 3.6 | 0.7 | 6.7 |
| Байгалийн гаралтай бордоо | 4.7 | 2.2 | 2.0 | 13.4 |
| Бусад органик бордоо | 5.5 | 15.8 | 2.3 | 0.01 |
| Эрдэс бордоо | 0.1 | 1.2 | 0.15 | 0.2 |
| Азотын бордоо | 0.03 | 0.7 | 0.03 | 0.02 |
| Фосфорын бордоо | 0.02 | 0.3 | 0.04 | 0.2 |
| Калийн бордоо | 0.02 | 0.1 | 0.04 | 0.004 |
| Нийлмэл бордоо | 0.04 | 0.1 | 0.04 | 0.01 |
| Ургамлын өсөлт идэвхжүүлэгч | | 0.5 | | 0.01 |
| Биохимийн гаралтай | | 0.02 | | 0.002 |

Өрх, ААНБ-ын хувьд нэг га талбайд ашиглаж буй бордооны төрөл, түүнд харгалзах хэмжээ харилцан адилгүй байна. Тухайлбал, өрхийн хувьд бусад органик бордоог нэг га талбайд их хэмжээгээр буюу 15.8 тонныг ашигласан бол ААНБ-ын хувьд байгалийн гаралтай бордоог нэг га талбайд их хэмжээгээр буюу 13.4 тонныг ашигласан байна. 2011 онтой харьцуулахад өрхийн нэг га талбайд ногдох бусад органик бордооны хэмжээ 10.3 тонноор нэмэгдсэн бол ААНБ-ын нэг га талбайд ногдох байгалийн гаралтай бордооны хэмжээ 11.4 тонноор нэмэгдсэн байна.

10 жилийн өмнөхтэй харьцуулахад газар тариалан эрхэлдэг өрх, ААНБ-ын хувьд үйлдвэрийн аргаар гаргаж авсан эрдэс бордоог ашиглах байдал нэмэгдэх хандлага харагдаж байна. Тухайлбал нэг га талбайд хэрэглэж буй эрдэс бордооны хэмжээ өрх 1.1 тонн, ААНБ-д 0.04 тонноор тус тус нэмэгдсэн байна.

УРГАМАЛ ХАМГААЛЛЫН БОДИС/ПЕСТИЦИД ХЭРЭГЛЭСЭН ТАЛБАЙ

Нэг төрлийн ургамлыг жил бүр нэг талбайд суулгах нь хортон шавжийг бий болгож, ургацын хэмжээнд нөлөөлдөг. Тиймээс тариалангийн газарт хортон шавж устгах зорилгоор ургамал хамгааллын бодисыг ашигладаг. Газар тариалан эрхэлдэг өрх, ААНБ нийт тариалсан талбайнхаа 42.4 хувь буюу 258.4 мянган га-д ургамал хамгааллын бодис ашигласан байна. Үүнээс, газар тариалан эрхэлдэг өрх нийт тариалсан талбайнхаа 14.9 хувьд нь ургамал хамгааллын бодис хэрэглэсэн бол ААНБ нийт тариалсан талбайнхаа 49.1 хувьд нь ургамал хамгааллын бодис хэрэглэсэн байна. 2011 онтой харьцуулахад ургамал хамгааллын бодис хэрэглэсэн талбайн хувь өрхөд 4.6 нэгж хувиар, ААНБ-д 5.4 нэгж хувиар нэмэгдсэн байна. 10 жилийн өмнөхтэй харьцуулахад ургамал хамгааллын бодис ашигласан талбайн хэмжээ 1.8 дахин (117.6 мянган га) нэмэгдэж, нийт ургамал хамгааллын бодисын хэмжээ 44.1 хувиар (5.0 мянган тонн) өссөн байна.

Нийт 258.4 мянган га талбайд ургамал хамгааллын бодис ашигласны 93.1 хувийг (240.5 мянган га) ААНБ, 6.9 хувийг (17.9 мянган га) өрх эзэлж байна.

Нийт хэрэглэсэн ургамал хамгааллын бодисыг өрх, ААНБ-ын түвшинд харвал нийт ашигласан бордооны 73.3 хувийг (3.7 мянган тонн) ААНБ, 26.7 хувийг (1.4 мянган тонн) өрх эзэлж байна.

Өрх, ААНБ нэг га талбайд дунджаар 19.8 кг бодис хэрэглэжээ. Өрх дунджаар 76.1 кг бодис хэрэглэсэн бол ААНБ дунджаар 15.6 кг бодис хэрэглэсэн байна. 10 жилийн өмнөхтэй харьцуулахад газар тариалан эрхлэгч өрх, ААНБ ургамлын өвчин, хөнөөлт шавж, мэрэгч амьтан, хог ургамалтай тэмцэх, агуулах, зоорио ариутгах зэргээр олон төрлийн ургамал хамгааллын бодисын хэрэглэх хандлага нэмэгдсэн байна.

ХҮСНЭГТ XI.23. УРГАМАЛ ХАМГААЛЛЫН БОДИС/ПЕСТИЦИД ХЭРЭГЛЭСЭН ТАЛБАЙ, АШИГЛАСАН ХЭМЖЭЭ

| | Бүгд | | Өрх | | ААНБ | |
|---|---|---|---|---|---|---|
| | 2011 | 2021 | 2011 | 2021 | 2011 | 2021 |
| Тариалсан талбай | 367 222.4 | 609 759.5 | 58 768.1 | 119 927.6 | 308 454.4 | 489 831.9 |
| Ургамал хамгааллын бодис хэрэглэсэн талбай, га | 140 714.4 | 258 355.8 | 6 053.8 | 17 894.0 | 134 660.6 | 240 461.8 |
| Ургамал хамгааллын бодис хэрэглэсэн хэмжээ, тн | 115.8 | 5 108.2 | 11.6 | 1 362.2 | 104.3 | 3 746.1 |
| Ургамал хамгааллын бодис хэрэглэсэн талбайн эзлэх хувь | 38.3 | 42.4 | 10.3 | 14.9 | 43.7 | 49.1 |
| Нэг га талбайд хэрэглэсэн ургамал хамгааллын бодис , кг | 0.8 | 19.8 | 1.9 | 76.1 | 0.8 | 15.6 |

ХЭРЭГЛЭСЭН УРГАМАЛ ХАМГААЛЛЫН БОДИС/ПЕСТИЦИД

Өрх тариалангийн талбайнхаа хортон шавжийг устгахад хэрэглэсэн ургамал хамгаалах бодисыг төрлөөр нь авч үзэхэд нийт хэрэглэсэн бодисын 25.9 хувийг гербицид, 1.2 хувийг фунгицид, 1.1 хувийг биохимийн бэлдмэл, 0.4 хувийг интектицид, 0.1 хувийг химийн бэлдмэл эзэлж байгаа бол 71.3 хувийг дээрхээс бусад төрлийн ургамал хамгааллын бодис эзэлж байна. Эндээс харахад өрх нь гербицид буюу таримал ургамлын өвчин, хөнөөлт шавж, мэрэгч амьтан, хог ургамалтай тэмцэх зориулалттай бодисыг ихэнхдээ тариалангийн талбайдаа ашигласан байна.

ХҮСНЭГТ XI.24. ГАЗАР ТАРИАЛАН ЭРХЭЛДЭГ ӨРХИЙН ТАРИАЛАНГИЙН ТАЛБАЙД АШИГЛАСАН УРГАМАЛ ХАМГААЛЛЫН БОДИС/ПЕСТИЦИДИЙН ХЭМЖЭЭ, бүсээр, тонноор

| | Өрх | | ААНБ | |
|---|---|---|---|---|
| | 2011 | 2021 | 2011 | 2021 |
| Бүгд | 11.6 | 1 362.2 | 104.3 | 3 746.1 |
| Гербицид | 9.0 | 352.8 | 81.6 | 2 959.2 |
| Интектицид | 1.0 | 5.9 | 4.1 | 1.0 |
| Фунгицид | 0.6 | 15.9 | 9.8 | 11.6 |
| Родентицид | 0.5 | - | 6.2 | - |
| Биохимийн бэлдмэл | 0.4 | 14.7 | 2.5 | 8.7 |
| Химийн бэлдмэл | - | 1.9 | - | 43.4 |
| Бусад | - | 970.9 | - | 722.2 |

ААНБ-ын хэрэглэсэн ургамал хамгааллын бодисыг төрлөөр нь авч үзэхэд нийт хэрэглэсэн бодисын 79.0 хувийг гербицид, 1.2 хувийг химийн бэлдмэл, 0.3 хувийг фунгицид, 0.2 хувийг биохимийн бэлдмэл үлдсэн 19.3 хувийн дээрхээс бусад ургамал хамгааллын бодис эзэлж байна. Эндээс харахад 10 жилийн өмнөхтэй адилаар ААНБ гербицид буюу таримал ургамлын өвчин, хөнөөлт шавж, мэрэгч амьтан, хог ургамалтай тэмцэх зориулалттай бодисыг тариалангийн талбайдаа түлхүү хэрэглэдэг нь харагдаж байна.

УРГАМАЛ ХАМГААЛЛЫН БОДИС/ПЕСТИЦИД ХЭРЭГЛЭСЭН ТАЛБАЙ

Өрхийн ургамал хамгааллын бодис ашигласан талбайг хэрэглэсэн бодисын төрлөөр авч үзэхэд 68.8 хувийг гербицид, 7.0 хувийг биохимийн бэлдмэл, 3.1 хувийг фунгицид, 0.8 хувийг интектицид, 0.6 хувийг химийн бэлдмэл үлдсэн 19.7 хувийг бусад төрлийн ургамал хамгаалах бодис ашигласан талбай эзэлж байна. 2011 онтой харьцуулахад гербицид ашигласан хувь Баруун бүсэд 60.6 нэгж хувиар буурсан бол Зүүн бүсэд 71.8 нэгж хувиар нэмэгдсэн байна. Баруун бүсийн өрхийн хувьд ургамал хамгааллын бусад бодисыг (32.6 хувь) ашиглах хандлага гербицидийн дараагаар орж буй бол Зүүн бүсийн хувь биохимийн бэлдмэлийг түлхүү ашиглах хандлагад өөрчлөлт орж гербицидийг (72.2 хувь) түлхүү ашиглах болжээ.

ХҮСНЭГТ XI.25. ГАЗАР ТАРИАЛАН ЭРХЭЛДЭГ ӨРХИЙН УРГАМАЛ ХАМГААЛЛЫН БОДИС/ПЕСТИЦИД ХЭРЭГЛЭСЭН ТАЛБАЙ , бүсээр, га

| | Бүгд | | Баруун бүс | | Хангайн бүс | | Төвийн бүс | | Зүүн бүс | | Улаанбаатар | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | 2011 | 2021 | 2011 | 2021 | 2011 | 2021 | 2011 | 2021 | 2011 | 2021 | 2011 | 2021 |
| Бүгд | 6 053.8 | 17 894.0 | 31.5 | 1 166.8 | 169.9 | 4 132.6 | 5 259.4 | 11 867.1 | 424.2 | 704.5 | 168.8 | 23.1 |
| Гербицид | 4 354.8 | 12 315.4 | 31.0 | 441.60 | 133.6 | 2 570.4 | 4 094.5 | 8 787.7 | 1.8 | 508.7 | 94.0 | 7.1 |
| Интектицид | 295.6 | 136.5 | 0.5 | 14.02 | 4.1 | 63.5 | 280.5 | 55.4 | 0.3 | 3.5 | 10.2 | 0.0 |
| Фунгицид | 477.5 | 548.4 | - | 100.30 | 0.1 | 0.8 | 477.2 | 447.3 | - | 0.1 | 0.2 | 0.0 |
| Родентицид | 407.3 | - | - | - | 0.5 | - | 406.7 | - | - | - | 0.1 | - |
| Биохимийн бэлдмэл | 518.7 | 1 260.2 | - | 226.56 | 31.6 | 531.9 | 0.7 | 350.9 | 422.1 | 150.8 | 64.4 | 0.1 |
| Химийн бэлдмэл | - | 106.1 | - | 3.71 | - | 83.3 | - | 13.6 | - | 0.5 | - | 5.0 |
| Бусад | - | 3 527.3 | - | 380.56 | - | 882.7 | - | 2212.2 | - | 40.9 | - | 10.8 |

ААНБ-ын хортон ургамал хамгаалах бодис ашигласан тариалангийн талбайг хэрэглэсэн бодисын төрлөөр авч үзвэл 80.1 хувийг гербицид, 4.7 хувийг биохимийн бэлдмэл, 2.0 хувийг химийн бэлдмэл, 1.1 хувийг фунгицид, үлдсэн 11.8 хувийг дээрхээс бусад төрлийн ургамал хамгааллын бодис эзэлж байна. 2011 онтой харьцуулахад гербицид ашигласан хувь Зүүн бүсэд 7.9 нэгж хувиар буурсан бол Баруун бүсэд 44.8 нэгж хувиар нэмэгдсэн байна. Баруун бүсийн өрхийн хувьд хувь биохимийн бэлдмэлийг (99.4 хувь) түлхүү ашигладаг байсан бол тус хандлагад өөрчлөлт орж гербицидийг ургамал хамгаалах зорилгоор ашиглах хандлага нэмэгдсэн байна.

ХҮСНЭГТ XI.26. ГАЗАР ТАРИАЛАН ЭРХЭЛДЭГ ААНБ-ЫН УРГАМАЛ ХАМГААЛЛЫН БОДИС/ПЕСТИЦИД ХЭРЭГЛЭСЭН ТАЛБАЙ , бүсээр, га

| | Бүгд | | Баруун бүс | | Хангайн бүс | | Төвийн бүс | | Зүүн бүс | | Улаанбаатар | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | 2011 | 2021 | 2011 | 2021 | 2011 | 2021 | 2011 | 2021 | 2011 | 2021 | 2011 | 2021 |
| Бүгд | 134 660.6 | 240 461.8 | 251.5 | 7 295.5 | 15 269.8 | 32 348.7 | 116 919.7 | 159 328.3 | 2 205.0 | 40 315.7 | 14.6 | 1 173.7 |
| Гербицид | 102 851.4 | 192 493.9 | 1.3 | 3 233.4 | 8 442.8 | 25 583.2 | 92 199.5 | 126 611.9 | 2 200.7 | 37 044.8 | 7.0 | 20.6 |
| Интектицид | 4 671.4 | 730.4 | - | - | 550.0 | 101.7 | 4 110.6 | 620.0 | 4.3 | 7.7 | 6.5 | 1.0 |
| Фунгицид | 17 740.4 | 2 709.1 | .2 | 1 100.0 | 5 843.0 | 130.0 | 11 897.2 | 1 478.0 | - | - | - | 1.1 |
| Родентицид | 7 359.4 | - | - | - | 30.0 | - | 7 329.4 | - | - | - | - | - |
| Биохимийн бэлдмэл | 2 038.0 | 11 275.8 | 250.0 | 2 035.0 | 404.0 | 1 736.6 | 1 383.0 | 5 714.2 | - | 1 790.0 | 1.0 | |
| Химийн бэлдмэл | - | 4 807.1 | - | 216.1 | - | 626.0 | - | 3 965.0 | - | - | - | - |
| Бусад | - | 28 445.4 | - | 711.0 | - | 4 171.1 | - | 20 939.2 | - | 1 473.2 | - | 1 150.9 |

## НЭГ ГА ТАЛБАЙД ХЭРЭГЛЭЖ БУЙ УРГАМАЛ ХАМГААЛЛЫН БОДИС/ПЕСТИЦИД

Өрх, ААНБ нэг га талбайд дунджаар 23.0 кг ургамал хамгааллын бодис хэрэглэсэн байна. Өрхүүд дунджаар 76.1 кг бодис хэрэглэсэн бол ААНБ нь 15.6 кг ургамал хамгааллын бодис хэрэглэсэн байна. 2011 онтой харьцуулахад ААНБ-ын нэг га талбайд ашиглах ургамал хамгаалах бодисын хэмжээ ААНБ-д 74.2 килограммаар, ААНБ-д 14.8 килограммаар нэмэгдсэн байна.

ХҮСНЭГТ XI.27. ӨРХ, ААНБ-ЫН НЭГ ГА ТАЛБАЙД ХЭРЭГЛЭЖ БУЙ УРГАМАЛ ХАМГААЛЛЫН БОДИС/ПЕСТИЦИД, бодисын төрлөөр, кг

| | Өрх | | ААНБ | |
|---|---|---|---|---|
| | 2011 | 2021 | 2011 | 2021 |
| Бүгд | 1.9 | 90.0 | 0.8 | 15.6 |
| Гербицид | 2.1 | 28.6 | 0.8 | 15.4 |
| Интектицид | 3.6 | 43.3 | 0.9 | 1.4 |
| Фунгицид | 1.3 | 29.0 | 0.6 | 4.3 |
| Родентицид | 1.1 | - | 0.8 | - |
| Биохимийн бэлдмэл | 0.6 | 11.7 | 1.2 | 0.8 |
| Химийн бэлдмэл | - | 18.2 | - | 9.0 |
| Бусад | - | 275.2 | - | 25.4 |

Өрх, ААНБ-ын хувьд нэг га талбайд ашиглаж буй ургамал хамгааллын бодисын төрөл, түүнд харгалзах хэмжээ харилцан адилгүй байна. Тухайлбал, өрхийн хувьд бусад интектицидийг нэг га талбайд их хэмжээгээр буюу 43.3 кг ашигласан бол ААНБ-ын хувьд гербицидийг нэг га талбайд их хэмжээгээр буюу 15.4 кг ашигласан байна. 2011 онтой харьцуулахад ААНБ-ын нэг га талбайд ногдох интектицидийн хэмжээ 39.7 килограммаар нэмэгдсэн бол ААНБ-ын нэг га талбайд ногдох гербицидийн хэмжээ 14.6 килограммаар нэмэгдсэн үзүүлэлттэй байна.

XII
БҮЛЭГ

# ХӨДӨӨ АЖ АХУЙН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ҮЙЛДВЭРЛЭГЧИЙН ҮНЭ



# XII. ХӨДӨӨ АЖ АХУЙН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ҮЙЛДВЭРЛЭГЧИЙН ҮНЭ

Хөдөө аж ахуйн салбарын бүтээгдэхүүний нийт гаргалт, завсрын хэрэглээ, нэмэгдэл өртгийн тооцоо, эдийн засгийн данс байгуулахад шаардагдах үйлдвэрлэгчийн үнийн суурь мэдээллийг цуглуулах зорилгоор ХААТ-ын хамрах хүрээнд багтааж мэдээлэл цуглуулсан.

Мал, тэжээвэр амьтдын үнийг нас гүйцсэн, өсвөр, төл гэсэн ангиллаар, газар тариалангийн бүтээгдэхүүний үнийг ургамлын нэр төрлөөр үйлдвэрлэл эрхэлж байгаа өрх, аж ахуйн нэгжээр цуглуулсан.

Хөдөө аж ахуйн салбарын хувьд үйлдвэрлэгчийн үнэ нь мал аж ахуй, газар тариалан эрхлэгчдийн бүтээгдэхүүн, түүхий эдийг шууд үйлдвэрлэгчийн байрнаас худалдан борлуулсан үнэ юм. Өөрөөр хэлбэл, үйлдвэрлэгчээс дараачийн үйлчилгээний шат дамжаагүй, тээвэр, худалдааны нэмэгдэл ороогүй үнэ болно.

## XII.1. Мал аж ахуйн бүтээгдэхүүний үнэ

### МАЛЫН ҮНЭ

Тооллогын дүнгээр 2021 онд дунджаар адууны үнэ өндөр уулын бүсэд 824 мянган төгрөг, үхрийн үнэ тал хээрийн бүсэд 805 мянган төгрөг, тэмээний үнэ хангайн бүсэд нэг сая төгрөг, хонины үнэ өндөр уулын бүсэд 168 мянган төгрөг, ямааны үнэ хангайн бүсэд 116 мянган төгрөг байгаа нь хамгийн өндөр үзүүлэлт болж байна. 2011 онтой харьцуулахад малын үнэ 2-4 дахин өссөн байна.

ХҮСНЭГТ XII.1. МАЛЫН ДУНДАЖ ҮНЭ, малын төрлөөр, бүсээр, мянган төгрөгөөр

| | Хангай | | Өндөр уул | | Тал хээр | | Говь | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | 2011 | 2021 | 2011 | 2021 | 2011 | 2021 | 2011 | 2021 |
| Адуу | 284 | 772 | 334 | 824 | 385 | 730 | 292 | 740 |
| Үхэр | 416 | 729 | 268 | 713 | 420 | 805 | 368 | 792 |
| Тэмээ | 450 | 1 027 | 472 | 977 | 410 | 718 | 428 | 967 |
| Хонь | 46 | 160 | 43 | 168 | 44 | 141 | 67 | 163 |
| Ямаа | 36 | 116 | 36 | 114 | 33 | 112 | 49 | 115 |

### МАХНЫ ҮНЭ

Тал хээрийн бүсэд 2021 онд адууны 1 кг мах 10169 төгрөг, үхрийн 1 кг мах 11780 төгрөг, тэмээний 1кг мах 7691 төгрөг, хонины 1 кг мах 10066 төгрөг, ямааны 1кг мах 8994 төгрөг, гахайн 1 кг мах говийн бүсэд 11966.1 төгрөг тус тус байгаа нь хамгийн өндөр үнэ ханштайд тооцогдож байна. Махны үнийг 2011 онтой харьцуулахад мөн 2-4 дахин өссөн байна.

ХҮСНЭГТ XII.2. МАХНЫ ДУНДАЖ ҮНЭ, мал, тэжээвэр амьтны төрлөөр, бүсээр, төгрөгөөр

| | Хангай | | Өндөр уул | | Тал хээр | | Говь | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | 2011 | 2021 | 2011 | 2021 | 2011 | 2021 | 2011 | 2021 |
| Адууны мах | 1 559 | 8 498 | 1 800 | 8 735 | 2 323 | 10 169 | 2 302 | 8 936 |
| Үхрийн мах | 2 619 | 10 743 | 3 000 | 9 985 | 2 546 | 11 780 | 2 858 | 8 315 |
| Тэмээний мах | 1 800 | 7 009 | - | 7 525 | - | 7 691 | 1 565 | 7 546 |
| Хонины мах | 2 330 | 9 439 | 3 000 | 9 651 | 2 193 | 10 066 | 2 792 | 9 783 |
| Ямааны мах | 1 919 | 7 747 | 2 500 | 8 164 | 1 776 | 8 994 | 2 080 | 8 453 |
| Гахайн мах | 4 300 | 11 643 | - | 10 909 | 5 700 | 9 791 | 5 200 | 11 966 |

## СҮҮНИЙ ҮНЭ

Сүүний үнийг төрлөөр нь авч үзвэл 2021 онд гүүний саам говийн бүсэд 1 литр нь 5604 төгрөг, үнээний сүү 1 литр нь 2822 төгрөг, бог малын сүү 1 литр нь 3067 төгрөг, ингэний саам хангайн бүсэд 1 литр нь 6238 төгрөг байгаа нь хамгийн өндөр үнэтэй байна. Сүүний үнийг 2011 онтой харьцуулахад 2-5 дахин өссөн байна.

ХҮСНЭГТ XII.3. СҮҮНИЙ ДУНДАЖ ҮНЭ, бүсээр, төгрөгөөр

| | Хангай | | Өндөр уул | | Тал хээр | | Говь | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | 2010 | 2021 | 2011 | 2021 | 2011 | 2021 | 2011 | 2021 |
| Гүү | 1 100 | 5 494 | 1 430 | 4 843 | 1 500 | 4 702 | - | 5 604 |
| Үнээ | 712 | 2 405 | 965 | 2 475 | 858 | 2 102 | 1 201 | 2 822 |
| Ингэ | 1 033 | 6 238 | 2 361 | 5 771 | - | 5 531 | 1 878 | 4 819 |
| Бог | 596 | 2 659 | 1 108 | 2 553 | - | 2 665 | 1 829 | 3 067 |

## НООС, НООЛУУРЫН ҮНЭ

Тэмээний 1 кг ноосны үнэ говийн бүсэд 8.5 мянган төгрөг, өндөр уулын бүсэд 8.3 мянган төгрөг, тал хээрийн бүсэд 7.1 мянган төгрөг, хангайн бүсэд 6.3 мянган төгрөг байна. Хонины 1 кг ноосны үнэ говийн бүсэд хамгийн өндөр 1827 төгрөг, хангайн бүсэд 1717 төгрөг, өндөр уулын бүсэд 1701 төгрөг, тал хээрийн бүсэд 1655 төгрөгийн үнэтэй байна. Ямааны 1 кг ноолуур өндөр уулын бүсэд хамгийн хямд 98.3 мянган төгрөг, бусад бүсэд ижил түвшинд байна. Бодын 1 кг хөөвөр хангайн бүсэд 13996 төгрөг, өндөр уулын бүсэд 7477 төгрөг, тал хээр болон, говийн бүсэд 6176 төгрөгөөр худалдаалагдаж байна.

ХҮСНЭГТ XII.4. НООС, НООЛУУР, ХӨӨВӨР, ХЯЛГАСЫН ДУНДАЖ ҮНЭ, бүсээр, төгрөгөөр

| | Хангай | | Өндөр уул | | Тал хээр | | Говь | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | 2011 | 2021 | 2011 | 2021 | 2011 | 2021 | 2011 | 2021 |
| Тэмээний ноос, мян.төг | 3.9 | 6.3 | 5.0 | 8.3 | 4.0 | 7.1 | 4.7 | 8.5 |
| Хонины ноос, төг | 441.0 | 1 717 | 269.0 | 1 701 | 413.0 | 1 655 | 411.0 | 1 827 |
| Ямааны ноолуур, мян.төг | 47.0 | 91.2 | 40.0 | 98.3 | 47.0 | 88.8 | 47.0 | 91.7 |
| Бодын хөөвөр, төг | - | 13 996 | 304.0 | 7 477 | - | 6 176 | - | 6 176 |
| Бодын хялгас, төг | 1 590.0 | - | 707.0 | - | 984.0 | - | - | - |

## АРЬС, ШИРНИЙ ҮНЭ

Адууны 1 ширхэг шир өндөр уул, тал хээрийн бүсэд 8.6 мянган төгрөг, хангайн болон говийн бүсэд 8.5 мянган төгрөг байна. Энэ нь 2011 онтой харьцуулахад 13.9-57.5 хувиар буурсан байна.

Үхрийн 1 ширхэг шир хангай, говийн бүсэд 5.3 мянган төгрөг, өндөр уулын бүсэд 4.6 мянган төгрөг, тал хээрийн бүсэд 4.4 мянган төгрөг байна.

Хонины 1 ширхэг нэхий 2.4-2.7 мянган төгрөг байгаа нь 4 бүс нутгаар харьцангуй жигд байна. 2011 онтой харьцуулахад 60.5-71.7 хувь буурсан байна.

Ямааны 1 ширхэг арьс говийн бүсэд 22.9 мянган төгрөг, өндөр уулын бүсэд 28.1 мянган төгрөг, хангай, тал хээрийн бүсэд 26.9 мянган төгрөг байна. 2011 онтой харьцуулахад 73.3-106.8 хувиар өссөн байна.

Тэмээний 1 ширхэг арьс хангайн бүсэд 24.2 мянган төгрөг, говийн бүсэд 22.9 мянган төгрөг, өндөр уулын бүсэд 19.3 мянган төгрөг, тал хээрийн бүсэд 11 мянга төгрөг байна.

ХҮСНЭГТ XII.5. АРЬС, ШИРНИЙ ДУНДАЖ ҮНЭ, бүсээр, төгрөгөөр

| | Хангай | | Өндөр уул | | Тал хээр | | Говь | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | 2011 | 2021 | 2011 | 2021 | 2011 | 2021 | 2011 | 2021 |
| Адууны шир | 20.0 | 8.5 | 19.0 | 8.6 | 10.0 | 8.6 | 15.0 | 8.5 |
| Үхрийн шир | 16.0 | 5.3 | 13.0 | 4.6 | 13.1 | 4.4 | 15.0 | 5.3 |
| Тэмээний шир | 12.5 | 24.2 | - | 19.3 | - | 11.0 | 12.7 | 22.9 |
| Хонины нэхий | 7.7 | 2.7 | 8.8 | 2.5 | 6.0 | 2.4 | 9.6 | 2.7 |
| Ямааны арьс | 14.3 | 26.9 | 16.2 | 28.1 | 13.0 | 26.9 | 15.0 | 29.9 |

## БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ҮЙЛДВЭРЛЭГЧИЙН БОЛОН ЗАХ ЗЭЭЛИЙН ҮНИЙН ЗЭРЭГЦҮҮЛЭЛТ

Мал аж ахуйн бүтээгдэхүүний үйлдвэрлэгчийн үнэ буюу малчны хотноос гарч байгаа үнийг зах зээлд зарагдаж байгаа үнийн хоорондын хамаарлыг харьцуулж хэдэн хувийн нэмэгдэл гарч байгааг судаллаа.

Адууны үнэ бүсүүдэд дунджаар үйлдвэрлэгчийн үнээс 24.6 хувиар, үхрийн үнэ 25.4 хувиар, тэмээний үнэ 29.1 хувиар, хонины үнэ 26.7 хувиар, ямааны үнэ 28.4 хувиар тус тус зах зээлд өндөр үнээр нийлүүлэгддэг байна.

ЗУРАГ XII.1. МАЛЫН ДУНДАЖ ҮНЭ, мянган төгрөгөөр, 2021 он




Адууны үнийн үйлдвэрлэгч болон зах зээлийн үнийн харьцаа тал хээрийн бүсэд хамгийн бага буюу 70.6 хувь байна. Энэ нь зах зээлийн үнийн 70.6 хувийг үйлдвэрлэгчийн үнэ эзэлж байна гэсэн үг юм.

Үхрийн үнийн хувьд говийн бүсэд үйлдвэрлэгч болон зах зээлийн үнийн харьцаа хамгийн бага буюу 67.8 хувь байна.

ХҮСНЭГТ XII.6. МАЛЫН ҮЙЛДВЭРЛЭГЧИЙН ҮНЭ БОЛОН ЗАХ ЗЭЭЛИЙН ҮНИЙН ХАРЬЦАА, бүсээр

| | Хангай | | Өндөр уул | | Тал хээр | | Говь | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | 2011 | 2021 | 2011 | 2021 | 2011 | 2021 | 2011 | 2021 |
| Адуу | 99.6 | 78.6 | 95.4 | 73.2 | 96.3 | 70.6 | 97.3 | 76.8 |
| Үхэр | 92.4 | 76.1 | 97.1 | 72.4 | 95.0 | 76.8 | 77.6 | 67.8 |
| Тэмээ | 97.2 | 74.2 | 94.4 | 66.5 | 98.6 | 78.4 | 83.9 | 73.3 |
| Хонь | 88.5 | 75.2 | 95.6 | 73.1 | - | 66.9 | 95.7 | 74.5 |
| Ямаа | 100.0 | 66.1 | 100.0 | 78.8 | - | 79.1 | 100.0 | 65.2 |

Махны дундаж үнийг авч үзэхэд ямааны мах (42.6 хувь), хонины мах (37.3 хувь), адууны мах (33.2 хувь) үйлдвэрлэгчийн үнээс хамгийн өндөр хувийн нэмэгдэлтэйгээр зах зээлд нийлүүлэгддэг байна. Харин гахайн махны хувьд хамгийн бага нэмэгдэлтэй буюу үйлдвэрлэгчийн үнийг 10.0 хувиар нэмэгдүүлж зах зээлд нийлүүлэгддэг байна.

ЗУРАГ XII.2. МАХНЫ ДУНДАЖ ҮНЭ, мянган төгрөгөөр, 2021 он




Адууны махны үнийн үйлдвэрлэгч болон зах зээлийн үнийн харьцаа хангайн бүсэд хамгийн бага буюу 52.3 хувь байна. Бусад бүсийн хувьд харьцангуй ойролцоо буюу 81.1-84.9 хувь байна.

Үхрийн махны үнийн хувьд өндөр уулын бүсэд бусад бүсээс ялгаатай буюу үйлдвэрлэгч болон зах зээлийн үнийн харьцаа хамгийн өндөр буюу 87.7 хувь байна. Энэ нь өндөр уулын бүсэд үйлдвэрлэгчээс зах зээлд хамгийн бага нэмэгдэлтэй нийлүүлэгдэж байна гэсэн үг юм.

Хонь, ямааны махны хувьд өндөр уулын бүсэд хамгийн их нэмэгдэлтэй буюу үйлдвэрлэгчийн үнэ болон зах зээлийн үнийн харьцаа хамгийн бага байна.

ХҮСНЭГТ XII.7. МАХНЫ ҮЙЛДВЭРЛЭГЧИЙН ҮНЭ БОЛОН ЗАХ ЗЭЭЛИЙН ҮНИЙН ХАРЬЦАА, бүсээр

| | Хангай | | Өндөр уул | | Тал хээр | | Говь | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | 2011 | 2021 | 2011 | 2021 | 2011 | 2021 | 2011 | 2021 |
| Адууны мах | 58.3 | 52.3 | 74.8 | 82.5 | 88.3 | 84.9 | 79.8 | 81.1 |
| Үхрийн мах | 68.3 | 67.0 | 95.4 | 87.7 | 70.3 | 67.6 | 66.6 | 67.9 |
| Тэмээний мах | 91.5 | 73.0 | - | 83.1 | - | 51.0 | 75.2 | 72.0 |
| Хонины мах | 68.9 | 63.5 | 99.0 | 55.4 | 74.4 | 63.7 | 78.4 | 78.3 |
| Ямааны мах | 66.8 | 55.9 | 95.2 | 55.5 | 69.8 | 58.9 | 72.7 | 63.0 |
| Гахайн мах | 91.8 | 93.4 | - | - | - | 80.7 | - | 79.7 |

Сүүний дундаж үнийг авч үзвэл үйлдвэрлэгчийн болон зах зээлийн үнэ харилцан адилгүй байна. Ингэний болон гүүний сүү үйлдвэрлэгчээс ойролцоо үнэтэй гарч байгаа боловч зах зээлийн үнэ нь гүүний сүү ингэний сүүнээс 2 дахин үнэтэй байна.

ЗУРАГ XII.3. СҮҮНИЙ ДУНДАЖ ҮНЭ, төгрөгөөр, 2021 он




Сүүний үйлдвэрлэгчийн үнэ болон зах зээлийн үнийн харьцааг авч үзвэл гүүний сүү бүс бүрт харилцан адилгүй байгаа бөгөөд хангайн бүсэд хамгийн бага буюу 37.0 хувь байна. Бусад сүүний үйлдвэрлэгчийн үнэ болон зах зээлийн үнийн харьцааг хүснэгт 13.8-д харуулав.

ХҮСНЭГТ XII.8. СҮҮНИЙ ҮЙЛДВЭРЛЭГЧИЙН ҮНЭ БОЛОН ЗАХ ЗЭЭЛИЙН ҮНИЙН ХАРЬЦАА, бүсээр

| | Хангай | | Өндөр уул | | Тал хээр | | Говь | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | 2011 | 2021 | 2011 | 2021 | 2011 | 2021 | 2011 | 2021 |
| Гүү | 54.0 | 37.0 | 63.9 | 71.7 | 75.0 | 69.8 | - | 49.7 |
| Үнээ | 55.2 | 56.5 | 67.7 | 60.0 | 72.2 | 69.0 | 63.0 | 63.4 |
| Ингэ | 46.8 | 53.7 | 86.7 | 80.9 | - | 95.8 | 94.2 | 99.9 |
| Бог | 49.0 | 67.0 | 75.0 | 68.1 | 27.7 | 55.3 | 94.0 | 82.5 |

Арьс, ширний дундаж үнийг авч үзвэл үйлдвэрлэгчийн болон зах зээлийн үнэ харилцан адилгүй байна. Ямааны арьсны үйлдвэрлэгчийн үнэ (27.8 мян.төг) болон зах зээлийн үнэ (40.3 мян.төг) хамгийн өндөр байна.

ЗУРАГ XII.4. АРЬС, ШИРНИЙ ДУНДАЖ ҮНЭ, мянган төгрөгөөр, 2021 он




Тэмээний ширний үйлдвэрлэгчийн үнэ өндөр боловч зах зээлийн үнэтэй ойролцоо байна. Хонины арьс хамгийн хямд буюу дунджаар 2.6 мянган төгрөгөөр үйлдвэрлэгчээс гардаг бөгөөд зах зээлд 3.0 мянган төгрөг байдаг байна.

Арьс, ширний үйлдвэрлэгчийн болон зах зээлийн үнийн харьцааг авч үзвэл ямааны арьс хамгийн өндөр үнэтэй хэдий ч үнийн харьцаа нь бүх бүсэд хамгийн бага 66.5-72.2 хувь байна.

ХҮСНЭГТ XII.9. АРЬС, ШИРНИЙ ҮЙЛДВЭРЛЭГЧИЙН ҮНЭ БОЛОН ЗАХ ЗЭЭЛИЙН ҮНИЙН ХАРЬЦАА, бүсээр

| | Хангай | | Өндөр уул | | Тал хээр | | Говь | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | 2011 | 2021 | 2011 | 2021 | 2011 | 2021 | 2011 | 2021 |
| Адууны шир | 90.1 | 89.6 | 87.6 | 97.0 | 49.3 | 74.9 | 69.8 | 86.9 |
| Үхрийн шир | 92.5 | 68.4 | 89.0 | 93.5 | 91.6 | 78.4 | 93.8 | 85.5 |
| Тэмээний шир | 95.4 | 100.0 | - | - | - | - | 74.0 | 89.8 |
| Хонины шир | 97.5 | 88.1 | 89.8 | 87.6 | 96.8 | 89.6 | 98.0 | 79.7 |
| Ямааны шир | 75.3 | 69.6 | 82.5 | 66.5 | 76.5 | 70.8 | 71.4 | 72.2 |

Ноос, ноолуурын хувьд харьцангуй үнэтэй байдаг бөгөөд ямааны ноолуурын үйлдвэрлэгчийн үнэ (93.6 мян.төг), зах зээлийн үнэ (120.4 мян.төг) хамгийн өндөр үнэтэй байна. Харин хониний ноосны үйлдвэрлэгч болон зах зээлийн үнэ хамгийн бага (1.7 мян.төг) байна.

ЗУРАГ XII.5. НООС, НООЛУУР, ХӨӨВӨРНИЙ ДУНДАЖ ҮНЭ, мянган төгрөгөөр, 2021 он



Ноос, ноолуур, хөөвөр, хялгасны үйлдвэрлэгч болон зах зээлийн үнийн харьцааг авч үзвэл хонины ноосны үйлдвэрлэгч болон зах зээлийн үнийн харьцаа хамгийн өндөр буюу бүсүүдэд 96.8-100.0 хувь байна. Энэ нь үйлдвэрлэгч шууд зах зээлд нийлүүлж байгааг харуулж байна.

ХҮСНЭГТ XII.10. НООС, НООЛУУР, ХӨӨВӨР, ХЯЛГАСЫН ҮЙЛДВЭРЛЭГЧИЙН ҮНЭ БОЛОН ЗАХ ЗЭЭЛИЙН ҮНИЙН ХАРЬЦАА, бүсээр

| | Хангай | | Өндөр уул | | Тал хээр | | Говь | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | 2011 | 2021 | 2011 | 2021 | 2011 | 2021 | 2011 | 2021 |
| Тэмээний ноос | 95.1 | 76.4 | 91.5 | 87.1 | 95.0 | 99.1 | 97.5 | 66.0 |
| Хонины ноос | 94.5 | 97.7 | 62.1 | 96.8 | 86.7 | 100.0 | 94.5 | 100.0 |
| Ямааны ноолуур | 99.3 | 79.9 | 90.9 | 72.7 | 92.4 | 89.1 | 84.4 | 78.8 |
| Бодын хөөвөр | - | 94.6 | 58.9 | 100.0 | - | - | - | - |
| Бодын хялгас | 36.4 | - | 18.3 | - | 24.1 | - | - | - |

## XII.2. Газар тариалангийн бүтээгдэхүүний үнэ

Буудайн нэг тонны үнэ Тал хээрийн бүсэд 737 мянган төгрөг, Өндөр уулын бүсэд 827 мянган төгрөг, Хангайн бүсэд 773 мянган төгрөг байна. Арвайн нэг тонны дундаж үнэ Хангайн бүсэд 1.2 сая төгрөг, Өндөр уулсын бүсэд 1.9 сая төгрөг, Тал хээрийн бүсэд 1.5 сая төгрөг байна. Хөх тарианы нэг тонны дундаж үнэ бүсүүдэд 3.3 сая төгрөг, овьёосны нэг тонны дундаж үнэ бүсүүдэд 1.1 сая төгрөг байна.

ХҮСНЭГТ XII.11. ҮР ТАРИА, ТӨМС, ХҮНСНИЙ НОГООНЫ КИЛЛОГРАММЫН ДУНДАЖ ҮНЭ, бүсээр, төгрөгөөр

| | Хангай | | Өндөр уул | | Тал хээр | | Говь | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | 2011 | 2021 | 2011 | 2021 | 2011 | 2021 | 2011 | 2021 |
| Үр тариа | | | | | | | | |
| Буудай | 281 | 773 | - | 827 | 385 | 737 | - | - |
| Арвай | 500 | 1 192 | 480 | 1 854 | - | 1 490 | - | - |
| Хөх тариа | - | 3 273 | 550 | 3 341 | 350 | - | - | - |
| Овьёос | 375 | 1 118 | 280 | 1 083 | 385 | 1 105 | - | - |
| Төмс, Хүнсний ногоо | | | | | | | | |
| Төмс | 557 | 1 064 | 358 | 1 192 | 554 | 1 219 | 770 | 1 332 |
| Байцай | 610 | 1 791 | 648 | 1 743 | 753 | 2 065 | 790 | 1 740 |
| Шар манжин | 550 | 3 159 | 528 | 3 200 | 995 | 2 951 | 829 | 3 003 |
| Улаан манжин | 607 | 3 065 | 477 | 2 730 | 985 | 3 019 | 740 | 3 000 |
| Лууван | 607 | 1 695 | 477 | 1 630 | 985 | 2 252 | 740 | 2 146 |
| Сонгино | 870 | 3 084 | 500 | 2 974 | 1 363 | 3 031 | 1 263 | 3 049 |
| Сармис | 1 390 | 8 665 | 800 | 11 233 | 1 000 | 10 683 | 1 000 | 9 445 |
| Өргөст хэмх (урт) | 1 309 | 7 274 | 1 000 | 7 419 | 1 257 | 7 193 | 838 | 7 270 |
| Өргөст хэмх (давжаа) | 487 | 2 662 | 572 | 3 547 | 900 | 3 098 | 872 | 3 413 |

Хүнсний бүтээгдэхүүний нэг кг-ийн дундаж үнэ

- төмсний дундаж үнэ Говийн бүсэд хамгийн өндөр буюу 1332 төгрөг, Тал хээрийн бүсэд 1219 төгрөг, Өндөр уулсын бүсэд 1192 төгрөг, Хангайн бүсэд 1064 төгрөг байна.

- байцайны дундаж үнэ Тал хээрийн бүсэд 2065 төгрөг, Өндөр уулын бүсэд 1743 төгрөг, Говийн бүсэд 1740 төгрөг, Хангайн бүсэд 1791 төгрөг байна.
- шар манжингийн дундаж үнэ Тал хээрийн бүсэд 2951 төгрөг, өндөр уулын бүсэд 3200 төгрөг, Говийн бүсэд 3003 төгрөг, Хангайн бүсэд 3159 төгрөг байна.
- саримсны дундаж үнэ Тал хээрийн бүсэд 10683 төгрөг, Өндөр уулын бүсэд 11233 төгрөг, Хангайн бүсэд 8665 төгрөг, Говийн бүсэд 9445 төгрөг байгаа

Тэжээлийн ургамлын нэг тонны дундаж үнийг тэжээлийн төрлөөр нь авч үзвэл өвс, хадлан 279.3 мянган төгрөг болж 2011 онтой харьцуулахад 3.2 дахин, ногоон тэжээл 338.9 мянган төгрөг болж 2.7 дахин, олон наст тэжээл 589.7 мянган төгрөг болж 5.9 дахин, даршны ургамал 198.4 мянган төгрөг болж 2.3 дахин, гар тэжээл 277.1 мянган төгрөг болж 7.3 дахин, хужир шүү 318.8 мянган төгрөг болж 6.0 дахин, сүрэл 332.4 мянган төгрөг болж 12.3 дахин тус тус өсжээ.

Тосны ургамал, рапсны нэг тонны дундаж үнэ 2.0 сая төгрөг болж 10 жилийн хугацаанд 4.0 дахин өссөн байна.

### ХҮСНЭГТ XII.12. ТЭЖЭЭЛИЙН УРГАМАЛ, ТЕХНИКИЙН УРГАМЛЫН НЭГ ТОННЫН ДУНДАЖ ҮНЭ, мянган төгрөгөөр

| Бүтээгдэхүүн | Нэгжийн үнэ | |
|---|---|---|
| | 2011 | 2021 |
| Тэжээлийн ургамал | | |
| Хадлан, өвс, | 86.0 | 279.3 |
| Ногоон тэжээл | 127.0 | 338.9 |
| Олон наст | 100.0 | 589.7 |
| Даршны ургамал | 85.0 | 198.4 |
| Гар тэжээл | 38.0 | 277.1 |
| Хужир шүү | 53.0 | 318.8 |
| Сүрэл | 27.0 | 332.4 |
| Техникийн ургамал | | |
| Тосны ургамал | 490.0 | 1 954.1 |

Газар тариалангийн бүтээгдэхүүний үйлдвэрлэгчийн үнэ болон зах зээлийн үнийн харьцааг авч үзвэл буудайн үнийн 89.7 хувь нь, төмсний үнийн 83.1 хувь нь, байцаан үнийн 80.9 хувь нь, луувангийн үнийн 81.0 хувь нь, сонгинонын үнийн 85.5 хувь нь тус тус үйлдвэрлэгчийн үнэ эзэлж байна.

### ХҮСНЭГТ XII.13. ГАЗАР ТАРИАЛАНГИЙН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ҮЙЛДВЭРЛЭГЧИЙН ҮНЭ БОЛОН ЗАХ ЗЭЭЛИЙН ҮНИЙН ХАРЬЦАА

| Бүтээгдэхүүн | Харьцаа | |
|---|---|---|
| | 2011 | 2021 |
| Буудай | 84.2 | 89.7 |
| Овьёос | 83.4 | 94.6 |
| Төмс | 56.6 | 83.1 |
| Байцай | 62.3 | 80.9 |
| Лууван | 70.0 | 81.0 |
| Сонгино | 81.7 | 85.5 |

# МАЛЫН АШИГ ШИМИЙН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ГАРЦ

## НООЛУУРЫН ЖИЛИЙН ДУНДАЖ ГАРЦ, бүсээр, гр

| Бүс | Гарц |
| --- | --- |
| БАРУУН БҮС | 412.5 |
| ХАНГАЙН БҮС | 362.7 |
| ТӨВИЙН БҮС | 388.6 |
| ЗҮҮН БҮС | 347.7 |
| УЛААНБААТАР | 473.6 |
| УЛСЫН ДУНДАЖ | 387.7 |

# XIII. МАЛЫН АШИГ ШИМИЙН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ГАРЦ

Манай улсын эдийн засагт хөдөө аж ахуйн салбар нь томоохон байр суурь эзэлдэг бөгөөд уг салбарын үйлдвэрлэлийн бодит хэмжээг тооцож, тодорхойлоход хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн биет хэмжээ болон ашиг шимийн үзүүлэлтүүд ихээхэн чухал юм. ХАА-н салбарын бодлого боловсруулах, төлөвлөлт, хяналтын үйл ажиллагаанд тоон мэдээлэлд суурилсан статистикийн хэрэгцээ, шаардлага тулгамдсан хэвээр байна.

Малын ашиг шимийн бүтээгдэхүүний гарцын мэдээлэл нь хөдөө аж ахуйн салбарын нийт үйлдвэрлэл, нэмэгдэл өртөг, завсрын хэрэглээг тооцоход шаардлагатай суурь мэдээлэл юм. Түүнчлэн хөдөө аж ахуйн салбарын нийт үйлдвэрлэл, нэмэгдэл өртгийг бүс, аймгаар тооцох, суурь шинэчлэхтэй холбоотой тооцооны үзүүлэлтийг шинэчлэх, нөөц ашиглалтын хүснэгт (НАХ), салбар хоорондын тэнцэл (СХТ)-ийг байгуулах, хүлэмжийн хийн тооцоо гэх мэт бодлогын шинжилгээний суурь мэдээлэл болдог.

Малын ашиг шимийн бүтээгдэхүүнд мал, тэжээвэр амьтдыг өсгөж үржүүлсний дүнд бий болсон ноос, ноолуур, арьс шир, хөөвөр, хялгас, мах, сүү, өндөг, зөгийн бал зэрэг бүтээгдэхүүнийг хамруулдаг. Тооллогоор цуглуулсан малын ашиг шимийн бүтээгдэхүүний гарцын хэмжээг малын төрөл, бүсээр тооцож энэхүү бүлэгт танилцууллаа.

## XIII.1. Малын сүүний гарц

Улсын дунджаар 2021 оны байдлаар үнээний сүүний өдрийн дундаж гарц 2.3 литр, сарлагийн үнээнийх 1.3 литр байна. Үнээний сүүний гарцыг бүсээр авч үзвэл, Баруун бүс болон Хангайн бүсэд дунджаар 2.0 литр, Төвийн бүсэд 3.3 литр, Зүүн бүсэд 2.4 литр, Улаанбаатарт 4.0 литр байна.

ХҮСНЭГТ XIII.1. ҮНЭЭНИЙ СҮҮНИЙ ӨДРИЙН ДУНДАЖ ГАРЦ, бүсээр, 2021 он

| Төрөл | Улсын дундаж | Баруун бүс | Хангайн бүс | Төвийн бүс | Зүүн бүс | Улаан-баатар |
|---|---|---|---|---|---|---|
| **Үнээ** | | | | | | |
| Өдрийн дундаж гарц, литр | 2.3 | 2.0 | 2.0 | 3.3 | 2.4 | 4.0 |
| Жилд саалинд хамрагдах хугацаа, сар | 4.8 | 5.0 | 4.4 | 5.4 | 4.1 | 7.0 |
| **Сарлагийн үнээ** | | | | | | |
| Өдрийн дундаж гарц, литр | 1.3 | 1.4 | 1.2 | 1.0 | 1.0 | 1.2 |
| Жилд саалинд хамрагдах хугацаа, сар | 5.0 | 5.3 | 4.8 | 4.7 | 2.1 | 6.0 |

Харин саалинд хамрагдсан хугацааг сараар авч үзвэл, үнээний жилийн саалинд хамрагдах дундаж хугацаа 4.8 сар, сарлагийнх 5.0 сар байна.

Монгол улсын мал аж ахуй нь ихэвчлэн нүүдлийн мал аж ахуйд суурилсан байдаг тул үнээний сүүний гарц нь улирлаар ялгаатай байдаг. Саалийн хэмжээг жилийн

турш сар бүрээр тэмдэглэл хийх аргаар мэдээлэл цуглуулсан. Ингэснээр сүүний гарцыг улирлаар тодорхойлох боломжийг олгосон. Үнээний сүүний өдрийн дундаж гарц зуны улиралд 2.9 литр, намрын улиралд 2.2 литр, хаврын улиралд 2.3 литр, өвлийн улиралд 2.0 литр сүү саадаг байна..

ХҮСНЭГТ XIII.2. ҮНЭЭНИЙ СҮҮНИЙ ӨДРИЙН ДУНДАЖ ГАРЦ, улирал, литрээр, 2021 он

| Төрөл | Жилийн дундаж | Хавар | Зун | Намар | Өвөл |
|---|---|---|---|---|---|
| Үнээ | 2.3 | 2.3 | 2.9 | 2.2 | 2.0 |
| Сарлагийн үнээ | 1.3 | 1.2 | 1.4 | 1.3 | 1.0 |

Харин сарлагийн үнээний сүүний өдрийн дундаж гарц зуны улиралд 1.4 литр, намрын улиралд 1.3 литр, хаврын улиралд 1.2 литр, өвлийн улиралд 1.0 литр сүү саадаг байна

ЗУРАГ XIII.1. ҮНЭЭНИЙ СҮҮНИЙ ӨДРИЙН ДУНДАЖ ГАРЦ, улирал, литрээр




Тооллогын дүнгээрх саалинд хамрагдалтын байдлыг (нийт хээлтэгч малаас саасан хээлтэгчийн тоо) авч үзвэл, үнээнийх 31.4 хувь, сарлагийнх 70.9 хувь нь саалинд хамрагдсан байна. Баруун бүсэд үнээний саалинд хамрагдалтын хувь 34.0 хувь, сарлагийнх 69.9 хувь, Хангайн бүсэд үнээнийх 28.8 хувь, сарлагийнх 71.7 хувь, Төвийн бүсэд үнээнийх 34.4 хувь, сарлагийнх 81.2 хувь, Зүүн бүсэд үнээнийх 25.1 хувь, сарлагийнх 92.1 хувь, Улаанбаатарт үнээнийх 43.3 хувь, сарлагийнх 79.2 хувь байна.

ХҮСНЭГТ XIII.3. ҮНЭЭНИЙ СААЛИНД ХАМРАГДАЛТЫН ХУВЬ, бүсээр, хувиар

| Төрөл | Улсын дундаж | Баруун бүс | Хангайн бүс | Төвийн бүс | Зүүн бүс | Улаанбаатар |
|---|---|---|---|---|---|---|
| Үнээ | 31.4 | 34.0 | 28.8 | 34.4 | 25.1 | 43.3 |
| Сарлагийн үнээ | 70.9 | 69.9 | 71.7 | 81.2 | 92.1 | 79.2 |

Үнээний сүүний жилийн дундаж гарц 284.3 литр, сарлагийн үнээний сүүнийх 200.0 литр байна. Үнээний сүүний жилийн дундаж гарц Улаанбаатарт 882.7 литр, Төвийн бүсэд 508.8 литр байгаа бөгөөд энэ бүсүүдэд томоохон сүүний чиглэлийн фермерүүд үйл ажиллагаа явуулж байгаатай холбоотой юм.

ХҮСНЭГТ XIII.4. ҮНЭЭНИЙ СҮҮНИЙ ЖИЛИЙН ДУНДАЖ ГАРЦ, бүсээр, литрээр

| Төрөл | Улсын дундаж | Баруун бүс | Хангайн бүс | Төвийн бүс | Зүүн бүс | Улаанбаатар |
|---|---|---|---|---|---|---|
| Үнээ | 284.3 | 230.9 | 186.4 | 508.8 | 235.2 | 882.7 |
| Сарлагийн үнээ | 200.0 | 218.8 | 185.9 | 174.9 | 55.1 | 227.5 |

Үнээний сүүний жилийн дундаж гарцыг аймгаар авч үзвэл Баян-Өлгий, Увс, Орхон, Төв, Сэлэнгэ, Дархан-Уул аймаг болон Улаанбаатар хотод улсын дунджаас 20.3-598.3 литрээр дээгүүр байна.

ЗУРАГ XIII.2. ҮНЭЭНИЙ СҮҮНИЙ ЖИЛИЙН ДУНДАЖ ГАРЦ, аймгаар, 2021 он




Үнээнээс бусад төрлийн хээлтэгчийн өдрийн дундаж сүүний гарц улсын дунджаар гүүнийх 2.5 литр, ингэнийх 0.7 литр, эм хониных болон эм ямааных 0.5 литр байна. Саалинд хамрагдсан хугацааг сараар авч үзвэл, гүүг жилд дунджаар 1.9 сар, ингийг 3.8 сар, эм хонийг 1.8 сар, эм ямааг 2.7 сар саадаг байна.

ХҮСНЭГТ XIII.5. ҮНЭЭНЭЭС БУСАД ТӨРЛИЙН ХЭЭЛТЭГЧИЙН СҮҮНИЙ ЖИЛИЙН ДУНДАЖ ГАРЦ, бүсээр

| Төрөл | Улсын дундаж | Баруун бүс | Хангайн бүс | Төвийн бүс | Зүүн бүс | Улаан-баатар |
|---|---|---|---|---|---|---|
| Гүү | | | | | | |
| Өдрийн дундаж гарц, литр | 2.5 | 2.4 | 2.5 | 2.5 | 2.4 | 2.4 |
| Жилд саалинд хамрагдах хугацаа, сар | 1.9 | 1.9 | 2.1 | 1.5 | 0.4 | 2.6 |
| Ингэ | | | | | | |
| Өдрийн дундаж гарц, литр | 0.7 | 0.7 | 0.9 | 0.7 | 0.8 | - |
| Жилд саалинд хамрагдах хугацаа, сар | 3.8 | 3.2 | 4.5 | 5.2 | 0.7 | - |
| Эм хонь | | | | | | |
| Өдрийн дундаж гарц, литр | 0.5 | 0.5 | 0.4 | 0.6 | 0.5 | 0.7 |
| Жилд саалинд хамрагдах хугацаа, сар | 1.8 | 1.9 | 1.6 | 1.7 | 0.5 | 2.5 |
| Эм ямаа | | | | | | |
| Өдрийн дундаж гарц, литр | 0.5 | 0.5 | 0.5 | 0.5 | 0.4 | 0.6 |
| Жилд саалинд хамрагдах хугацаа, сар | 2.7 | 2.9 | 2.0 | 2.2 | 1.3 | 2.9 |

Үнээнээс бусад төрлийн хээлтэгчийн саалинд хамрагдалтын хувь гүүнийх 14.8 хувь, ингэнийх 16.9 хувь, эм хониных 10.5 хувь, эм ямааных 14.9 хувь байна.

ХҮСНЭГТ XIII.6. ҮНЭЭНЭЭС БУСАД ТӨРЛИЙН ХЭЭЛТЭГЧИЙН СААЛИНД ХАМРАГДАЛТЫН ХУВЬ, бүсээр, 2021 он

| Төрөл | Улсын дундаж | Баруун бүс | Хангайн бүс | Төвийн бүс | Зүүн бүс | Улаанбаатар |
|---|---|---|---|---|---|---|
| Гүү | 14.8 | 15.5 | 16.9 | 9.8 | 3.0 | 19.7 |
| Ингэ | 16.9 | 15.8 | 18.5 | 19.1 | 35.9 | 42.7 |
| Эм хонь | 10.5 | 11.7 | 8.9 | 6.5 | 1.0 | 13.7 |
| Эм ямаа | 14.9 | 16.1 | 10.1 | 7.2 | 3.3 | 16.3 |

Үнээнээс бусад төрлийн хээлтэгчийн жилийн дундаж сүүний гарцыг хээлтэгчийн төрлөөр авч үзвэл гүүний улсын жилийн дундаж сүүний гарц 136.5 литр, ингэнийх 87.9 литр, эм хониных 26.8 литр, эм ямааных 38.6 литр байна. Гүүний сүүний жилийн дундаж сүүний гарцыг бүсээр авч үзвэл Улаанбаатарт 194.8 литр, Хангайн бүсэд 149.2 литр, Баруун бүсэд 139.9 литр, Төвийн бүсэд 115.5 литр, Зүүн бүсэд 26.5 литр байна.

ХҮСНЭГТ XIII.7. ҮНЭЭНЭЭС БУСАД ТӨРЛИЙН ХЭЭЛТЭГЧИЙН СҮҮНИЙ ЖИЛИЙН ДУНДАЖ ГАРЦ, бүсээр, 2021 он

| Төрөл | Улсын дундаж | Баруун бүс | Хангайн бүс | Төвийн бүс | Зүүн бүс | Улаанбаатар |
|---|---|---|---|---|---|---|
| Гүү | 136.5 | 139.9 | 149.2 | 115.5 | 26.5 | 194.8 |
| Ингэ | 87.9 | 71.5 | 148.9 | 114.5 | 15.9 | - |
| Эм хонь | 26.8 | 28.0 | 21.6 | 30.3 | 11.3 | 45.4 |
| Эм ямаа | 39.6 | 41.4 | 28.9 | 31.7 | 21.3 | 47.0 |

## XIII.2. Ноос, ноолуур, хөөвөр, хялгасны гарц

Нэг малаас самнасан ноос, ноолуур, хялгасны гарцыг тооцоход жилд дунджаар өсвөр насны тэмээний ноос 4087.2 гр, нас гүйцсэн тэмээний ноос 5062.2 гр, хонины уртын ноос 1166.7 гр, хурганы ноос 404.1 гр, ямааны ноолуур 387.7 гр, ямааны хялгас 171.3 гр, бодын хөөвөр 479.9 гр-г тус тус самнасан байна.

ХҮСНЭГТ XIII.8. НООС, НООЛУУР, ХӨӨВӨР, ХЯЛГАСЫН ЖИЛИЙН ДУНДАЖ ГАРЦ, малын төрөл, бүсээр, грамм, 2021 он

| Төрөл | Улсын дундаж | Баруун бүс | Хангайн бүс | Төвийн бүс | Зүүн бүс | Улаанбаа-тар |
|---|---|---|---|---|---|---|
| Тэмээний ноос, өсвөр | 4 087.2 | 4 443.8 | 4 194.1 | 3 430.8 | 3 276.5 | - |
| Тэмээний ноос, нас гүйцсэн | 5 062.2 | 5 502.6 | 5 543.9 | 4 036.9 | 3 680.4 | - |
| Хонины уртын ноос | 1 166.7 | 1 230.0 | 1 102.7 | 1 200.7 | 1 021.6 | 1 592.9 |
| Хурганы ноос | 404.1 | 436.1 | 351.7 | 410.8 | 389.6 | 672.3 |
| Ноолуур | 387.7 | 412.5 | 362.7 | 388.6 | 347.7 | 473.6 |
| Ямааны хялгас | 171.3 | 159.1 | 178.2 | 171.3 | 163.8 | 267.4 |
| Бодын хөөвөр | 473.9 | 489.9 | 414.0 | 607.6 | 439.0 | 412.2 |

## XIII.3. Малын амьдын болон гулуузны жин

Нэг малын дундаж амьдын болон гулуузны жингийн үзүүлэлтийг өрх, ААНБ-аас асууж малын төрөл, байгалийн бүсээр нэгтгэсэн.

Улсын дунджаар малын төрлөөр авч үзвэл адууны амьдын дундаж жин 264.2 кг, үхрийнх 280.2 кг, тэмээнийх 411.3 кг, хониных 44.6 кг, ямааных 37.9 кг байна.

ХҮСНЭГТ XIII.9. МАЛЫН АМЬДЫН ЖИН, малын төрөл, бүсээр, кг-аар

| Бүс | Адуу | Үхэр | Тэмээ | Хонь | Ямаа |
|---|---|---|---|---|---|
| **Улсын дундаж** | **264.2** | **280.2** | **411.3** | **44.6** | **37.9** |
| Баруун бүс | 300.0 | 303.3 | 454.8 | 48.5 | 40.9 |
| Хангайн бүс | 240.4 | 259.4 | 356.5 | 43.1 | 37.6 |
| Төвийн бүс | 244.6 | 262.5 | 373.8 | 41.0 | 34.6 |
| Зүүн бүс | 233.6 | 268.2 | 318.8 | 42.3 | 35.8 |
| Улаанбаатар | 280.8 | 304.2 | - | 35.0 | 28.2 |

Бод малын амьдын жинг бүсээр авч үзэхэд баруун бүсэд адууны дундаж жин 300.0 кг, үхрийнх 303.3 кг, тэмээнийх 454.8 кг байна. Энэ нь улсын дундаж жингээс адуу 36.1 кг, үхэр 23.8 кг, тэмээ 34.4 кг -аар тус тус их байна.

ЗУРАГ XIII.3. БОД МАЛЫН АМЬДЫН ЖИН, малын төрөл, бүсээр, кг-аар




Харин бог малын амьдын жин Улаанбаатарт улсын дундаж жингээс хониных 9.6 кг, ямааных 9.8 кг-аар бага байна.

ЗУРАГ XIII.4. БОГ МАЛЫН АМЬДЫН ЖИН, малын төрөл, бүсээр, кг-аар



Малын амьдын жин, гулуузны гарцын харьцааг малын төрлөөр авч үзвэл адуу, үхэр, тэмээний 50.0 хувь, хонины 48.0 хувь, ямааны амьдын жингийн 43.0 хувь, гахайны 60.0 хувь, тахианы 70 хувь нь гулуузны жинтэй тэнцүү байдаг (Статистикийн төв газар, 1973, хууд. 18) гэж үзэж дараах хүснэгтэд гулуузны жинг тооцсон.

ХҮСНЭГТ XIII.10. МАЛЫН АМЬДЫН ЖИН, ГУЛУУЗНЫ ГАРЦ, малын төрөл, кг-аар

| Төрөл | Гарц/хувь/ | Амьдын жин | Гулуузны жин |
|---|---|---|---|
| Адуу | 0.50 | 264.2 | 132.1 |
| Үхэр | 0.50 | 280.2 | 140.1 |
| Тэмээ | 0.50 | 411.3 | 205.6 |
| Хонь | 0.48 | 44.6 | 21.4 |
| Ямаа | 0.43 | 37.9 | 16.3 |

Гахайны амьдын дундаж жин улсын дунджаас Баруун бүсэд 18.2 кг, Хангайн бүсэд 20.1 кг-аар их байна.

ХҮСНЭГТ XIII.11. ГАХАЙ, ТАХИАНЫ АМЬДЫН БОЛОН ГУЛУУЗНЫ ЖИН, төрөл, бүсээр, кг-аар

| Бүс | Гахай | | Тахиа | |
|---|---|---|---|---|
| | Амьдын жин | Гулуузны жин | Амьдын жин | Гулуузны жин |
| Гарц/хувь/ | | 60% | | 70% |
| **Улсын дундаж** | **126.2** | **75.7** | **3.6** | **2.5** |
| Баруун бүс | 144.4 | 86.6 | 2.3 | 1.6 |
| Хангайн бүс | 146.3 | 87.8 | 4.7 | 3.3 |
| Төвийн бүс | 123.2 | 73.9 | 4.2 | 2.9 |
| Зүүн бүс | 119.1 | 71.5 | 3.0 | 2.1 |
| Улаанбаатар | 120.0 | 72.0 | 3.0 | 2.1 |

Харин тахианы амьдын дундаж жин Хангайн бүсэд 4.7 кг, Төвийн бүсэд 4.2 кг, Зүүн бүс, Улаанбаатарт 3.0 кг, Баруун бүсэд 2.3 кг байна.

ЗУРАГ XIII.5. ТАХИАНЫ АМЬДЫН БОЛОН ГУЛУУЗНЫ ЖИН, бүсээр, кг-аар



**XIV БҮЛЭГ**

# ХӨДӨӨ АЖ АХУЙ ЭРХЭЛДЭГ ӨРХИЙН ХҮНСНИЙ ХАНГАМЖ

**ХҮНСНИЙ ДУТАГДАЛД ОРСОН ӨРХИЙН ШАЛТГААН, эзлэх хувиар**



# XIV.ХӨДӨӨ АЖ АХУЙ ЭРХЭЛДЭГ ӨРХИЙН ХҮНСНИЙ ХАНГАМЖ

НҮБ-ын ХХААБ-аас ХАА-н тооллогоор өрхийн хүнсний аюулгүй байдлын талаарх мэдээллийг цуглуулах, тооллогын асуулгад өөрийн орны нөхцөл байдал, онцлогт тохирсон асуулт тусган оруулахыг зөвлөмж болгосон байдаг.

Хүнсний аюулгүй байдал гэж хүн ам амьдралынхаа туршид чанартай, шим тэжээллэг, аюулгүй хүнсийг улсын эдийн засаг, нийгмийн нөхцөл байдал, газар зүйн байршлаас үл хамааран тогтвортой, хүртээмжтэй сонгон хэрэглэх боломж бүрдсэн байх гэдгээр тодорхойлогдох бөгөөд хүнсний хангамж; хүнсний илчлэг, шим тэжээл; хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдал гэсэн үндсэн 3 үзүүлэлтээс бүрддэг.

Тухайн улс нь хүн амаа зайлшгүй хэрэгцээт хүнсний бүтээгдэхүүнээр хангаж чадаж байгааг улсын түвшинд тооцож гаргахаас хүнсний хангамжаас гадна өрхийн түвшинд хүнсний хүртээмжийн байдал ямар байгааг өрхөд суурилсан судалгаагаар тогтоох нь чухал юм.

ХАА-н үйлдвэрлэл эрхэлж байгаа өрхийн хувьд хүнсний бүтээгдэхүүн нь хүрэлцээтэй байгаа эсэх, хүнсний бүтээгдэхүүний хэрэглээгээ багасгаж, дутагдалд орсон эсэх, жилийн аль сар, улиралд ихэвчлэн хүнсний дутагдалд ордог, үндсэн шалтгаан хүнсэндээ зайлшгүй хэрэглэх шаардлагатай гол нэрийн бүтээгдэхүүнийг байнга хэрэглэж чаддаг эсэх зэрэг ХХААБ-аас зөвлөмж болгосон үзүүлэлтийг ХАА-н тооллогын асуулгад тусгаж, үр дүнг гаргалаа.

## XIV.1. Хүнсний дутагдалд орсон өрх

Тогтмол хэрэглэдэг хүнсний бүтээгдэхүүн нь хүрэлцээгүйгээс хэрэглээнийхээ хэмжээг багасгасан эсвэл хэрэглэх боломжгүй тохиолдол гарсан бол “Хүнсний дутагдал”-д орсон гэж үзнэ.

ХАА-н тооллогод 2021 онд мал аж ахуй эрхэлдэг нийт 245.4 мянган өрхийн 0.7 хувь нь буюу 1.7 мянган өрх, газар тариалан эрхэлдэг нийт 18.8 мянган өрхийн 1.2 хувь нь буюу 0.2 мянган өрх хүнсний дутагдалд орсон гэж хариулсан байна.

2011 оны тооллогын дүнтэй харьцуулахад, мал аж ахуй эрхэлдэг хүнсний дутагдалд орсон өрхийн тоо 2.9 (5.9 мянга) хувиар, газар тариалан эрхэлдэг хүнсний дутагдалд орсон өрхийн тоо 3.5 (1.4 мянга) хувиар тус тус буурсан байна.

ХҮСНЭГТ XIV.1. ХҮНСНИЙ ДУТАГДАЛД ОРСОН ӨРХИЙН ТОО, өрхөд эзлэх хувь

| | Бүгд | | Мал аж ахуй | | Газар тариалан | |
|---|---|---|---|---|---|---|
| | 2011 | 2021 | 2011 | 2021 | 2011 | 2021 |
| Өрхийн тоо | 9 155 | 1 962 | 7 594 | 1 740 | 1 561 | 222 |
| Мал аж ахуй, газар тариалан эрхэлдэг өрхөд эзлэх хувь | 3.8 | 0.7 | 3.6 | 0.7 | 4.7 | 1.2 |

ХАА эрхэлдэг өрхүүд нь монголчуудын хүнсний хэрэглээний голлох бүтээгдэхүүн болох мах, махан бүтээгдэхүүн болон төмс, хүнсний ногоог өөрсдийн хүчээр үйлдвэрлэж, өөрсдийн хүнсний хэрэглээгээ шууд хангах, зарим төрлийн

бүтээгдэхүүнийг борлуулалт хийж, орлого олох боломжтой байдагтай холбоотойгоор хүнсний дутагдалд орох нь харьцангуй бага байна. 2010-2011 онд манай улсад зудын нөхцөл байдалтай байсан нь хүнсний дутагдал өндөр байхад нөлөөлж байсан бол ээлжит тооллого явагдсан 2021 оны хувьд байгаль, цаг уур тааламжтай үе таарч, мөн ковид цар тахлын үед засгийн газраас өрх бүрт нийгмийн халамж өндөр хэмжээгээр өгч байсан нь наад захын хэрэгцээг хангахад ээрэг нөлөө үзүүлсэн хүнсний дутагдалд орсон өрхийн тоо буурахад нөлөөлсөн байна.

## XIV.2. Хүнсний дутагдалд орсон хугацаа

Хүнсний хангамжид нөлөөлөх улирлын нөлөөллийг тодорхойлох зорилгоор тооллогын асуулгад сар сараар дутагдалд өртсөн хугацааг асуусан.

Өрхийн 41.4 орчим хувь нь намар, өвлийн идэш бэлтгэсэн, нөөцөлсөн бүтээгдэхүүн дуусаж, олдоц багасаж, үнэ нэмэгддэг хаврын саруудад буюу монголчуудын ярьдгаар хаврын тарчиг цагт (3, 4, 5 сар) голлон хүнсний дутагдалд оржээ. 2011 оны тооллогын дүнгээс хаврын улиралд хүнсний дутагдалд орсон өрх 14.6 нэгж хувиар буурсан байна.

ХҮСНЭГТ XIV.2. ХҮНСНИЙ ДУТАГДАЛД ОРСОН ӨРХИЙН ТОО, сараар

| Сар | Өрхийн тоо | | | | Хүнсний дутагдалд орсон өрхөд эзлэх хувь | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | Мал аж ахуй | | Газар тариалан | | Мал аж ахуй | | Газар тариалан | |
| | 2011 | 2021 | 2011 | 2021 | 2011 | 2021 | 2011 | 2021 |
| I | 1 422 | 387 | 325 | 69 | 18.7 | 22.3 | 20.8 | 31.1 |
| II | 1 941 | 276 | 406 | 61 | 25.6 | 15.9 | 26.0 | 27.5 |
| III | 3 825 | 732 | 840 | 88 | 50.4 | 42.1 | 53.8 | 39.6 |
| IV | 4 480 | 858 | 1 081 | 108 | 59.0 | 49.3 | 69.3 | 48.6 |
| V | 3 357 | 598 | 903 | 76 | 44.2 | 34.4 | 57.9 | 34.2 |
| VI | 1 525 | 245 | 404 | 39 | 20.1 | 14.1 | 25.9 | 17.6 |
| VII | 971 | 144 | 193 | 15 | 12.8 | 8.3 | 12.4 | 6.8 |
| VIII | 991 | 186 | 121 | 12 | 13.0 | 10.7 | 7.8 | 5.4 |
| IX | 1 074 | 242 | 88 | 12 | 14.1 | 13.9 | 5.6 | 5.4 |
| X | 1 116 | 230 | 139 | 29 | 14.7 | 13.2 | 8.9 | 13.1 |
| XI | 1 063 | 214 | 220 | 46 | 14.0 | 12.3 | 14.1 | 20.7 |
| XII | 1 144 | 188 | 279 | 29 | 15.1 | 10.8 | 17.9 | 13.1 |

Хүнсний дутагдалд орсон өрхийн хүнсний дутагдалд орсон нийт өрхөд эзлэх хувийг сараар авч үзвэл, 41.8 хувь нь 3 дугаар сард, 49.3 хувь нь 4 дүгээр сард, 34.4 хувь нь 5 дугаар сард хүнсний дутагдалд орсон байгаа нь бусад саруудтай харьцуулахад өндөр байна.

2011 оны тооллогын дүнтэй харьцуулж авч үзэхэд 2021 оны 3 дугаар сард 9.2 нэгж хувиар, 4 дүгээр сард 11.4 нэгж хувиар, 5 дугаар сард 12.1 нэгж хувиар тус тус буурсан байна.

## XIV.3. Хүнсний дутагдалд орсон шалтгаан

ХАА эрхэлдэг өрхүүдийн хүнсний дутагдалд орсон гол шалтгааныг авч үзвэл, 57.6 хувь нь "хүнсний бүтээгдэхүүний үнэ нэмэгдсэн" -ээс, 47.2 хувь нь "орлого буурсан" -аас, 24.3 хувь нь "олдоц багассан" -аас болсон гэж үзсэн байна. Мал аж ахуй эрхэлдэг өрхийн хувьд 16.2 хувь нь "малын хорогдол" -оос болсон гэсэн бол газар тариалан эрхэлдэг хүнсний дутагдалд орсон өрхүүдийн 12.6 хувь нь "ажлын байр олдоогүй" гэсэн шалтгаантай гэж хариулсан байна.

ХҮСНЭГТ XIV.3. ХҮНСНИЙ ДУТАГДАЛД ОРСОН ӨРХИЙН ТОО, шалтгаанаар

| | Өрхийн тоо | | | | Хүнсний дутагдалд орсон өрхөд эзлэх хувь | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | Мал аж ахуй | | Газар тариалан | | Мал аж ахуй | | Газар тариалан | |
| | 2011 | 2021 | 2011 | 2021 | 2011 | 2021 | 2011 | 2021 |
| Үнэ нэмэгдсэн | 4 484 | 876 | 1 162 | 144 | 59.1 | 50.3 | 74.5 | 64.9 |
| Орлого буурсан | 3 749 | 655 | 670 | 126 | 49.4 | 37.6 | 42.9 | 56.8 |
| Мал хорогдсон | 2 451 | 282 | 113 | 11 | 32.3 | 16.2 | 7.2 | 5.0 |
| Олдоц багассан | 976 | 284 | 334 | 72 | 12.8 | 16.3 | 21.5 | 32.4 |
| Ажлын байр олдоогүй | 1 847 | 202 | 397 | 28 | 24.3 | 11.6 | 25.4 | 12.6 |
| Байгалийн гамшигт өртсөн | 873 | 85 | 59 | 4 | 11.5 | 4.9 | 3.8 | 1.8 |
| Хөдөлмөрийн чадвараа алдсан /өвдөж, гэмтэж бэртэх, хөгжлийн бэрхшээл гэх мэт/ | 631 | 63 | 145 | 19 | 8.3 | 3.6 | 9.3 | 8.6 |
| Малын хулгайд өртсөн | 370 | 41 | 33 | 4 | 4.9 | 2.3 | 21.0 | 1.8 |
| Ургац алдсан | 122 | 41 | 200 | 14 | 1.6 | 2.3 | 12.8 | 6.3 |
| Бусад | 210 | 192 | 32 | 17 | 2.8 | 11.0 | 2.1 | 7.7 |

2011 оны тооллогод мөн адил ХАА эрхэлдэг өрхүүд хүнсний дутагдалд орсон гол шалтгаан нь "хүнсний бүтээгдэхүүний үнэ нэмэгдсэн"-ээс болон "өрхийн орлого буурсан" -аас болсон гэж үзжээ. Газар тариалан эрхэлдэг өрхийн хувьд "ажлын байр олдохгүй" байгаа нь 12.8 нэгж хувиар, мал аж ахуй эрхэлдэг өрхийн "малын хорогдсон" гэсэн шалтгаан нь 16.1 нэгж хувиар тус тус буурсан байна.

## XIV.4. Хүнсний дутагдлаас гарахын тулд авсан арга хэмжээ

Хүнсний дутагдалд орсон өрх нь хүнсний дутагдлаас гарахын тулд "зээл авах" (32.9-36.5 хувь), "бусдаас тусламж, дэмжлэг авах" (24.6-27.5 хувь) зэрэг арга хэмжээг авсан байна.

Хүснэгт XIV.4. ХҮНСНИЙ ДУТАГДЛААС ГАРАХЫН ТУЛД АВСАН АРГА ХЭМЖЭЭ, хүнсний дутагдалд орсон өрхөд эзлэх хувиар

| | Мал аж ахуй | | Газар тариалан | |
|---|---|---|---|---|
| | 2011 | 2021 | 2011 | 2021 |
| Бусдаас тусламж, дэмжлэг авсан | 42.0 | 24.6 | 38.8 | 27.5 |
| Зээл авсан | 33.4 | 32.9 | 35.7 | 36.5 |
| Мөнгөн хуримтлалаасаа хэрэглэсэн | 11.1 | 12.1 | 11.7 | 20.7 |
| Гэр бүлийн бизнесээ өргөжүүлсэн | 3.3 | 2.1 | 9.6 | 3.6 |
| Мал, газар, хөрөнгөө худалдсан | 16.2 | 12.3 | 9.2 | 5.9 |

| | Мал аж ахуй | | Газар тариалан | |
|---|---|---|---|---|
| | 2011 | 2021 | 2011 | 2021 |
| Төрийн байгууллагаас тусламж дэмжлэг авсан | 11.6 | 3.0 | 6.4 | 3.2 |
| Гэр бүлийн бизнес шинээр эхлүүлсэн | 3.2 | 1.4 | 4.7 | 3.2 |
| Төрийн бус байгууллагаас тусламж дэмжлэг авсан | 3.9 | 1.7 | 2.6 | 1.4 |
| Бусад | 5.4 | 10.5 | 8.1 | 12.6 |

Хүнсний дутагдалд орсон ХАА эрхэлдэг хүнсний дутагдлаас гарахын тулд бусад арга хэмжээг авсан өрхүүд “хөл хорионоос гарсан”, “арга хэмжээ аваагүй”, “хэрэглээгээ багасгасан” гэж хариулсан байна. Үүнээс Ковид-19 цар тахлын үеийн хатуу хөл хорионы үед мал аж ахуй болон газар тариалан эрхэлдэг өрхүүд хүнсний дутагдлаас гарахад хүндрэл бэрхшээлтэй байсан байна.

ХҮСНЭГТ XIV.5. ХҮНСНИЙ ДУТАГДЛААС ГАРАХЫН ТУЛД АВСАН БУСАД АРГА ХЭМЖЭЭ, бусад арга хэмжээ авсан өрхөд эзлэх хувиар

| | Мал аж ахуй | Газар тариалан |
|---|---|---|
| Арга хэмжээ аваагүй байгаа | 27.0 | 21.4 |
| Өөрсдөө зохицуулалт хийсэн | 15.6 | 7.1 |
| Ажил хөдөлмөр эрхэлсэн | 15.2 | 14.3 |
| Хөл хорионоос гарсан | 32.7 | 32.1 |
| Хэрэглээгээ багасгасан | 5.0 | 21.4 |
| Хүнсний талоноор амьдарсан | 4.5 | 3.6 |

## XIV.5. Хүнсний гол нэрийн бүтээгдэхүүний хэрэглээ

Хүнсний хангамжийн статистикийн үзүүлэлтийг тооцоход монгол хүн эрүүл аж төрөхийн тулд хоногт шаардагдах илчлэг, тэжээлийг хангахад зайлшгүй чухал шаардлагатай мах, махан бүтээгдэхүүн; сүү; сүүн бүтээгдэхүүн; гурил; гурилан бүтээгдэхүүн; төрөл бүрийн будаа; сахар, чихрийн зүйл; төмс; хүнсний ногоо; буурцагт ургамал; жимс, жимсгэнэ; өндөг; ургамлын тос, цөцгийн тос зэрэг 16 гол нэр төрлийн бүтээгдэхүүнийг хамруулан авч үздэг бөгөөд уг бүтээгдэхүүний нэр төрлийг ЭМЯ-ны Хоол судлалын төвөөс тусгайлан судалгаагаар тогтоосон байна.

ХАА-н тооллогын маягтад ХАА эрхэлдэг хүнсний дутагдалд орсон өрх нь дээрх нэр төрлийн бүтээгдэхүүнийг хүнсний хэрэглээндээ хэрэглэж чаддаг эсэх, ямар гол нэрийн хүнсний бүтээгдэхүүнийг байнга хэрэглэдгийг тогтоох зорилгоор холбогдох үзүүлэлтийг тусгаснаас ХАА эрхэлдэг өрхийн хувьд зайлшгүй хэрэглэх 16 нэр төрлийн бүтээгдэхүүнээс мах махан бүтээгдэхүүн, гурил, гурилан бүтээгдэхүүн, хүнсний ногоо болон ургамлын тос өндөр байдаг нь харагдлаа.

ХАА эрхэлдэг өрхийн хувьд малын мах, гурил, гурилан бүтээгдэхүүн болон сүүний хэрэглээ өндөр байгаа бол загас, шувууны мах, болон вандуй шошийн хэрэглээ бага байна.

ХҮСНЭГТ XIV.6. ХҮНСНИЙ ДУТАГДАЛД ОРСОН ӨРХИЙН ХҮНСНИЙ БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ХЭРЭГЛЭЭ, хөдөө аж ахуй эрхэлдэг өрхөд эзлэх хувь

| | Нийт | Мал аж ахуй | Газар тариалан |
|---|---|---|---|
| Малын мах | 99.0 | 99.0 | 99.2 |
| Загас | 3.2 | 2.8 | 8.9 |
| Шувууны мах | 5.3 | 4.5 | 16.2 |
| Сүү | 81.2 | 80.8 | 86.2 |
| Тараг, аарц | 73.0 | 72.6 | 77.3 |
| Гурил | 92.1 | 91.9 | 94.4 |
| Гурилан бүтээгдэхүүн | 79.3 | 78.7 | 86.8 |
| Бүх төрлийн будаа | 70.0 | 69.5 | 77.1 |
| Сахар, чихрийн зүйл | 51.1 | 50.3 | 61.1 |
| Пүнтүүз | 12.9 | 12.2 | 23.0 |
| Төмс | 63.2 | 61.7 | 83.5 |
| Хүнсний ногоо | 66.5 | 65.1 | 84.5 |
| Вандуй, шош | 6.0 | 5.3 | 15.0 |
| Жимс, жимсгэнэ | 23.2 | 21.4 | 46.7 |
| Өндөг | 28.3 | 26.1 | 56.1 |
| Ургамлын тос | 64.3 | 63.1 | 79.6 |

Мал аж ахуй эрхэлдэг өрхийн хувьд мах, махан бүтээгдэхүүн, сүү, цагаан идээ, гурил гурилан бүтээгдэхүүн өндөр байгаа бөгөөд дунджаар 7-8 төрлийн хүнсний бүтээгдэхүүнийг ихэвчлэн хэрэглэдэг байна.

Харин газар тариалан эрхэлдэг өрхүүд хүнсэндээ дунджаар 10 төрлийн хүнсний бүтээгдэхүүн хэрэглэдэг бөгөөд нэр төрөл нь мах, махан бүтээгдэхүүн, гурил гурилан бүтээгдэхүүн, төмс, хүнсний ногоо, болон будааны хэрэглээ өндөр байна.

## XIV.6. Байгалийн аюулт үзэгдэл, цаг уурын байдал

Байгалийн аюулт үзэгдэл нь хүчтэй цасан болон шороон шуурга, ган, зуд, үер, газар хөдлөлт, цөлжилт болох, гал түймэр, хүн, мал, амьтны болон ургамлын гоц халдварт өвчин гарах, хортон мэрэгчид тархах зэргийг ойлгоно.

Байгалийн аюулт үзэгдлийн давтамж, ган, зудад өртөж байгаа байдлыг судлах зорилгоор энэ талаарх асуулгыг тооллогын асуулгад тусган оруулж, үр дүнг нэгтгэсэн.

### БАЙГАЛИЙН АЮУЛТ ҮЗЭГДЭЛД ӨРТСӨН ӨРХ

ХАА-н 2021 оны тооллогод мал аж ахуй эрхэлдэг нийт өрхийн 6.3 хувь нь буюу 15.3 мянган өрх, газар тариалан эрхэлдэг нийт өрхийн 3.0 хувь буюу 0.6 мянган өрх байгалийн аюулт үзэгдэлд өртсөн байна.

ХҮСНЭГТ XIV.7. БАЙГАЛИЙН АЮУЛТ ҮЗЭГДЭЛД ӨРТСӨН ӨРХИЙН ТОО, хувиар

| | Мал аж ахуй | Газар тариалан |
|---|---|---|
| Өрхийн тоо | 15 348 | 564 |
| Мал аж ахуй, газар тариалан эрхэлдэг өрхөд эзлэх хувь | 6.3 | 3.0 |

## XIV.7. Байгалийн аюулт үзэгдэлд өртсөн байдал

Байгалийн аюулт үзэгдэлд улирлын нөлөөллийг тодорхойлох зорилгоор тооллогын асуулгад холбогдох асуулгыг тусгасан.

2021 оны тооллогод мал аж ахуй эрхэлдэг байгалийн аюулт үзэгдэлд өртсөн өрхийг нийт өрхөд эзлэх хувиар нь харж үзвэл 4.6 хувь нь 3 дугаар сард, 3.4 хувь нь 4 дүгээр сард, 2.1 хувь нь 2 дугаар сард байгалийн аюулт үзэгдэлд өртсөн нь бусад саруудтай харьцуулахад өндөр байгаа бөгөөд 3.7 хувь нь хүчтэй салхи, шуургад өртсөн байна.

ХҮСНЭГТ XIV.8. БАЙГАЛИЙН АЮУЛТ ҮЗЭГДЭЛД ӨРТСӨН ӨРХИЙН ТОО, сараар

| Сар | Өрхийн тоо | | Мал аж ахуй, газар тариалан эрхэлдэг өрхөд эзлэх хувь | |
|---|---|---|---|---|
| | Мал аж ахуй | Газар тариалан | Мал аж ахуй | Газар тариалан |
| I | 4 945 | 39 | 2.0 | 0.2 |
| II | 5 107 | 40 | 2.1 | 0.2 |
| III | 11 254 | 81 | 4.6 | 0.4 |
| IV | 8 317 | 60 | 3.4 | 0.3 |
| V | 4 926 | 81 | 2.0 | 0.4 |
| VI | 1 048 | 189 | 0.4 | 1.0 |
| VII | 580 | 301 | 0.2 | 1.6 |
| VIII | 394 | 158 | 0.2 | 0.8 |
| IX | 171 | 51 | 0.1 | 0.3 |
| X | 205 | 9 | 0.1 | 0.05 |
| XI | 534 | 2 | 0.2 | 0.01 |
| XII | 860 | 2 | 0.4 | 0.01 |

Тооллогод хамрагдсан газар тариалан эрхэлдэг байгалийн аюулт үзэгдэлд өртсөн өрхийг нийт өрхөд эзлэх хувиар нь дэлгэрүүлэн авч үзвэл, 1.6 хувь нь 7 дугаар сард, 1.0 хувь нь 6 дугаар сард, 0.8 хувь нь 8 дугаар сард өртсөн байгаа бөгөөд бусад саруудтай харьцуулахад өндөр гарсан ба 2.0 хувь нь үерт өртсөн байна.

ХҮСНЭГТ XIV.9. БАЙГАЛИЙН АЮУЛТ ҮЗЭГДЭЛД ӨРТСӨН ӨРХИЙН ТОО, аюулт үзэгдлийн төрлөөр

| | Өрхийн тоо | | Мал аж ахуй, газар тариалан эрхэлдэг өрхөд эзлэх хувь | |
|---|---|---|---|---|
| | Мал аж ахуй | Газар тариалан | Мал аж ахуй | Газар тариалан |
| Ган | 14 | 86 | 0.01 | 0.5 |
| Зуд | 2 069 | 43 | 0.8 | 0.2 |
| Үер | 6 192 | 370 | 2.5 | 2.0 |
| Газар хөдлөлт | 617 | 2 | 0.3 | 0.01 |
| Хүчтэй салхи, шуурга | 9 049 | 116 | 3.7 | 0.6 |
| Аянга | 33 | 5 | 0.01 | 0.03 |
| Хяруу цохисон | 1 | 22 | 0.1 | 0.1 |
| Бусад | 140 | 40 | 0.1 | 0.2 |

2021 оны тооллогоос мал аж ахуй эрхэлдэг байгалийн аюулт үзэгдэлд өртсөн өрхийн учирсан хохирлоор авч үзвэл 5.6 мянга (2.3 хувь) нь 2 сая хүртэлх төгрөгийн, 3.7 мянга (1.5 хувь) нь 2-5 сая төгрөгийн, 2.4 мянга (1.0 хувь) нь хохиролгүй, 2.1 мянга (0.8 хувь) нь 5-10 сая төгрөгийн, 1.4 мянга (0.6 хувь) нь 10 сая төгрөгөөс дээш төгрөгийн хохирол учирсан гэж хариулжээ. Газар тариалан эрхэлдэг өрхүүдийн

хувьд 0.2 мянга (0.9 хувь) нь 2 сая хүртэлх төгрөгийн, 0.1 мянга (0.7 хувь) нь 10 сая төгрөгөөс дээш төгрөгийн, 0.1 мянга (0.6 хувь) нь 2-5 сая төгрөгийн, 0.1 мянга (0.5 хувь) нь 5-10 сая төгрөгийн, 0.1 мянга (0.4 хувь) нь хохиролгүй гэжээ.

ХҮСНЭГТ XIV.10. БАЙГАЛИЙН АЮУЛТ ҮЗЭГДЭЛД ӨРТСӨН ӨРХӨД УЧИРСАН ХОХИРОЛ, түвшинээр

| | Өрхийн тоо | | Мал аж ахуй, газар тариалан эрхэлдэг өрхөд эзлэх хувь | |
|---|---|---|---|---|
| | Мал аж ахуй | Газар тариалан | Мал аж ахуй | Газар тариалан |
| Хохиролгүй | 2 360 | 67 | 1.0 | 0.4 |
| 2 сая төгрөг хүртэлх | 5 586 | 168 | 2.3 | 0.9 |
| 2-5 сая төгрөг | 3 720 | 104 | 1.5 | 0.6 |
| 5-10 сая төгрөг | 2 079 | 96 | 0.8 | 0.5 |
| 10 сая төгрөгөөс дээш | 1 429 | 134 | 0.6 | 0.7 |

**XV БҮЛЭГ**

# ОЙ, ЗАГАСНЫ АЖ АХУЙ, АН АГНУУРЫН САЛБАРЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА

**ТАРЬЦ, СУУЛГАЦЫН ТОО, мянган ширхэг**



## XV.1. Ойн аж ахуй

ХАА-н тооллогоор ой, загасны аж ахуй, ан агнуурын салбарын үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгж, байгууллагыг хамруулан холбогдох мэдээллийг ерөнхий мэдээлэл, ойн аж ахуйн гаралтай бүтээгдэхүүний үйлдвэрлэлт, борлуулалт, ойн аж ахуйн бүтээгдэхүүний орлого, зардал, газар, машин, тоног төхөөрөмж гэсэн үндсэн 4 бүлгээр цуглуулсан. Энэ удаагийн тооллогод цөөн тооны загас (4), ан агнуур (8)-ын салбарын аж ахуйн нэгж, байгууллага хамрагдсан учраас мэдээллийн нууцыг хангах үүднээс тайланд тусгаагүй болно.

### XV.1.1. Ойн аж ахуй эрхэлдэг аж ахуйн нэгж, байгууллагын тоо

2021 онд улсын хэмжээнд ойн аж ахуйн үйл ажиллагаа эрхэлдэг 297 аж ахуйн нэгж, байгууллага бүртгэгдсэнээс 157 аж ахуйн нэгж, байгууллага үйл ажиллагаа явуулж, үлдсэн 140 нь үйл ажиллагаа явуулаагүй байна. 2011 онтой харьцуулахад ойн аж ахуй эрхэлдэг аж ахуйн нэгж, байгууллага 28.0 хувиар өссөн байна.

ХҮСНЭГТ XV.1. АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГЫН ТОО, бүсээр

| | Бүгд | | Баруун бүс | | Хангайн бүс | | Төвийн бүс | | Зүүн бүс | | Улаанбаатар | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | 2011 | 2021 | 2011 | 2021 | 2011 | 2021 | 2011 | 2021 | 2011 | 2021 | 2011 | 2021 |
| **Бүгд** | **232** | **297** | **28** | **55** | **33** | **99** | **102** | **92** | **5** | **16** | **64** | **35** |
| Үйл ажиллагаа явуулсан | 202 | 157 | 26 | 27 | 31 | 63 | 96 | 47 | 5 | 8 | 44 | 12 |
| Үйл ажиллагаа явуулаагүй | 30 | 140 | 2 | 28 | 2 | 36 | 6 | 45 | 0 | 8 | 20 | 23 |

Үйл ажиллагаа явуулсан аж ахуйн нэгж, байгууллагыг бүсээр авч үзвэл 17.2 хувь нь Баруун бүсэд, 40.1 хувь нь Хангайн бүсэд, 29.9 хувь нь Төвийн бүсэд, 5.1 хувь нь Зүүн бүсэд, 7.6 хувь нь Улаанбаатар хотод байна.

ХҮСНЭГТ XV.2 ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛААГҮЙ ШАЛТГААН, бүсээр

| | Бүгд | Баруун бүс | Хангайн бүс | Төвийн бүс | Зүүн бүс | Улаанбаатар |
|---|---|---|---|---|---|---|
| ААНБ-ын тоо | 140 | 28 | 36 | 45 | 8 | 23 |
| Бусад ААНБ-тай нэгдсэн | 5 | 2 | - | 3 | - | - |
| Үйл ажиллагааны чиглэлээ өөрчилсөн цөөн | 33 | 9 | 10 | 8 | - | 6 |
| Хөрөнгө санхүүгийн дутагдлаас | 19 | 3 | 6 | 6 | 2 | 2 |
| Зах зээл борлуулалтгүйгээс | 14 | 8 | 1 | 3 | - | 2 |
| Түймрийн аюултай улиралд мод бэлтгэх зөвшөөрөл өгөөгүй | 8 | 2 | 4 | - | 1 | 1 |
| Модны хуваарь оройтож гарсан | 10 | - | 2 | 7 | - | 1 |
| Мод бэлтгэх квот хуваарилаагүй | 28 | 4 | 6 | 16 | - | 2 |
| Бусад | 65 | 10 | 15 | 15 | 6 | 19 |

2021 онд үйл ажиллагаа явуулаагүй аж ахуйн нэгж, байгууллагуудын 23.6 хувь нь үйл ажиллагааны чиглэлээ өөрчилж, 13.6 хувь нь хөрөнгө санхүүгийн дутагдлаас болж, 10.0 хувь нь зах зээл борлуулалтгүй байсан бол 46.4 хувь нь бусад шалтгаанаар үйл ажиллагаа явуулаагүй байна. Үүнд: Ковид-19 цар тахлын улмаас, мод бэлтгэл явуулах зөвшөөрөлгүй, мөн тусгай зөвшөөрлийн хугацаа дууссан зэрэг шалтгаанууд хамрагдаж байна.

### XV.1.2. Ойн аж аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага

2021 онд аж ахуйн нэгж, байгууллагуудын удирдлагын 67.3 хувь нь эрэгтэй, 32.7 хувь нь эмэгтэй байна. Удирдлагын хүйсийн бүтцийг харахад эрэгтэйчүүд давамгайлах хандлага хэвээр хадгалагдаж байна.

ХҮСНЭГТ XV.3. АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГЫН УДИРДЛАГЫН ТОО, хүйсээр, бүсээр

| | Бүгд | | Баруун бүс | | Хангайн бүс | | Төвийн бүс | | Зүүн бүс | | Улаанбаатар | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | 2011 | 2021 | 2011 | 2021 | 2011 | 2021 | 2011 | 2021 | 2011 | 2021 | 2011 | 2021 |
| Бүгд | 232 | 297 | 28 | 55 | 33 | 99 | 102 | 92 | 5 | 16 | 64 | 35 |
| Эрэгтэй | 148 | 200 | 18 | 45 | 20 | 67 | 66 | 53 | 3 | 13 | 41 | 22 |
| Эмэгтэй | 84 | 97 | 10 | 10 | 13 | 32 | 36 | 39 | 2 | 3 | 23 | 13 |

### XV.1.3. Үйл ажиллагааны талаарх мэдээлэл

Ойн аж ахуйн салбарт үйл ажиллагаа явуулсан ААНБ-уудад нийт 2.4 мянган ажиллагчид ажиллаж байгаа нь 2011 оны тооллогын дүнгээс 3.3 хувиар буурсан байна. Ойн аж ахуйн салбарт үйл ажиллагаа явуулсан ААНБ-ын нийт ажиллагчдын 28.7 хувь нь эмэгтэй ажиллагчид байна.

ХҮСНЭГТ XV.4. ОЙН АЖ АХУЙН САЛБАРТ АЖИЛЛАГЧИД, хүйсээр, бүсээр

| | Бүгд | | Баруун бүс | | Хангайн бүс | | Төвийн бүс | | Зүүн бүс | | Улаанбаа-тар | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | 2011 | 2021 | 2011 | 2021 | 2011 | 2021 | 2011 | 2021 | 2011 | 2021 | 2011 | 2021 |
| ААНБ-ын тоо | 202 | 157 | 26 | 27 | 31 | 63 | 96 | 47 | 5 | 8 | 44 | 12 |
| Ажиллагчдын тоо | 2 456 | 2 375 | 185 | 327 | 279 | 946 | 1 579 | 707 | 29 | 118 | 384 | 277 |
| Эмэгтэй ажиллагчид | 912 | 491 | 80 | 80 | 117 | 176 | 598 | 125 | 10 | 18 | 107 | 92 |

Ажиллагчдын тоог бүсээр авч 39.8 хувь нь Хангайн бүсэд, үлдсэн нь Баруун, Төвийн, Зүүн бүс болон Улаанбаатар хотод ажиллаж байна.

Ойн аж ахуйн үйл ажиллагаа эрхлэлтэд ойн арчилгаа, цэвэрлэгээ, ойжуулалт, мод үржүүлэг, ойн дагалт баялаг түүх, бусад чиглэлийн үйл ажиллагааг авч үзэхэд үйл ажиллагаа явуулсан ААНБ-ын дийлэнх нь дээрх чиглэлийн үйл ажиллагааг хослуулан ажилладаг бөгөөд дийлэнхдээ (75.8%) ойн дагалт баялаг түүх, бусад чиглэлийн үйл ажиллагааг эрхэлж, мод үржүүлэг, ойжуулалтын чиглэлээр 53.5 хувь, ойн арчилгаа, цэвэрлэгээний ажлын чиглэлээр 48.4 хувь нь ажилдаг байна.

Улсын хэмжээнд 2021 онд ойн аж ахуйн салбарт үйл ажиллагаа явуулсан нийт ААНБ-аас 70.1 хувь нь буюу 110 ААНБ-д 70.9 мян.м3 мод бэлтгэсэн байна. 2011 онтой харьцуулахад мод бэлтгэсэн аж ахуйн нэгж, байгууллагын тоо 59.4 хувиар, бэлтгэсэн модны хэмжээ 38.0 хувиар тус тус өсжээ.

## ХҮСНЭГТ XV.5 МОД БЭЛТГЭЛТ, бүсээр

| | Бүгд | | Баруун бүс | | Хангайн бүс | | Төвийн бүс | | Зүүн бүс | | Улаанбаатар | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | 2011 | 2021 | 2011 | 2021 | 2011 | 2021 | 2011 | 2021 | 2011 | 2021 | 2011 | 2021 |
| **Бүгд** | **202** | **157** | **26** | **27** | **31** | **63** | **96** | **47** | **5** | **8** | **44** | **12** |
| Мод бэлтгэсэн ААНБ-ын тоо | 69 | 110 | 1 | 19 | 10 | 56 | 56 | 31 | 2 | 4 | - | - |
| Бэлтгэсэн модны хэмжээ, м^3 | 51 399 | 70 922 | 800 | 6 555 | 3 745 | 30 877 | 36 714 | 25 051 | 10 140 | 8 439 | - | - |

Мод бэлтгэсэн ААНБ-ын дийлэнх нь Хангайн бүсийнх бөгөөд нийт бэлтгэсэн модны 43.5 хувийг бэлтгэсэн байна.

## ХҮСНЭГТ XV.6. БЭЛТГЭСЭН МОД СӨӨГНИЙ ҮРИЙН ХЭМЖЭЭ, бүсээр

| | Бүгд | | Баруун бүс | | Хангайн бүс | | Төвийн бүс | | Зүүн бүс | | Улаанбаатар | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | 2011 | 2021 | 2011 | 2021 | 2011 | 2021 | 2011 | 2021 | 2011 | 2021 | 2011 | 2021 |
| Мод сөөгний үр бэлтгэсэн ААНБ-ын тоо | 106 | 69 | 15 | 2 | 19 | 36 | 51 | 26 | 3 | 3 | 18 | 2 |
| Бэлтгэсэн үрийн хэмжээ, бүгд, кг | 15 374.9 | 8 024.2 | 1 954.0 | 0.5 | 3 069.6 | 3 515.7 | 7 638.6 | 4 472.0 | 54.0 | 20.0 | 2 658.7 | 16.0 |
| Нарс | 3 064.4 | 1 120.7 | 500.0 | - | 673.8 | 6.7 | 1 846.6 | 1 099.0 | 24.0 | 15.0 | 20.0 | - |
| Шинэс | 2 860.4 | 3 132.0 | 518.0 | - | 521.0 | 1 311.0 | 1 733.4 | 1 805.0 | - | - | 88.0 | 16.0 |
| Хайлаас | 1 101.1 | 345.0 | 76.0 | - | 457.3 | 315.0 | 220.8 | 30.0 | - | - | 347.0 | - |
| Улиас | 4 032.0 | 118.0 | 500.0 | - | 574.0 | 113.0 | 1 715.0 | 5.0 | - | - | 1 243.0 | - |
| Шар хуайс | 1 536.7 | 1 290.5 | 56.0 | 0.5 | 689.0 | 235.0 | 654.0 | 1 055.0 | - | - | 137.7 | - |
| Бусад | 2 780.3 | 2 018.0 | 304.0 | - | 154.5 | 1 535.0 | 1 468.8 | 478.0 | 30.0 | 5.0 | 823.0 | - |

2021 онд ойн аж ахуйн салбарын аж ахуйн нэгж, байгууллагуудаас 43.9 хувь нь мод сөөгний үр бэлтгэсэн бөгөөд ихэвчлэн шинэс, нарс, улиасны үрийг бэлтгэсэн байна.

## ХҮСНЭГТ XV.7. ТАРЬЦ, СУУЛГАЦЫН ХЭМЖЭЭ, бүсээр

| | Бүгд | | Баруун бүс | | Хангайн бүс | | Төвийн бүс | | Зүүн бүс | | Улаанбаатар | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | 2011 | 2021 | 2011 | 2021 | 2011 | 2021 | 2011 | 2021 | 2011 | 2021 | 2011 | 2021 |
| Тарьцны тоо, бүгд, мян.ш | 5 088.0 | 1 454.6 | 113.0 | 11.0 | 338.7 | 296.7 | 3 136.8 | 790.5 | 11.1 | 149.8 | 1 488.4 | 206.6 |
| Нарс | 3 150.4 | 317.1 | - | 0.0 | 211.8 | 25.2 | 2 435.3 | 261.9 | 2.1 | 20.0 | 501.2 | 10.0 |
| Шинэс | 585.6 | 574.2 | 25.0 | 0.0 | 81.1 | 186.3 | 413.5 | 337.9 | 9.0 | 50.0 | 57.0 | 0.0 |
| Хайлаас | 1 070.1 | 231.6 | 40.0 | 0.6 | 9.2 | 28.0 | 174.7 | 99.0 | - | 59.0 | 846.2 | 45.0 |
| Улиас | 86.3 | 39.3 | 13.0 | 0.0 | 28.1 | 8.3 | 30.0 | 20.3 | - | 0.8 | 15.2 | 10.0 |
| Шар хуайс | 101.2 | 38.5 | 17.0 | 10.4 | 4.2 | 24.2 | 38.8 | 3.9 | - | 0.0 | 41.2 | 0.0 |
| Бусад | 94.4 | 254.0 | 18.0 | 0.1 | 4.3 | 24.8 | 44.5 | 67.5 | - | 20.0 | 27.6 | 141.6 |

| | Бүгд | | Баруун бүс | | Хангайн бүс | | Төвийн бүс | | Зүүн бүс | | Улаанбаатар | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | 2011 | 2021 | 2011 | 2021 | 2011 | 2021 | 2011 | 2021 | 2011 | 2021 | 2011 | 2021 |
| Суулгацын тоо, бүгд, мян.ш | 4 741.3 | 1 395.2 | 399.5 | 71.5 | 315.4 | 285.8 | 3 548.6 | 751.1 | 0.2 | 77.2 | 477.6 | 209.7 |
| Нарс | 3 453.7 | 264.4 | - | - | 191.7 | 8.7 | 3 257.0 | 235.7 | - | 18.0 | 5.0 | 2.0 |
| Шинэс | 171.1 | 619.8 | 24.5 | - | 76.0 | 204.1 | 55.0 | 351.7 | - | 59.0 | 15.6 | 5.0 |
| Хайлаас | 543.6 | 174.5 | 124.0 | 2.5 | 5.9 | 33.0 | 144.5 | 99.0 | - | 0.0 | 269.2 | 40.0 |
| Улиас | 238.2 | 56.7 | 137.5 | 35.0 | 27.4 | 8.6 | 30.0 | .2 | - | 0.2 | 43.3 | 12.7 |
| Шар хуайс | 219.8 | 29.1 | 108.5 | 3.9 | 9.4 | 21.2 | 40.1 | 4.0 | - | 0.0 | 61.8 | 0.0 |
| Бусад | 114.9 | 250.7 | 5.0 | 30.0 | 5.0 | 10.2 | 22.0 | 60.5 | 0.2 | 0.0 | 82.7 | 150.0 |

2021 онд тарьц 1454.5 мянган ширхэг байгаа бөгөөд ихэвчлэн шинэс, хайлаасны тарьц болон суулгац тарьж, суулгасан байна. Бүсээр авч үзвэл, Зүүн бүсээс бусад бүс тарьц болон, суулгацыг багагүй хэмжээгээр тарьж, суулгажээ.

## ОЙН АЖ АХУЙН ГАРАЛТАЙ БҮТЭЭГДЭХҮҮНИЙ БОРЛУУЛАЛТ

Ойн аж ахуйн салбарын мод, суулгац тарьсан, үр, тарьц суулгасан, ойн дагалт бүтээгдэхүүн түүсэн зэрэг үйл ажиллагааны бүтээгдэхүүнийг зах зээлд хэрхэн борлуулж байгаа талаар судаллаа. ААНБ-ын бүтээгдэхүүний борлуулдаг хэлбэрүүдийг олон сонголттойгоор асууж, үр дүнг нэгтгэлээ.

ААНБ-ын бүтээгдэхүүнээ өөрсдөө ирж авдаг гэдэгт түүхий эдийн ченжүүд болон хувь хүнд борлуулсан бол "Хувь хүн ирж авдаг", мод, самар, жимс бэлтгэдэг компанийн төлөөлөгч өрх, хувь хүн, хоршоо зэрэгт борлуулсан бол "Аж ахуйн нэгж, байгууллагад", сум, аймгийн төв зэрэг төвлөрсөн хот сууринд өөрсдөө хүргэж борлуулсан бол "Зах зээлд өөрсдөө" гэж ангилж үзсэн. Харин дээрх гурваас бусад байдлаар бүтээгдэхүүнээ борлуулсан бол бусад гэсэн ангилалд оруулсан болно.

Бүтээгдэхүүнээ зах зээлд өөрсдөө борлуулдаг аж ахуйн нэгж, байгууллага олон байгаа бол хувь хүнд болон аж ахуйн нэгж, байгууллагад борлуулдаг аж ахуйн нэгж, байгууллага цөөнгүй байна.

ХҮСНЭГТ XV.8. БҮТЭЭГДЭХҮҮНЭЭ БОРЛУУЛДАГ ХЭЛБЭР, бүсээр

| | Хувь хүн ирж авдаг | | Аж ахуйн нэгж, байгууллагад | | Зах зээлд өөрсдөө нийлүүлдэг | | Бусад | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | 2011 | 2021 | 2011 | 2021 | 2011 | 2021 | 2011 | 2021 |
| Бүгд | 36.1 | 50.4 | 34.2 | 15.1 | 55.0 | 63.9 | 19.8 | 35.3 |
| Баруун бүс | 65.4 | 80.0 | 53.8 | - | 65.4 | 10.0 | 15.4 | 40.0 |
| Хангайн бүс | 45.2 | 49.1 | 45.2 | 17.5 | 54.8 | 71.9 | 19.4 | 38.6 |
| Төвийн бүс | 32.3 | 36.4 | 26.0 | 18.2 | 62.5 | 78.8 | 18.8 | 30.3 |
| Зүүн бүс | 20.0 | 33.3 | 60.0 | - | 20.0 | 66.7 | 20.0 | 33.3 |
| Улаанбаатар | 22.7 | 66.7 | 29.5 | 66.7 | 36.4 | 100.0 | 25.0 | - |

Улаанбаатарт үйл ажиллагаа явуулдаг газрууд дээрх 3н төрлөөр аль алинаар нь борлуулалт хийдэг хандлагатай байхад Зүүн бүс, Баруун бүсийн ААНБ-ын зах

зээлээс хувь хүмүүст шууд борлуулдаг эсвэл өөрсдөө зах зээлд нийлүүлэх байдал элбэг байна.

Түүнчлэн, ААНБ-ын бүтээгдэхүүнээ борлуулахад гардаг хүндрэлүүдийг судалж үзэхэд нийт ойн салбарын ААНБ-ын 28.6 хувьд ямар нэгэн хүндрэл гардаггүй гэсэн байна. Хамгийн их хүндрэлтэй байдаг зүйл нь зах зээлээс алслагдмал, хэрэглэгч цөөн, бүтээгдэхүүн хадгалах зоорь, агуулах дутагдалтай гэсэн байна. Түүнчлэн өсөлдөгч, хэрэглэгч цөөн байдаг тул хэрэглэгчтэйгээ харилцан тохиролцож, зах зээлийн ханшийн дагуу үнээ тогтоодог байдал элбэг байдаг байна.

ОЙН АЖ АХУЙН САЛБАРЫН ААНБ-ЫН ОРЛОГО, ЗАРДАЛ

Ойн аж ахуйн салбарын нийт орлого 19.637 сая.төг байгаа ба үүнийг бүсээр авч үзвэл, Төвийн бүсийн ААНБ нийт орлогын 33.6 хувийг бүрдүүлжээ.

ХҮСНЭГТ XV.9. ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГО, ЗАРДАЛ, зардлын төрлөөр

| | Бүгд | | Зардалд эзлэх хувь | |
|---|---|---|---|---|
| | 2011 | 2021 | 2011 | 2021 |
| Нийт орлого | 3 516.4 | 19 637.5 | | |
| Нийт зардал | 2 958.8 | 9 236.1 | 100.0 | 100.0 |
| Ажиллагчдын нийгмийн даатгал, эрүүл мэндийн даатгалын зардал | - | 285.2 | - | 3.1 |
| Байгаль орчныг нөхөн сэргээхтэй холбогдсон зардал | 206.9 | 699.7 | 7.0 | 7.6 |
| Барилга, байшин түрээсэлсний зардал | - | 86.4 | - | .9 |
| Газар эзэмшигчид төлсөн төлбөр, татаас | 44.4 | 216.5 | 1.5 | 2.3 |
| Зээлийн хүүгийн зардал | - | 260.9 | - | 2.8 |
| Машин, тоног төхөөрөмж түрээсэлсний зардал | - | 119.1 | - | 1.3 |
| Сэлбэг, хэрэгсэл | 369.1 | 794.6 | 12.5 | 8.6 |
| Тээврийн зардал | 205.3 | 860.8 | 6.9 | 9.3 |
| Түүхий эд, материал | - | 1 067.8 | - | 11.6 |
| Хөдөлмөр хамгааллын зардал | - | 482.0 | - | 5.2 |
| Цалин хөлс | 746.7 | 1 771.8 | 25.2 | 19.2 |
| Цахилгаан эрчим хүч, дулаан | - | 485.6 | - | 5.3 |
| Шатахуун, шатах тослох материал | 692.3 | 1 824.5 | 23.4 | 19.8 |
| Бусад | 694.1 | 281.1 | 23.5 | 3.0 |

2011 оны тооллогын дүнгээр ойн аж ахуйн салбарын нийт зардлын 23.4 хувийг түлш, шатахууны, 25.2 хувийг цалингийн зардал эзэлж байсан бол энэ удаагийн тооллогоор нийт зардлын 19.8 хувийг түлш, шатахууны, 19.2 хувийг цалингийн зардал, түхийн эд, материалын зардал 11.6 хувийг эзэлж байна.

## XV.1.4. Ой, загасны аж ахуй, ан агнуурын үйл ажиллагаа эрхэлдэг өрх

Ой, загасны аж ахуй, ан агнуурын үйл ажиллагааг туслах үйл ажиллагаа хэлбэрээр давхар эрхэлдэг Мал аж ахуй, газар тариалан эрхэлдэг өрхүүдийн талаарх мэдээллийг нэгтгэж, энэ дэд бүлэгт тусгалаа.

ОЙН АЖ АХУЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЭЛДЭГ ӨРХ

Ойн аж ахуйн үйл ажиллагаа эрхэлдэг нийт өрхийн 42.0 хувь буюу 10.7 мянган өрх мод бэлтгэснээс 9.8 мянган өрх буюу 91.3 хувь нь түлээний зориулалтаар мод бэлтгэсэн байна. Түлээний зориулалтаар мод бэлтгэсэн өрхийг бүсээр авч үзвэл 6.1 мянган өрх буюу 62.9 хувь нь Хангайн бүсийн өрхүүд байна. Мөн бэлтгэсэн модыг зориулалтаар нь 2011 оны тооллогын дүнтэй харьцуулбал түлээний зориулалтаар бэлтгэсэн мод 84.5 хувиар, хэрэглээний зориулалтаар бэлтгэсэн мод 22.5 хувиар буурсан байна.

ХҮСНЭГТ XV.10. МОД БЭЛТГЭСЭН ӨРХИЙН ТОО, зориулалтаар, бүсээр

| | Бүгд | Баруун бүс | Хангайн бүс | Төвийн бүс | Зүүн бүс | Улаанбаатар |
|---|---|---|---|---|---|---|
| Бүгд | 25 479 | 5 622 | 11 523 | 5 267 | 2 000 | 1 066 |
| Мод бэлтгэсэн өрхийн тоо | 10 692 | 2 153 | 6 954 | 1 329 | 211 | 45 |
| Зориулалт | | | | | | |
| Түлээний | 9 767 | 2 125 | 6 140 | 1 271 | 198 | 33 |
| Хэрэглээний | 1 141 | 46 | 905 | 117 | 61 | 12 |
| Зүсмэл материал | 83 | 15 | 44 | 19 | 5 | - |
| Бусад | 22 | 9 | 9 | 4 | - | - |

Зарим өрх ойгоос мод түлээ бэлтгэхийн зэрэгцээ мод, сөөгний үр бэлтгэх ажлыг эрхэлсэн байна. Мод, сөөгний үр бэлтгэсэн өрхийн хувьд 358 буюу 67.4 хувь нь Хангайн болон Төвийн бүсийнх байна. Бэлтгэсэн мод, сөөгний үрийг нэр төрлөөр нь авч үзвэл нийт бэлтгэсэн үрийн 64.4 хувийг хайлаас, улиасны үр эзэлж байна.

ХҮСНЭГТ XV.11. МОД, СӨӨГНИЙ ҮР БЭЛТГЭСЭН ӨРХИЙН ТОО, мод, сөөгний төрлөөр, бүсээр

| | Бүгд | Баруун бүс | Хангайн бүс | Төвийн бүс | Зүүн бүс | Улаанбаатар |
|---|---|---|---|---|---|---|
| Мод, сөөгний үр бэлтгэсэн өрхийн тоо | 532 | 56 | 177 | 181 | 50 | 67 |
| Бэлтгэсэн мод сөөгний үрийн хэмжээ, кг | | | | | | |
| Нарс | 717 | - | - | 483 | 36 | 198 |
| Шинэс | 1 944 | 79 | 1 766 | 49 | 50 | - |
| Хайлаас | 9 670 | - | 5 057 | 4 502 | 2 | 109 |
| Улиас | 11 187 | 6 103 | 62 | 4 180 | - | 841 |
| Шар хуайс | 3 328 | - | 95 | 3 016 | - | 217 |
| Бусад | 5 524 | 22 | 511 | 4 105 | 606 | 280 |

Мод үржүүлгийн газар болон тарьц суулгацын хүлэмжтэй өрхүүд ихэвчлэн шинэс, улиас, нарсны тарьцыг харин хайлаас, нарс, улиасны суулгацыг ургуулж, хөрсөнд суулган, үндэслүүлсэн байна.

## ХҮСНЭГТ XV.12. МОД УРЖУУЛГИЙН ГАЗАР БОЛОН ТАРЬЦ, СУУЛГАЦЫН ХҮЛЭМЖТЭЙ ӨРХИЙН ТОО, тарьц, суулгацын тоо, бүсээр

| | Бүгд | Баруун бүс | Хангайн бүс | Төвийн бүс | Зүүн бүс | Улаанбаатар |
|---|---|---|---|---|---|---|
| Мод уржуулгийн газар болон тарьц, суулгацын хүлэмжтэй өрхийн тоо | 420 | 96 | 102 | 129 | 47 | 45 |
| Тарьцны тоо, бүгд, ш | | | | | | |
| Нарс | 5 844 | - | - | 2 714 | 3 053 | 77 |
| Шинэс | 3 365 | - | 1 193 | 1 472 | 700 | - |
| Хайлаас | 15 584 | 1 841 | 3 159 | 6 351 | 722 | 3 511 |
| Улиас | 8 997 | 3 909 | 1 535 | 2 030 | - | 1 523 |
| Шар хуайс | 6 483 | 300 | 3 287 | 842 | - | 2 054 |
| Бусад | 38 300 | 11 069 | 8 865 | 10 394 | 1 608 | 6 364 |
| Суулгацын тоо, бүгд, ш | | | | | | |
| Нарс | 3 545 | - | - | 2 514 | 954 | 77 |
| Шинэс | 1 966 | - | 893 | 973 | 100 | - |
| Хайлаас | 18 224 | 2 574 | 5 073 | 6 750 | 722 | 3 105 |
| Улиас | 8 671 | 3 851 | 1 664 | 1 633 | - | 1 523 |
| Шар хуайс | 6 645 | 300 | 3 449 | 842 | - | 2 054 |
| Бусад | 35 195 | 10 334 | 8 173 | 9 290 | 1 056 | 6 342 |

Нэг өрх дунджаар 41 мод тарьж, суулгасан бол арван жилийн өмнө нэг өрх дунджаар 150 мод тарьж, суулгаж, Зүүн бүс болон Баруун бүсийн 1 өрх улсын дунджаас 35-81-ээр илүү харин бусад бүс, нийслэлд 22-46 цөөн мод тарьж, суулгасан байна.

## ХҮСНЭГТ XV.13. МОД ТАРЬСАН ӨРХИЙН ТОО

| | Бүгд | Баруун бүс | Хангайн бүс | Төвийн бүс | Зүүн бүс | Улаанбаатар |
|---|---|---|---|---|---|---|
| Мод тарьсан өрхийн тоо | 10 279 | 2 793 | 2 228 | 3 246 | 1 062 | 951 |
| Тарьсан мод, суулгацын тоо, ш | 443 349 | 119 154 | 87 189 | 171 897 | 29 517 | 35 591 |

2011 онд ойгоос дагалт баялаг ашигласан нийт өрхийн 3.0 мянга буюу 50.8 хувь нь Хангайн бүсийнх бөгөөд энэ бүсийн өрх ашигласан дагалт баялгийн 62.5 хувийг бүрдүүлж байна.

## ХҮСНЭГТ XV.14. ОЙГООС ДАГАЛТ БАЯЛАГ АШИГЛАСАН ӨРХИЙН ТОО, төрлөөр, бүсээр

| | Бүгд | Баруун бүс | Хангайн бүс | Төвийн бүс | Зүүн бүс | Улаанбаатар |
|---|---|---|---|---|---|---|
| Ойгоос дагалт баялаг ашигласан өрхийн тоо | 1 601 | 495 | 771 | 190 | 140 | 5 |
| Ашигласан дагалт баялгийн хэмжээ, кг | | | | | | |
| Самар | 41 241.1 | 538.1 | 14 986.8 | 21 244.0 | 4 468.5 | 3.8 |
| Жимс | 120 301.3 | 15 085.7 | 97 665.4 | 5 847.3 | 1 699.3 | 3.8 |
| Мөөг | 303.1 | 18.2 | 283.0 | 2.0 | - | - |
| Ойн хөвд | 72.5 | - | 72.5 | - | - | - |
| Эмийн ургамал | 410.2 | 66.6 | 206.5 | 110.3 | 26.9 | - |
| Бусад | 29 745.5 | 21 533.2 | 763.5 | 3 138.9 | 4 309.9 | - |

Харин 2021 онд ойгоос дагалт баялаг ашигласан нийт өрхийн 0.8 мянга буюу 48.2 хувь нь Хангайн бүсийнх бөгөөд энэ бүсийн өрх ашигласан дагалт баялгийн 59.3 хувийг бүрдүүлж байна. Ойн хөвдийг Хангай бүсийн өрх ашигласан бол бусад төрлийн дагалт баялгийг бүх бүсэд ашиглаж байсан бол арван жилийн өмнө Ойн хөвдийг Хангай, Төв болон Зүүн бүсийн өрх ашиглаж байсан байна.

## XV.2. АН АГНУУРЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЭЛСЭН ӨРХ

2021 оны байдлаар 1.2 мянган өрх 2.6 мянган ан амьтан агнажээ. Ан агнасан өрхийн дийлэнх нь буюу 39.2 хувь нь Хангайн бүсийнх өрхүүд байна. Агнуурын зориулалтыг авч үзвэл дийлэнх нь ахуйн зориулалтаар, цөөн хэдэн өрх үйлдвэрлэлийн болон тусгай зориулалтаар ан агнасан байна.

ХҮСНЭГТ XV.15. АН АГНАСАН ӨРХИЙН ТОО, зориулалтаар, бүсээр

| | Бүгд | Баруун бүс | Хангайн бүс | Төвийн бүс | Зүүн бүс | Улаанбаатар |
|---|---|---|---|---|---|---|
| Бүгд | 1 183 | 627 | 345 | 93 | 108 | 11 |
| Ан агнасан өрхийн тоо | 382 | 115 | 150 | 36 | 82 | - |
| Зориулалт | | | | | | |
| Ахуйн | 381 | 114 | 150 | 36 | 82 | |
| Үйлдвэрлэлийн | 10 | 1 | - | - | 9 | - |
| Тусгай | 1 | 1 | - | - | - | - |

Өрхийн агнасан анг төрлөөр авч үзвэл, цагаан зээр, тарвага, чоно агнаж, амьдрал ахуйдаа ихэвчлэн хэрэглэсэн байна.

ХҮСНЭГТ XV.16. АН АГНАСАН ӨРХИЙН ТОО, агнасан ангаар, бүсээр

| | Бүгд | Баруун бүс | Хангайн бүс | Төвийн бүс | Зүүн бүс | Улаанбаатар |
|---|---|---|---|---|---|---|
| Зэрлэг гахай | 27 | - | 13 | 9 | 5 | - |
| Шар үнэг | 45 | 24 | 4 | 2 | 15 | - |
| Чоно | 756 | 563 | 135 | 20 | 38 | - |
| Тарвага | 1 501 | 661 | 402 | 403 | 35 | - |
| Хярс | 39 | 8 | 8 | - | 23 | - |
| Цагаан зээр | 173 | - | 1 | - | 172 | - |
| Бор гөрөөс | 44 | - | 39 | - | 5 | - |
| Буга | 2 | 2 | - | - | - | - |
| Бусад | 10 | - | 10 | - | - | - |

Ан агнасан нийт өрхийн 70 буюу 18.3 хувь нь агнасан ангаа борлуулсан бөгөөд борлуулалтын нийт орлого нь 101.8 сая төгрөг байсан бол арван жилийн өмнө нийт орлого нь 75.0 сая төгрөг байжээ. Харин ан агнахад гаргасан нийт зардал нь 44.3 сая төгрөг байсан бол 2021 онд 94.1 сая төгрөг бөгөөд нийт зардлын ихэнхийг ангийн хэрэгсэл, сэлбэг, сум, түлшний зардалд гаргажээ.

ХҮСНЭГТ XV.17. АН АГНАСАН ӨРХИЙН ЗАРЛАГА, зардлын төрлөөр

| | Бүгд | Зардалд эзлэх хувь |
|---|---|---|
| **Нийт зардал, сая төг** | **94.1** | **100.0** |
| Шатахуун, шатах тослох материал | 27.1 | 28.8 |
| Тээврийн зардал | 9.4 | 10.0 |
| Хөдөлмөр хамгааллын зардал | 0.1 | 0.1 |

| | | |
|---|---|---|
| Ангийн хэрэгсэл, буу | 10.8 | 11.4 |
| Сумны зардал (бууны) | 46.5 | 49.4 |
| Ан, амьтны нөөц ашигласны төлбөр | 0.2 | 0.2 |

## XV.3. ЗАГАСНЫ АЖ АХУЙ ЭРХЭЛСЭН ӨРХ

2011 онд МАА эрхэлдэг 220 өрх загасны аж ахуйн эрхэлж байсан бол 2021 онд 156 өрх загасны аж ахуйн эрхэлжээ. Тэдгээр өрхийн 64 буюу 40.7 хувь нь Хангайн бүсийнх ба нийт барьсан загасны 29.0 хувь нь энэ бүсэд ногдож байна. Харин 33.2 хувь буюу нийт барьсан загасны дийлэнх хувийг Зүүн бүсэд ногдож байна.

Зориулалтаар нь авч үзвэл дийлэнх нь ахуйн зориулалтаар болон үйлдвэрлэлийн зориулалтаар Хангайн бүс, тусгай зориулалтаар Баруун бүсэд цөөн тооны өрх загас барьсан байна.

ХҮСНЭГТ XV.18. ЗАГАСНЫ АЖ АХУЙ ЭРХЭЛСЭН ӨРХИЙН ТОО, барьсан загасны хэмжээ, бүсээр

| | Бүгд | Баруун бүс | Хангайн бүс | Төвийн бүс | Зүүн бүс | Улаанбаатар |
|---|---|---|---|---|---|---|
| Бүгд | 3 216 | 1 149 | 991 | 737 | 286 | 53 |
| Загас барьсан өрхийн тоо | 156 | 28 | 64 | 41 | 23 | 1 |
| Барьсан загасны хэмжээ, кг | 2 888.3 | 608.7 | 837.7 | 471.7 | 960.2 | 10.0 |

ХҮСНЭГТ XV.19. ЗАГАСНЫ АЖ АХУЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЭЛСЭН ӨРХИЙН ЗАРЛАГА, зардлын төрлөөр

| | Бүгд | Зардалд эзлэх хувь |
|---|---|---|
| **Нийт зардал, мян.төг** | **30 793.9** | **100.0** |
| Тээврийн зардал | 26 099.8 | 84.8 |
| Хөдөлмөр хамгааллын зардал | 335.8 | 1.1 |
| Цахилгаан эрчим хүч, дулаан | 200.0 | 0.6 |
| Сэлбэг хэрэгсэл | 1 554.1 | 5.0 |
| Түүхий эд, материал | 2 080.0 | 6.8 |
| Машин, тоног төхөөрөмж түрээсэлсний зардал | 50.0 | 0.2 |
| Газар эзэмшигчид төлсөн төлбөр, татаас | 40.0 | 0.1 |
| Бусад | 434.2 | 1.4 |

Загасны аж ахуй эрхэлсэн нийт өрхийн 9.0 хувь нь барьсан загасаа борлуулж, 4.2 сая төгрөгийн орлого олжээ. Харин загасны аж ахуй эрхлэхэд нийт 30.8 сая төгрөгийн зардал гаргасны ихэнхийг байгалийн нөөц ашигласны төлбөр, түлш шатахуун болон загасны хэрэгслийн зардалд зарцуулжээ.

XVI
БҮЛЭГ

# СУМДЫН ЗАРИМ ҮЗҮҮЛЭЛТҮҮД

## ГАН, ЗУДАД ӨРТСӨН СУМЫН ТОО



# XVI. СУМЫН ЗАРИМ ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Тооллогын үзүүлэлтийн бүрэлдэхүүн хэсэгт Засаг захиргааны анхан шатны нэгжээс авах асуулга багтсан бөгөөд уг асуулгаар 2021 оны улсын хэмжээний бүх сумдыг хамруулж, судалгааг явуулсан.

Энэхүү судалгаа нь анхан шатны нэгжийн түвшин дэх газар зүй, байгаль орчин, нийгэм эдийн засгийн байдлыг тодорхойлж, тэдгээрийн хөгжилд нөлөө үзүүлж байгаа дэд бүтэц, үйлчилгээний салбарын хөгжил, байгалийн гамшигт өртсөн байдлыг цаг хугацааны дарааллаар гаргахад чиглэсэн юм.

## XVI.1. Газар зүй, байгаль орчин

### СУМДЫН БАЙРЛАЖ БУЙ БАЙГАЛИЙН БҮС

Монгол улсын байгалийн бүсийг тал хээрийн, ойт хээрийн, өндөр уулын, говийн (цөлийн, цөлөрхөг хээрийн) гэсэн 4 бүсэд хуваан, сум дотроо олон төрлийн хосолсон хөрс, ургамалжилттай сумдыг холимог гэж ангиллаа. Тооллогын үр дүнгээс харахад 10 жилийн өмнөх байгалийн ургамалжилт, хөрсний байдал өндөр уул, ойт хээр, тал хээр, говийн дагнасан байдал холимог, өөрчлөгдөж байгаа байдал ажиглагдаж байна.

Нийт сумдаас ойт хээрийн бүс 63 сум буюу 19.1 хувь болж 2011 оноос 6 сум буюу 1.9 хувиар, Өндөр уулын бүс 40 сум буюу 12. хувь болж 2011 оноос 6 сум буюу 1.9 хувиар, Говийн бүс 22 сум буюу 6.7 хувь болж 2011 оноос 40 сум буюу 12.2 хувиар тус тус буурсан байна.

Харин 75 сум холимог байгалийн бүсийн ангилалд багтаж, хөрс, ургамалжилтын байдал өөрчлөгдсөн ба 2011 оноос 3 дахин нэмэгдсэн байна.

ХҮСНЭГТ XVI.1. СУМДЫН ТОО, байгалийн бүс, бүсээр

| | Бүгд | | Баруун бүс | | Хангайн бүс | | Төвийн бүс | | Зүүн бүс | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | 2011 | 2021 | 2011 | 2021 | 2011 | 2021 | 2011 | 2021 | 2011 | 2021 |
| **Бүгд** | **329** | **330** | **91** | **91** | **99** | **99** | **95** | **95** | **44** | **45** |
| Тал хээр | 127 | 130 | 23 | 16 | 29 | 30 | 39 | 50 | 36 | 34 |
| Ойт хээр | 69 | 63 | 8 | 11 | 36 | 29 | 19 | 15 | 6 | 8 |
| Өндөр уул | 46 | 40 | 28 | 31 | 17 | 8 | 1 | 1 | 0 | 0 |
| Говь | 62 | 22 | 20 | 5 | 8 | 3 | 34 | 11 | 0 | 3 |
| Холимог | 25 | 75 | 12 | 28 | 9 | 29 | 2 | 18 | 2 | 0 |

### ГАЗРЫН ХӨРСНИЙ ТӨРӨЛ

Монгол улсын хөрсний төрлийг элсэрхэг, шаварлаг, хар шороон, хүрэн шороон гэсэн 4 төрөлд хувааж авч үзлээ.

ХҮСНЭГТ XVI.2. СУМДЫН ТОО, хөрсний төрөл, бүсээр

| | Бүгд | | Баруун бүс | | Хангайн бүс | | Төвийн бүс | | Зүүн бүс | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | 2011 | 2021 | 2011 | 2021 | 2011 | 2021 | 2011 | 2021 | 2011 | 2021 |
| **Бүгд** | **329** | **330** | **91** | **91** | **99** | **99** | **95** | **94** | **44** | **45** |
| Элсэрхэг | 74 | 73 | 26 | 26 | 16 | 21 | 27 | 22 | 5 | 4 |
| Шаварлаг | 21 | 26 | 7 | 7 | 4 | 5 | 9 | 9 | 1 | 5 |
| Хар шороон | 37 | 57 | 7 | 18 | 19 | 18 | 7 | 8 | 4 | 13 |
| Хүрэн шороон | 72 | 76 | 8 | 5 | 29 | 25 | 19 | 28 | 16 | 18 |
| Холимог | 125 | 98 | 43 | 35 | 31 | 30 | 33 | 28 | 18 | 5 |

Нийт сумдыг 2021 оны хөрсний төрлөөр авч үзвэл элсэрхэг хөрстэй сум 73 буюу 22.1 хувь болж 2011 оноос 0.4 хувиар, холимог хөрстэй сум 98 буюу 29.7 хувь болж 2011 оноос 8.3 хувиар тус тус буурсан байна. Харин 26 сум буюу 7.9 хувь нь шаварлаг, 57 буюу 17.3 хувь нь хар шороон, 76 сум буюу 23.0 хувь нь хүрэн шороон хөрстэй байна.

## XVI.2. Нийгэм эдийн засгийн байдал

### ӨРХИЙН ТОО

Улсын хэмжээнд 2021 оны жилийн эцэст 920.2 мянган өрх байгаагаас 507.6 мянган өрх аймаг, орон нутагт буюу сумдад амьдарч байна. 2011 онтой харьцуулахад нийт өрхийн тоо 21.1 хувиар, орон нутагт амьдарч байгаа өрхийн тоо 12.0 хувиар өссөн байна. Нийт орон нутагт амьдарч байгаа өрхүүдийн 34.9 хувь нь Хангайн бүсэд, 30.0 хувь нь Төвийн бүсэд, 21.6 хувь нь Баруун бүсэд, 13.5 хувь нь Зүүн бүсэд амьдарч байгаа ба сүүлийн 10 жилд Улаанбаатар луу шилжих өрхүүд бүсүүдийн хувьд жигд байна.

ХҮСНЭГТ XVI.3. ӨРХИЙН ТОО, бүсээр, мянган өрх

| | Бүгд | | Баруун бүс | | Хангайн бүс | | Төвийн бүс | | Зүүн бүс | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | 2011 | 2021 | 2011 | 2021 | 2011 | 2021 | 2011 | 2021 | 2011 | 2021 |
| Өрхийн тоо, бүгд | 453. 1 | 507.6 | 96.8 | 109.4 | 160.2 | 177.1 | 137.1 | 152.4 | 59.0 | 68.7 |
| Өрхийн бүсэд эзлэх хувь | 100.0 | 100.0 | 21.4 | 21.6 | 35.3 | 34.9 | 30.3 | 30.0 | 13.0 | 13.5 |

Өрхийн тоог аймгаар авч үзвэл Дорнод, Хэнтий, Баян-Өлгий, Баянхонгор, Архангай, Төв, Орхон, Дархан-Уул, Сэлэнгэ, Өвөрхангай, Хөвсгөл аймгуудад хамгийн олон буюу 24.7-39.7 мян.өрх бүртгэлтэй байгаа нь нийт өрхийн 63.3 хувийг эзэлж, Говьсүмбэр, Дундговь, Говь-Алтай, Сүхбаатар, Булган, Дорноговь, Завхан, Увс, Өмнөговь, Ховд аймгуудад хамгийн бага буюу 5.3-23.3 мян.өрх ногдож, нийт өрхийн 36.7 хувийг эзэлж байна.

Нэг суманд ногдох дундаж өрхийн тоогоор Баянхонгор, Ховд, Хэнтий, Сүхбаатар, Архангай, Дорноговь, Өмнөговь, Хөвсгөл, Говьсүмбэр, Сэлэнгэ, Дорнод, Өвөрхангай, Баян-Өлгий, Дархан-Уул, Орхон, аймгууд 1.3-1.5 мян.өрхтэй тэргүүлж

байна. Завхан, Говь-Алтай, Дундговь, Төв, Увс, Булган аймгууд бага буюу 0.9-1.2 мян.өрхтэй байна.

## ЦАХИЛГААНЫ ЭХ ҮҮСВЭР

Нийт 330 сумаас 325 сум буюу 98.5 хувь нь төвлөрсөн цахилгаан хангамжид холбогдсон нь 2011 оноос 28 сум буюу 9.4 хувиар өссөн бол, үлдсэн 5 сум буюу 1.5 хувь нь холбогдоогүй байна.

ХҮСНЭГТ XVI.4. ЦАХИЛГААНЫ ЭХ ҮҮСВЭР, бүсээр

| | Бүгд | | Баруун бүс | | Хангайн бүс | | Төвийн бүс | | Зүүн бүс | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | 2011 | 2021 | 2011 | 2021 | 2011 | 2021 | 2011 | 2021 | 2011 | 2021 |
| **Бүгд** | **329** | **330** | **91** | **91** | **99** | **99** | **95** | **95** | **44** | **45** |
| Төвлөрсөн цахилгаан хангамжинд холбогдсон сумын тоо | 297 | 325 | 66 | 90 | 96 | 96 | 91 | 95 | 44 | 44 |

## СУМЫН ТӨВӨӨС АЙМГИЙН ТӨВД ХҮРЭХ ЗАМ

Сумаас төвлөрсөн хот, сууринд хүрэх замын төрлийг хатуу хучилттай /цемент, асфальт, хөнгөвчилсөн хар зам/, хайрган зам /засаж, сайжруулсан хөрсөн зам дээр хайрга, чулуу асгаж нягтруулсан/, сайжруулсан хөрсөн зам /энгийн хөрсөн замыг тэгшлэн, засаж, нягтруулсан/, энгийн шороон зам буюу ердийн хөрсөн зам / хээрийн зам/ гэсэн ангиллаар мэдээллийг цуглууллаа.

ХҮСНЭГТ XVI.5. СУМААС ТӨВЛӨРСӨН ХОТ, СУУРИН ХҮРЭХ ЗАМЫН ТӨРӨЛ, бүсээр

| | Бүгд | | Баруун бүс | | Хангайн бүс | | Төвийн бүс | | Зүүн бүс | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | 2011 | 2021 | 2011 | 2021 | 2011 | 2021 | 2011 | 2021 | 2011 | 2021 |
| **Бүгд** | **329** | **330** | **91** | **91** | **99** | **99** | **95** | **94** | **44** | **45** |
| Хатуу хучилттай | 37 | 109 | 5 | 25 | 10 | 27 | 19 | 44 | 3 | 13 |
| Хайрган | 4 | 8 | 1 | 2 | 1 | 4 | 2 | 1 | 0 | 1 |
| Сайжруулсан хөрсөн | 8 | 11 | 4 | 3 | 2 | 2 | 2 | 3 | 0 | 3 |
| Энгийн | 178 | 148 | 53 | 37 | 57 | 55 | 42 | 29 | 26 | 27 |
| Холимог | 102 | 54 | 28 | 24 | 29 | 11 | 30 | 18 | 15 | 1 |

Нийт сумдыг төвлөрсөн хот, сууринд хүрэх замыг замын төрлөөр авч үзвэл 109 сум буюу 33.0 хувь нь хатуу хучилттай, 8 сум буюу 2.4 хувь нь хайрган, 11 сум буюу 3.3 хувь нь сайжруулсан хөрсөн, 148 сум буюу 44. хувь нь энгийн, 54 сум буюу 16.4 хувь нь холимог замтай байна.

## СУМЫН ТӨВИЙН УСАН ХАНГАМЖ

Сумын усан хангамжийн байдлыг төвлөрсөн системд холбогдсон ус түгээх байр, хамгаалагдсан худаг, хамгаалагдсан булаг, шанд төвлөрсөн системд холбогдоогүй ус түгээх байр, хамгаалагдаагүй булаг, шанд, зөөврийн ус, гол, мөрөн, нуур, хамгаалагдаагүй худаг, булаг, шанд, задгай ус гэсэн ангиллаар авч үзсэн.

ХҮСНЭГТ XVI.6. СУМДЫН ТӨВИЙН УСАН ХАНГАМЖ, төрөл, бүсээр

| | Бүгд | | Баруун бүс | | Хангайн бүс | | Төвийн бүс | | Зүүн бүс | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | 2011 | 2021 | 2011 | 2021 | 2011 | 2021 | 2011 | 2021 | 2011 | 2021 |
| **Бүгд** | **329** | **330** | **91** | **91** | **99** | **99** | **95** | **95** | **44** | **45** |
| Төвлөрсөн системээр | 7 | 2 | 1 | 0 | 2 | 0 | 2 | 2 | 2 | 0 |
| Төвлөрсөн системд холбогдон ус түгээх байр | 8 | 0 | 1 | 0 | 4 | 0 | 3 | 0 | 0 | 0 |
| Хамгаалагдсан худаг | 86 | 9 | 23 | 0 | 21 | 0 | 29 | 9 | 13 | 0 |
| Хамгаалагдсан булаг, шанд | 3 | 0 | 0 | 0 | 1 | 0 | 1 | 0 | 1 | 0 |
| Төвлөрсөн системд холбогдоогүй ус түгээх байр | 2 | 0 | 0 | 0 | 2 | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| Зөөврийн ус | 11 | 2 | 1 | 0 | 5 | 0 | 3 | 2 | 2 | 0 |
| Гол, мөрөн, нуур, хамгаалагдаагүй булаг, шанд | 15 | 0 | 6 | 0 | 4 | 0 | 3 | 0 | 2 | 0 |
| Холимог | 197 | 317 | 59 | 91 | 60 | 99 | 54 | 82 | 24 | 45 |

Нийт сумдын сумын төвийн дийлэнх нь 317 буюу 96.1 хувь нь усан хангамжийн холимог байдлаар, 9 буюу 2.7 хувь нь хамгаалагдсан худгаар  2 буюу 1.2 хувь нь төвлөрсөн системээр болон зөөврийн эх үүсвэрээ хангаж байна. Эндээс харахад сүүлийн 10 жилд дан худгаас усан хангамжаа хангадаг сумдын тоо буурч, ямар нэгэн байдлаар төвлөрсөн систем, бусад эх үүсвэртэй хосолсон усан хангамжтай болсон харагдаж байгаа боловч, төвлөрсөн системд холбогдсон сумдын тоо өсөөгүй байна.

## ҮЙЛЧИЛГЭЭНИЙ САЛБАР

### БОЛОВСРОЛ, СОЁЛ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ БАЙГУУЛЛАГА

Сумдын иргэдэд үйлчилгээ үзүүлж байгаа боловсрол, соёл, үйлчилгээний байгууллагын тоог сургууль, эмнэлэг, цэцэрлэг, ахуй үйлчилгээний цэг, шуудан холбооны цэг, интернэтийн үйлчилгээний цэг, банкны салбар, хүнсний дэлгүүр, цэг, соёлын төв, эмийн сан, уул уурхайн нэгж гэсэн төрлүүдээр авч үзлээ.

## ХҮСНЭГТ XVI.7. СУМДЫН БОЛОВСРОЛ, СОЁЛ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ БАЙГУУЛЛАГЫН ТОО, бүсээр

| | Бүгд | | Баруун бүс | | Хангайн бүс | | Төвийн бүс | | Зүүн бүс | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | 2011 | 2021 | 2011 | 2021 | 2011 | 2021 | 2011 | 2021 | 2011 | 2021 |
| **Бүгд** | 12 155 | 17 487 | 3 336 | 5 299 | 3 939 | 5 379 | 3 537 | 4 619 | 1 343 | 2 190 |
| Сургууль | 560 | 832 | 153 | 169 | 176 | 179 | 167 | 415 | 64 | 69 |
| Эмнэлэг | 498 | 599 | 130 | 132 | 165 | 234 | 133 | 168 | 70 | 65 |
| Цэцэрлэг | 566 | 781 | 153 | 195 | 174 | 237 | 167 | 243 | 72 | 106 |
| Ахуйн үйлчилгээний цэг | 960 | 1 478 | 230 | 382 | 252 | 393 | 346 | 353 | 132 | 350 |
| Шуудан, холбооны цэг | 380 | 348 | 106 | 107 | 122 | 107 | 100 | 90 | 52 | 44 |
| Интернэтийн үйлчилгээний цэг | 352 | 255 | 59 | 89 | 128 | 58 | 120 | 82 | 45 | 26 |
| Банкны салбар | 834 | 857 | 213 | 227 | 234 | 239 | 276 | 276 | 111 | 115 |
| Хүнсний дэлгүүр, цэг | 7 255 | 7 770 | 2 170 | 2 351 | 2 501 | 2 564 | 1 949 | 2 035 | 635 | 820 |
| Соёлын төв | 349 | 380 | 97 | 117 | 104 | 112 | 100 | 105 | 48 | 46 |
| Эмийн сан | 0 | 996 | 0 | 271 | 0 | 331 | 0 | 280 | 0 | 114 |
| Уул уурхайн нэгж | 401 | 3191 | 25 | 1259 | 83 | 925 | 179 | 572 | 114 | 435 |

Боловсрол, соёл, үйлчилгээний байгууллагыг төрлөөр авч үзвэл 2021 оны хүнсний дэлгүүр, цэг буюу худалдааны салбар сумдад илүү хөгжсөн бөгөөд соёлын төв, шуудан, холбооны цэг ихэнх сумдад нэг байдаг гэсэн ерөнхий дүр төрх гарч байна. Интернэт үйлчилгээний цэг 97 буюу 27.6 хувиар, шуудан, холбооны цэг 32 буюу  8.4 хувиар тус тус буурсан нь иргэд гар утас /ухаалаг/-ны хэрэглээ нэмэгдсэнтэй холбоотой байна. Харин уул уурхайн нэгжийн тоо 2021 онд 3191 болж 2011 оноос 8 дахин нэмэгдсэн байна.

## ХӨДӨӨ АЖ АХУЙН ЗОРИУЛАЛТТАЙ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ БАЙГУУЛЛАГА

Сумдын иргэдэд үйлчилгээ үзүүлж байгаа хөдөө аж ахуйн зориулалттай үйлчилгээний байгууллагын тоо 2022 онд 4121 болж 1911 буюу 32 хувиар буурсан байна. 2021 оноос мал эмнэлгийн цэг, ХАА-н бүтээгдэхүүн борлуулах цэг, хадгалах агуулах, зоорь, боловсруулах цэг, боловсруулах үйлдвэр, мал үржүүлэг, технологийн ажил, үйлчилгээний нэгж, ХАА-н техникийн засварын газар гэсэн төрлүүдээр авч нэгтгэсэн.

ХАА-н бүтээгдэхүүн борлуулах цэг гэдэгт ноос, арьс, шир, цагаан идээ, сүү зэргийг борлуулах тусгайлсан цэгийг, ХАА-н бүтээгдэхүүн хадгалах агуулахад үр тариа, өвсний агуулахыг, ХАА-н бүтээгдэхүүн хадгалах зоориндтөмс, хүнсний ногоо, махны зоорийг, ХАА-н бүтээгдэхүүн боловсруулах цэг, үйлдвэрт ноос, арьс, шир, цагаан идээ, сүү, жимс, жимсгэнэ боловсруулах цэг, үйлдвэрийг хамруулав.

### ХҮСНЭГТ XVI.8. ХӨДӨӨ АЖ АХУЙН ЗОРИУЛАЛТТАЙ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ БАЙГУУЛЛАГЫН ТОО, бүсээр

| | Бүгд | | Баруун бүс | | Хангайн бүс | | Төвийн бүс | | Зүүн бүс | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | 2011 | 2021 | 2011 | 2021 | 2011 | 2021 | 2011 | 2021 | 2011 | 2021 |
| **Бүгд** | **6 032** | **4 121** | **1 145** | **1 525** | **1 261** | **1 023** | **3 281** | **1 108** | **345** | **465** |
| Мал эмнэлгийн цэг | 804 | 894 | 274 | 235 | 212 | 282 | 199 | 225 | 119 | 152 |
| **ХАА-н бүтээгдэхүүн** | | | | | | | | | | |
| Борлуулах цэг | 763 | 878 | 87 | 510 | 387 | 165 | 257 | 148 | 32 | 55 |
| Хадгалах агуулах | 317 | 469 | 107 | 107 | 78 | 127 | 69 | 195 | 63 | 40 |
| Хадгалах зоорь | 3 646 | 653 | 537 | 118 | 475 | 219 | 2 535 | 176 | 99 | 140 |
| Боловсруулах цэг | 246 | 739 | 54 | 398 | 31 | 118 | 146 | 197 | 15 | 26 |
| Боловсруулах үйлдвэр | 119 | 100 | 53 | 45 | 39 | 18 | 21 | 30 | 6 | 7 |
| Мал үржүүлэг, технологийн ажил, үйлчилгээний нэгж | | 158 | | 54 | | 39 | | 50 | | 15 |
| ХАА-н машин техникийн засварын газар | 137 | 230 | 33 | 58 | 39 | 55 | 54 | 87 | 11 | 30 |

Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн хадгалах зоорь 2011 онд хамгийн их буюу 3646 байна хамгийн олон байсан бол 2021 онд 653 болж 2993 буюу 5.6 дахин буурсан байна. Харин боловсруулах үйлдвэр, ихэнх сумдад байдаггүй байна.

## БАЙГАЛИЙН ГАМШИГТ ӨРТСӨН БАЙДАЛ

Байгалийн гамшигт үзэгдлийн давтамж, ган, зуд, үер, газар хөдлөлт, малын гаралтай халдварт өвчин, хүчтэй цасан болон шороон шуурга, ой хээрийн түймэр, өртөж байгаа байдлыг судалж үр дүнг нэгтгэсэн.

### ХҮСНЭГТ XVI.9. БАЙГАЛИЙН ГАМШИГТ ӨРТСӨН СУМЫН ТОО, сүүлийн 10 жилийн байдлаар

| 2012 оны тооллого | | | | | | 2022 оны тооллого | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Дүнд эзлэх хувь | | | | | | Дүнд эзлэх хувь | |
| Он | Сум-дын тоо | Зудад өртсөн сум | Ганд өртсөн сум | Зудад өртсөн сум | Ганд өртсөн сум | Он | Сум-дын тоо | Зудад өртсөн сум | Ганд өртсөн сум | Зудад өртсөн сум | Ганд өртсөн сум |
| 2002 | 330 | 123 | 75 | 37.3 | 22.7 | 2012 | 330 | 27 | 24 | 8.2 | 7.3 |
| 2003 | 331 | 46 | 46 | 13.9 | 13.9 | 2013 | 330 | 11 | 6 | 3.3 | 1.8 |
| 2004 | 331 | 19 | 48 | 5.7 | 14.5 | 2014 | 330 | 12 | 16 | 3.6 | 4.8 |
| 2005 | 331 | 17 | 54 | 5.1 | 16.3 | 2015 | 330 | 24 | 28 | 7.3 | 8.5 |
| 2006 | 331 | 25 | 39 | 7.6 | 11.8 | 2016 | 330 | 25 | 28 | 7.6 | 8.5 |
| 2007 | 331 | 23 | 42 | 6.9 | 12.7 | 2017 | 330 | 33 | 47 | 10.0 | 14.2 |
| 2008 | 329 | 54 | 51 | 16.4 | 15.5 | 2018 | 330 | 23 | 41 | 7.0 | 12.4 |
| 2009 | 329 | 153 | 80 | 46.5 | 24.3 | 2019 | 330 | 36 | 46 | 10.9 | 13.9 |
| 2010 | 329 | 140 | 39 | 42.6 | 11.9 | 2020 | 330 | 49 | 60 | 14.8 | 18.2 |
| 2011 | 329 | 7 | 8 | 2.1 | 2.4 | 2021 | 330 | 27 | 44 | 8.2 | 13.3 |

Зудад өртсөн байдлыг сүүлийн 20 жилийн байдлаар авч үзэхэд 2012 онд нийт сумын 8.2 хувь, 2017 онд 10.0 хувь, 2019 онд 10.9 хувь, 2020 онд 14.8 хувь нь зуд турханд хамгийн олон сумууд нэрвэгдсэн байна. 2012 оны тооллогын үр дүнгээс харахад 2009 онд 153 сум буюу 46.5 хувь, 2010 онд 140 сум буюу 42.6 хувь нь зудад өртсөн бол сүүлийн 10 жилийн 2020 онд 49 сум буюу 14.8 хувь нь зудад өртсөн байна.

Сүүлийн жилүүдэд нийт сумдын 10-аас дээш хувь нь ганд тогтмол өртдөг болсон ба 2017-2020 онд нийт нутгаар ганд өртсөн байна.

## ХӨДӨӨ АЖ АХУЙН ЧИГЛЭЛЭЭР ХЭРЭГЖИЖ БУЙ ТӨСӨЛ, ХӨТӨЛБӨР

Сумдын түвшинд хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн салбарт 2021 онд давхардсан тоогоор нийт 1920 төсөл, хөтөлбөр хэрэгжсэн нь 2011 оноос 72 буюу 3.6 хувиар буурсан байна.

ХҮСНЭГТ XVI.10. ХЭРЭГЖИЖ БУЙ ТӨСӨЛ, ХӨТӨЛБӨР, санхүүжилтийн эх үүсвэр, бүсээр

| | Бүгд | | Баруун бүс | | Хангайн бүс | | Төвийн бүс | | Зүүн бүс | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | 2011 | 2021 | 2011 | 2021 | 2011 | 2021 | 2011 | 2021 | 2011 | 2021 |
| **Бүгд** | **1 992** | **1 920** | **530** | **367** | **478** | **621** | **624** | **564** | **360** | **368** |
| Төрийн байгууллага | 1 056 | 1 021 | 216 | 166 | 249 | 296 | 366 | 351 | 225 | 208 |
| Төрийн бус байгууллага | 269 | 662 | 126 | 127 | 57 | 253 | 68 | 155 | 18 | 127 |
| Олон улсын байгууллага | 549 | 129 | 141 | 38 | 155 | 36 | 181 | 34 | 72 | 21 |
| Бусад эх үүсвэр | 118 | 108 | 47 | 36 | 17 | 36 | 9 | 24 | 45 | 12 |

Хэрэгжиж буй төсөл хөтөлбөрийг эх үүсвэрээр нь авч үзвэл 1021 буюу 53.2 хувь нь төрийн байгууллагаас хэрэгжүүлж буй төсөл хөтөлбөрт хамрагдаж байна. Төрийн бус байгууллага, олон улсын байгууллага, бусад эх үүсвэрээр хэрэгжүүлж буй төсөл, хөтөлбөр 899 буюу 46.8 хувийг эзэлж байна.

Тооллогын дүнгээр нийтдээ 2408 малчдын бүлэг сумдын хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа гэж хариулсан нь 2011 оноос 1.7 хувиар өссөн байна. Малчдын бүлгийн тоо Баруун бүсэд 96 буюу 17.1 хувиар, Төвийн бүсэд 89 буюу 13.5 хувиар тус тус буурсан байхад Зүүн бүсэд 21 буюу 7.0 хувиар, Хангайн бүс 24.1 хувиар тус тус өссөн байна.

ХҮСНЭГТ XVI.11. МАЛЧИД, ГАЗАР ТАРИАЛАНЧДЫН БҮЛГИЙН ТОО, бүсээр

| | Бүгд | | Баруун бүс | | Хангайн бүс | | Төвийн бүс | | Зүүн бүс | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | 2011 | 2021 | 2011 | 2021 | 2011 | 2021 | 2011 | 2021 | 2011 | 2021 |
| Малчдын бүлэг | 2 368 | 2 408 | 563 | 467 | 845 | 1 049 | 660 | 571 | 300 | 321 |

## ДҮГНЭЛТ

“Статистикийн тухай” Монгол Улсын хуулийн дагуу хөдөө аж ахуйн ээлжит тооллогыг 2022 оны 5 дугаар сарын 21-ний өдрөөс 7 дугаар сарын 08-ны өдрийг хүртэлх хугацаанд зохион байгуулж, ийнхүү үр дүнгийн тайланг бэлтгэн гаргаад байна.

Энэ удаагийн тооллогод таблет ашиглан ХАА-н салбарын өрх, ААНБ-аас нүүр тулсан ярилцлага хийх аргаар мэдээлэл цуглуулсан. Шат шатны тооллогын комисын ажилчид, тоологч, шалгагч, мэргэжилтнүүд нийтдээ 1200 гаруй хүн тооллогын ажилд ажиллаа.

Улсын хэмжээнд 2021 оны жилийн эцэст 920.2 мянган өрх байгаагаас 507.6 мянган өрх аймаг, орон нутагт буюу сумдад амьдарч байна. 2011 онтой харьцуулахад нийт өрхийн тоо 21.1 хувиар, орон нутагт амьдарч байгаа өрхийн тоо 12.0 хувиар өссөн байна.

Сүүлийн жилүүдэд нийт сумдын 10-аас дээш хувь нь ганд тогтмол өртдөг болсон ба 2017-2020 онд нийт нутгаар ганд өртсөн байна. Зудад өртсөн байдлыг сүүлийн 10 жилийн байдлаар авч үзэхэд 2012 онд нийт сумын 8.2 хувь, 2017 онд 10.0 хувь, 2019 онд 10.9 хувь, 2020 онд 14.8 хувь нь зуд турханд хамгийн олон сумууд нэрвэгдсэн байна. 2012 оны тооллогын үр дүнгээс харахад 2009 онд 153 сум буюу 46.5 хувь, 2010 онд 140 сум буюу 42.6 хувь нь зудад өртсөн бол сүүлийн 10 жилийн 2020 онд 49 сум буюу 14.8 хувь нь зудад өртсөн байна.

Тооллогод хамрагдсан мал аж ахуйн эрхэлдэг өрхийн 19.0 хувь буюу 46.6 мянган өрх малын индексжүүлсэн даатгал, арилжааны даатгал болон бусад төрлийн даатгалд хамрагдсан байгаа бол газар тариалан эрхэлдэг өрхийн 1.1 хувь нь үр тарианы болон арилжааны бусад даатгалуудад хамрагдсан байна. Харин мал аж ахуй эрхлэгч ААНБ-ын 24.1 хувь, газар тариалан эрхлэгч ААНБ-ын 3.6 хувь нь даатгалд хамрагдсан гэж хариулжээ. ХАА-н өрхүүд бусад салбартай харьцуулахад богино хугацааны зээлд хамрагдах хандлагатай хэвээр байгаа боловч өмнөх 10 жилтэй харьцуулахад зээлийн хугацааг уртасгах хандлага давхар ажиглагдаж байна.

**Өрх, ААНБ-ын тоо.** ХАА-н тооллогод 2021 онд 297.0 мянган өрх, аж ахуй нэгж бүртгэгдсэн нь 2011 оноос 51.5 мянган өрх, аж ахуй нэгж байгууллага буюу 21.0 хувиар өссөн байна. Үүнээс ХАА-н салбарт үйл ажиллагаа явуулдаг 294.1 мянган өрх байгаагаас, 245.4 мянган өрх буюу 83.4 хувь нь мал аж ахуй, 18.8 мянган өрх буюу 6.4 хувь нь газар тариалан, 25.5 мянган өрх буюу 8.7 хувь нь ойн аж ахуй, 3.4 мянган өрх буюу 1.1 хувь нь загасны аж ахуй, 1.2 мянган өрх буюу 0.4 хувь нь ан агнуурын аж ахуй эрхэлж байна.

Мал аж ахуй эрхэлдэг 245.4 мянган өрхөд 688.4 мянган хүн, газар тариалан эрхэлдэг 18.8 мянган өрхөд 48.6 мянган хүн амьдарч, нэг өрх дунджаар 2-3 ам бүлтэй байна.

**Ажиллагч.** ХАА-н салбарт 2021 оны байдлаар нийт 457.4 мянган хүн мал аж ахуй, газар тариалангийн үйл ажиллагаанд ажилласан байна. Үүнээс 89.9 хувь (410.9

мянга) нь байнгын, 10.1 хувь (46.5 мянга) нь түр ажиллагч байна. Салбараар ажиллагчдыг авч үзвэл байнгын ажиллагчдын 91.6 хувь нь мал аж ахуйн үйл ажиллагаа эрхэлдэг, 8.4 хувь нь газар тариалангийн үйл ажиллагаа эрхэлдэг байна.

Хөдөө аж ахуйн салбарт байнгын ажиллагчдыг насны бүлгээр харахад дийлэнх нь 40-өөс дээш насны хүмүүс байна. Тухайлбал, 2011 оны тооллогын байнгын ажиллагчдын 40-өөс доош насны хүмүүсийн нийт байнгын ажиллагчид эзлэх хувь 50.1 хувь нь байсан бол 2021 оны байдлаар 40.2 хувь болж 9.9 нэгж хувиар буурсан байна.

Улсын хэмжээнд 2021 онд газар тариалангийн салбарт 7.8 мянган мэргэжлийн ажиллагчид ажилласан ба үүний 0.7 мянга буюу 9.5 хувь нь өрхөд, 7.1 мянга буюу 90.5 хувь аж ахуйн нэгж, байгууллагад ажилласан байна.

**Газар тариалан.** Тооллогын дүнгээр 2021 онд нийт 550.7 мянган тонн үр тариа, 192.1 мянган тонн төмс, 150.1 мянган тонн хүнсний ногоо, 378.0 мянган тонн тэжээлийн ургамал, 49.3 мянган тонн техникийн ургамал хураан авсан байна. Аж ахуйн нэгж байгууллагын хураасан ургац нийт хураасан үр тарианы 90.1 хувь, төмсний 20.3 хувь, хүнсний ногооны 24.1 хувь, тэжээлийн ургамлын 52.4 хувь, техникийн ургамлын 90.0 хувийг тус тус эзэлж байна. Харин иргэд, өрхийн аж ахуйн хураасан ургац нийт хураасан үр тарианы 9.9 хувь, төмсний 79.7 хувь, хүнсний ногооны 75.9 хувь, тэжээлийн ургамлын 47.6 хувь, техникийн ургамлын 10.0 хувийг тус тус эзэлж байна.

Аж ахуйн нэгж байгууллага үр тариа, техник, тэжээлийн ургамал дийлэнхдээ тариалж байгаа бол төмс, хүнсний ногоог өрхийн тариалалтаар хангаж байна.

Газар тариалан эрхэлдэг өрх, ААНБ нь нэг га талбайгаас дунджаар 14.1 центнер үр тариа, 99.7 центнер төмс, 43.1 центнер тэжээлийн ургамал, 5.3 центнер техникийн ургамал хураан авсан байна.

Жишсэн хүн амын жилийн төмсний хэрэгцээг 2021 онд 99.9 хувь, хүнсний ногооны 66.5 хувийг дотоодын үйлдвэрлэлээр хангасан байна.

Тоног төхөөрөмж. 2011 оны тооллогын дүнтэй харьцуулахад нийт газар тариалангийн салбарын өрх, ААНБ-ын машин, тоног төхөөрөмж 2.5 мянгаар буурсан байна. Газар тариалангийн зориулалттай машин, тоног төхөөрөмжийн ихэнх нь өртөг өндөр, ашиглалтын хугацаа урт байдаг. Тоног төхөөрөмжийн ашиглалтын хугацаа улсын дунджаар 10.8 жил байна. Сүүлийн 10 жилд газар тариалангийн тоног төхөөрөмж дорвитой шинэчлэгдээгүй, уламжлалт тоног төхөөрөмж ашиглан тариалан эрхэлсээр байна.

Барилга байгууламж. Газар тариалан эрхэлдэг өрхөд ХАА-н зориулалттай 8 төрлийн нийт 10.7 мянган барилга, байгууламж тоологдсоноос 60.7 хувь нь зоорь, 35.7 хувь нь хүлэмж, 1.7 хувь нь агуулах, 1.9 хувь нь ХАА-н зориулалттай бусад барилга байгууламж байна. Газар тариалан эрхэлдэг өрхийн нийт зоорины тоо 10 жилийн өмнөх түвшинд байгаа хэдий ч багтаамжийн хэмжээ 7 дахин нэмэгдсэн байна. Агуулахын хувьд газар тариалан эрхэлдэг өрхөд нийт 5.9 мянган тонн багтаамж бүхий 184 агуулах тоологдсон бөгөөд энэ нь 2011 оноос агуулахын тоо 31.4 хувиар,

багтаамж нь 2 дахин нэмэгдсэн байна. Харин тооллогоор газар тариалан эрхэлдэг ААНБ-д нийт 72.5 мянган тонн багтаамж бүхий 725 зоорь тоологдсон нь 2011 оныхтой харьцуулахад багтаамж нь 30.8 мянган тонноор, зоорины тоо 10.0 хувиар нэмэгдсэн байна. Тооллогын дүнгээс харахад зоорь нь өрхийн хэрэглээнд, агуулах нь ААНБ-ын хэрэгцээнд илүү ашиглагддаг нь харагдаж байна.

Хүлэмжийн аж ахуй. ХАА-н тооллогоор 4468.4 мянган га-д хүлэмжийн аж ахуй эрхэлсэн 3.1 мянган өрх, 242 ААНБ бүртгэгдлээ. Хүлэмжийн тариалалт хийсэн талбайн 78.3 хувийг өрх, 21.7 хувийг ААНБ эзэлж байна.

Бордоо, ургамал хамгааллын бодис/пестицид хэрэглэсэн талбай. Газар тариалан эрхэлдэг нийт өрхийн 29.3 хувь нь, нийт ААНБ-ын 45.0 хувь нь бордоо, бодис ашигласан байна. Газар тариалан эрхэлдэг өрх, ААНБ нийт тариалсан талбай 609.8 мянган га болж 10 жилийн өмнөхөөс 1.7 дахин (242.5 мянган га) өссөн байна. Тариалсан талбайн өсөлттэй зэрэгцэн газар тариалан эрхэлж буй өрх, аж ахуйн нэгж, байгууллагууд ургацын хэмжээг нэмэгдүүлж, шим тэжээлийг хадгалах зорилгоор бордоо, ургамлын өсөлт дэмжих бодисыг хэрэглэх хандлага нэмэгдсэн байна.

Нэг га талбайд дунджаар 6.4 тонн бордоо, 18.8 кг тонн ургамал хамгааллын бодис/пестицид ногдож байна. 10 жилийн өмнөхтэй харьцуулахад газар тариалан эрхлэгч өрх, ААНБ ургамлын өвчин, хөнөөлт шавж, мэрэгч амьтан, хог ургамалтай тэмцэх, агуулах, зоорио ариутгах зэргээр олон төрлийн ургамал хамгааллын бодисын хэрэглэх хандлага нэмэгдсэн байна.

Хөрсний доройтол. Газар тариалангийн үйл ажиллагаа эрхэлдэг өрхийн 3.6 хувь буюу 0.7 мянган өрх тариалангийн талбайдаа агрохимийн шинжилгээ хийлгэсэн байна. 2011 онтой харьцуулахад хөрсний агрохимийн шинжилгээ хийлгэсэн өрхийн хувь 0.2 нэгж хувиар буурсан байна.

Харин агрохимийн шинжилгээ хийсэн өрхүүдийн хөрсний элэгдэл, эвдрэлийн зэрэг хэвийнээс сул руу, сулаас дундаж руу шилжсэн хандлага эрдсийн төрөл тус бүрт ажиглагдсан байна. Түүнчлэн тариалангийн талбай тэжээл болон органик бодис, давслаг, ислэг, шүлтлэгээ алдсантай холбоотой хөрсний химийн чанар болох хөрсний нитратын азот, хөрсний хөдөлгөөнт фосфор, хөрсний хөдөлгөөнт кали буурах буюу бохирдох үзэгдэл нэмэгдэж байгааг илтгэжээ.

Үнэ. Газар тариалангийн бүтээгдэхүүний үйлдвэрлэгчийн үнэ болон зах зээлийн үнийн харьцааг авч үзвэл буудайн үнийн 89.7 хувь нь, төмсний үнийн 83.1 хувь нь, байцаан үнийн 80.9 хувь нь, луувангийн үнийн 81.0 хувь нь, сонгины үнийн 85.5 хувь нь тус тус үйлдвэрлэгчийн үнэ эзэлж байна.

**Мал аж ахуй.** Мал тооллогын 2021 оны жилийн эцсийн дүнгээр малын тоо толгой 67.3 сая болж, төрлөөр нь авч үзвэл, адуу 4.3 сая, үхэр 5 сая, тэмээ 454 мянга, хонь 31.1 сая, ямаа 26.5 сая толгой тоологдсон. Монгол Улсын мал тооллогын 1926-1992 оны 66 жилийн үр дүнгээс үзэхэд сүрэгт бод мал дунджаар 21.7 хувь, бог мал дунджаар 78.3 хувийг эзэлдэг байсан бол 2021 оны байдлаар бод мал дунджаар 14.6 хувь, бог мал дунджаар 85.4 хувийг эзэлж байгаа нь бод малын хувийн жин 7.1 нэгж

хувиар буурч, бог малынх 7.1 нэгж хувиар нэмэгдсэн байна. Энэ нь сүүлийн жилүүдэд бэлчээрийн хүрэлцээ муудах, хөрсний доройтол нэмэгдэх сөрөг талуудыг үүсгэсэн билээ.

Тоног төхөөрөмж. ХААТ-д МАА-н зориулалттай 175.0 мянган ширхэг машин, тоног төхөөрөмж бүртгэгджээ. 2021 онд мал аж ахуйн зориулалттай машин, тоног төхөөрөмжийн 96.4 хувийг суудлын болон ачааны машин, мотоцикл, трактор эзэлж байгаа нь 10 жилийн өмнөхөөс 17.4 нэгж хувиар өссөн үзүүлэлттэй байна.

Барилга, байгууламж. МАА эрхэлдэг өрхөд 3141 зориулалтын технологийн байр, ферм, 130 зоорь, 402 агуулах тоологдсон байна. МАА эрхэлдэг өрхийн зориулалтын технологийн байр, фермийн тоо 2011 оноос 4.4 дахин нэмэгдсэн бөгөөд нийт тоологдсон фермийн 53.6 хувь нь Төвийн бүсэд, 14.8 хувь Улаанбаатар хотод байна.

МАА эрхэлдэг ААНБ-ын хувьд зориулалтын голлох технологийн байр буюу фермийн нийт багтаамжийн 98.9 мянган хонин толгой байгаа бөгөөд дунджаар нэг ферм 2 041 хонин толгойн багтаамжтай байна.

2021 оны ХАА-н тооллогод хүн, мал ундаалах зориулалт бүхий 75.7 мянган худаг, 509 усан сан тоологдлоо. 2011 онтой харьцуулахад нийт худаг, усан сангийн тоо 2.0 дахин нэмэгдсэн байна. 2011 онд нийт худгийн 28.3 мянга буюу 73.6 хувь нь бэлчээрт байршилтай байсан бол энэ удаагийн тооллогод 35.7 мянга буюу 47.2 хувь нь бэлчээрт байршилтай байна.

Мал аж ахуйн бүтээгдэхүүний нэгжийн гарц. Үнээний сүүний өдрийн дундаж гарц 2.3 литр, гүүнийх 2.5 литр, ингэнийх 0.7 литр, эм хониных болон эм ямааных 0.5 литр байна.

Нэг малаас самнасан ноос, ноолуур, хялгасны гарцыг тооцоход жилд дунджаар өсвөр насны тэмээний ноос 4087.2 гр, нас гүйцсэн тэмээний ноос 5062.2 гр, хонины уртын ноос 1166.7 гр, хурганы ноос 404.1 гр, ямааны ноолуур 387.7 гр, ямааны хялгас 171.3 гр, бодын хөөвөр 479.9 гр-г тус тус самнасан байна.

Улсын дунджаар малын төрлөөр авч үзвэл адууны амьдын дундаж жин 264.2 кг, үхрийнх 280.2 кг, тэмээнийх 411.3 кг, хониных 44.6 кг, ямааных 37.9 кг байна.

Мал аж ахуйн бүтээгдэхүүний үнэ. Мал аж ахуйн гаралтай бүтээгдэхүүний үнэ арван жилийн өмнөхтэй харьцуулахад 2-5 дахин өссөн байна. Махны дундаж үнийг авч үзэхэд ямааны мах (42.6 хувь), хонины мах (37.3 хувь), адууны мах (33.2 хувь) үйлдвэрлэгчийн үнээс хамгийн өндөр хувийн нэмэгдэлтэйгээр зах зээлд нийлүүлэгддэг байна. Хонь, ямааны махны хувьд өндөр уулын бүсэд хамгийн их нэмэгдэлтэй буюу үйлдвэрлэгчийн үнэ болон зах зээлийн үнийн харьцаа хамгийн бага байна.

# ХАВСРАЛТ ХҮСНЭГТ

ЭНД дарж (мөн QR кодыг уншуулж)

хавсралт хүснэгтүүдийг татаж авах боломжтой